Анд-Энерги ХХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

2017 он

АНД-ЭНЕРГИ ХХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаасны төрөл:	Энгийн хувьцаа
Санал болгож буй үнэт цаасны тоо:	26,544,058
Үнэт цаасны нэрлэсэн үнэ:	1 төгрөг
Үнэт цаасны санал болгох үнэ:	60 төгрөг
Андеррайтер:	Бумбат-Алтай ҮЦК

2017 он

Мэдэгдэл: "Энэхүү баримт бичиг нь Үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны Бүртгэлийн журам, Монголын үнэт цаасны биржийн Бүртгэлийн журамд заасан үнэт цаасыг олон нийтэд санал болгохтой холбоотой бүх шаардлагатай мэдээллийг агуулсан болно. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь энэ баримт бичигт агуулсан мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд бөгөөд хуурамчаар бүрдүүлсэн ямар нэгэн баримт байхгүй гэдгийг албан ёсоор батална байна. Энд заасан мэдэгдэл худал байх тохиолдолд үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь данган болон хамтын журмаар хариуцлага хүлээхийг хүлээн зөвшөөрч байна".

"Монголын үнэт цаасны биржийн ХХК нь энэхүү баримт бичигт агуулагдсан аливаа мэдээлэл, баримт бичиг, материалын агуулга, тэдгээрийн үнэн зөв, бүрэн гүйцэд эсэх асуудлаар ямар нэг хариуцлага хүлээхгүй. Тус баримт бичгийн агуулгын улмаас үүссэн аливаа хохирол, үр дагаврыг гаргахүү үнэт цаас гаргагч хариуцна".

Хөрөнгө оруулагчдын анхааралд:

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7.1-д заасны дагуу нийтэд санал болгон гаргаж буй энэхүү үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороо бүртгэсэн нь уг үнэт цаасны эрсдэлийн талаар аливаа баталгаа гаргаагүй болохыг анхаарах нь зүйтэй. Энэхүү үнэт цаасыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч таны хувьд ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, үнэт цаасны танилцуулга, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

ГАРЧИГ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	6
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	7
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	7
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	8
ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	11
ТӨЛӨВЛӨЖ БУЙ БҮРТГҮҮЛЭХ АЖЛЫН ХУВААРЬ	12
НЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГЫН ХУРААНГУЙ	13
1.1. Компанийн товч түүх	13
1.2. Үндсэн үйл ажиллагаа	13
1.3. Стратеги	14
1.4. Зах зээлийн багтаамж, давуу тал	14
1.5. Хөрөнгө оруулалт	15
1.6. Санхүүгийн үзүүлэлтүүд	15
1.7. Ногдол ашгийн бодлого	16
1.8. Эрсдэл	16
ХОЁР. ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛ, УДИРДЛАГА	17
2.1. Бизнес, үйлдвэрлэлтэй холбоотой эрсдэл	17
2.2. Хууль эрх зүйн тогтворгүй байдлын эрсдэл	19
2.3. Үнэт цаас санал болгохтой холбоотой эрсдэл	20

СӨХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

ГУРАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ 22

ДӨРӨВ. САЛБАРЫН ТОЙМ 23
4.1. Гэрлийн үүсэл, хөгжил 23
4.2. Дэлхийн LED гэрлийн зах зээл 24
4.3. LED гэрэл үйлдвэрлэгч 24
4.4. Монголын гэрэл болон LED гэрлийн зах зээл 27
ТАВ. КОМПАНИЙН ТҮҮХ, ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАЛТ, БҮТЭЦ 32
5.1. Компанийн тухай 32
5.2. Компанийн хувьцаааны эзэмшил, хэлбэр, өөрчлөн байгуулалт 35

ЗУРГАА. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА 38
6.1. Бизнесийн тухай 38
6.2. Бизнесийн ирээдүйн тухай 49
6.3. Бизнесийг өргөжүүлэх боломж 61

ДОЛОО. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД 63
7.1. Төлөөлөн удирдах зөвлөл 63
7.2. Эрх бүхий албан тушаалтан 66

НАЙМ. НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ХЯНАЛТЫН БАГЦ ЭЗЭМШИГЧ 67

ЕС. ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ 68

АРАВ. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ 69
10.1. Санхүүгийн тайлангийн хураангуй 69
10.2. Үйл ажиллагаа, санхүүгийн нөхцөл байдалд нөлөөлөх хүчин зүйлс 70
10.3. Орлогын тайлангийн үзүүлэлтүүдийн тайлбар 71
10.4. Үйл ажиллагааны үр дүн 74
2016, 2015 оны үйл ажиллагааны үр дүнгийн харьцуулалт 74
2015, 2014 оны үйл ажиллагааны үр дүнгийн харьцуулалт 76
10.5. Ажлын капитал 77
10.6. Мөнгөн гүйлгээний мэдээлэл 78
10.7. Дансны авлага, бусад авлага 80
10.8. Холбоотой талуудын ажил гүйлгээ 80

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА*01070 4335772

Булган Алтай
2087103
ПҮОН0230

10.9. Зээл 81
10.10. Санхүүгийн эрсдэлийн удирдлага 81
10.11. Болзошгүй өр төлбөр 81
10.12. Хөрөнгө оруулалтын зардал 82
10.13. Ашгийн таамаглал 83
10.14. Төсөвлөсөн цэвэр хөрөнгийн тохиргоо тайлан 83
10.15. Хөрөнгийн үнэ цэнэ 84
10.16. Ногдол ашиг 84

АРВАН НЭГ. ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ 85

АРВАН ХОЁР. ХАРИЛЦАН ХАМААРАЛТАЙ ХЭЛЦЭЛ 90

АРВАН ГУРАВ. АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА 92

АРВАН ДӨРӨВ. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗОХИЦУУЛАЛТ 95

АРВАН ТАВ. ҮНЭТ ЦААСЫГ НИЙТЭД САНАЛ БОЛГОХ 97
15.1. Биржийн бүртгэлийн шалгуур шаардлагын хөнгөлөлт, чөлөөлөлт 97
15.2. Үнэт цаасыг нийтэд санал болгох арга 98

АРВАН ЗУРГАА. НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ 99

ХАВСРАЛТ 1. ТӨСӨВЛӨСӨН САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ 100
1. Төсөвлөсөн санхүүгийн тайлан 100
Төсөвлөсөн санхүүгийн байдлын тайлан 101
Төсөвлөсөн орлого, үр дүнгийн тайлан 104
Төсөвлөсөн мөнгөн гүйлгээний тайлан 110
2. Төсөвлөсөн санхүүгийн тайлангийн харьцааны үзүүлэлтүүд 111
3. Нэгж хувьцаанд ногдох ашгийн төсөөлөл 112

ХАВСРАЛТ 2. МЭРГЭШСЭН НЯГТЛАН БОДОГЧИЙН ДҮГНЭЛТ 113
1. Танилцуулга 113
1.1. Мэргэшсэн нягтлан бодогчийн дүгнэлт гаргагчийн танилцуулга 113
1.2. Компанийн мэдээлэл 113
1.3. МНБД-ийн хамрах хүрээ 114

СЭХ он сар өдөр БҮРТГЭВ

ОРХОН АЙМАГ АНД-ЭНЕРГИ ХХК КА101070 4335772

Бумбат Алтай 2087103 ПЮН0230

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

2. Санхүүгийн тайлан 115
2.1. Санхүүгийн байдлын тайлангийн харьцуулсан үзүүлэлтүүд 115
2.2. Орлогын дэлгэрэнгүй тайлангийн харьцуулсан үзүүлэлтүүд 116
2.3. Өмчийн өөрчлөлтийн тайлангийн харьцуулсан үзүүлэлтүүд 117
2.4. Мөнгөн гүйлгээний тайлангийн харьцуулсан үзүүлэлтүүд 118
3. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн тайлбар 119
4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого 129
5. Бусад 132

ХАВСРАЛТ 3. АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
3-А. Хараат бус аудиторын дүгнэлт, 2016 137
3-Б. Аудитлагдсан санхүүгийн тайлан, 2015 166
3-В. Аудитлагдсан санхүүгийн тайлан, 2014 187

ХАВСРАЛТ 4. ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН 209

ХАВСРАЛТ 5. ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ 230

ХАВСРАЛТ 6. ЧИЙДЭНГИЙН ЧАНАРТ ХИЙСЭН ТУРШИЛТ БОЛОН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА 278

ХАВСРАЛТ 7. БУСАД
Бүтээгдэхүүний үнийн судалгаа 293
Үйлдвэрийн шинэ байрны план зураг 295
Үйлдвэрийн шинэ шугамын үнийн санал 298
Тогтоолын хуулбарууд 300

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ
ХХК
КА!!01070 4385772

2087103
ПЮН0230

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөвлөсөн санхүүгийн мэдээллийн хураангуй	15
Хүснэгт 2. Зах зээлийн багтаамжийн тооцооллын эрсдэл	18
Хүснэгт 3. Цэвэр ашгийн бууралтын харьцуулалт	18
Хүснэгт 4. Валютын ханшийн эрсдэл	19
Хүснэгт 5. Татварын орчны өөрчлөлтийн эрсдэл	20
Хүснэгт 6. Гэрэлтүүлгийн түүхэн хөгжил	23
Хүснэгт 7. Монгол Улсын 2016 оны өрхийн мэдээ	29
Хүснэгт 8. Улаанбаатар хотын өрхийн гэрлийн хэрэглээ	30
Хүснэгт 9. Хөдөө орон нутгийн өрхийн гэрлийн хэрэглээ	30
Хүснэгт 10. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо	38
Хүснэгт 11. Үйлдвэрийн тоног төхөөрөмж	40
Хүснэгт 12. Борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ	42
Хүснэгт 13. Үйлдвэрлэлт, борлуулалтын харьцаа	43
Хүснэгт 14. Түүхий эд бэлтгэн нийлүүлэлт	44
Хүснэгт 15. Өрсөлдөгч бүтээгдэхүүний дундаж үнэ	46
Хүснэгт 16. Өрсөлдөгч гэрлүүдийг өөрийн гэрэлтэй харьцуулан үзвэл	48
Хүснэгт 17. Эрдэнэт LED гэрлийн SWOT шинжилгээг гаргавал	49
Хүснэгт 18. Худалдан авахаар төлөвлөж буй тоног төхөөрөмж	51
Хүснэгт 19. Үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө	54
Хүснэгт 20. Шинэ үйлдвэрлэлээр зах зээлд эзлэх хэмжээ	55
Хүснэгт 21. Үйлдвэрлэлийн маркетингийн иж бүрдэл	55
Хүснэгт 22. Түгээлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө-Орхон аймаг	58
Хүснэгт 23. Түгээлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө-УБ хот	59
Хүснэгт 24. Идэвхжүүлэлтийн арга хэрэгслийг тодорхойлох	60
Хүснэгт 25. Мэдээллийн сувгуудын харьцуулалт	61
Хүснэгт 26. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө	68
Хүснэгт 27. Орлогын дэлгэрэнгүй тайлангийн хураангуй	69
Хүснэгт 28. Санхүүгийн байдлын тайлангийн хураангуй	70
Хүснэгт 29. Борлуулалтын орлогын задаргаа	72
Хүснэгт 30. Ерөнхий ба удирдлагын зардлын задаргаа	73
Хүснэгт 31. Ажлын капитал	77
Хүснэгт 32. Мөнгөн гүйлгээний тайлангийн хураангуй	78

СЭХ
он сар
БҮРТГЭВ
№ 01

АНД ЭНЕРГИ ХХК
КА01070 4385772

2067103
ПЮН0230

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
БҮРТГЭВ
№ 31

Хүснэгт 33. Дансны ба бусад авлага 80
Хүснэгт 34. Урт хугацаат өр төлбөр 81
Хүснэгт 35. Хөрөнгө оруулалтын мэдээ 82
Хүснэгт 36. IPO-оор татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт 83
Хүснэгт 37. Төсөвлөсөн цэвэр хөрөнгийн тохиргоо тайлан 84
Хүснэгт 38. Худалдан авах бусад тоног төхөөрөмжийн үнийн санал 89

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Дэлхийн LED гэрлийн үйлдвэрлэл, харьцуулсан судалгаа 25
График 2. Улайсах, сүүн, LED гэрлийн харьцуулсан судалгаа 25
График 3. LED гэрлийн зах зээл (бүх бүтээгдэхүүн) 26
График 4. LED гэрэлтүүлгийн зах зээл 26
График 5. LED гэрэлтүүлгийн ангилал 27
График 6. Монгол Улсын цахилгааны хэрэглээний бүтэц 28
График 7. Импортын гэрлийн тоо ширхэг 28
График 8. Эрчим хүч хэрэглэгчдийн бүтэц 29

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Компанийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц 37
Зураг 2. Компанийн засаглалын шинэ бүтэц 37
Зураг 3. Одоогийн үйлдвэрийн байрны план зураг 40
Зураг 4. Компанийн бүтэц, орон тоо 53

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
БҮРТГЭЛИЙН БАРИМТ БИЧИГ
2087103 ПҮОН0230

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

“андеррайтер”	Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, Монголын үнэт цаасны биржийн Бүртгэлийн журмын 6.2-т заасны дагуу үнэт цаас гаргагчтай андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан хуулийн этгээд
“Аудитын хороо”	Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2-т заасны дагуу байгуулагдсан Анд-Энерги ХХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх хороо
“ашгийн таамаглал”	Компанийн ашиг алдагдлын таамаглал буюу ирээдүйн ашиг алдагдлын урьдчилсан түвшинг шууд эсхүл өмнөх жилүүдийн түвшин болон харьцуулалтад үндэслэн гаргасан тооцооллын тайлан
“Бирж”	Монголын үнэт цаасны бирж
“бүртгэлийн баримт бичиг”	Монголын үнэт цаасны биржийн бүртгэлийн журмын 8 дугаар бүлэгт заасны дагуу бэлтгэсэн үнэт цаасны танилцуулга, түүнд хавсаргасан бусад мэдээлэл, баримт бичгүүд
“Бүртгэлийн журам”	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 47.2.3-т заасны дагуу баталсан Монголын үнэт цаасны биржийн Бүртгэлийн журам
“бүртгэлийн баримт бичгийн анхны төсөл”	Бүртгүүлэх өргөдөл анх гаргахад ирүүлэх тухай Монголын үнэт цаасны биржийн бүртгэлийн журмын 7.14-т заасан мэдээллийг агуулсан бүртгэлийн баримт бичгийн анхны төсөл
“бүртгэлийн баримт бичгийн эцсийн төсөл”	Монголын үнэт цаасны биржийн Бүртгэлийн журмын 7.16-д заасны дагуу Биржийн саналыг бүрэн тусгасан бүртгэлийн баримт бичиг
“Бүртгэлийн хороо”	Монголын үнэт цаасны биржийн Бүртгэлийн журмын 2 дугаар бүлэгт заасан Биржийн үйл ажиллагааны нэгж
“гаргасан хувьцаа”	Компанийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-т заасан ойлголт
“дотоод мэдээлэл”	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 76.1-д заасан мэдээлэл

“зарласан хувьцаа”	Компанийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасан ойлголт
“итгэмжлэгдсэн төлөөлөгч”	Монголын үнэт цаасны биржийн Бүртгэлийн журмын 13 дугаар бүлэгт заасан ойлголт
“Компани”	Анд-Энерги ХХК
“мэдэгдвэл зохих хэлцэл”	Биржийн мэдэгдэх шаардлагатай гэж үзсэн аливаа төрлийн хэлцэл
“мэргэжлийн зөвлөх”	Монголын үнэт цаасны биржийн Бүртгэлийн журамд заасны дагуу Компанид мэргэжлийн зөвлөгөө үзүүлэх санхүүгийн зөвлөх, хуульч, нягтлан бодогч, хөрөнгийн үнэлгээчин болон бусад этгээд
“мэргэшсэн нягтлан бодогчийн дүгнэлт”	Монголын үнэт цаасны биржийн Бүртгэлийн журмын 9 дүгээр бүлэгт заасан ойлголт
“Нэр дэвшүүлэх хороо”	Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2-т заасны дагуу байгуулагдсан Анд-Энерги ХХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх хороо
“нөлөө бүхий хувьцаа эзэмшигч”	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.29-д заасан этгээд
“Нийцүүлэгч”	Монголын үнэт цаасны биржийн Бүртгэлийн журмын 6.18, 6.19-т заасны дагуу Компанийн үйл ажиллагаа Биржээс гаргасан дүрэм журамд нийцэж байгаа эсэхэд зөвлөмж, зааварчилгаа өгөх үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 эсвэл 24.1.17-д заасан зохицуулалттай үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд
“нийт хөрөнгө”	Бүртгэлийн баримт бичиг гаргахаас өмнөх Компанийн хамгийн сүүлийн аудитлагдсан санхүүгийн тайланд тусгасан эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн нийлбэр
“өргөдөл гаргагч”	Анд-Энерги ХХК
“Төлөөлөн удирдах зөвлөл”	Анд-Энерги ХХК-ийн Төлөөлөх удирдах зөвлөл
“тусгай зөвшөөрөл”	Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу эрх бүхий байгууллагаас Компанид олгосон үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
БҮРТГЭВ
ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
2087103 ПЮН0230
БҮРТГЭЛИЙН БАРИМТ БИЧИГ

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

“төсөвлөсөн санхүүгийн мэдээлэл”	Монголын үнэт цаасны биржийн Бүртгэлийн журмын 9 дүгээр бүлэгт заасан ойлголт
“хамааралтай этгээд”	Монголын үнэт цаасны биржийн Бүртгэлийн журмын 1 дүгээр бүлэгт заасан ойлголт
“хамаарал бүхий компани”	Компанийн охин болон хараат компани
“харилцан хамааралтай хэлцэл”	Компанийн зүгээс хамааралтай этгээдүүдтэй байгуулсан хэлцэл
“холбоотой этгээд”	Монголын үнэт цаасны биржийн Бүртгэлийн журмын 1 дүгээр бүлэгт заасан ойлголт
“Хороо”	Санхүүгийн зохицуулах хороо
“хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх зар”	Хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх, илгээх, нийтлэх мэдээ мэдээлэл, баримт бичиг
“хөрөнгийн үнэ цэнэ “	Хөрөнгийн үнэлгээ хийсний үр дүнд тогтоосон мөнгөөр илэрхийлэгдэх үнэлгээ
“Цалин урамшууллын хороо”	Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2-д заасны дагуу байгуулагдсан Анд-Энерги ХХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх хороо
“шинжээч”	Мэргэжлийн дүгнэлт гаргах эрх бүхий инженер, үнэлгээчин, аудитор болон бусад этгээд
“эрх бүхий албан тушаалтан”	Анд-Энерги ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн.

СЭХ
ОН СЕР
ВТРТ-ROM
№ 31

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ
ХХК
КА201070 4385772

“АНД ЭНЕРГИ” ХХК

Бумбат Алтан
2087103
ПЮН0230

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
ОН САР ӨДӨР
БҮРТГЭВ
№ 11

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ААНОАТ	-	аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АНУ	-	Америкийн Нэгдсэн Улс
БНХАУ	-	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	-	Бүгд Найрамдах Солонгос Улс
БТКУС	-	бараа тодорхойлох, кодлох уялдуулсан систем
БОЭТ	-	Бүсийн оношлогоо эмчилгээний төв
ЗДТГ	-	Засаг даргын Тамгын газар
ИТХ	-	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МНБ	-	мэргэшсэн нягтлан бодогч
МНБД	-	мэргэшсэн нягтлан бодогчийн дүгнэлт
МУИС	-	Монгол Улсын Их Сургууль
МҮЦБ	-	Монголын үнэт цаасны бирж
НББОУС	-	нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	-	нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	-	нэмэгдсэн өртгийн албан татвар
ОХУ	-	Оросын Холбооны Улс
СЗХ	-	Санхүүгийн зохицуулах хороо
СТОУС	-	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
СЭЗДС	-	Санхүү эдийн засгийн дээд сургууль
ТӨХК	-	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	-	төлөөлөн удирдах зөвлөл
ҮСХ	-	Үндэсний статистикийн хороо
ҮЦК	-	үнэт цаасны компани
ХК	-	хувьцаат компани
ХХБ	-	Худалдаа хөгжлийн банк
ХХК	-	хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХН	-	хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл
ХХОАТ	-	хувь хүний орлогын албан татвар
ШТС	-	шатахуун түгээх станц
ШУТИС	-	Шинжлэх ухаан технологийн их сургууль
ЭМНДШ	-	эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл
CAGR	-	compound annual growth rate (жилийн дундаж өсөлтийн хувь)
CFL	-	compact fluorescent lamp (компакт флюресцент гэрэл)
FIFO	-	first in, first out (эхэлж авсныг эхэлж зарлагадах)
IPO	-	initial public offering (нийтэд анх удаа санал болгох)
IRR	-	internal rate of return (дотоод өгөөжийн хувь)
LED	-	ligth emitted diode (гэрэл цацруулагч диод)
NPV	-	net present value (цэвэр өнөөгийн үнэ цэнэ)
PBP	-	payback period (буцаан төлөгдөх хугацаа)
PCB	-	printed circuit board (хэвлэмэл хэлхээний самбар)
ROA	-	return on assets (хөрөнгийн өгөөж)
ROE	-	return on equity (хувьцаат хөрөнгийн өгөөж)
SWOT	-	strengths, weaknesses, opportunities, threats (нөхцөл байдлын шинжилгээ)

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА1301070 4385772

БҮРТГЭЛИЙН БАРИМТ БИЧИГ 11
2087103 ПЮН0230

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

ТӨЛӨВЛӨЖ БУЙ БҮРТГҮҮЛЭХ АЖЛЫН ХУВААРЬ

1. **Бүртгэлийн баримт бичгийн анхны төслийг Биржид хүргүүлэх**
   2017 оны 05 дугаар сарын 10
2. **Бүртгэлийн баримт бичгийн эцсийн төслийн урьдчилсан зөвлөгөөн хийх**
   2017 оны 06 дугаар сарын 14
3. **Бүртгэлийн баримт бичгийн эцсийн төсөл, үнэт цаас бүртгүүлэх хүсэлтийг Хороо болон Биржид хүргүүлэх**
   2017 оны 06 дугаар сарын 21
4. **Бирж өргөдлийг хэлэлцэж шийдвэрлэх**
   2017 оны 07 дугаар сарын 10
5. **Үнэт цаасыг Хороонд бүртгүүлэх**
   2017 оны 06 дугаар сарын 21 ~ 10 дугаар сарын 09
6. **Бүртгэлийн баримт бичгийг хэвлэх**
   2017 оны 10 дугаар сарын 10
7. **Бүртгэлийн баримт бичгийг батламжлах**
   2017 оны 10 дугаар сарын 10
8. **Бүртгэлийн баримт бичгийг олон нийтэд танилцуулах**
   2017 оны 10 дугаар сарын 11 ~ 11 дүгээр сарын 01
9. **Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах зөвшөөрөл авах**
   2017 оны 10 дугаар сарын 25 ~ 11 дүгээр сарын 01
10. **Захиалга авах, захиалгыг хаах**
    2017 оны 10 дугаар сарын 25 ~ 11 дүгээр сарын 01
11. **Захиалга дүгнэх, үнэ тогтоох**
    2017 оны 11 дүгээр сарын 01
12. **Хуваарилалт хийх, анхдагч зах зээлийн арилжаа явуулах**
    2017 оны 11 дүгээр сарын 01
13. **Анхдагч зах зээлийн арилжааны дүнг Хороонд танилцуулах, үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааны зөвшөөрөл авах**
    2017 оны 11 дүгээр сарын 01 ~ 11 дүгээр сарын 03
14. **Үнэт цаас гаргагчтай бүртгэлийн гэрээ байгуулах**
    2017 оны 11 дүгээр сарын 01
15. **Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх**
    2017 оны 11 дүгээр сарын 03

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
БҮРТГЭВ
№ 11

НЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГЫН ХУРААНГУЙ

Энэхүү бүлэг нь үнэт цаасны танилцуулгын үндсэн агуулгыг тоймлон хүргэх зорилготой бөгөөд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад нөлөөлөх бүх тоо баримтуудыг бүрэн багтаах боломжгүй учраас шийдвэр гаргахаасаа өмнө Үнэт цаасны танилцуулгыг бүхэлд нь бүрэн гүйцэд судлахыг зөвлөж байна. Аливаа хөрөнгө оруулалт өгөөжөөс гадна эрсдэл үүсгэдэг тул эцсийн шийдвэр гаргахаасаа өмнө "ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛ" бүлэгт анхаарлаа дахин хандуулахыг онцгойлон сануулж байна.

1.1. Компанийн товч түүх

Манай компани 2011 онд цахилгаан, электроникийн инженерүүдийн санаачилгаар үүсгэн байгуулагдаж, цахилгааны угсралт, суурилуулалт, автоматжуулалтын үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Бид 2011-2014 онд дээрх ажлуудыг гүйцэтгэхийн зэрэгцээ LED гэрлийн үйлдвэрлэлийн судалгааны ажлыг амжилттай гүйцэтгэснээр 2014 оны 9 дүгээр сард "Эрдэнэт лед" гэрлийн үйлдвэрээ ашиглалтад оруулсан юм. Ингэснээр Компанийн үндсэн бизнес нь LED гэрлийн үйлдвэрлэл болон өргөжиж, одоогоор 32 нэр төрлийн LED гэрэл үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж байна.

2017 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар өөрийн оффис, үйлдвэрийн байр, агуулах, үндсэн болон гэрээт 14 ажилтантай, жилдээ 680 гаруй сая төгрөгийн борлуулалтын орлоготой, олон улсын стандарт, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн брэнд бүтээгдэхүүн нийлүүлэгч, зах зээлд танигдсан, нэр хүндтэй компани болон өргөжөөд байна.

1.2. Үндсэн үйл ажиллагаа

Компанийн үндсэн үйл ажиллагааг дараах 4 төрөлд хуваан авч үзнэ:

- LED гэрэл, гэрэлтүүлгийн үйлдвэрлэл;
- Цахилгаан тоног төхөөрөмжийн угсралт, засвар үйлчилгээ;
- Үйлдвэрлэлийн автоматжуулалт;
- Худалдаа.

2016 оны тайлангаар LED гэрэл, гэрэлтүүлгийн үйлдвэрлэлийн орлого нийт борлуулалтын 47.3 хувийг, цахилгаан тоног төхөөрөмжийн угсралт, засвар үйлчилгээ, үйлдвэрлэлийн автоматжуулалт, худалдааны орлого 52.7 хувийг тус тус эзэлж байна.

- LED гэрлийн үйлдвэрийг ашиглалтад оруулснаар Компанийн үндсэн бизнес LED гэрэл, гэрэлтүүлгийн үйлдвэрлэл болон өөрчлөгдөж, нийт орлогод эзлэх хувь жил дараалан өсч байна.
- "Эрдэнэт лед" гэрлийн үйлдвэрт үйлдвэрлэж буй гэрэл, гэрэлтүүлгийн бүтээгдэхүүнийг айл өрх, албан байгууллагын ахуйн зориулалттай гэрэл, гудамж талбайн зориулалттай гэрэл хэмээн ангилж болох бөгөөд гудамж

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА301070 4385772

Бумбат Алтай
2067103
ПҮОН0230

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

талбайн гэрэлтүүлэгтэй уялдан цахилгаан тоног төхөөрөмжийн угсралт, засвар үйлчилгээний ажил хийгдэж байна.

- Орхон аймаг нь үйлдвэрийн бүс нутаг учраас уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр, Дулааны цахилгаан станц зэрэг томоохон хэрэглэгчдээс үйлдвэрийн автоматжуулалтын ажлын захиалга аван гүйцэтгэж байна.
- Өнгөрсөн оноос бүтээгдэхүүнээ экспортод гаргах зорилгоор ОХУ-ын Эрхүү мужийн зарим байгууллагатай хамтран гадаад худалдааны гэрээ, хэлэлцээрийг эхлүүлээд байна.

Цаашид LED гэрлийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах, бизнесээ өргөжүүлэх зорилгоор үйлдвэрийн шинэ барилга барих, тоног төхөөрөмжөө боловсронгуй болгох, шинэ шугам нэмэх зорилго тавин ажиллаж байна.

1.3. Стратеги

Манай компани Монгол инженерүүдийн мэдлэг оюуныг орчин үеийн өндөр технологитой хослуулан, олон улсын стандартад нийцсэн чанартай брэнд бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх замаар 2018-2021 онд дотоодын гэрлийн зах зээлийн 5 хувийг хангах зорилт дэвшүүлж байна.

Энэхүү зорилгоо хэрэгжүүлэхийн тулд үйлдвэрлэлийн шугамыг нэмэгдүүлэх, маркетинг сургалчилгааны ажлыг өргөжүүлэх, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах стратегийг баримтална.

1.4. Зах зээлийн багтаамж, давуу тал

Дэлхийн болон Монгол Улсын гэрлэн бүтээгдэхүүний зах зээлийн багтаамж, ирээдүйн хөгжлийн чиг хандлага, Компанийн туршлага, байршил, хүний нөөц зэрэг үзүүлэлтүүдээс шалтгаалан бидэнд дараах давуу талууд бүрдээд байна.

- Дотоодын зах зээлд жилд ойролцоогоор 3.0 сая ширхэг гэрэл, гэрлэн бүтээгдэхүүн ашиглагдаж байгаагаас 0.5 хувь буюу 15.0 мянган ширхэг гэрлийг Анд-Энерги ХХК үйлдвэрлэн нийлүүлж, 99.5 хувийг импортын бүтээгдэхүүн эзэлж байна.
- Зах зээлийн багтаамж өндөр, дотоодын өрсөлдөөн сул байгаа нь Компанийн бизнесийн амжилт бидний үйл ажиллагаанаас шууд хамаарах магадлал нэн өндөр байгааг илэрхийлж байна.
- Өндөр мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлснээр гадаадаас өндөр үнээр худалдан авдаг импортын бүтээгдэхүүн буюу LED гэрлийн зарим эд ангийг дотооддоо харьцангуй хямд үнээр үйлдвэрлэж, зардлыг бууруулж байна.
- LED гэрлийн үйлдвэрлэлийн гол түүхий эдийн нэг болох зэс утсыг дотоодын Эрдмин үйлдвэрээс худалдан авснаар зардал хэмнэгдэж, бүтээгдэхүүний өртгийг бууруулах боломж бүрдэж байна.
- LED гэрлийг дотооддоо үйлдвэрлэснээр гадаадын ижил төрлийн бүтээгдэхүүний импортын татвар, тээврийн зардлыг хэмнэн бүтээгдэхүүний өртгийг хямдруулах боломж бүрдэж байна.
- Орон нутагт үйл ажиллагаа эрхэлснээр орон нутгийн цалингийн сүлжээтэй уялдсан харьцангуй хямд ажиллах хүчнийг татах боломж бүрдэж байна.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
АНД-ЭНЕРГИ ХХК
КА:101070 4385772
Бумбат Алтан
2087103
ПЮН0230

- Үйлдвэрлэлийн бүс нутагт үйл ажиллагаа эрхэлснээр үйлдвэрлэлийн зориулалттай бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх боломж бүрдэж байна.
- Эрчим хүчний хэмнэлттэй гэрлийн шилний үйлдвэрлэл болон борлуулалт орлогын албан татвараас чөлөөлөгдөж байгаа нь Компанийн ашгийг нэмэгдүүлэх чухал хүчин зүйл болж байна.

1.5. Хөрөнгө оруулалт

Бид үнэт цаасны зах зээл дээр хувьцаагаа олон нийтэд санал болгох замаар нийт 1,592.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт татахаар төлөвлөсөн бөгөөд энэхүү эх үүсвэрийг дараах байдлаар зарцуулна. Үүнд:

- Үйлдвэрийн барилга барихад 775.0 сая төгрөг,
- Үйлдвэрийн тоног төхөөрөмж, шугам нэмэхэд 507.0 сая төгрөг,
- Эргэлтийн хөрөнгийн нөөц бүрдүүлэхэд 215.0 сая төгрөг,
- Үнэт цаасыг олон нийтэд санал болгох үйл ажиллагааны зардалд 95.6 сая төгрөгийг тус тус зарцуулна.

1.6. Санхүүгийн үзүүлэлтүүд

Компанийн 2016 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр 528.2 сая төгрөгийн хөрөнгө, 188.8 сая төгрөгийн өр төлбөр, 339.3 сая төгрөгийн өөрийн хөрөнгөтэй. Тайлант онд 682.4 сая төгрөгийн борлуулалт хийж, 639.4 сая төгрөгийн зардал гарган, 43.0 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Үнэт цаасыг нийтэд санал болгон 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татсанаар жилд үйлдвэрлэх бүтээгдэхүүний тоо хэмжээг 150.0 мянган нэгжид хүргэнэ.

Төсөвлөсөн санхүүгийн үзүүлэлтээр Компанийн борлуулалтын орлогын хэмжээ ирэх 5 жилийн эцэст 2016 оны гүйцэтгэлтэй харьцуулахад ойролцоогоор 5 дахин өсөх хандлагатай байгаагаас гадна үйлдвэрлэх бүтээгдэхүүний тоо хэмжээ нэмэгдэх тусам нэгж бүтээгдэхүүний өртөг буурч, ахиуц ашгийн харьцаа буюу нийт ашгийн борлуулалтанд эзлэх хувь хэмжээ 60 хувьд хүрч өсөхөөр тооцоолж байна.

Хүснэгт 1. Төсөвлөсөн санхүүгийн мэдээллийн хураангуй

	Төсөвлөсөн дүн /сая төгрөгөөр/				
	2017	2018	2019	2020	2021
Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүд					
Нийт хөрөнгө	1,935.46	2,329.50	2,865.55	3,542.39	4,410.02
Үүнээс: Эргэлтийн хөрөнгө	494.45	914.64	1,551.03	2,335.58	3,310.91
Нийт өр төлбөр	133.43	23.75	18.34	21.80	25.94
Орлогын дэлгэрэнгүй тайлангийн үзүүлэлтүүд					
Борлуулалтын орлого	1,036.21	2,358.11	2,547.65	3,007.40	3,608.87
Борлуулалтын өртөг	510.60	1,063.65	1,126.22	1,324.96	1,589.96
Татварын дараах ашиг	(9.39)	503.73	541.46	673.38	863.48

Ирэх 5 жилийн хугацаанд Компанийн борлуулалтын орлого 1 тэрбум төгрөгөөс 3.6 тэрбум төгрөг, татварын дараах цэвэр ашиг 500.0 сая төгрөгөөс 860.0 сая төгрөг болж тус тус өсөх бөгөөд ахиуц ашгийн түвшин 5 жилийн дундаж нь 20.5 хувь байна.

Нэгж хувьцааны үнэ ба ашгийн харьцаа (P/E) харьцаа 5.97, хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж 19.44 хувь, төслийн дотоод өгөөж 21.12 хувь, цэвэр өнөөгийн үнэ цэнэ 35.0 сая төгрөг, хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх хугацаа 4.9 жил байна.

1.7. Ногдол ашгийн бодлого

Компани тогтмол өсөлттэй ногдол ашгийн бодлогыг баримтална. ТУЗ-ийн 2017 оны 04 сарын 03-ны өдрийн 03 тоот тогтоолоор батлагдсан "Ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах журам"-д заасны дагуу Компани жил бүрийн цэвэр ашгийн 5-8 хувийг ногдол ашигт хуваарилах бөгөөд ногдол ашигт хуваарилах цэвэр ашгийн хувь хэмжээг жил бүр тогмол нэмэгдүүлэх бодлого баримтална.

1.8. Эрсдэл

Компанид дараах эрсдэлүүд тохиолдож болно. Үүнд:

- Бизнес, үйлдвэрлэлтэй холбоотой эрсдэлүүд
  - Зах зээлийн багтаамжийг тооцоолохтой холбоотой эрсдэл
  - Үнийн эрсдэл
  - Түүхий эдийн үнийн эрсдэл
  - Түүхий эдийн худалдан авалттай холбоотой эрсдэл
  - Түүхий эд импортолж буй орны валютын ханшийн өсөлтийн эрсдэл
  - Түүхий эдийн чанартай холбоотой эрсдэл
  - Өрсөлдөгч бий болох, технологитой холбоотой эрсдэл
  - Хүний нөөцтэй холбоотой эрсдэл
- Хууль эрх зүйн орчны эрсдэлүүд
  - Татвар
  - Эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалах эрсдэл
- Үнэт цаас гаргахтай холбоотой эрсдэлүүд
  - Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн дэд бүтэцтэй холбоотой эрсдэл
  - Үнэт цаасны үнэлгээнд гарч болох эрсдэл.

Дээрх эрсдэл, эрсдэлд нөлөөлөх хүчин зүйл, эрсдэлийн удирдлагын чиглэлээр Компаниас авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний талаар "ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛ" бүлгээс дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 11

ХОЁР. ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛ, УДИРДЛАГА

2.1. Бизнес, үйлдвэрлэлтэй холбоотой эрсдэл

Зах зээлийн багтаамжийг тооцоолохтой холбоотой эрсдэл

Энэхүү танилцуулгад ашигласан зах зээл тодорхойлох судалгаагаар LED гэрлийн зах зээлийн багтаамжийг бүрэн гүйцэд, үнэн зөв тооцох боломжгүй, судалгааны үр дүн бодит байдлаас зөрүүтэй байх эрсдэлтэй. Учир нь өнөөдрийг хүртэл гааль, бүртгэл, статистикийн асуудал хариуцсан төрийн байгууллагууд болон бусад судалгааны байгууллагуудын дотоодын гэрлэн бүтээгдэхүүний зах зээлийн хэмжээг тодорхойлсон албан ёсны судалгаа хийгдээгүй байна. Иймд зах зээлийн багтаамжийг тодорхойлохдоо Монгол Улсын айл өрх, албан байгууллагын тоо хэмжээг тодорхойлсон статистик мэдээлэл, тэдний жилд ашиглах боломжит гэрлэн бүтээгдэхүүний тоо хэмжээг бүтээгдэхүүний насжилттай уялдуулан ерөнхий тооцоог гаргасан болно. Хэрэглэгчийн тоо, бүтээгдэхүүний насжилт дээр тулгуурлан хийсэн бидний тооцоолол бодит байдалтай нийцэх эсэх талаар ямар нэгэн дүгнэлт урьдчилан гаргах боломжгүй юм. Энэ нь бодит байдалтай зөрөх магадлалтай тул эрсдэлийг хамгийн бага төвшинд барих зорилгоор судалгааны үр дүнд гарсан Монгол Улсын гэрлэн бүтээгдэхүүний хэрэглээний үзүүлэлтүүдээс хамгийн бага үзүүлэлтийг ашиглан зах зээлийн багтаамжийг тодорхойллоо. Бидний тооцооллын үр дүн бодит байдлаас давсан бол төслийн борлуулалтын орлого тэр зөрүүнд харгалзах хэмжээгээр буурах эрсдэлтэй юм. Энэхүү эрсдэлийг тооцоолохын тулд зах зээлийн судалгаа хэсгийг нягтлан үзэх шаардлагатайг анхаарна уу. Хэрэв бидний тооцооллын үр дүн бодит байдлаас бага дүнтэй гарсан бол төслийн борлуулалтын орлого тэр зөрүүнд харгалзах хэмжээгээр өсөх боломжтой юм.

Хүснэгт 2. Зах зээлийн багтаамжийг бодит байдлаас давуулан тооцсон тохиолдолд үүсэх эрсдэл

Тооцоолсон зах зээлийн багтаамж бодит байдлаас илүү байх хувь	Борлуулалтын орлогын буурах хэмжээ (сая төгрөг)	Татварын дараах цэвэр ашгийн буурах хэмжээ (сая төгрөг)	Төслийн NPV-ийн буурах хэмжээ (сая төгрөг)
5	516.29	222.41	(224.24)
10	1,032.58	444.81	(483.50)
20	2,065.15	889.63	(1,002.04)

Үнийн эрсдэл

Гэрэл, гэрлэн бүтээгдэхүүн нь нэг хэрэглэгч жилд цөөн тоогоор худалдан авдаг, тухайн гэрлэн бүтээгдэхүүний чанарыг энгийн нөхцөлд тодорхойлох боломжгүй тул өрсөлдөгчийн зах зээлд нийлүүлэх ижил төрлийн боловч чанар муутай, хямд бүтээгдэхүүнээс шалтгаалан бидний тооцоолсон борлуулалтын орлого буурах эрсдэлтэй.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА/001070 4385772

БҮРТГЭЛИЙН БАРИМТ БИЧИГ
2087103 ПҮОН0230

Бидний үйлдвэрлэж буй LED гэрэл нь БНХАУ-ын импортын гэрлээс 55 хувиар өндөр үнэтэй, БНСУ-ын GP брэндийн гэрэл (чанарын хувьд гол өрсөлдөгч)-ээс дунджаар 32 хувиар хямд байна. Энэ нь импортын гэрлийг гаалиар хууль бусаар оруулж ирэх, чанарын шаардлага хангахгүй байгаатай холбоотой юм. Өрсөлдөгчийн үнэ буурах эрсдэл нь гаалийн хяналтыг сайжруулах, чанар стандартыг мөрдүүлж ажиллах буюу төрийн байгууллагын үйл ажиллагааны чанараас шууд хамаарах юм. Гаалийн хяналт шалгалт, мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд чанарын өөрчлөлт гараагүй тохиолдолд энэхүү эрсдэл хэвээр үргэлжлэх юм.

Нөгөө талаас бидний үйлдвэрлэсэн LED гэрлийн үнэ тооцоолсноос өндөр байх шаардлага гарах эрсдэлтэй. Энэ эрсдэл нь бүтээгдэхүүний өртгийг бодит гүйцэтгэлээс багаар тооцсон тохиолдолд үүснэ.

Дээр дурдсан болзошгүй эрсдэлээс урьдчилан хамгаалах, борлуулалтаа нэмэгдүүлэх зорилгоор бид жилийн борлуулалт, маркетингийн зардалд 145-360 сая төгрөгийг ирэх 5 жилд тогтмол өсөх байдлаар төсөвлөж байна.

Түүхий эдийн үнийн эрсдэл

LED гэрлийн нэгж бүтээгдэхүүний өртгийн 83 хувийг түүхий эдийн зардал эзэлж байна. Түүхий эдийн үнэ сүүлийн 3 жилийн хугацаанд төгрөгийн ханшийн сулралтай дүйцэх хувиар өсч ирсэн бөгөөд бидний тооцоолсноос илүү үнэтэй болсон тохиолдолд Компанийн ашгийн хувь хэмжээ буурах эрсдэлтэй.

Хүснэгт 3. Түүхий эдийн үнийн өсөлтөд харгалзах цэвэр ашгийн бууралтын харьцуулалт

Түүхий эдийн үнэ бидний тооцоолсноос илүү байх хувь	Цэвэр ашгийн буурах хэмжээ (сая төгрөг)
5	211.85
10	423.70
20	847.40
50	2,118.49

Түүхий эдийн худалдан авалттай холбоотой эрсдэл

Үйлдвэрлэл жигд тасралтгүй явагдах нөхцөлийг бүрдүүлэхэд түүхий эдийн тогтвортой нийлүүлэлт чухал үүрэгтэй. Манай үйлдвэрлэлд шаардлагатай түүхий эдийн худалдан авалт олон улсын тээвэр, хилийн боомтын үйл ажиллагааны доголдлоос шалтгаалан төлөвлөсөн хугацаанаас хоцрох эрсдэлтэй юм. Тиймээс Компани жил бүр нийт үйлдвэрлэлийн 20 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний түүхий эд нөөцөлж байхаар төсөвлөөд байна.

Түүхий эд импортолж буй орны валютын ханшийн өсөлтийн эрсдэл

Нэгж бүтээгдэхүүний өртгийн 83 хувьтай тэнцэх үнийн дүн бүхий хэсгийг БНХАУ-аас импортолж байна. Тиймээс юанийн төгрөгтэй харьцах ханш бидний тооцоолсноос илүү өсвөл Компанийн цэвэр ашиг тэр хэмжээгээр буурах эрсдэлтэй.

Валютын ханшийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор бид төгрөгийн эх үүсвэрийн зарим хэсгийг валютын данс нээлгэн байршуулахаар төлөвлөж байна.

Мөнгөн хөрөнгийн хэдэн хувийг ямар төрлийн валютаар хадгалах тухай асуудлыг төлөвлөсөн хугацааны туршид тухай бүр тогтоох болно.

Хүснэгт 4. Валютын ханшийн эрсдэл

Төгрөгийн ханш бидний тооцоолсноос илүү сулрах хувь	Цэвэр ашгийн буурах хэмжээ (сая төгрөг)
5	217.94
10	435.87
20	871.74

Түүхий эдийн чанартай холбоотой эрсдэл

Өнгөрсөн хугацаанд түүхий эдийг шууд нийлүүлэгчээс бус дамжуулан зуучлагчаас худалдан авч ирсэн бөгөөд худалдан авсан түүхий эдийн 1-3 хүртэл хувь нь үйлдвэрлэлийн болон тээвэрлэлтийн явцад бий болсон чанарын доголдолтой гарч байсан. Энэ нь нэгж бүтээгдэхүүний өртгийг шууд бусаар 0.83-2.49 хувиар өсгөхөд хүрч байна. Цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлж, түүхий эд худалдан авах тогтвортой гэрээ байгуулж ажилласнаар түүхий эдийн хорогдлыг бага байлгаж, өртөг хэмнэх боломжтой бөгөөд тогтвортой нийлүүлэлтийн гэрээ байгуулж ажиллахаар төлөвлөж байна.

Өрсөлдөгч бий болох, технологитой холбоотой эрсдэл

LED гэрэл үйлдвэрлэх технологи нь дэлхий нийтэд танигдсан нээлттэй технологи юм. Өөрөөр хэлбэл дотоодын зах зээлд шинэ үйлдвэрлэгч гарч ирэхэд технологийн талаас ямар нэг оюуны өмч, нууцлал байхгүй. Энэ нь зах зээлд шинэ өрсөлдөгч гарч ирэх эрсдэлийг дагуулж байна. Гэсэн хэдий ч манай компани нь LED гэрлийн зах зээлд анхдагч, туршлагатай компани тул бидэнд олон давуу тал бий. Нөгөө талаас LED гэрлийн технологийн дараагийн үеийн шинэ технологи өнөөдрийн байдлаар гараагүй байна.

Хүний нөөцийн эрсдэл

Бүтээгдэхүүн үйлдвэрлэх явцад ажилчдын болгоомжгүй, туршлагагүй байдлаас шалтгаалан 5 хувийн гологдол бүтээгдэхүүн гарч байсан тохиолдол бий. Энэ нь Компанийн зардлыг өсгөж, ашгийг бууруулдаг. Тиймээс компани цаашид чадварлаг хүний нөөц бүрдүүлэх бодлого хэрэгжүүлж ажиллахаас гадна ажилчдыг чадавхжуулах, бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр тогтмол сургалтанд хамруулна.

2.2. Хууль эрх зүйн тогтворгүй байдлын эрсдэл

Татварын хууль тогтоомжийн өөрчлөлт

Улс төр, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан татварын тогтолцоонд өөрчлөлт орвол бидний тооцоолсон цэвэр ашгийн хэмжээ буурах эрсдэлтэй.

Компанийн үндсэн үйл ажиллагаа болох үйлдвэрлэлээс олж буй орлого нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу татвараас чөлөөлөгддөг тул Компани одоогоор

зөвхөн ажил үйлчилгээний орлогодоо татвар ногдуулан төлж байна. Цаашид төр засгийн бодлого, шийдвэрээр татварын хууль, түүнд нийцүүлэн гаргасан Засгийн газрын тогтоол шийдвэрт өөрчлөлт орж, татварын чөлөөлөлтийг хүчингүй болговол Компанийн цэвэр ашигт дараах байдлаар нөлөөлнө.

Хүснэгт 5. Татварын өөрчлөлттэй холбоотойгоор цэвэр ашиг буурах хэмжээ

ААНОАТ-ын өөрчлөлт		Цэвэр ашгийн буурах хэмжээ (сая төгрөг)
Татварын хувь хэмжээ	10 хувь	8.93
	20 хувь	17.86
Хуулийн 18.1.8 хүчингүй болох		176.9

Түүнчлэн Монгол Улсын Засгийн Газрын шийдвэр гарч, ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т тусгагдсаны дагуу Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийг нэмэгдүүлэх тохиолдолд байгууллагын төлөх ЭМНДШ-ийн зардал нэмэгдэж, 5 жилийн төсөвлөсөн цэвэр ашгийн хэмжээ 30 орчим сая төгрөгөөр буурах эрсдэлтэй.

Мөн НӨАТ-ын хувь хэмжээ нэмэгдэх нь бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлэх, улмаар борлуулалтын тоо хэмжээ буурч, цэвэр ашгийг бууруулах эрсдэлтэй.

Эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалах эрсдэл

LED гэрэл нь хүний анхдагч хэрэгцээний бүтээгдэхүүн биш юм. Энэ төрлийн бүтээгдэхүүний онцлог нь хэрэглэгчийн орлого нэмэгдэхэд хэрэглэгч илүү чанартай, дэвшилтэт технологийн бүтээгдэхүүнийг сонгох хандлагатай, эсрэг тохиолдолд хямд үнэтэйг сонгох хандлагатай байдаг. Тиймээс эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдал бидний сонгосон таамаглалаас муу үр дүн үзүүлбэл борлуулалтын орлого буурах эрсдэлтэй. Энэ төрлийн эрсдэлийг олон улсын болон дотоодын мэргэжлийн байгууллагуудын гаргасан Монгол Улсын эдийн засгийн, банк санхүүгийн үндсэн үзүүлэлтүүдийн албан ёсны таамаглалтай танилцаж тооцоолох нь зүйтэй.

2.3. Үнэт цаас санал болгохтой холбоотой эрсдэл

Монголын үнэт цаасны биржийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэл

Монголын үнэт цаасны биржийн үйл ажиллагаа цаашид хэрхэх нь хөрөнгийн зах зээлд томоохон хүлээлт үүсгэж байгаа бөгөөд Компанийн хувьцаа Монголын үнэт цаасны биржийн анхны арилжаар нээж байгаа нь хувьцааны арилжаар урьдчилан таамаглах боломжийг багасгаж байна. Хэдийгээр бэлтгэл ажлыг урт хугацаанд чанартай гүйцэтгэсэн боловч Монголын үнэт цаасны биржид хандах хөрөнгө оруулагчдын хандлага манай хувьцааны үнэлгээнд нөлөөлөх эрсдэлтэй.

Үнэт цаасны үнэлгээ

Тухайн үеийн эдийн засаг, санхүүгийн салбарын нөхцөл байдал, хөрөнгө оруулагчдын Компанид итгэх итгэл зэргээс шалтгаалан хувьцааны зах зээлийн үнэ

бидний санал болгож буй үнээс доогуур байх эрсдэлтэй. Энэ нь төсөвлөсөн хөрөнгө оруулалтыг бүрэн босгож чадахгүйд хүрэх, улмаар төлөвлөсөн ажлууд хойшлогдох эрсдэл үүсгэж болзошгүй юм.

Дээрх эрсдэлийг Бумбат-Алтай ҮЦК, Монсек ҮЦК, Дэлгэрхангай секюритиз ҮЦК, Батс инвест ҮЦК, Булган брокер ҮЦК зэрэг Монголын үнэт цаасны биржийн гишүүд хуваан хариуцаж байгаа тул хөрөнгө оруулагчдад үзүүлэх нөлөөллийг хамгийн бага байлгахаар зохицуулсан.

ГУРАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

Ноосон нэр:	Анд-Энерги ХХК
Оршин байгаа хаяг:	Орхон аймаг, Баян-Өндөр сум, 21-р баг, Уртын голын 13-2 тоот
Эрхэлж буй үйл ажиллагаа:	LED гэрэл, гэрэлтүүлгийн үйлдвэрлэл, цахилгаан тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, худалдаа, үйлдвэрлэлийн автоматжуулалт
Биржид бүртгэлтэй эсэх:	Үгүй
Улсын бүртгэлийн дугаар:	2011015075
Бүртгэсэн он, сар, өдөр:	2011 оны 05 дугаар сарын 23-ны өдөр
Регистрийн дугаар:	4385772
Холбогдох этгээдийн тухай:	Толгой, охин, хараат, зэргэлдээ компани байхгүй
Албан ёсны вэб хуудас:	www.erdenetled.mn
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга:	Баянмандалын Пүрэвдолгор
Итгэмжлэгдсэн төлөөлөгч:	Баянмандалын Пүрэвдолгор Төмөрбатын Барс
Нийцүүлэгч:	Од бүртгэл аудит ХХК Өмгөөллийн Цогт энд Нандин ХХН
Аудитын хорооны гишүүд:	Төмөрбаатарын Баярсайхан Мөнхжаргалын Ганбат Төмөрбатын Барс
Цалин урамшууллын хорооны гишүүд:	Дагвапунцагийн Алтангэрэл Мөнхжаргалын Ганбат Ганхуягийн Түвшин
Нэр дэвшүүлэх хорооны гишүүд:	Далхаагийн Мөнхбаяр Төмөрбатын Барс Дагвапунцагийн Алтангэрэл
Харилцагч банк:	Худалдаа хөгжлийн банк, ХААН банк
Хувьцаа хадгалуулах байгууллага:	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

СЭХ БҮРТГЭЛ № 01

ОРХОН АНД-ЭНЕРГИ ХХК КА/001070 4385772

22 | АНД-ЭНЕРГИ ХХК

2087103 ПЮН0230

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
БҮРТГЭЛ
№ 1

ДӨРӨВ. САЛБАРЫН ТОЙМ

4.1. Гэрлийн үүсэл, хөгжил

Хүн төрөлхтөн гэрэл, гэрэлтүүлгийн арга хэрэгслийг бий болгох, хөгжүүлэх чиглэлээр тасралтгүй эрэл хайгуул хийсээр өнөөдрийг хүрчээ. 19 дүгээр зуунаас өмнө амьтны гаралтай тосон дэнлүүг гэрэлтүүлэгт ашиглаж байсан бол 1879 онд АНУ-ын эрдэмтэн Tomas Edison улайсах гэрлийг нээснээр гэрэлтүүлгийн салбарт огцом үсрэлт гарсан юм. 20 дугаар зууны дундуур сүүн гэрэл зах зээлд гарснаар улайсах болон сүүн гэрэл гэрэлтүүлгийн зах зээлийг бүрэн хангаж байсан бол 1998 онд анхны цагаан өнгөтэй LED гэрлийг бүтээснээр аюулгүй байдал, хүчин чадал, ашиглалтын хугацаа, бат бөх чанар, үр ашиг зэрэг олон давуу талыг харуулсан LED гэрэл хэрэглээнд шинээр нэвтэрсэн байна.

Хүснэгт 6. Гэрэлтүүлгийн түүхэн хөгжил

Үүсэл	Гэрэлтүүлгийн төрөл	Гол түүхий эд	Ашиглалт	Давуу, сул тал	Хөгжлийн үе
1968 он	 LED гэрэл	Хагас дамжуулагч	Хэлхээ	Байгаль орчинд зэлтэй	5-р үе
1938 он	 Сүүн гэрэл	Мөнгөн ус	Урсах	Гэрэлтэлт сайн	4-р үе
1879 он	 Улайсах гэрэл	Судал	Халууны цацраг	Халдаг	3-р үе
МЭӨ 2-3	 Лаа	Тос	Шатаах байдлаар	Өдрийн цагаар ашиглахгүй	2-р үе
Балар эртний үе	 Гал	Мод	Шатаах байдлаар	Өвөл ашиглахгүй	1-р үе

Эрчим хүчний эх үүсвэрийн хомсдол, дэлхийн дулаарлын асуудал олон улсын хэмжээнд хурцаар тавигдах болсноос гадна дээр дурдсан LED гэрлийн онцлог, давуу талуудтай уялдан эрчим хүчний хэмнэлттэй LED гэрлийн үйлдвэрлэл хурдацтай өсөн нэмэгдэж байна. АНУ-ын эрдэмтэн Herry Josef Round 1907 онд LED гэрлийн санааг анх дэвшүүлж байсан бол Оросын эрдэмтэн Олег Владиморович Лосев 1927

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА/01070 4385772

2087103
ПЮН0230

онд анхны LED (Light emitting diode) хагас дамжуулагч бүхий гэрэлтүүлгийг бүтээсэн боловч үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломж хязгаарлагдмал байжээ. АНУ-ын эрдэмтэн Rubin Braunstein, Nick Holonyak нар LED гэрлийн судалгааг өргөжүүлснээр General electric компани 1962 онд анхны улаан өнгийн гэрэл ялгаруулагч диодыг, Японы Nichia корпораци (эрдэмтэн Shuji Nakamura) 1994 онд хөх, ногоон өнгийн LED гэрлийг, 1998 онд цагаан өнгийн LED гэрлийг бүтээснээ зарласнаар 1998 оноос LED гэрлийг бөөнөөр үйлдвэрлэх, ахуйн болон бусад хэрэглээнд ашиглах боломж нээгдсэн байна.

4.2. Дэлхийн LED гэрлийн зах зээл

Олон улсын зах зээл дээр нефтийн үнэ өсөхийн хирээр нарны эрчим хүч зэрэг ногоон эрчим хүчний үйлдвэрлэл илүү хөгжих болж, бас нэгэн төрөл болох эрчим хүч бага зарцуулах, удаан эдэлгээтэй, тэсвэртэй, овор хэмжээ бага, хариу үйлдэл хурдан үзүүлдэг зэрэг олон давуу талуудтай, хамгийн гол нь халахгүй, туяа гаргадаг гэрэл цацруулагч диод (Light Emitting Diode, товчоор LED) нь эрчим хүч хэмнэх хамгийн үр ашигтай олны анхаарал татсан үйлдвэрлэл болж, 2016 оны байдлаар дэлхийн LED гэрлийн зах зээл 26.9 тэрбум долларт хүрсэн бөгөөд 2022 он гэхэд 54.28 тэрбум долларт хүрэх хандлагатай байна[1].

2016-2020 онуудад LED гэрлийн зах зээлийн жилийн дундаж өсөлт 17.0 хувь, ялангуяа үйлдвэрлэлийн хэрэгслийн зориулалтай LED гэрлийн жилийн дундаж өсөлт 21.7 хувь байхаар тооцогдсон нь LED гэрлийн хэрэглээ цаашид улам бүр өсөн нэмэгдэх хандлагатай байгааг нотолж байна[2].

Technavio байгууллагын шинжээчид LED гэрлийн үйлдвэрлэлийг зориулалтаар нь ахуйн буюу ерөнхий зориулалттай, үйлдвэрлэлийн буюу телевиз, электрон хэрэгслийн доторх эд ангиудад ашиглагдах зориулалттай, автомашины салбарын зориулалттай гэж 3 хуваан ангилсан бөгөөд 2015 оны байдлаар ахуйн буюу ерөнхий зориулалттай LED гэрлийн үйлдвэрлэл хамгийн их буюу 42 хувийг, үлдсэн хэсгийг үйлдвэрлэлийн болон автомашины гэрлийн үйлдвэрлэл эзэлж байна.

Дээрх судалгаанд дурдсанаар эрчим хүчийг хэмнэх, дэлхийн дулаарлыг бууруулахад нөлөөлөх, аюулгүй байдлыг хангах зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэгт LED гэрлийг өргөнөөр ашиглах, иргэдийн LED гэрлийн ашиглалтад урамшуулал хөнгөлөлт үзүүлж буй зарим орны Засгийн газрын бодлого шийдвэрүүд LED гэрлийн үйлдвэрлэлд эерэгээр нөлөөлж байна. Газарзүйн байршил, бүс нутгийн хувьд LED гэрлийн хэрэглээг Америк, Ази номхон далайн бүс, Европын бүсүүдэд хуваан авч үзсэн бөгөөд 2020 оны эцэст Ази номхон далайн бүс нутаг LED гэрлийн хэрэглээгээр тэргүүлэх дүн гарчээ. Энэ нь бүс нутгийн хүн амын өсөлт болон улайсах чийдэн ашиглахыг хориглосон БНХАУ зэрэг орны шийдвэртэй холбоотой юм.

4.3. LED гэрэл үйлдвэрлэгч

LED гэрлийн зах зээлд электроникийн салбарт тэргүүлэгч Sony, Samsung, LG, Philips, General Electric, Sharp корпорациуд бүтээгдэхүүнээ нийлүүлж байгаагаас гадна АНУ-ын Cree, Японы Nichia, Германы Osram, Тайванийн Everligth electronics, БНСУ-ын Seoul semiconductor зэрэг компаниуд хүчтэй өрсөлдөж байна. Дээр дурдсан компаниудаас гадна БНХАУ, БНСУ, Тайвань зэрэг Азийн орнуудад LED гэрлийн эд анги үйлдвэрлэдэг олон тооны жижиг, дунд үйлдвэрүүд ажиллаж байна.


---

[1] Zion Market Research, 2017 оны 4 дүгээр сарын 24, (GLOBE NEWSWIRE)

[2] Technavio, 2017 оны 5 дугаар сар, (Globe LED Market 2016-2020)

LEDinside байгууллага 2014, 2015 онуудын дэлхийн LED гэрлийн үйлдвэрлэлд тэргүүлэгч орнуудын судалгааг 2016 онд гаргасан байна.

График 1. Дэлхийн LED гэрлийн үйлдвэрлэлд улс орны эзлэх хэмжээг харьцуулсан судалгаа




Эх үүсвэр: LEDinside, 2016 он

Дээрх судалгаанаас харахад Азийн тэргүүлэгч 4 орон дэлхийн LED гэрлийн үйлдвэрлэлийн 90 гаруй хувийг эзэлж байна. LED гэрлийн дэлхийн зах зээлд эзлэх БНХАУ-ын хувь хэмжээ 2015 онд 40 хувь, Япон улсын хувь хэмжээ 19 хувь болж өссөн бол Тайвань, БНСУ, АНУ-ын дэлхийн LED гэрлийн үйлдвэрлэлд эзлэх хувь хэмжээ буурсан байна.

LED технологи нь цахилгаан зарцуулалт, гэрэлтэлт, удаан асдаг зэргээрээ бусад гэрэлтэй харьцуулбал урт хугацаанд зардал хэмнэх давуу талтай.

График 2. Улайсах (incandescent), сүүн гэрэл (CFL), LED гэрлүүдийн ашиглалтын зардлын харьцуулсан судалгаа




Эх үүсвэр: LEDinside, 2016 он

LED гэрэл эрчим хүчний ихээхэн хэмнэлтийг бий болгож байгаа учир энгийн уламжлалт дэн хүртэл LED гэрлээр солигдож, явган хүний замын гэрлэн дохио, гар чийдэн, машины жижиг гэрлүүд, камерийн ламп, чимэглэлийн гэрлүүдийг бүгдийг LED


технологиор үйлдвэрлэж байна. Мөн ахуйн хэрэглээний цахилгаан бараа тухайлбал гар утас, notebook, iPOD, электрон тоглоомонд LED гэрэлтүүлгийг өргөнөөр ашиглах болжээ.Strategies Unlimited байгууллагын 2015 онд гаргасан судалгаанд LED гэрлийн зах зээлийг 2014 онд 15.5 тэрбум доллар байсан бол 2019 онд 21.5 тэрбум долларт хүрч жилд дунджаар 7% өсөхөөр тооцоолол гаргасан байна[3].

График 3. LED гэрлийн зах зээл (бүх бүтээгдэхүүн)



Энэхүү судалгаанд дэлхийн LED гэрлийн зах зээлийг гэрэлтүүлэг, автомашин, гар утас, дэлгэц, дохио болон бусад гэж 6 хэсэгт хуваан авч үзжээ.

График 4. LED гэрэлтүүлгийн зах зээл




Дээрх 6 ангиллаас 2014 онд 5.2 тэрбум доллар байсан гэрэлтүүлгийн борлуулалт 2019 онд 9.1 тэрбум доллар болж өссөн нь бусад ангиллын LED бүтээгдэхүүнээсээ хамгийн их өсөлттэй буюу жилд дунджаар 12% өссөн үзүүлэлттэй байна.

[3] *Strategies Unlimited, 2015 он*

ДӨРӨВ САЛБАРЫН ТОЙМ
БҮРТГЭВ
№ 1

График 5. LED-н гэрэлтүүлгийн ангилал



Мөн нийт LED бүтээгдэхүүнийг ахуйн гэрэл, сурталчилгааны, үйлдвэрийн, гадна гэрэл, орон сууцны, архитектурын, зөөврийн, үзвэрийн, гадуурх сүлжээний, жижиглэн худалдааны үзэсгэлэнгийн, аюулгүй байдал, зурвас гэсэн илүү олон төрөл ангилалд хуваан судлахад хамгийн их өсөлтийг ахуйн гэрэл эзэлсэн дүн гарчээ.

4.4. Монголын гэрэл болон LED гэрлийн зах зээл

Монголд LED гэрлийн үйлдвэр байгуулах үндэслэл

Дэлхийн улс орнууд 1998 оноос эхлэн ажлын байр, гудамж талбай, орон сууцны гэрэлтүүлэгт хэрэглэгддэг улайсах чийдэнг эрчим хүчний хэмнэлттэй чийдэнгээр солих бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд өнөөгийн дэвшилтэт технологитой, байгальд ээлтэй, LED гэрлийг ашиглах болсон. Манай улс сүүлийн жилүүдэд LED гэрлийг хэрэглэх болсон хэдий ч LED гэрлийн давуу талыг ойлгон хэрэглэж хэвшээгүйгээс гэрлийн хэрэглээнд ихэвчлэн улайсах гэрлийг ашигласаар байна. LED гэрэл нь бусад бүх төрлийн гэрлээс ашиглалтын хугацаа урт, галын аюулгүй байдал, цахилгаан эрчим хүчний зарцуулалт болон эдийн засгийн хувьд 5-9 дахин хэмнэлттэй байдаг.


Бид Монгол улсад улайсах гэрлийн хэрэглээг багасган, эрчим хүчний хэмнэлт гаргах зорилгоор LED гэрлийг үйлдвэрлэх, хөгжүүлэх, борлуулах зах зээл байна гэж тооцон энэхүү бизнесийг эрхлэсэн. Иймээс Анд-Энерги ХХК нь монгол хүний хүч хөдөлмөр шингэсэн, дэвшилтэд технологитой, байгальд ээлтэй, импорт орлуулах бүтээгдэхүүн болох LED гэрлийн “Эрдэнэт лед” үйлдвэрийг барьж байгуулан ашиглалтанд оруулан ажиллаж байна.

Экологийн тэнцвэрийг хангах, эдийн засгийн хэмнэлттэй, дэвшилтэт технологид суурилагдсан, нийгмийн хөгжилд үнэтэй хувь оруулах байгальд ээлтэй бүтээгдэхүүнийг Монголд үйлдвэрлэж, нэвтрүүлэх нь Анд-Энерги ХХК-ийн гол зорилт юм.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА#01070 4385772

Бумбат Алтай
2087103
ПЮН0230

График 6. Монголын цахилгааны хэрэглээ



Эх үүсвэр: Гаүли ҮЦК-иас гаргасан судалгаа

Дээрх графикаас харахад 2006-2014 он хүртэл Монгол Улсын цахилгааны хэрэглээ жил ирэх бүр өсч байна. Үйлдвэр, барилга, өрх гэр, орон сууц, нийтийн аж ахуйн салбаруудын гэрлийн хэрэглээ өндөр өсөлттэй харагдаж байна. Цахилгаан хэрэглээний өсөлт нь түүнийг дагасан бүтээгдэхүүний зах зээлд эерэг нөлөө үзүүлнэ.


Монгол Улсын LED гэрлийн зах зээлийн хэмжээ

Манай улсад "Эрдэнэт лед" гэрлийн үйлдвэрээс өөр LED гэрэл үйлдвэрлэж буй компани байхгүй. Иймд Монгол Улсын LED гэрлийн зах зээлд импортын гэрэл томоохон байр эзэлнэ. LED гэрэл тогтмол импортолж буй Номин Холдинг, Зиг заг трейд компани байдаг бөгөөд хувь хүмүүс их хэмжээгээр импортлон зах зээлд нийлүүлдэг.

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооны гаргасан "Импортын барааны мэдээлэл"-д LED гэрлийн импорттой холбоотой мэдээлэл хомс байна. Энэ нь LED гэрлийг тодорхойлсон стандарт, түүнтэй холбоотой мэдээлэл дутагдалтай байдагтай холбоотой.

Дээрх "Импортын барааны мэдээлэл"-д гэрэл, чийдэнтэй холбоотой хамгийн боломжтой бараа нь "хэт ягаан туяаны чийдэн" гэсэн мэдээлэл орсон бөгөөд импортоор ирж буй улайсах гэрэл, сүүн гэрэл, LED гэрлийг дээрх бараанд оруулан гаальд мэдүүлдэг гэж үзвэл 2015 онд 2.3 сая ширхэг гэрэл импортлосон байна (График 7). 2010-2015 оны хугацаанд жилд дунджаар 2.5 сая гэрэл импортоор орж иржээ.


График 7. Монгол Улсын 2010-2015 оны импортын гэрлийн мэдээ (ширхэг)



Импортоор ирж буй гэрлийн мэдээ жил бүр харилцан адилгүй байна. 2014 онд хамгийн өндөр 3 сая гэрэл оруулж ирсэн байна.

2015 оны эрчим хүчний хэрэглэгчдийн бүтцийг харахад үйлдвэр, барилга болон өрх, орон сууц, нийтийн аж ахуйн хэрэглэгчид ихэнхи хувийг эзэлж байна. Эдгээр хэрэглэгчдэд чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь тохиромжтой юм.

График 8. Эрчим хүчний хэрэглэгчдийн бүтэц 2015 он



Эх үүсвэр: Гаүли ҮЦК-иас гаргасан судалгаа

Дээрх мэдээллээс үндэслэн Монгол Улсын LED гэрлийн зах зээлийн нийт хэмжээг гол хэрэглэгчдийн хэрэглээнд тулгуурлан боловсруулав. Гол хэрэглэгчдээр дараах бүлгийг тодорхойлов. Үүнд:

- Нийт өрх (Монгол Улсын нийт өрхийн тоо, тэдгээрийн амьдардаг орчин)
- Байгууллага (Улаанбаатар хотын оффиссуудын талбайн хэмжээ, түүний гэрэлтүүлгийн хэмжээ)
- Гудамжны гэрэлтүүлэг (Улаанбаатар, Дархан-Уул аймаг, Орхон аймгуудын гудамжны гэрэлтүүлгийн тоо)

Нийт өрхийн хэрэглээ:

Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгааны мэдээнд Монгол Улсын нийт өрхийн тоо 859,404 өрх байгаагаас хөдөө орон нутагт 482,985 өрх, Улаанбаатар хотод 376,419 өрх амьдардаг байна[4].

Хүснэгт 7. Монгол Улсын 2016 оны өрхийн мэдээ

Мэдээлэл	Өрхийн тоо
Монгол Улсын нийт өрхийн тоо	859,404
Хөдөө орон нутаг дахь өрхийн тоо	482,985
Улаанбаатар дахь нийт өрх	376,419

Дээрх судалгааны мэдээнд Улаанбаатар хотын нийт өрхийн амьдрах нөхцөлийг тусгасан байгааг ашиглан тэдгээрийн LED гэрлийн хэрэглээг тодорхойлов.

[4] *Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, 2017 оны 3 дугаар сар, "Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны 2010-2015 оны танилцуулга"*

Хүснэгт 8. Улаанбаатар хотын 2016 оны өрхийн мэдээ, LED гэрлийн хэрэглээ

Нөхцөл		Өрхийн тоо	Жилийн дундаж хэрэглээ /ширхэгээр/	Жилийн нийт хэрэглээ /ширхэгээр/
Аймгийн төв	Гэр	44,222	1	44,222
	Тохилог сууц	33,674	8	269,390
	Байшин	54,230	4	216,918
	Бусад	3,110	1	3,110
Сумын төв	Гэр	59,262	1	59,262
	Тохилог сууц	10,867	8	86,937
	Байшин	71,868	4	287,473
	Бусад	3,043	1	3,043
Хөдөө	Гэр	175,468	1	175,468
	Тохилог сууц	203	8	1,623
	Байшин	25,762	4	103,050
	Бусад	1,420	1	1,420
НИЙТ				1,251,916

Мөн судалгаанд тусгасан хөдөө орон нутгийн өрхүүдийн амьдрах нөхцөлийн мэдээнд үндэслэн тэдгээрийн LED гэрлийн хэрэглээг гаргав.

Хүснэгт 9. Хөдөө орон нутгийн 2016 оны өрхийн мэдээ, LED гэрлийн хэрэглээ

Нөхцөл		Өрхийн тоо	Жилийн дундаж хэрэглээ /ширхэгээр/	Жилийн нийт хэрэглээ /ширхэгээр/
Орон сууцны хороолол	нийтийн орон сууц	157,242	8	1,257,939
	тохилог орон сууц	1,289	16	20,621
Гэр хороолол	тохилог орон сууц	1,825	16	29,208
	байшин	116,048	4	464,192
	Гэр	99,712	1	99,712
НИЙТ				1,871,672

Дээрх мэдээллийг нэгтгэн Улаанбаатарт 1,871,672 ширхэг, орон нутагт 1,251,916 ширхэг буюу нийтдээ өрхийн хэрэглээнд 1 жилд 1,871,672 +1,251,916 = 3,123,588 ширхэг LED гэрэл ашиглах тооцоолол гарав (1 ширхэг LED гэрлийн ашиглалтын хугацааг 1 жилээр тооцов).

Байгууллагын хэрэглээ:

Байгууллагын ашиглах гэрлийн хэрэглээг гаргахдаа Улаанбаатар хотын хэмжээнд оффисын барилгын тоо хэмжээг гаргаж, тэдгээрт ашиглах боломжтой LED гэрлийн хэмжээг тооцоолов.

Улаанбаатар хотод 2014 оны эхний хагас жилийн байдлаар 333,482 м^2 талбайг оффисын цэвэр талбайгаар ашиглаж байв[5]. 2016 оны байдлаар 212 арилжааны үл хөдлөх хөрөнгө "Оффисын зах зээлийн судалгаа"-нд хамрагдсанаас 90.1% нь одоо үйл ажиллагаа явуулж байгаа, үлдсэн 9.9% нь одоогоор ашиглалтанд ороогүй оффисын

[5] *UMC Alpha судалгааны газар, 2014 оны 6 дугаар сар, "Оффисын зах зээлийн судалгаа"*

төсөл байв[6]. Дээрх үл хөдлөх хөрөнгийн талбайн хэмжээ ойролцоогоор 516,000 м² талбайтай. Энэ нь зөвхөн Улаанбаатар хотын оффисын талбайн хэмжээ юм.

Оффист хэрэглэдэг энгийн 1 ширхэг LED гэрэл 4м² талбайг гэрэлтүүлнэ гэж үзвэл ойролцоогоор Улаанбаатар хотын оффист 129,000 ширхэг LED гэрлийн хэрэглээ байна (Бид оффисын гэрлийн хэрэглээг гаргахдаа орон нутгийн оффисын зах зээлийн мэдээлэл хомс байгаагаас шалтгаалан зөвхөн Улаанбаатар хотын хэмжээнд гаргасан болно).

Гудамжны гэрэлтүүлэг:

Гудамжны гэрэлтүүлгийн хэмжээг гаргахдаа Монгол Улсын хүн амын ихэнх хэсэг төвлөрсөн Улаанбаатар хот, Дархан-Уул аймаг, Орхон аймгуудын гудамжны гэрлийн тоог үндэслэн гаргав[7].

Улаанбаатар хот:	40,000 ширхэг
Дархан-Уул аймаг:	9,000 ширхэг
Орхон аймаг:	8,000 ширхэг
Гудамжны гэрэл ойролцоогоор	57,000 ширхэг гэрлийн хэрэглээтэй.

ДҮГНЭЛТ:

Эрчим хүчний хэмнэлт, аюулгүй байдал, бөх бат чанар, насжилт зэрэг олон давуу талаасаа шалтгаалан LED технологийн хэрэглээ дэлхий даяар эрчимтэй өсөн нэмэгдэж, ахуйн зориулалттай гэрэл, чийдэнгээс гадна телевизор, гар утас, автомашин, компьютер зэрэг орчин үеийн өндөр технологийн бүтээгдэхүүнд өргөн ашиглагдаж байна.

Манай улсын хувьд LED технологи бүхий телевизор, компьютер, гар утас зэрэг бүтээгдэхүүний хэрэглээ нэвтрээд багагүй хугацаа өнгөрсөн бөгөөд айл өрх, албан байгууллагууд сүүлийн жилүүдэд ахуйн зориулалттай LED гэрлийг өргөнөөр ашиглах боллоо. Статистикийн мэдээгээр жилд дунджаар 2.5-3.0 сая ширхэг гэрэл импортолдог боловч хэрэглэгчийн тоо, тэдний бодит хэрэгцээнд үндэслэн гаргасан судалгаа нь Монгол Улс жилд 3.3 сая ширхэг хүртэл ахуйн зориулалттай LED гэрэл ашиглах боломжтойг харуулж байна. Импортын мэдээнд дурдагдсан гэрлийн тоонд улайсах, сүүн, LED гэрлүүд бүгд багтсан учраас хүн ам өсөн нэмэгдэх, LED гэрлийн ач холбогдол, давуу талыг хэрэглэгчид таньж мэдэхийн хэрээр зах зээлийн багтаамж нэмэгдэх юм. Technavio судалгааны институт LED гэрлийн дэлхийн зах зээл 2020 он хүртэл жилд дунджаар 17.0 хувийн өсөлттэй байх таамаглалыг гаргасан бөгөөд энэ хэмжээгээр Монгол Улсын LED гэрлийн зах зээл өснө гэж тооцвол 2020 онд манай улсын жилийн хэрэглээ 5 саяд хүрэх боломж харагдаж байна.

Монгол Улсын гэрлийн хэрэглээнд улайсах гэрлийг хязгаарлаж, LED гэрлийг өргөн хэрэглэснээр микро орчинд хэрэглэгчдэд удаан хэрэглэх, зардал бага зарцуулах ач холбогдолтой бол макро орчны хувьд байгаль орчинд эзлэгдэх, эрчим хүчний хэмнэлттэй зэрэг таатай үр дүн харагдаж байна.

[6] *www.barilga.mn, 2016 он, "Барилга, үл хөдлөх хөрөнгийн судалгаа 2016" тайлан*

[7] *Гаули ҮЦК-ийн гаргасан судалгаа*

ТАВ. КОМПАНИЙН ТҮҮХ, ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАЛТ, БҮТЭЦ

5.1. Компанийн тухай

Манай компани 2011 онд 4 хүний бүрэлдэхүүнтэй, цахилгааны угсралт, суурилуулалт, автоматжуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар байгуулагдсан.

Компанийн эрхэм зорилго нь Монгол хүний мэдлэг шингэсэн, чанартай, олон нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, олон улсад өрсөлдөхүйц бие даасан томоохон корпораци болоход оршино.

Компани байгуулагдсаны дараах жилүүдэд буюу 2011-2014 онд цахилгааны угсралт, суурилуулалт, автоматжуулалтын чиглэлээр захиалгат ажлыг гүйцэтгэхийн зэрэгцээ LED гэрлийн үйлдвэрлэлийн судалгааны ажлыг амжилттай хэрэгжүүлсний үр дүнд 2014 оны 9 дүгээр сард "Эрдэнэт лед" гэрлийн үйлдвэрээ ашиглалтад оруулснаар Компанийн үндсэн бизнес нь LED гэрлийн үйлдвэрлэл болон өөрчлөгдөж, одоогоор олон улсын стандартад нийцсэн, өндөр чанартай 32 нэр төрлийн LED гэрэл үйлдвэрлэхийн зэрэгцээ цахилгааны угсралт, суурилуулалт, автоматжуулалтын ажлыг гүйцэтгэн, жилийн 680.0 гаруй сая төгрөгийн борлуулалттай, 14 хүний бүрэлдэхүүнтэй, зах зээлд танигдсан, нэр хүнд бүхий компани болон өргөжөөд байна.

Менежментийн багийн зөв бодлого, оновчтой шийдвэр, инженер техникийн ажилтнуудын хөдөлмөр зүтгэлийн үр дүнд өнгөрсөн хугацаанд Компанийн үйлдвэрлэлийн технологид томоохон шинэчлэл өөрчлөлтүүд хийгдсэн.

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн түүхэн хөгжил

2011 он	• Анд-Энерги ХХК-ийг үүсгэн байгуулав.
2014 он	• 9 сард: "Эрдэнэт лед" гэрлийн үйлдвэрийг ашиглалтад оруулав.
	• 9-10 сард: Гоёлын болон энгийн хийцтэй, 3-12 ваттын чадалтай, цагаан ба шар өнгөний тусгалтай, E14, E27 маркийн суурьтай чийдэнгүүд үйлдвэрлэв.
	• 11-12 сард: Суурьтай болон суурьгүй 9, 18 ваттын чадалтай, цагаан ба шар өнгөний тусгалтай T8 хоолой хэлбэрийн гэрлүүдийг үйлдвэрлэв.
2015 он	• 4-5 сард: Малчдад зориулсан суурьтай 5, 12 ваттын чадалтай, цагаан өнгөний тусгалтай T8 хоолой хэлбэрийн гэрлүүд үйлдвэрлэв.
	• 4-5 сард: Суурьтай 36 ваттын чадалтай, цагаан ба шар өнгөний тусгалтай T8 хоолой хэлбэрийн гэрэл үйлдвэрлэв.
	• 4-5 сард: LED гэрлийн корпусыг хөнгөн цагаан хайлш болгон шинэчлэв.
	• 4-5 сард: T8 гэрлийн тэжээлийн блокны тусгаарлагчийг шинэчлэв.

	• 5-6 сард: 50-150 ваттын чадалтай, усны хамгаалалттай гадна талбайн гэрэлтүүлгүүдийг хийв.
	• 6 сард: Авто замын гэрэлтүүлгийн шон, гоёлын гэрэлтүүлгийн шон үйлдвэрлэв.
	• 6-7 сард: 30-200 ваттын чадалтай заалны гэрлүүд (түмпэн гэрэл) үйлдвэрлэв.
	• 6-7 сард: 60x60 см хэмжээтэй, 24-48 ваттын чадалтай, дүүжин таазны панель гэрлүүд үйлдвэрлэв.
	• 6-7 сард: 3, 5 ваттын чадалтай, цагаан ба шар өнгөний тусгалтай гоёлын нүдэн гэрлүүдийг үйлдвэрлэж эхлэв.
	• 10 сард: Малчдад зориулсан суурьтай 10, 12 ваттын чадалтай, цагаан өнгөний тусгалтай T8 хоолой хэлбэрийн гэрлүүдийг үйлдвэрлэж эхлэв.
2016 он	• 6 сард: Шинэ загварын гудамжны гэрэлтүүлэгч толгой үйлдвэрлэж эхлэв.
	• 8 сард: Аялагчдад зориулсан USB залгуур бүхий 3, 5 ваттын чадалтай зөөврийн гэрэл үйлдвэрлэж эхлэв.

Тусгай зөвшөөрөл

Компанийн үйл ажиллагааны онцлогоос хамааран дараах тусгай зөвшөөрлүүдийг эзэмшиж байна. Үүнд:

- Эрчим хүчний яамны 0.4-10.0 кВ хүртэлх цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар угсралт, түүний туршилт, тохируулга, дагалдах үйлчилгээ;
- Барилга хот байгуулалтын яамны Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт.

Хийж гүйцэтгэсэн томоохон ажлууд

Өнгөрсөн хугацаанд бид дараах томоохон ажил үйлчилгээг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

- 32 нэр төрлийн LED гэрлийн үйлдвэрлэл;
- Орхон аймгийн Баян-Өндөр сумын нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн ажил;
- Ачит-Ихт ХХК-ийн өргөх насосны 6кВ-ийн хөдөлгүүр дээр вакум таслуур суурилуулах, автоматжуулах ажил;
- Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн төв гудамжны гэрэлтүүлэг;
- Орхон аймгийн төв гудамжны гэрэлтүүлэг;
- Орхон аймгийн төв гудамжны гоёлын гэрэлтүүлэг;
- Эрдэнэт үйлдвэрийн Ган бөөрөнцөг цехийн иж бүрэн автоматжуулалт.

Хамтран ажилладаг байгууллагууд

Сүүлийн жилүүдэд төрийн болон хувийн хэвшлийн олон байгууллагатай харилцан ашигтай хамтран ажиллаж, үйлдвэрлэл үйлчилгээгээ өргөжүүлсэн бөгөөд зарим томоохон харилцагч байгууллагуудыг танилцуулж байна. Үүнд:

- Архангай аймгийн ЗДТГ
- Архангай аймгийн Өндөр-Улаан сум
- Ачит-Ихт ХХК
- БОЭТ
- Булган аймгийн Бүрэгхангай сум
- Завхан аймгийн Тосонцэнгэл сум
- Зохимж ХХК
- Монхангай групп
- Мобикомын Орхон дахь салбар
- Монголросцветмет ХХК
- Мөнхийн үсэг групп
- МУИС-ийн Орхон аймаг дах салбар
- Орхон аймгийн ЗДТГ
- Орхон аймгийн дунд сургуулиуд
- Петровис ХХК
- Улаанбаатар төмөр зам
- Шинэ эрин дунд сургууль
- Шунхлай ХХК
- Төв аймгийн Заамар сум
- Хаан банкны Орхон аймгийн салбар
- Хөвсгөл аймгийн ЗДТГ
- ХХБ-ны Орхон аймаг дахь салбар
- Эрдэнэт үйлдвэр ХХК
- Эрдэнэтийн ДЦС ТӨХК

Бидний амжилтууд

Импортыг орлох дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн орчин үеийн өндөр технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх зэрэг зорилтуудыг хэрэгжүүлсний үр дүнд манай хамт олон Эрдэнэт LED гэрлийн үйлдвэрээ ашиглалтад оруулснаас хойших богино хугацаанд олон амжилтад хүрснийг бидний хүртсэн шагнал урамшууллын жагсаалтаас харж болно. Үүнд:

- Импортыг орлох бүтээгдэхүүн “Хангайн бүсийн түншлэл Орхон - 2015” үзэсгэлэн худалдааны шилдэг байгууллага;
- Enterprenuer 2015 оны Онцлох шинэ бизнес эрхлэгч;
- Орхон аймгийн ИТХ-ын дээд шагнал, Соёрхол, Цагаан арслан цомын эзэн;
- Орхон аймгийн Засаг даргын шагнал, 2015 оны шилдэг байгууллага;
- Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс – “Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, шилдэг ажил олгогч байгууллага” (2016);
- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, “Ногоон технологи инноваци-2016” үзэсгэлэнгийн “Ногоон бүтээгдэхүүн үйлдвэрлэгч шилдэг байгууллага” (2016);
- “Улаанбаатар түншлэл - 2016” үзэсгэлэнгийн “Орчин үеийн технологитой бүтээгдэхүүн “ өргөмжлөл, цом (2016.09.12);
- “Эрдэнэт түншлэл - 2016” үзэсгэлэнгийн “Дэвшилтэт технологитой бүтээгдэхүүн” өргөмжлөл, цом (2016.10.09);
- Өрсөлдөх чадварыг дэмжин судлах төв ТББ-ын “Цагаан сүлд” одон (2016.11.01);

- Орхон аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын "Ногоон батламж" (2016.11.07);
- Зүүн-хойд Азийн хотуудын дарга нарын форумын "Хотын ногоон шийдлүүд -2016" Ногоон батламж;
- Уртын гол багийн Шилдэг аж ахуй нэгж (2016);
- Эрдэнэт хотын Захирагчийн шагнал (2016).

Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлууд

Манай хамт олон үндсэн үйл ажиллагаагаа явуулахын зэрэгцээ нийгмийн хариуцлагын чиглэлээр тодорхой ажлуудыг санаачлан, холбогдох байгууллагуудтай тогтмол хамтран ажиллаж байна. Нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн зарим ажлуудыг танилцуулбал:

- Уртын гол багийн нийгэмд чиглэсэн үйл ажиллагаануудад байнга идэвхтэй оролцож хамтран ажилладаг, тухайлбал жил бүрийн цагаан сараар уламжлал болгон тус багийн 1 өрхөд тусламж үзүүлдэг.
- БОЭТ-ийн хүүхдийн тасгийн тохижилтод зориулан гэрэлтүүлэг суурилуулсан.
- Орхон аймаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн "Найдвар" төвийн 15 жилийн ойн баярт зориулсан хандивын үйл ажиллагаанд оролцож, гэрэлтүүлгийн асуудлыг бүрэн шийдвэрлэж өгсөн.
- Хөгжмийн зохиолч Нямаагийн Болдын найзад зориулсан хандивын аянд оролцож, CD худалдан авалт хийсэн.
- Орхон аймгийн гар бөмбөгийн "Эрдэнэтийн од" клубын эмэгтэй өсвөрийн баг тамирчдыг дэмжин ажилладаг.
- БОЭТ-ийн Төрөх тасгийн хүлээн авах өрөөний тохижилтын ажилд хандив үзүүлж, гэрлэн бүтээгдэхүүн бэлэглэн, суурилалтыг хариуцан ажилласан.

Бид өдөрт дунджаар 100-150 гэрэл үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд дотоодын 10 гаруй аймагт өөрийн үйлдвэрийн бүтээгдэхүүнээ нийлүүлж байна. Гадаад зах зээлийн судалгааг эхлүүлж одоогоор ОХУ-д бүтээгдэхүүнээ экспортлох ажлыг эхлүүлээд байна.

Цаашид гэрлийн үйлдвэрт E14, E27 төрлийн чийдэн, T8 төрлийн суурьтай, суурьгүй гэрэл, гудамж, заал, хонгилын гэрэл, дэлгэцэн гэрэл, нүдэн гэрлүүдийг үйлдвэрлэхийн зэрэгцээ цахилгаан хэрэгсэл, электрон бараа үйлдвэрлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Бид "МЭДЛЭГ ШИНГЭСЭН БҮТЭЭГДЭХҮҮН, ХӨДӨЛМӨР ШИНГЭСЭН ҮЙЛДВЭРЛЭЛ" уриатайгаар өндөр технологийн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг зорьж, хэрэглэгчиддээ боломжийн үнээр орчин үеийн, өндөр чанартай, монгол хүний хөдөлмөр шингэсэн бүтээгдэхүүнийг санал болгож байна.

5.2. Компанийн хувьцааны эзэмшил, хэлбэр, өөрчлөн байгуулалт

Компанийг 2011 онд Т.Барс, Ц.Гүррагчаа, Д.Баярсайхан, Я.Мягмарсүрэн нар нэг бүр нь 10.0 мянган төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 100 ширхэг энгийн хувьцаатай, нийт 1.0 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгээр байгуулсан бөгөөд үүсгэн байгуулагч тус бүр Компанийн 25.0 хувийг эзэмшсэн юм.

2015 оны 07 дугаар сарын 16-ны өдөр хувьцаа эзэмшигч Д.Баярсайхан өөрийн эзэмшлийн 25 ширхэг хувьцааг иргэн Д.Мөнхбаярт, хувьцаа эзэмшигч Я.Мягмарсүрэн

өөрийн эзэмшлийн 25 ширхэг хувьцааг иргэн Г.Түвшинд "Хувьцаа худалдах худалдан авах гэрээ"-ний дагуу тус тус худалдсан.

Хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит бус хурлын 03 тоот тогтоолоор Компанийн 10,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1 ширхэг энгийн хувьцааг 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1000 ширхэг энгийн хувьцаанд хөрвүүлэн хуваах шийдвэр гаргасан.

Хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит бус хурлын 04 тоот тогтоолоор Компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоог 5,152,670 ширхэг болгон өөрчлөх, нэг бүр нь арван төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5,052,670 ширхэг энгийн хувьцааг гүйлгээнд нэмж гаргах, Компанийн 2016 оны 3 дугаар улирлын санхүүгийн байдлын тайлангийн "эздийн өмчийн бусад хэсэг"-т бүртгэгдсэн 50,526,700 төгрөгийг гүйлгээнд нэмж гаргасан энгийн хувьцааны төлбөрт тооцон санхүүгийн байдлын тайлангийн "хувийн өмч" хэсэгт нэмэгдүүлэн бүртгэх шийдвэрүүдийг гаргасан. Дээрх шийдвэрийг Компанийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусган, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн болно.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит бус хурлын 01 тоот тогтоолоор Компанийн 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1 ширхэг энгийн хувьцааг 1 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 10 ширхэг энгийн хувьцаанд хөрвүүлэн хуваах шийдвэр гаргасан. Мөн уг тогтоолоор Компанийн зарласан хувьцааны тоог нэмэгдүүлэн 100.0 сая ширхэг болгох, 9 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөн удирдах зөвлөлтэй байх шийдвэрүүдийг гаргасан юм.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит бус хурлын 03 тоот тогтоолоор Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дахь заалтыг үндэслэн Анд-Энерги хязгаарлагдмал хариуцлагатай компанийг Анд-Энерги хувьцаат компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчлөх шийдвэр гаргаж, уг тогтоолын 01 дүгээр хавсралтаар Компанийг өөрчлөх төслийг баталсан.

Мөн энэхүү тогтоолоор Компанийн зарласан хувьцаанаас 26,544,058 ширхэг хувьцааг эргэлтэд гарган Биржээр дамжуулан олон нийтэд худалдах шийдвэр гаргасан.

Ийнхүү 2017 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар Компанийн зарласан хувьцааны тоо 100,000,000 ширхэг, гаргасан хувьцааны тоо 78,070,758 ширхэг, үүнээс 51,526,700 ширхэг хувьцааг нэр бүхий 4 хувьцаа эзэмшигч тэнцүү хувь хэмжээгээр буюу тус бүр 16.5 хувийг эзэмшиж, 26,544,058 ширхэг хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 34 хувийг нийтэд санал болгон Биржээр арилжихаар хүлээгдэж байна.

Дээрх шийдвэрийг гаргаснаар бид Монгол Улсын хууль тогтоомж, тухайлбал Компанийн тухай хуульд заасан нээлттэй хувьцаат компанид тавигдах эрх үүргийг хэрэгжүүлэх, Санхүүгийн зохицуулах хорооноос батлагдсан Монголын компанийн засаглалын кодексыг мөрдөх зэргээр Компанийн дотоод үйл ажиллагаа, дүрэм, зохицуулалтад олон өөрчлөлт хийх шаардлага гарсан юм.

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2, Компанийн дүрмийн 11 дүгээр бүлэгт заасны дагуу компани нь төлөөлөн удирдах зөвлөл, төлөөлөн удирдах зөвлөлийн хороод, нарийн бичгийн даргатай байх ёстой тул хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 03 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит бус хурлын 02 тоот тогтоолоор Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан болно.

Төлөөлөн удирдах зөвлөл 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр анхны хуралдаанаа хийж 01 тоот тогтоолоор ТУЗ-ийн даргаар хувьцаа эзэмшигч Т.Барсыг,

ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Б.Пүрэвдолгорыг тус тус томилсон болно. Мөн хурлын 02 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулж, дарга гишүүдийг томилсон.

Компанийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц


Компани анх байгуулагдахдаа 1 алба, 4 мэргэжилтэнтэй ажлаа эхэлж байсан бол үйл ажиллагаагаа өргөжүүлэн нийт 3 алба, 14 орон тоотой ажиллаж байна. Компани 2017 оны 03 дугаар сарын 29-нийг хүртэл дараах зохион байгуулалтын бүтэцтэй байв.

Зураг 1. Компанийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц



ТУЗ-ийн 2017 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн хурлын 02 тоот тогтоолоор Компанийн засаглалын бүтцийг шинэчлэн баталсан болно (Зураг 2).

Зураг 2. Компанийн засаглалын шинэ бүтэц



АНД-ЭНЕРГИ ХХК
БҮРТГЭЛИЙН БАРИМТ БИЧИГ

ЗУРГАА. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

6.1. Бизнесийн тухай

Компанийн бизнесийн үйл ажиллагаа нь гэрлийн үйлдвэрлэл, түүний засвар үйлчилгээг хийх, үйлдвэрлэсэн гэрлийг борлуулах чиглэлд голлон ажилладаг. Компани үүсгэн байгуулагдсанаас хойш гэрэл, гэрэлтүүлгийн суурилуулалт, засвар үйлчилгээний чиглэлийн ажлыг гэрээгээр хийж гүйцэтгэдэг байсан бол 2014 оноос Компанийн үйл ажиллагааг өргөтгөх, бизнесийн цаашдын хөгжих боломж зэргийг судлан LED гэрлийн үйлдвэрлэлийг сонгон ажиллаж байна. LED гэрлийн бизнес нь дэлхийн зах зээлд өсөн нэмэгдэж буй салбар юм. Монгол улсад LED гэрлийг үйлдвэрлэж буй цор ганц компани гэдгээр бидний бизнесийн онцлог, давуу тал илэрхийлэгдэнэ. Энэхүү онцлог, давуу талаа ашиглан одоогийн үйл ажиллагааг өргөжүүлэх зайлшгүй шаардлагатай. Иймд Компанийн цаашдын бизнесийн үйл ажиллагааг LED гэрлийн үйлдвэрлэл, борлуулалтыг нэмэгдүүлэх, хөгжүүлэх, түүнийг дагасан бусад үйлчилгээг нэвтрүүлэх чиглэлээр төлөвлөн ажиллаж байна.

6.1.1. Гэрлийн үйлдвэрлэл

Компани LED гэрлийг Монгол улсад үйлдвэрлэх, зах зээлд нийлүүлэх, хөгжүүлэх зорилгоор 2014 оны 9 дүгээр сард "Эрдэнэт лед" гэрлийн үйлдвэрийг Орхон аймагт ашиглалтанд оруулсан. Одоо ашиглагдаж буй үйлдвэрийн шугам хоногт 100-150 ширхэг LED гэрэл үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд 2016 онд 32 нэр төрлийн 15,044 ширхэг LED гэрэл үйлдвэрлэсэн байна (Хүснэгт 10).

Хүснэгт 10. Үйлдвэрлэсэн гэрлийн нэр төрөл, тоо ширхэг

№	Гэрлийн нэр төрөл, марк	2016 оны үйлдвэрлэл (ш)
1	T8 – 9W, 18W, 36W-н суурьтай, суурьгүй гэрэл	5,694
2	T5 – 18W суурьтай	14
3	12v – 5W, 10W гэрэл	726
4	Аялагч гэрэл	196
5	E27 – 4W, 5W, 7W, 9W, 12W чийдэн	3,577
6	E14 – 3W candle	1,114
7	НГ – 3W, 5W, 3W COB, 5W COB	486
8	Панель гэрэл 48W	234
9	Таазны гэрэл 30W, 160W	91
10	ГГ – 50W, 60W, 80W, 100W, 120W, 150W, 180W гэрэл	888
11	ХГ – 40W, 50W, 60W, 100W, 150W гэрэл	2,024
	НИЙТ	**15,044**

СЭХ
БҮРТГЭВ
№ 01


ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
38 | "АНД-ЭНЕРГИ" ХХК
КА#01070 4385772

2087103
ПІОН0230

ЗУРГАА. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Одоогийн байдлаар үйлдвэрлэлтийн нийт хүчин чадлын 30-40%-ийг ашиглаж байгаа нь үйлдвэрийн хүчин чадлын бүрэн ашиглаагүй буюу ихэвчлэн захиалгаар гэрэл үйлдвэрлэж ирсэнтэй холбоотой. Үйлдвэрлэсэн гэрлээс багахан хэсгийг өөрийн цэгээр борлуулж ирсэн. Дээрх гэрлээс Т8 гэрэл, Е27 төрлийн чийдэн, ХГ гэрэл, Е14 төрлийн чийдэнг хамгийн их үйлдвэрлэсэн байна. Эдгээр нь цаашид Компанийн нэрийн бүтээгдэхүүн болгохоор зорьж буй гэрлүүд юм.

Үйлдвэрлэлийн технологийн дамжлага:



Ашиглаж буй тоног төхөөрөмж:

- Led өрөгч машин MD-1200V-L2
- Гагнуурын машин T-960
- Плат зүсэгч машин
- MD-603
- Шингэн тугалга түрхэгч машин
- Утас таслагч машин AWS220
- Laser машин ML1064-R20W
- CNC Машин
- GDZ-80-1.5
- OTS-1100X2

Одоогийн ашиглаж буй тоног төхөөрөмжийн товч танилцуулга, техникийн үзүүлэлтийг Хүснэгт 11-д харуулав.

Үйлдвэрийн байр:

Хаяг: Орхон аймгийн Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян зам 3-6 тоот.

Үйлдвэрийн байрны план зургийг Зураг 3-т харуулав.
Үйлдвэрийн байр нь 16х12м хэмжээтэй, 1 давхар байшин.

Гэрэл үйлдвэрлэхэд орох үндсэн түүхий эд, материал:

- PCB зэс хавтан
- LED чип
- Цахилгааны утас
- Тэжээлийн блок
- Хөнгөнцагаан гэр
- Хуванцар таг
- Хайрцаг, сав баглаа боодол

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
KA#01070 4335772


БҮРТГЭЛИЙН БАРИМТ БИЧИГ
ПЮН0230

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт 11. Гэрлийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Тоног төхөөрөмж	Техникийн үзүүлэлт
1	LED өрөгч машин MD-1200V-L2	PCB хавтангийн хэмжээ: 1215x315mm Тэжээлийн хүчдэл: 220V/50Hz 110V/60Hz Шаардлагатай хийн даралтын хэмжээ: 0.5-0.6Мра Дундаж чадал: 800W Жин: 350 Kg Хэмжээ: 1980X880X1500mm Координатын цэгийн тусламжтайгаар программчлагддаг. Дагалдах төхөөрөмжүүд: Компьютер, Компрессор
2	Гагнуурын машин T-960	Гагнах хэмжээ: 960:300мм Автомат ажиллагаатай Тэжээлийн хүчдэл: 220V/50Hz Чадал: 4500W Дамжуургын хурд: 0-1600мм/мин Машины жин: 90кг Хэмжээ: 1450*630*470 Хөргүүр: Сэнсэн хөргүүртэй
3	Плат зүсэгч машин MD-603	Тэжээлийн хүчдэл: 220V/50Hz Чадал: 40W Дамжуургын хурд: 0-400мм/с Машины жин: 50кг Хэмжээ: 1200x4200x330mm Зүсэх хавтангийн хэмжээ: 0.8-3.0mm Зүсэх материал: Хөнгөн цагаан, Зэс, Шил
4	Шингэн тугалга түрхэгч машин	MD-XL:140*40см MD-L:45*60см MD-S:25*30см
5	Утас таслагч машин AWS220	Тэжээлийн хүчдэл: 220V/50Hz Чадал: 240W Жин: 40кг Утас үзүүрлэх хэмжээ : 0.1-30мм Утас таслах хэмжээ: 0.1mm - 99999mm Утасны төрөл: PVC, Teflon, Glass Wire
6	Laser машин ML1064-R20W	Тэжээлийн хүчдэл: 220V/50Hz Чадал: 20W Долгион: 1064nm Repeatability: ±0.003mm Хурд: 7000mm/s Бичих гүн: ≤0.3mm Хамгийн бага зураасын өргөн: 0.015mm Сэнсэн хөргөлттэй
7	CNC Машин GDZ-80-1.5	Тэжээлийн хүчдэл: 220V/400Hz Чадал: 1500W Хурд: 24000 r/min
8	OTS-1100X2	Тэжээлийн хүчдэл: 220V/50Hz Чадал: 2200W Хурд: 1380r/min
9	LD-808AL	Тэжээлийн хүчдэл: 220v 50/60hz Чадал: 100W
10	LED-1206TS	Тэжээлийн хүчдэл: 220v 50/60hz Чадал: 1500W
11	RF-8810	Тэжээлийн хүчдэл: 380VAC 50/60Hz Чадал: 7000W
12	X-10	Тэжээлийн хүчдэл: 380VAC 50/60Hz Чадал: 1000W

Зураг 3. Одоогийн үйлдвэрийн байрны план зураг



Түүхий эд, материалын цахилгааны утсыг Монгол дахь Эрдмин ХХК-аас авдаг бол хайрцаг, савыг Мөнхийн үсэг ХХК, Экопак ХХК, Финпак ХХК-ийн хэвлэлийн үйлдвэрүүдээр захиалан хийлгэдэг. Бусад түүхий эд, материалыг БНХАУ, Тайвань зэрэг улсаас татан авдаг.

Маркетинг, борлуулалтын өнөөгийн байдал

Өнөөдрийн байдлаар манай компанийн нийт борлуулалтын орлогын 47.3 хувийг LED гэрлийн борлуулалт, 52.7 хувийг бусад ажил үйлчилгээ эзэлж байна.

Иймээс LED гэрэл, T8 загварын гэрэл, нүдэн гэрэл, малчдын гэрэл гэх мэт дотор гэрэлтүүлгүүдийг хэрэглэгчийн хэрэгцээнд тулгуурлан, чанар, өнгө үзэмж, загварт нь монгол хүний мэдлэг шингээн, өртөг багатайгаар үйлдвэрлэж, зах зээл дээрх өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэн, хамгийн их эрэлттэй бүтээгдэхүүн болгон борлуулалтын хэмжээг өсгөх нь нэн тэргүүний зорилт болоод байна.

Хүснэгт 12. 2016 оны борлуулалтын хэмжээ

№	Гэрлийн төрөл	2016 оны борлуулалт /ш/
1	T8 – 9W, 18W, 36W-н суурьтай, суурьгүй гэрэл	5,394
2	T5 – 18W суурьтай	14
3	12v – 5W, 10W гэрэл	641
4	Аялагч гэрэл	441
5	E27 – 4W, 5W, 7W, 9W, 12W чийдэн	2,403
6	E14 – 3W candle	669
7	НГ – 3W, 5W, 3W COB, 5W COB	333
8	Панель гэрэл 48W	235
9	Таазны гэрэл 30W, 160W	89
10	ГГ – 50W, 60W, 80W, 100W, 120W, 150W, 180W гэрэл	778
11	ХГ – 40W, 50W, 60W, 100W, 150W гэрэл	2,005
	НИЙТ	**13,002**

Дээрх борлуулалтыг Эрдэнэт хотын 100 айл төв болон Стандарт төвүүд дээр павилон түрээслэн нэрийн барааны дэлгүүрээр борлуулах, гэрээт буюу захиалгат ажил үйлчилгээг үйлдвэрлэх байдлаар хийж гүйцэтгэв.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
42 | "АНД-ЭНЕРГИ" ХХК
КА1001070 4385772

2087103
ПЮН0230

ЗУРГАА. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хүснэгт 13. 2016 оны үйлдвэрлэлт, борлуулалтын харьцаа

№	Гэрлийн төрөл	Үйлдвэрлэлт /ш/	Борлуулалт /ш/	Гүйцэтгэлийн хувь
1	T8 – 9W, 18W, 36W-н суурьтай, суурьгүй гэрэл	5,694	5,394	95%
2	T5 – 18W суурьтай	14	14	100%
3	12v – 5W, 10W гэрэл	726	641	88%
4	Аялагч гэрэл	196	441	225%
5	E27 – 4W, 5W, 7W, 9W, 12W чийдэн	3,577	2,403	67%
6	E14 – 3W candle	1,114	669	60%
7	НГ – 3W, 5W, 3W COB, 5W COB	486	333	69%
8	Панель гэрэл 48W	234	235	100%
9	Таазны гэрэл 30W, 160W	91	89	98%
10	ГГ – 50W, 60W, 80W, 100W, 120W, 150W, 180W гэрэл	888	778	88%
11	ХГ – 40W, 50W, 60W, 100W, 150W гэрэл	2,024	2,005	99%

Зарим бүтээгдэхүүний хувьд агуулахын үлдэгдэлтэй байснаас борлуулалт нь үйлдвэрлэлтээс өндөр гарсан байна.

2016 оны үйлдвэрлэлтийг борлуулалтанд харьцуулан үзвэл үйлдвэрлэсэн гэрлийг бүрэн борлуулдаг нь харагдаж байна. Энэ нь борлуулалтын ихэнх хувьд гэрээт буюу захиалгат ажил үйлчилгээ хийгдсэнтэй холбоотой. Гэрээт ажил гүйцэтгэхэд маркетингийн хувьд зардал багатай, үйлдвэрлэсэн гэрлийг шууд борлуулах сайн талтай ч байнгын борлуулалт гэж үзэхгүй.

Компани дээрх борлуулалтыг гүйцэтгэхэд маркетингийн үйл ажиллагаанд төдийлөн зардал гаргалгүйгээр хийсэн. Үүнд:

- Орхон аймаг болон Улаанбаатар хотод зохиогдсон үзэсгэлэнгүүдэд оролцож бүтээгдэхүүнээ танилцуулах,
- Орхон аймгийн 100 айл төв, Стандарт төвүүд дээрх нэрийн барааны дэлгүүрээр борлуулах,
- Гэрээт ажил гүйцэтгэх.

Дээрх үзүүлэлтүүдээс харахад Компани цаашдаа зөвхөн гэрээт ажлыг гол болгохоос илүүтэй борлуулалт сайтай гэрлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тэдгээрийг зарж борлуулах дээр анхааран ажиллах шаардлагатай.

Компани өөрийн нөөц боломжид тулгуурлан гэрлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, тогтмол үйлдвэрлэдэг брэнд бүтээгдэхүүнийг бий болгох бүрэн боломжтой.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА#01070 4385772

6.1.2. Түүхий эд бэлтгэн нийлүүлэлт

Гэрлийн үйлдвэрийн түүхий эд, материалын нийлүүлэгчийг дараах байдлаар тооцоолон сонгож байна.

Хүснэгт 14. Түүхий эд бэлтгэн нийлүүлэлт

№	Түүхий эдийн нэр	Нийлүүлэлт	Чанар
1	PCB зэс хавтан	LED гэрэлтүүлгийн төрлөөс хамаарсан цахилгааны схемийг боловсруулан, БНХАУ улсад захиалгаар хийлгэнэ.	Олон улсын стандартад нийцсэн
2	LED чип	Тайвань улсын Epistar брэндийн LED чипүүдийг хэрэглэнэ.	Олон улсын стандартад нийцсэн
3	Цахилгааны утас	"Эрдмин" ХХК	Монгол улсын стандартад нийцсэн
4	Тэжээлийн блок	Тайвань улсын дэлхийд тэргүүлэгч брэнд болох "MEAN WELL" брэндийн тэжээлийн блокыг хэрэглэнэ. Төслийн хүрээнд өөрсдийн гэрэлд тохирсон тэжээлийн блокыг туршилт, судалгаагаар бий болгон PCB хавтанг захиалж хийлгэн үйлдвэр дээрээ угсарч хэрэглэх төлөвлөгөөтэй.	Олон улсын стандартад нийцсэн
5	Хөнгөн цагаан корпус, хуванцар таг	Монголын хэрэглэгчдэд тохирсон гэрлийн корпусуудын зураг төслийг боловсруулж, БНХАУ дахь түншүүдээрээ захиалгаар хийлгэнэ.	Олон улсын стандартад нийцсэн
6	Хайрцаг сав баглаа боодол	"Мөнхийн үсэг" ХХК, "ЭКОПАК Монгол" ХХК, "ФИНПАК" ХХК-ийн хэвлэлийн үйлдвэрүүдээр хийлгэнэ.	Монгол улсын стандартад нийцсэн

Дээрх хүснэгтэд дурдсан байгууллагуудтай цаашид хамтын ажиллагаагаа улам сайжруулан ажиллахаар төлөвлөж байна. Мөн түүхий эд, материалын үнэ, чанарын хувьд давуу талтай бусад газрыг судлан хамтран ажиллах боломжтой.

6.1.3. Өрсөлдөгч

Өрсөлдөгчийг тодорхойлох

Салбарын тойм хэсэгт дурдсан мэдээллээс харахад манай улсын гэрлийн зах зээлийн ихэнх хэсгийг импортын чийдэн эзэлдэг бөгөөд гаалийн мэдээнээс үзэхэд БНХАУ, БНСУ, ОХУ зэрэг улсаас импортолдог байна. Иймд бидний гол өрсөлдөгч нь импортын чийдэн учраас өрсөлдөгчийг тодорхойлох зорилгоор дараах судалгаа шинжилгээг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Өрсөлдөгчид, тэдгээрийн үнийн судалгаа
2. Анд-Энерги ХХК-ийн Эрдэнэт LED брэндийн чийдэнгийн чанарт хийсэн судалгаа.

1. Өрсөлдөгч бүтээгдэхүүн, тэдгээрийн үнийн судалгаа

Зорилго: Эрдэнэт LED гэрлийн гол өрсөлдөгч чийдэн, тэдгээрийн үнэ, тархалтыг тодорхойлоход энэхүү судалгааны зорилго оршино.

Судалгааны үндэслэл, шаардлага: "Эрдэнэт лед" гэрлийн үйлдвэр нь 2014 оны 9 дүгээр сараас үйл ажиллагаа явуулан Монгол улсад LED гэрлийг үйлдвэрлэн ажиллаж байна. Манай улс гэрлийн хэрэгцээгээ 100% импортын гэрлээр хангадаг. Иймд "Эрдэнэт лед" гэрлийн үйлдвэрийг өргөжүүлэхэд импортын гэрлийн талаар судлах шаардлагатай юм.

Судалгааны арга зүй, хамрах хүрээ: Энэхүү судалгааг 2016 оны 12 дугаар сард Орхон аймгийн 100 айл, Стандарт барилгын материалын дэлгүүрт, 2017 оны 04 дүгээр сард Улаанбаатар хотын 100 айл барилгын материалын зах, Hermes худалдааны төв, супермаркетад зарагдаж буй гэрлийн талаарх асуулга, ажиглалтын аргаар судалгааг явуулав.

Судалгаанд:

- 3W-4W
- 5W-6W
- 7W-8W
- 9W-10W
- 12W
- T5 гэсэн гэрлүүдийг сонгон авав.

Эдгээр гэрлүүд нь "Эрдэнэт лед" үйлдвэрийн үндсэн бүтээгдэхүүнүүд юм.

Өрсөлдөгч бүтээгдэхүүнүүд: Судалгаанд хамрагдсан газруудад дараах брэндийн гэрлүүд байв. Үүнд:

1. FSL брэндийн гэрэл

FSL Lighting нь 1958 онд үүсгэн байгуулагдсан Фошан Лайтинг корпорацийн брэнд юм. Фошан нь боломжийн үнэтэй LED гэрэл үйлдвэрлэдгээрээ дэлхийд танигдан нэр хүндийг бий болгосон. FSL бренд нь Европ, Америк, Зүүн Өмнөд Азид буюу дэлхийн 20 гаруй оронд бүтээгдэхүүнээ экспортлодог. Өнгөрсөн жил FSL нь дэлхий даяар 100 гаруй сая LED гэрлийн шил борлуулсан ба үүнийг Шинэ Зеландаас хүртэл авах боломжтой болсон. Энэхүү брэндийн гэрлийг хувь хүмүүс импортлон оруулж ирдэг.

2. GP брэндийн гэрэл

GP Lighting брэндийн үйлдвэрлэгч Хонконгийн Gold Peak групп нь батерей болон түүний дагалдах бүх төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр 50 жилийн турш үйл ажиллагаагаа явуулж буй Азид тэргүүлэгч компани юм. Зиг Заг Трейд компани 2014 онд GP Lighting брэндийн албан ёсны эрхийг авсан бөгөөд олон улсын стандартад нийцсэн LED, CFL өдрийн гэрэл гэсэн төрлүүдээр 10 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг худалдаалж байна.

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 05

3. Opple брэндийн гэрэл

Opple Lighting нь БНХАУ-ын Шанхай хотод байрладаг томоохон гэрлийн үйлдвэрлэгч юм. Анх 1996 онд өдрийн гэрэл болон таазны цахилгаан холболт хийж бизнесээ эхлүүлсэн ба Opple үйл ажиллагаагаа цахилгаан хэрэгсэлээс авахуулаад том хэмжээний гэрэлтүүлгийн шийдэл зэрэг бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлөө нэмэн өргөжүүлсэн. Хятадын гэрэлтүүлэгийн зах зээлд 30,000 гаруй борлуулалтын цэгтэй хамгийн том гэрэлтүүлгийн компани болгосон. Opple нь зөвхөн дотоодын зах зээлд өсөлттэй байгаад зогсохгүй 50 гаруй орон бүтээгдэхүүн үйлчилгээгээ түгээн олон улсын зах зээлд мөн өсөлттэй байгаа юм. Энэ нь ганц бүтээгдэхүүний өндөр эрэлт хэрэгцээнээс үүсэлтэй бус, компанийн судалгаа хөгжүүлэлтэд чухал ач холбогдол өгдөгтэй холбоотой. Opple инновацид өндөр ач холбогдол өгдөг учраас LED технологид шилжилтийн үед тэргүүлэгчдийн нэг гэсэн байр суурыа хадгалж чадсан. Opple нь дэлхий даяар 6,000 хүнийг ажлын байраар хангадаг.

Монгол дахь албан ёсны дистрибютер компани нь "Номин Холдинг" компанийн салбар Номин Энержи ХХК юм. Тус брэндийг оруулж ирэн 3 жил болж байна.

4. Hippo брэндийн гэрэл

HIPPO нь БНСУ-ын тэргүүлэгч LED гэрэл үйлдвэрлэгч юм. Уг бүтээгдэхүүнийг өрсөлдөхүйц үнээр худалдан авах боломжтой ба БНСУ-ын LED гэрэлтүүлгийн зах зээлд номер нэг бүтээгдэхүүн байсаар ирсэн. Бүтээгдэхүүнээ Европ, Ойрхи дорнод, Азийн 20 гаруй оронд экспортолдог ба LOTTE, KUMHO, KOCOM зэрэг томоохон үйлдвэрлэгчдэд бүтээгдэхүүнээ нийлүүлдэг.

Энэхүү брэндийн Монгол дахь албан ёсны дистрибютерээр Номин Холдинг компанийн салбар Номин Энержи ХХК ажилладаг. Уг брэндийг оруулж ирснээс хойш 5 жил болж байна. Хэдий албан ёсны эрхтэй компани байгаа ч БНХАУ-д дуурайлган хийсэн, хямд гэрэл маш ихээр орж ирдэг.

Эдгээр брэндүүдээс гадна Monel, Philips, Barom, Efficient, Kmong, MANHA, IEK зэрэг маш олон брэндийн гэрлүүд зах зээл дээр зарагддаг. Дээрх онцолсон брэндүүд нь судалгаанд хамрагдсан газруудад түгээмэл байсан брэндүүд болно.

Өрсөлдөгч бүтээгдэхүүний үнэ: Өрсөлдөгч бүтээгдэхүүний судалгаатай хамт тэдгээрийн үнийг судалсан бөгөөд гэрлийн техникийн үзүүлэлтээс хамааруулан ангилан үзэв. Өрсөлдөгч бүтээгдэхүүний үнийн судалгааны дэлгэрэнгүйг "ХАВСРАЛТ 7"-д хавсаргав. Үнийн мэдээллийг нэгтгэн гаргавал:

Хүснэгт 15. Өрсөлдөгч бүтээгдэхүүний дундаж үнэ (төгрөгөөр)

Төрөл	3W-4W	5W-6W	7W	9W-10W	12W	T5	Харьцаа
Хятад хямд гэрэл	2,440	3,293	4,850	-	5,460	7,000	+55%
Эрдэнэт LED	4,950	7,700	10,000	12,100	15,000	14,500	-
GP	9,000	-	-	15,000	-	-	-32%
Opple	-	-	-	-	15,000	-	-

Үнийн судалгаанаас харахад дэлгүүрүүдэд хамгийн ихээр байдаг БНХАУ-ын дуурайлган хийсэн гэрлүүд хамгийн хямд, манай гэрлээс дунджаар 55%-иар хямд үнэтэй, сүлжээ супермаркетуудаар хамгийн их байдаг GP брэндийн гэрэл дунджаар 32% үнэтэй байна.

СЭХ ХХК
"АНД-ЭНЕРГИ" ХХК
КА31010170 4305772
2087103 ПЮН0230

СЗХ он сар өдөр БҮРТГЭВ № 01

2. LED гэрлийн чанарт хийсэн судалгаа

LED гэрлийн чанарт хийсэн судалгааг ШУТИС-ийн Мэдээлэл Холбооны Технологийн Сургуулийн Электроникийн салбарын ахлах багш докторант Г.Мөнхжаргал хийж гаргасан. Судалгааны тайланг "ХАВСРАЛТ 6"-д хавсаргав.

Судалгааны зорилго: Анд-Энерги ХХК-ийн Эрдэнэт LED брэндийн гэрэл (E14, E27, ба T8)-үүд болон гудамжны гэрэлтүүлгийн гэрлийн үйлдвэрлэл, ажиллагаа, чанарт дүн шинжилгээ хийх, мөн бусад өрсөлдөгч гэрлүүдтэй харьцуулах

Судалгааны цар хүрээ: Уг судалгаанд Анд-Энерги ХХК-ийн гүйцэтгэсэн гудамжны гэрэлтүүлгүүд, E14, E27 төрлийн LED гэрэл болон T8 төрлийн урт гэрэл хэрэглэж буй 3 айл өрх, 10 албан газраар орж бүтээгдэхүүний чанар, ажиллагаа, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авсан. Мөн Эрдэнэт LED брэндийн 12 гэрэл, 2 нүдэн гэрэл, 2 урт гэрэл, бусад брэнд (Opple, Barom, FSL, Efficient LED, LED, GP, KMONG, QML)-ийн 14 ширхэг буюу нийт 30 ширхэг гэрлийг ашиглан гэрэл тус бүрийн харьцуулан судалсан.

Эрдэнэт LED брэндийн гэрлийн давуу талууд

1. Хэмнэлт өндөр: Эрдэнэт LED брэндийн гэрлүүд улайсдаг гэрэлтэй харьцуулахад 9.9-13.7 дахин бага цахилгаан зарцуулж байсан нь хангалттай сайн үзүүлэлт юм.

2. Гэрэлтэлт сайн: Эрдэнэт LED брэндийн гэрлийн гэрэлтэлт ижил чадалтай бусад гэрлүүдтэй ойролцоо, эсвэл илүү байсан нь эерэг үр дүн юм.

3. Халалт бага: Халалтын хувьд Эрдэнэт LED брэндийн гэрлүүд бусад гэрлүүдтэй ойролцоо байсан, мөн чадал ихсэх тусам халалт нь бусад гэрлээс багасах хандлага харагдаж байлаа.

4. Гэрэлтэлтээ барих чадвар сайн: Эрдэнэт LED брэндийн 1 жил хэрэглэгдсэн 12Вт-н чадалтай гэрлийн цахилгааны хэрэглээ 25%-аар нэмэгдсэн байсан нь сул тал боловч гэрэлтэлт нь шинэ 12Вт-н гэрэлтэй харьцуулахад 4.5%-аар их байсан нь сайн тал. Учир нь 1 жил хэрэглэгчийн гар дээр ашиглагдсан гэрлийн гэрэлтэлт муудаж бууражгүй нь Эрдэнэт LED брэндийн гэрлийн гэрлэн диодын чанар сайн байгааг илтгэж байна.

Эрдэнэт LED брэндийн гэрлийн сул талууд

1. Хүнд: Эрдэнэт LED брэндийн гэрлүүд нь бусад ижил чадалтай LED гэрлээс 45-105% хүртэл илүү жинтэй байсан. Харин зөвхөн 5Вт-ын чадалтай гэрэл нь LED_5 гэрлээс хөнгөн байв. Энэ нь гэрлийн хөргүүр зузаан хөнгөн цагааны хайлшаар хийгдсэн харин бусад LED гэрлийн хөргүүр нимгэн метал эсвэл хуванцар материалаар хийгдсэнтэй холбоотой юм.

2. Овор хэмжээ их: Гэрлийн чадал ихсэх тусам овор хэмжээ нь бусад гэрлээс харьцангуй ихээр ихсэж байна.

3. Хөргүүр нүхтэй: Гэрлийн хөргүүр агааржуулах нүхэлгээтэй байсан бол бусад гэрлийнх ихэнхдээ битүү хийгдсэн байна. Битүү байх нь гэрэл дотор ус, тоос шороо орохгүй учир гэрлийн насжилт, гэрэлтэлтэнд эерэгээр нөлөөлнө.

4. Цахилгааны хэрэглээ ашиглалтын хугацаанд ихсэх магадлалтай: 1 жил хэрэглэгдсэн 12Вт-ын чадалтай гэрлийн цахилгааны хэрэглээ шинэ 12Вт-ын чадалтай гэрлийнхээс 25% аар нэмэгдсэн байсан. Энэ нь тэжээлийн блокын тогтворгүй байдлыг

АНД-ЭНЕРГИ ХХК КА01070 4395772
2087103 ПЮН0230

харуулж байна. Гэхдээ энэ асуудлыг цаашид илүү олон гэрэл дээр туршилт хийж нарийвчилж үзэх шаардлагатай. Учир нь энэ туршилтыг зөвхөн нэг гэрэл дээр хийсэн учраас алдааны магадлал өндөр байх боломжтой.

Чанарт хийсэн судалгааны дүгнэлт

1. Эрдэнэт LED брэндийн гэрэл нь шилэн бус хуванцар, төмөр учраас бусад өрсөлдөгч бүтээгдэхүүнтэй харьцуулахад бат бөх байна. Улайсдаг болон сүүн гэрэл нь газар унагаахад хагарч байгаа бол Эрдэнэт LED гэрэл нь хагарахгүй бөгөөд унагасны дараа ашиглахад ажиллагаа нь хэвийн байна.

2. Гэрлэн диодын ажиллах хугацаанд үндэслэн чийдэнгийн ажиллах хугацааг тооцвол 12 жил байна.

3. Эрдэнэт LED брэндийн гэрлийн зардлаа эргэн төлөх хугацааг улайсдаг гэрлүүдтэй харьцуулан тооцоход 4.4-5.6 сар гарсан нь өрсөлдөгч бүтээгдэхүүнүүдтэй харьцуулахад дундаж үзүүлэлт байлаа.

Дээрх судалгаанаас нэгтгэн дүгнэвэл:

Манай улсын LED гэрлийн зах зээл дээр дэлхийд тэргүүлэгч болох Sony, Samsung, LG, Philips, General Electric, Sharp корпорациудын LED гэрэл байхгүй байна. Харин БНХАУ-ын FSL, IEK, OPPLE, MANHA, GP брэнд болон БНСУ-ын Hippo брэндийн гэрлүүд түгээмэл байдаг. Өрсөлдөгч гэрлүүд нь үнэ, чанарын хувьд харилцан адилгүй бөгөөд үнэ өндөртэй гэрлүүд нь чанартай байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Эрдэнэт LED гэрлийн хувьд чанарын үзүүлэлт сайтай бөгөөд үнийн хувьд өрсөлдөгчидтэй харьцуулбал, GP болон Opple брэндээс хямд, БНХАУ-д үйлдвэрлэсэн зарим гэрлээс үнэтэй байна.

Иймд үнэ болон чанарын үзүүлэлтээр гол өрсөлдөгчийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

1. GP болон OPPLE брэнд
2. Бусад хямд гэрэл (дуурайлган хийсэн хятад гэрлүүд)

6.1.4. Нөхцөл байдлын шинжилгээ

Хүснэгт 16. Өрсөлдөгч гэрлүүдийг өөрийн гэрэлтэй харьцуулан үзвэл:

	Давуу тал	Сул тал
GP болон OPPLE брэнд	Түгээлт сайтай	Үнэ өндөр
	Идэвхжүүлэлт сайтай	Гадаадад үйлдвэрлэсэн
	Зах зээл дээр удаан тогтсон	Засвар үйлчилгээ байхгүй
	Импортлогч компани туршлагатай	
Бусад хямд гэрэл	Үнэ хямд	Чанар муу
	Түгээлт сайтай	Хэрэглэгчдэд танигдаагүй
		Идэвхжүүлэлт байхгүй

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01
ЗУРГАА. БИЗНЕСИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 17. Эрдэнэт LED гэрлийн SWOT шинжилгээг гаргавал:

Боломж	Аюул занал
• Хэрэглэгчид байгальд ээлтэй, цахилгаан хэмнэлттэй бүтээгдэхүүнийг сонгох хандлагатай болсон • LED технологийг түгээмэл хэрэглэх • Манай улс үндэсний үйлдвэрлэлээ дэмжих бодлого хэрэгжүүлдэг • Бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх • Түгээлт хийх борлуулалтын суваг их	• Томоохон импортлогч компаниуд зах зээл дээр үйл ажиллагаа явуулдаг • Импортын LED гэрлийн хэрэглээ нэмэгдэх • Үйлдвэрлэлийн түүхий эдийн үнэ өсөх. Энэ нь валютын ханшийн өсөлттэй хамааралтай
Давуу тал	**Сул тал**
• Бүтээгдэхүүний чанар сайн • Монголд LED гэрэл үйлдвэрлэж буй анхны компани • Гэрлийн хэлбэр, хийц, савлагаа зэргийг хэрэглэгчдийн хүсэл, шаардлагад нийцүүлэн өөрчлөх, сайжруулах • Бүтээгдэхүүний баталгаат хугацаа, засвар үйлчилгээ явуулах • Өөрсдөө бүтээгдэхүүний түгээлт хийх	• Олон нийтэд танигдаагүй • Зах зээл дээр түгээмэл байгаа гэрлүүдтэй харьцуулахад үнэ өндөр • Ихэнх түүхий эдээ импортоор авдаг

Өрсөлдөгчийн давуу, сул талыг судлан өрсөлдөх тактик, маркетингийн үйл ажиллагааг дараах байдлаар хэрэгжүүлэх нь зүйтэй.

- Одоогийн үйлдвэрлэж буй гэрлээс борлуулалт сайтай, зах зээл дээр өрсөлдөх боломжтой бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх
- Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг дэлгүүрүүдэд түгээх, лангуун дээр байршуулах ажлыг хэрэгжүүлэх
- Идэвхжүүлэлт сайн явуулан “Монголд үйлдвэрлэсэн гэрэл” гэдгийг хэрэглэгчдэд таниулах
- “Эрдэнэт LED гэрэл” гэсэн хүчтэй брэнд болгох
- Зах зээлийг судлан шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд эзлэх хэмжээг нэмэгдүүлэх

6.2. Бизнесийн ирээдүйн тухай

6.2.1. Бизнесийн үндсэн чиглэл

Өнөөдрийн байдлаар манай компанийн нийт борлуулалтын орлогын 47.3 хувийг LED гэрлийн борлуулалт, 52.7 хувийг бусад ажил үйлчилгээний орлого эзэлдэг. Компанийн цаашдын бизнесийг захиалгат ажил, жижиглэнгийн борлуулалт гэсэн

АНД-ЭНЕРГИ ХХК
КА 01070 4385772
2087103 ПЮН0230

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

2 чиглэлээр хувааж үзэх нь зүйтэй бөгөөд Компанийн борлуулалтын орлогын ихэнх хэсгийг жижиглэнгийн борлуулалтад чиглүүлэн ажиллана.

Захиалгат ажил – Одоогийн үйл ажиллагаанд томоохон хувийг эзэлж буй гэрээт ажлуудыг тасралтгүй хэрэгжүүлэх, шинээр хийгдэх боломжтой ажлыг хайн ажиллана. Гэрээт ажил нь Компанийн борлуулалтанд чухал нөлөөтэй боловч тэдгээрийг төлөвлөхөд бэрхшээлтэй юм. Учир нь удаан хугацааны гэрээт ажил байхгүй, зарлагдсан тендерийн ажил авах эсэх нь эргэлзээтэй байдаг. Компанийн орлогод гэрээт ажлын үр дүн хэрхэн нөлөөлөх, орлогоос хамааралтай үйл ажиллагааг төлөвлөх, шаардлагатай хүний нөөцийг бэлдэх зэрэг нь хүндрэлтэй юм.

Жижиглэнгийн борлуулалт – "Эрдэнэт лед" гэрлийн үйлдвэрийг өргөтгөн хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинэ гэрлийг үйлдвэрлэх, тэдгээрийг түгээх, борлуулах үйл ажиллагааг зорилго болгон ажиллана. Компанийн цаашдын үйл ажиллагааг жижиглэнгийн борлуулалтад тулгуурлан санхүүгийн тооцоо, зах зээлийн багтаамж, хүний нөөц зэргийг төлөвлөн ажиллаж байна.

Бид зах зээл дээр эрэлттэй байгаа гол LED гэрлүүдийг үйлдвэрлэх замаар Монгол Улсын гэрэлтүүлгийн зах зээлд “Эрдэнэт LED” брэндийн гэрлийг гол бүтээгдэхүүн болгохоор ажиллана.

Цаашид голлон үйлдвэрлэхээр төлөвлөж буй бүтээгдэхүүнүүд:

1. T8 LED гэрэл (18 Вт, 120 см, суурьгүй);
2. E27 LED чийдэн (9 Вт);
3. Нүдэн гэрэл (5 Вт);
4. Гудамжны гэрэл (100 Вт);
5. Прожектор (100 Вт);
6. Таазны гэрэлтүүлэг (160 Вт);
7. Дүүжин таазны гэрэлтүүлэг (48 Вт).

6.2.2. Бизнес стратеги

Компанийн цаашдын бизнесийг хэрэгжүүлэхэд дараах стратегийг баримтлан ажиллаж, холбогдох үйл ажиллагааг гүйцэтгэхээр төлөвлөж байна.

6.2.2.1. Үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх стратеги

Компанийн одоогийн бизнесийг харахад цаашид бид Компанийг хөгжүүлэх, үйл ажиллагааг өргөжүүлэхэд үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Бид үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх стратегийг баримтлан ажиллах бөгөөд үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхдээ дараах 4 ажлыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Үйлдвэрийн байрыг өргөтгөх,
2. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх,
3. Үйлдвэрлэлийн технологийн шугам өргөтгөх,
4. Хүний нөөцийг нэмэгдүүлэх.

Үйлдвэрийн байрыг өргөтгөх

Компанийн үйлдвэрлэлийг өргөтгөхийн тулд одоогийн үйлдвэрлэл явуулж буй байрыг томсгох шаардлагатай. Үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлэх

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА1601070 4395772

2087103
ПЮН0230

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн шугам, хүний нөөцийг нэмэгдүүлэхээр төлөвлөсөн. Эдгээр нэмэгдэхийн хэрээр үйлдвэрийн байрыг өргөтгөх зайлшгүй шаардлага үүснэ. Одоогийн үйлдвэрийн байр 16м х 12м харьцаатай 1 давхар бол бид хөрөнгө оруулалтыг шийдсэнээр 24м х 20м харьцаатай 3 давхар байранд ажиллахаар төлөвлөж байна.

Үйлдвэрийн шинэ байрны план зураг, давхарын зохион байгуулалтыг "ХАВСРАЛТ 7"-д хавсаргав. Шинэ байр ашиглалтанд оруулснаар судалгаа хөгжлийн лаборатори, LED гэрлийн үзүүлэнгийн өрөө, нэрийн дэлгүүр зэргийг шинээр байгуулна. Компанийн хөрөнгө оруулалтын зардлын 775.0 сая төгрөгийг энэхүү ажилд зарцуулахаар төлөвлөж байгаа нь нийт хөрөнгө оруулалтын зардлын 50 хувийг эзлэх болно.

Үйлдвэрлэлийн технологийн шугам дээр хийгдэх өргөтгөлүүд

Үйлдвэрийн байрыг шинээр барин ашиглалтанд оруулсны дараа одоогийн үйлдвэрлэлийн технологийн шугамыг дараах байдлаар өргөтгөхөөр төлөвлөв. Үүнд:

- Судалгаа хөгжлийн лаборатори,
- Техникийн үзүүлэлт тодорхойлох стенд,
- Автомат угсралтын шугам,
- Угсралтын ширээ,
- Гэрэл шалгах стенд,
- Механик цех.

Өргөтгөлийг хийснээр бид одоогийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд бүтээмжийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүнийг судлах, хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх

Үйлдвэрлэлийн шугаманд өөрчлөлт оруулах, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд тоног төхөөрөмжийг зайлшгүй нэмэх шаардлагатай. Бид үйлдвэрээ өргөтгөхөд шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг худалдан авахдаа энэ төрлийн бизнес хийдэг компаниудыг судлан үзэж, БНХАУ-ын "Shenzhen Jaguar Automation Equipment" компани болон "Shenzhen leadsmt technology" компаниудтай холбогдон үнийн санал авсан. Эдгээрээс чанар болон үнийн хувьд "Shenzhen leadsmt technology" компани илүү давуу талтай байна. Дараах тоног төхөөрөмжүүдийг шинээр худалдан авахаар төлөвлөв. Үүнд:

Хүснэгт 18. Худалдан авахаар төлөвлөж буй тоног төхөөрөмж

Тоног төхөөрөмжийн нэр	Зориулалт	Тоо ширхэг
CNC лазер машин	Өнгөт хавтангаар гэрлэн үсэг, лого зүсэх	1 ширхэг
CNC машин	Нимгэн төмрөөр гудамжны гоёлын гэрлийн корпусны бэлдэц, дотор гэрлийн корпусны бэлдэц, хээ, үсэг, лого зүсэх	1 ширхэг
Лист нугалагч машин	Нимгэн төмөр нугалж гэрлийн корпус болон бусад төмөр хийц хийх	1 ширхэг
Лист хайчлагч машин	Нимгэн төмөр хайчлах	1 ширхэг
Хагас автомат гагнуурын машин	Нимгэн төмөр гагнах, гагнуурын чанар сайжирна. Гудамжны гоёлын гэрэл хийхэд хэрэглэнэ.	1 ширхэг

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ
ХХК
КА/01070 4335772

2087103
ПЮН0230

СЗХ
он . . сар . . өдөр
БҮРТГЭВ
№ 01

Хэмжүүрийн болон гар багажууд	Гар дриль, гагнуурын алх, хэмжүүрийн багаж зэрэг нь гэрэлтүүлэг угсрах үед хэрэглэгдэх ба эдгээр багаж хэрэгслээр угсралтын ширээг тоноглоно. Ингэснээр гар ажиллагаа багасах ба илүү хөдөлгөөнүүд хязгаарлагдана.	1 ширхэг
Нүх ухагч трактор	Тендерийн болон төслөөр хийгдэх авто замын гэрэлтүүлэг, цахилгаан дамжуулах шугамын ажил хийхэд голлох үүрэг гүйцэтгэнэ.	1 ширхэг
Крантай машин	Тендерийн болон төслөөр хийгдэх Авто замын гэрэлтүүлэг, Цахилгаан дамжуулах шугамын ажил хийхэд голлох үүрэг гүйцэтгэнэ. Цаашид гудамжны гэрэлтүүлгийн урсгал засварын ажил хийхэд шаардлагатай	1 ширхэг
Тугалга түрхдэг машин /LED printer/ LD-P808AL	LED чипийг PCB хавтан дээр гагнах зорилгоор, тусгай хэвний тусламжтайгаар PCB платан дээр шингэн тугалга түрхэх зориулалт бүхий автомат машин	1 ширхэг
LED өрөгч машин LED-1206TS	LED чипийг PCB хавтан дээрх зураглалын дагуу координатын цэгийн тусламжтайгаар өрж байрлуулах зориулалт бүхий автомат машин	1 ширхэг
Гагнуурын машин RF-8810	PCB хавтан дээр түрхэгдсэн шингэн тугалгыг өндөр температурт хайлуулах замаар LED чипийг PCB хавтан дээр гагнах машин	1 ширхэг
Конвейр LD-330CR	Нэг автомат машинаас нөгөө машинруу PCB хавтанг шилжүүлэн зөөвөрлөх зориулалттай	4 ширхэг
PCB хавтангийн хөрөө LD-330PS	PCB хавтанг хийгдэх гэрлийн их биений хэмжээнд тохируулан тасдах зориулалт бүхий машин	1 ширхэг
Угсралтын ширээ 12м	Тухайн гэрлийн деталлуудыг шугаман дараалалаар угсрах зориулалтаар хэрэглэнэ. *Ізөөвөрлөх ажиллагааг хөнгөвчилж конвейр дунд нь суурилуулж өгсөн/*	1 ширхэг
Гэрлийн техник тодорхойлдог лаборатори Х-10	Спектометрийн тусламжтайгаар гэрлийн тусгалын өнцөг, өнгө ялгаралын коэффициент, гэрэлтүүлгийн өнгө, гэрэл-түүлэх хэмжээ зэргийг тодорхойлдог төхөөрөмж	1 ширхэг
Техникийн үзүүлэлт тодорхойлдог стенд	Гэрлийн хэрэглэх чадал, гүйдэл, ашигт үйл коэффициент зэрэг гол техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлдог төхөөрөмж	1 ширхэг
Гэрэл шалгах стенд 40м	Бэлэн болсон гэрлийг хүчдэлийн хэлбэлзэл доор чанарыг нь шалгадаг төхөөрөмж. Хэрэглэгчид чанартай бүтээгдэхүүн хүргэх зорилгоор шалгадаг төхөөрөмж	1 ширхэг
Хэмжүүрийн болон гар багажууд		1 ширхэг

Тоног төхөөрөмжийн худалдан авалтад 507.0 сая төгрөг зарцуулахаар төсөвлөсөн.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА1101070 4335772

Бумбат Алтай
2087103 ПЮН0230


СӨХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01
ЗУРГАА. БИЗНЕСИЙН ТӨЛӨӨЛӨГЧГАА

Хүний нөөцийг нэмэгдүүлэх

Гэрлийн үйлдвэрлэлийн нэг чухал хэсэг нь ажиллах хүч буюу хүний нөөц юм. Бид үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэхдээ түүнд хамаарах ажиллах хүчний орон тоог нэмэх зайлшгүй шаардлагатай. Үйлдвэрийн шат дамжлага, маркетинг, борлуулалтын хэсэгт хүний нөөцийг нэмэгдүүлнэ.

2017 оноос Компанийн бүтэц, орон тооны зохион байгуулалтыг дараах байдлаар төлөвлөж байна. Үүнд:

Зураг 4. Компанийн бүтэц, орон тоо



Компанийн одоогийн бүтцээр үндсэн ажилчид 14 ажилладаг бол дээрх бүтцээр хүний нөөцийг 2 дахин нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Үүнд хангамжийн менежер, өрөгч, гагнуурчин, механик инженер, цахилгааны инженер зэрэг албан тушаалууд нэмэгдэнэ. Мөн үйлдвэрийн үйл ажиллагаа, борлуулалтын хэмжээ зэргээс хамааран хүний нөөцийг нэмэгдүүлэх, гэрээт ажилчид ажиллуулах зэргийг шийдвэрлэх болно.

"Үйлдвэрийн байрыг өргөтгөх", "Үйлдвэрийн шугам өргөтгөх", "Тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх", "Хүний нөөцийг нэмэгдүүлэх" зэргийг шат дараатай хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд дээрх ажлуудыг гүйцэтгэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг гаргавал:

ХХК
БҮРТГЭЛИЙН БАРИМТ БИЧИГ 53
2087103
ПЮН0230

СЗХ он сар өдөр БҮРТГЭВ № 01

Хүснэгт 19. Үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

№	Хэрэгжилтийн үе шат	2017 он					2018 он	
		IV-V	VI-VII	VIII-IX	X-XI	XII	I	II
1	Төслийг боловсруулах							
2	Үнэт цаас бүртгүүлэх							
2	Хөрөнгө оруулагчдад төслийг танилцуулах							
3	Шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх							
4	Үйлдвэрийн байр барих материал татах							
5	Үйлдвэрийн байр барих							
6	Тоног төхөөрөмжийг худалдан авах, тээвэрлэх							
7	Тоног төхөөрөмжийг суурилуулах							
8	Туршилтын үйлдвэрлэл явуулах							
9	Ажиллах хүчнийг бүрдүүлэх, сургаж дадлагажуулах							
10	Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг жигдрүүлэх							

Дээрх төлөвлөгөөнөөс харахад 2017 онд бид үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхтэй холбоотой ажлуудыг хийн 2018 оноос шинэ шугамаар үйлдвэрлэлээ явуулахаар төлөвлөж байна. Одоогийн үйлдвэрлэлээр өдөрт 100-150 гэрэл үйлдвэрлэх хүчин чадалтай бол технологийн шугам өргөтгөн, дээрх ажлыг хэрэгжүүлснээр үйлдвэрлэлийн хэмжээг 4 дахин нэмэгдүүлэн өдөрт 600 гаруй гэрэл үйлдвэрлэх хүчин чадалтай болно.

Үйлдвэрлэлийн хүчин чадлыг 9 дахин нэмэгдүүлснээр 2018 оноос эхлэн жилд 130,000 ширхэг LED гэрэл үйлдвэрлэх бөгөөд энэ нь Монгол Улсын нэг жилийн LED гэрлийн зах зээлийн багахан хувийг эзлэх юм. Одоогийн үйлдвэрлэлээр бид Монгол Улсын LED гэрлийн зах зээлд 0.5%-ийг эзэлдэг бол 2018 оноос 3.9% болж өснө. Энэ хэмжээнд хүрч ажиллахад бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулахад илүү анхаарч ажиллана. Бүтээгдэхүүн үйлдвэрлэхдээ зах зээлийг илүү нарийвчлан судлах, хэрэглэгчдийн хэрэглээ, таашаалд нийцүүлэх замаар хийж гүйцэтгэнэ.

Бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах ажлыг уялдуулан гүйцэтгэхдээ Монгол Улсын нийт LED гэрлийн зах зээлээс бидний зорилтот зах зээлээр Орхон аймаг, Улаанбаатар хотыг сонгон авав. Учир нь үйлдвэрийн байршил, тээврийн зардал, түгээлтийн боломж, хэрэглэгчдийн худалдан авалт зэргээс хамааран дээрх 2 сегментийг сонгов. Компани үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг дээрх зорилтот зах зээлд зарж борлуулах чиглэлд төлөвлөн ажиллах нь илүү оновчтой гэж үзэв.

Монгол Улсын нийт LED гэрлийн зах зээлд Улаанбаатар хотын зах зээл нь 62%, Орхон аймгийн зах зээл нь 3.3%-ийг эзэлдэг.

ОРХОН АЙМАГ АНД-ЭНЕРГИ ХХК 54 "АНД-ЭНЕРГИ" ХХК КАЛЛ01070 4385772

Бумбат Алтан 2097103 ПЮН0230

Зорилтот зах зээлд эзлэх хэмжээг гаргавал:

Хүснэгт 20. Шинэ үйлдвэрлэлээр зах зээлд эзлэх хэмжээ

Үзүүлэлт	Зорилтот зах зээл	Үйлдвэрлэлт		Зах зээлд эзлэх хэмжээ	
		Одоогийн	2018 оноос	Одоогийн	2018 оноос
Улаанбаатар хот	2,040,672			0.7%	6.4%
Орхон аймаг	108,775	15,000	130,000	13.8%	119.5%
Монгол улс	3,309,588			0.5%	3.9%

Одоогийн байдлаар бидний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нийт хэмжээ нь зорилтот зах зээл буюу Улаанбаатар хотод 0.7%, Орхон аймагт 13.8%-ийг эзэлж байгаа бол үйлдвэрлэлийг нэмэгдүүлснээр Улаанбаатар хотод 6.4%, Орхон аймгийн зах зээлийг бүрэн хангах боломжтой болно. Иймд бид сонгосон зорилтот зах зээлд тохируулан бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж, маркетинг, борлуулалтыг хэрэгжүүлэн амжилттай ажиллавал үйлдвэрлэлийн төлөвлөгөөг гүйцэтгэх, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг амжилттай борлуулах боломжтой юм. Зорилтот зах зээлээр Улаанбаатар хот, Орхон аймгийг сонгосон ч, бусад газруудад бүтээгдэхүүнээ түгээн борлуулах боломжийг тогтмол ашиглан үйл ажиллагаагаа явуулна.

Цаашид Монгол Улсын нийт зах зээлийг хангах, мөн бүтээгдэхүүнээ экспортлох чиглэлийг судлан ажиллах болно.

6.2.2.2. Маркетинг ба борлуулалтыг нэмэгдүүлэх стратеги

Компанийн үйлдвэрлэлийн хэмжээг өсгөхийн зэрэгцээ үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай. Бид Компанийн маркетинг, борлуулалтыг нэмэгдүүлэхэд дараах бодлогыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 21. Үйлдвэрлэлийн маркетингийн иж бүрдэл

Үйлдвэрлэлийн 4Р	Зорилго
Бүтээгдэхүүний бодлого	Чанартай, цахилгаан зарцуулалт бага, гэрэлтүүлэг сайтай, ашиглалтын хугацаа урт, олон нэр төрлийн LED гэрэл үйлдвэрлэх, хүчтэй брэнд болгох
Үнийн бодлого	Өртөгт суурилсан үнийн бодлого баримтална. Чанар ижил бүтээгдэхүүний хувьд зах зээлийн үнээс хямд үнэтэй байна.
Хуваарилалтын сувгийн бодлого	Худалдан авагчдад бүтээгдэхүүнээ илүү ойрхон байлгах, эргэх холбоог сайжруулахыг эрмэлзэнэ. Түгээлтийн сувгийг нэмэгдүүлнэ.
Урамшуулал, идэвхжүүлэлтийн бодлого	Бүтээгдэхүүний давуу талыг харуулсан идэвхжүүлэлтийн үйл ажиллагааг зорилтот хэрэглэгчдийн бүлэгт тохируулан хэрэгжүүлнэ.

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

Бүтээгдэхүүний бодлого

Чанартай, цахилгаан зарцуулалт бага, гэрэлтүүлэг сайтай, ашиглалтын хугацаа урт, олон нэр төрлийн LED гэрэл үйлдвэрлэх, хүчтэй брэнд болгох

Бүтээгдэхүүний бодлогыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

- Бүтээгдэхүүний чанар,
- "Эрдэнэт LED" брэндийн бүтээгдэхүүнийг бий болгох,
- Хаягжилт, сав, боодол.

Бүтээгдэхүүний чанар

Бид 2014 оноос Эрдэнэт LED гэрлийг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж эхлээд багагүй хугацааг өнгөрүүлсэн байна. Энэ хугацаанд манай бүтээгдэхүүний хувьд хэрэглэгчдээс авсан хамгийн өндөр үнэлгээ нь чанар юм. Бид бүтээгдэхүүний чанарыг үйлдвэрлэлийн хамгийн гол үзүүлэлт гэж үздэг бөгөөд дээрх хугацаанд чанартай холбоотой асуудал үүсээгүй нь бүтээгдэхүүний чанарыг харуулж байна.

Мөн бүтээгдэхүүний чанарын тухай ШУТИС-ийн Мэдээлэл холбооны технологийн сургуулиас хийгдсэн Эрдэнэт LED брэндийн чийдэнгийн чанарт хийсэн судалгааны тайланд тодорхой тусгасныг харж болно.

Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 9-10 дахин нэмэгдүүлж байгаа ч бүтээгдэхүүний чанарыг алдагдуулахгүй барих нь бидний гол бодлого болно. Өнгөрсөн хугацаанд бүтээгдэхүүнийг хэрэглэн чанарыг мэдэрсэн хэрэглэгчдийг тогтоон барих, шинэ хэрэглэгчдэд бүтээгдэхүүнийг таниулах гол үзүүлэлт нь бүтээгдэхүүний чанар байна. Мөн зах зээл дээрх өрсөлдөгч бүтээгдэхүүнээс чанараар ялгаран "Эрдэнэт LED" брэндийг хүчтэй болгох нь чухал.

Цаашид бид борлуулалт өндөртэй, зах зээл дээр эрэлттэй байгаа бүтээгдэхүүнийг илүү үйлдвэрлэх, тэдгээрийг борлуулах, шинэ бүтээгдэхүүнийг судлан, үйлдвэрлэх зэрэг ажлыг төлөвлөн ажиллаж байна.

"Эрдэнэт LED" брэндийн бүтээгдэхүүнийг бий болгох

Манай бүтээгдэхүүний хувьд хэрэглэгчдэд бүтээгдэхүүний давуу талыг таниулан мэдрүүлэх нь чухал байна. "Эрдэнэт LED" брэндийг 2014 оноос үүсгэн ажиллаж байгаа ч маркетингийн хувьд брэндийг хэрэглэгчдэд таниулах, хоногшуулах үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй ирсэн.

Брэндийг хэрэглэгчийн болон үйлдвэрлэгчийн үүднээс ялгаатай авч үзэж болно.

- Үйлдвэрлэгчийн хувьд брэнд нь бүтээгдэхүүн эсвэл түүний үйлдвэрлэгчийг тодорхойлох нэр, лого, загвар эсвэл тэдгээрийн нийлбэр цогцыг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэгчийн хувьд брэнд нь бүтээгдэхүүнийг өрсөлдөгчөөс нь ялгах бүхий л шинж чанаруудын нийлбэр цогц юм. Өрсөлдөөний чиг баримжаатай өнөө үед өрсөлдөгчөөсөө ялгаран бүтээгдэхүүнээ брэнд болгох нь маркетингийн үйл ажиллагааны гол зорилго болоод байна.
- Хэрэглэгчийн хувьд брэнд гэдэг нь өрсөлдөгч бүтээгдэхүүнүүдээс тодорхой онцлог шинжээр ялгаран хэрэглэгчийн сэтгэлд хоногшиж чадсан бүтээгдэхүүн юм.

Өнөө үед хэрэглэгч лангууны өмнө маш олон төрлийн сонголттой гэрлийн дундаас өөртөө хэрэгтэйг олж авах хүнд даалгавартай тулгардаг. Тэгвэл амжилттай хийгдсэн

ОРХОН АЙМАГ
АНД ЭНЕРГИ
ХХК
56 |" "АНД-ЭНЕРГИ" ХХК
КАМ01070 4385772

2087103
ПЮН0230

СЗХ он сар өдөр
ЗУРГАА, БИЗНЕСИЙН ХӨГЖЛИЙН АЖИЛЛАГАА
БҮРТГЭВ

брэндчилэл нь бараа, үйлчилгээг лангууны өмнө бус, харин хэрэглэгчийн ухамсарт урьдчилан борлуулдаг учраас нэг талаас хэрэглэгчийн сонголтыг нөгөө талаас нийлүүлэгчийн борлуулалтыг хялбар болгодог. Иймд "Эрдэнэт LED" брэндийг амжилттай хөгжүүлэх нь бүтээгдэхүүнийг зарж борлуулахад чухал нөлөөтэй.

Брэндчилэл нь бусдаас ялгарах зарчим дээр тулгуурладаг. Бид өрсөлдөгч бүтээгдэхүүнээс дараах давуу талаа ашиглан ялгарна. Үүнд:

- Үндэсний брэнд бүтээгдэхүүн;
- Өндөр чанар;
- Баталгаат хугацаа, засвар үйлчилгээ.

Хэрэглэгчдийн ой тойнд бүтээгдэхүүнээ онцгой, цорын ганц, давтагдашгүй гэдгийг ойлгуулж хоногшуулах нь чухал. Брэнд бүтээж эс чадваас, өөрөөр хэлбэл хэрэглэгчийн ухамсарт өөрийн орон зайг эзэлж чадаагүй бол хэрэглэгчид ихэнх тохиолдолд зөвхөн үнийг нь харьцуулаад хямдыг нь сонгодог байна.

Брэндийн агуулга

1. Брэндийн нэр – "Эрдэнэт LED гэрэл"

Энэхүү нэрийг өгөхдөө үйлдвэрийнхээ нэрээр нэрлэсэн бөгөөд Анд-Энерги ХХК нь Орхон аймаг буюу Эрдэнэт хотод үйл ажиллагаагаа явуулдаг. Энэ нэрээр бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж байна. Компанийн хөгжлийн явцад брэндийн нэрийг өөрчлөх, шинэ нэр өгөх зэргийг судлан хэрэгжүүлнэ.

2. Брэндийн лого

Логоны тайлбар:

- LED бичиг: Гэрэлтүүлгийн суурь 3 өнгө
- Дэлхийг ногооноор дүрсэлсэн: Байгальд ээлтэй
- Гарын хэлбэр: Хамтын хүч
- Ерөнхий хэлбэр: Чийдэн

3. Брэндийн уриа үг

Өндөр технологид суурилсан чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх

Хаягжилт, савлагаа

Бүтээгдэхүүний борлуулалтад хамгийн чухал хэсэг нь хаягжилт, сав, баглаа боодлын асуудал байдаг. Одоогийн үйлдвэрлэлд хэрэглэж буй бүтээгдэхүүний хаягжилт, савлагааг үргэлжлүүлэн хэрэглэнэ.

Хаягжилт: Одоогийн байдлаар бид хаягжилтыг гар аргаар гүйцэтгэдэг бөгөөд үйлдвэрийн аргаар хийх төхөөрөмж худалдан авахаар төлөвлөсөн. Энэ нь хүний оролцоо багасгах, богино хугацаанд их бүтээгдэхүүний хаягжилт хийх давуу талтай.

Савлагаа: Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн болгоныг нэг бүрчлэн үйлдвэрийн лого, холбоо барих мэдээллийг агуулсан хайрцагт савладаг бөгөөд зарим бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд хялбар болгох үүднээс багцлан гадуур хайрцагт савладаг.

- Цаашид бүтээгдэхүүний хаягжилт, савлагааг хөгжүүлэн хэрэглэгчдэд хялбар, харагдах байдал, лангууны өрөлт хийхэд тохиромжтой байдал, тээвэрлэлт зөрөг нөлөөлөх хүчин зүйлийг харгалзан үзэж сайжруулан ажиллана.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КАМ01070 4395772

Үнийн бодлого

Өртөгт суурилсан үнийн бодлого баримтална. Чанар ижил бүтээгдэхүүний хувьд зах зээлийн үнээс хямд үнэтэй байна.

Бид бүтээгдэхүүний үнийн хувьд өртөгт суурилсан аргаар үнэ тогтоон, борлуулна. Гэрэл үйлдвэрлэлийн ихэнх түүхий эдийг БНХАУ-аас импортлон оруулж ирдэг тул валютын ханшийн өсөлт ихээхэн нөлөө үзүүлдэг. Дээрх нөлөөллийг багасгах боломжийг судлан хэрэгжүүлснээр үнийг тогтвортой байлгах, боломжтой бүтээгдэхүүний үнийг бууруулах хүртэл ажиллана.

Хуваарилалтын сувгийн бодлого

Худалдан авагчдад бүтээгдэхүүнээ илүү ойрхон байлгах, эргэх холбоог сайжруулахыг эрмэлзэнэ. Түгээлтийн сувгийг нэмэгдүүлнэ.

Бүтээгдэхүүнээ аль болох худалдан авагчдад ойр байлгах нь борлогдох магадлалыг өндөр болгодог. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг агуулахад хадгалснаас лангуун дээр гарган тавьж улмаар идэвхжүүлэлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхдээ зорилтот зах зээлээс хамааруулан:

- Орхон аймаг
- Улаанбаатар хот гэж хуваан төлөвлөв.

Орхон аймагт хэрэгжүүлж буй ажиллагааг туршин амжилттай болбол Улаанбаатар хотод хэрэгжүүлэх замаар ажиллана.

Хүснэгт 22. Орхон аймагт түгээлтийн сувгийг нэмэгдүүлэх

Одоогийн ажиллаж буй 2 нэрийн цэгийг үргэлжлүүлэх	Орхон аймгийн 100 айл төв, Стандарт төвүүд дээрх нэрийн барааны дэлгүүрүүдийг тогтмол ажиллуулах, хаягжилтыг нэмэгдүүлэх
Гэрлийн хүргэлттэй үйлчилгээг нэвтрүүлэх	Орхон аймагт "Эрдэнэт LED" гэрэл худалдан авах хүсэлтэй иргэдэд хүргэлт хийх борлуулах үйлчилгээг нэвтрүүлэх. Дуудлага хүлээн авах утас ашиглана.
Дуудлагаар засвар, үйлчилгээг хийх	Хүргэлтийн дуудлага хүлээн авах утсыг ашиглан худалдан авсан гэрлэнд дуудлагаар засварлах үйлчилгээг хийнэ.
Байрны гадаах дэлгүүрүүдэд бүтээгдэхүүнээ байршуулах	Орхон аймгийн байрнууд, гэр хорооллын дундах томоохон дэлгүүрүүдэд жижиглэнгийн бүтээгдэхүүнээ гэрээ хийн байршуулна. Өрхийн хэрэглэгчид ихэвчлэн байрны гаднах дэлгүүрээс ахуйн хэрэглээний бүтээгдэхүүнээ авдаг.
Сүлжээ дэлгүүрүүдэд бүтээгдэхүүнээ байршуулах	Орхон аймагт үйл ажиллагаа явуулдаг Номин, Миний дэлгүүр болон бусад сүлжээ дэлгүүрүүдэд гэрээ байгуулан бүтээгдэхүүнээ нийлүүлнэ.
Барилгын материалын дэлгүүрүүдийн лангуун дээр байршуулах	Барилгын материал худалддаг дэлгүүр, лангуунуудад гэрээ байгуулан бүтээгдэхүүнээ байршуулна.
Өөрийн нэрийн барааны цэгийг ажиллуулах	Өөрийн үйлдвэрийн байранд тусгай тохижуулалт хийн "Эрдэнэт LED" нэрийн барааны дэлгүүрийг ажиллуулна.

СӨХ он сар өдөр БҮРТГЭВ
АНД-ЭНЕРГИ ХХК
58-I "АНД-ЭНЕРГИ" ХХК
2087103 ПЮН0230

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01
ЗУРГАА. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хүснэгт 23. Улаанбаатар хотод түгээлтийн сувгийг нэмэгдүүлэх

Нэрийн барааны дэлгүүр олноор байгуулах	"Эрдэнэт LED" брэндийн нэрийн цэгийг Улаанбаатар хотын барилгын материалын захуудад байгуулна. 2017 ондоо Зуун айл зах болон Hermes худалдааны төвүүдэд байгуулахаар төлөвлөж байна. Цаашид зөвхөн барилгын материалын зах гэлтгүй бусад захуудад нэрийн цэгийг нэмэгдүүлэн ажиллана.
Байрны гадаах дэлгүүрүүдэд бүтээгдэхүүнээ байршуулах	Улаанбаатар хотын томоохон хороолууд, гэр хорооллын дундах томоохон дэлгүүрүүдэд жижиглэнгийн бүтээгдэхүүнээ гэрээ хийн байршуулна. Өрхийн хэрэглэгчид ихэвчлэн байрны гаднах дэлгүүрээс ахуйн хэрэглээний бүтээгдэхүүнээ авдаг.
Барилгын материалын дэлгүүрүүдийн лангуун дээр байршуулах	Барилгын материал худалддаг дэлгүүр, лангуунуудад гэрээ байгуулан бүтээгдэхүүнээ байршуулна.
Сүлжээ супермаркетуудад бүтээгдэхүүнээ байршуулах	Сүлжээ дэлгүүрүүдэд гэрээ байгуулан бүтээгдэхүүнээ нийлүүлнэ. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг Номин, Оргил, Миний дэлгүүр, Боса, Сансар, Макс зэрэг дэлгүүрүүд байна.
Гэрлийн хүргэлт, дуудлагын засвар үйлчилгээг нэвтрүүлэх	Орхон аймагт хэрэгжүүлэн амжилттай болвол Улаанбаатар хотод хэрэгжүүлэн ажиллана.

Идэвхжүүлэлтийн бодлого

Бүтээгдэхүүний давуу талыг харуулсан идэвхжүүлэлтийн үйл ажиллагааг зорилтот хэрэглэгчдийн бүлэгт тохируулан хэрэгжүүлнэ.

Идэвхжүүлэлтийн хувьд дараах зарчмыг баримтлан ажиллана.

1. Хэрэглэгчийн зан төлөв
2. Идэвхжүүлэлтийн арга хэрэгслийг тодорхойлох
3. Мэдээллийн сувгийн сонголт

Хэрэглэгчийн зан төлөв

Бараа, үйлчилгээ нь тухайн хүний хэрэгцээ, амьдралын хэв маягт хэр зэрэг таарч тохирч байгаагаас шалтгаалаад худалдаж авна, эсвэл худалдаж авахгүй. Худалдагч хичнээн хүчин чармайлт гаргалаа ч худалдан авагч бараа бүтээгдэхүүнийг нь авахгүй байж болно. Иймд хэрэглэгчийн зан төлвийг судлан идэвхжүүлэлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй.

Бид өөрийн үйлдвэрлэх бүтээгдэхүүний онцлогт тохируулан хэрэглэгчийн зан төлвийг тодорхойлбол:

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА/301070 4385772

2087103 ПҮЭН0230

Хүснэгт 24. Идэвхжүүлэлтийн арга хэрэгслийг тодорхойлох

Бүтээгдэхүүн	Хэрэглэгчийн зан төлөв	Идэвхжүүлэлтийн зорилго, хүргэх мэдээлэл
LED гэрэл үйлдвэрлэх	LED технологийн талаар мэдээлэл багатай	• Байгаль орчинд ээлтэй • Чанартай бүтээгдэхүүн • Удаан хэрэглэгдэх
Монголд үйлдвэрлэсэн	Үндэсний үйлдвэрлэлээ дэмжих	• Монголд үйлдвэрлэсэн гэрэл • Баталгаат хугацаа, засвар үйлчилгээ
Бүтээгдэхүүний үнэ	Өндөр үнэтэй бүтээгдэхүүн чанартай байдаг	Өрсөлдөх бүтээгдэхүүнээс өндөр чанартай, чанар ижил бүтээгдэхүүнээс үнэ хямд
Нийт зах зээлд танигдсан байдал	Худалдан авалт хийн хэрэглэж байгаа	Эхний худалдан авалтыг хийлгэн чанарыг мэдрүүлэх

Бид идэвхжүүлэлтийн дараах арга хэрэгслийг сонгохоор төлөвлөж байна. Үүнд:

1. Биечилсэн борлуулалт

Биечилсэн борлуулалт нь хэрэглэгчийн сонголтонд нөлөөлөх, тэднийг ятгах, худалдан авалт хийлгэх хүчтэй арга хэрэгсэл юм. Хоёр талын нүүр тулан уулзах харилцаанд тулгуурладаг.

2. Зар сурталчилгаа

Бүтээгдэхүүний онцлог, давуу талыг харуулсан утга бүхий реклам, сурталчилгааг хийнэ. Энэ нь хэдий зардал өндөртэй боловч богино хугацаанд олон хүмүүст хүрэх, газарзүйн хувьд алслагдмал, тархай бутархай зах зээлд хүрэх боломжийг олгодог. Хүмүүс зар сурталчилгааг нь үзэж сонссон бүтээгдэхүүнд илүү итгэлтэй байдаг.

3. Олон нийтийн харилцаа

"Эрдэнэт лед" гэрлийн үйлдвэрийн үйл ажиллагааг харуулсан мэдээг бэлтгэн олон нийтэд таниулах байдлаар ажиллана. Энэ арга нь зар сурталчилгааг бодвол харьцангуй зардал багатай, бүтээгдэхүүний талаарх мэдээллийг дэлгэрэнгүй өгөх давуу талтай.

Дээрх идэвхжүүлэлтийн арга хэрэгслийг ашиглан мэдээлэл өгөхдөө дараах 3 бодлогыг баримтлан ажиллана.

Мэдээлэл өгөх	✦ Бүтээгдэхүүний хийц, загвар, ур чадвар, удаан эдэлгээний талаар мэдээлэл өгөх ✦ Зах зээлд шинэ бүтээгдэхүүний тухай түүний давуу тал болоод онцлог талыг харуулсан мэдээлэл болон бусад өрсөлдөгч бүтээгдэхүүний харьцуулалтыг мэдээлэл хэлбэрээр хүргэх ✦ Бүтээгдэхүүний шинэ нэр төрлийг танилцуулах

Мэдээллийн сувгийн сонголт хийх зарчим

Мэдээллийн сувгийн сонголт хийхдээ дараах хэрэгслүүдээс давуу болон сул талыг судлан сонгоно. Үүнд:

СӨХ
он сар өдөр
БҮРТГЭВ
ЗУРГАА БИЗНЕСИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
№ 01

Хүснэгт 25. Мэдээллийн сувгийн давуу болон сул тал

№	Сурталчилгааны хэрэгсэл	Давуу тал	Сул тал
1	Интернет	Сүүлийн үед мэдээллийн хэрэгслийн хамгийн том сүлжээ болсон. Богино хугацаанд мэдээллийг хүргэнэ.	Олон нийтээс сөрөг мэдээлэл хурдан хүрэх
2	Гудамжны самбар	Дүрс, дуу, хөдөлгөөний хослолыг таниулах	Зардал өндөр
3	Сонин	Уян хатан байдал, цаг үеэ олсон байдал, орон нутгийн зах зээлийг бүрэн хамрах байдал, хүлээн авах, хүлээн зөвшөөрөх өргөн боломж, үнэн магадлалтай байх	Богино хугацаанд оршин тогтнох, чанар муутай, дахин уншигчид нь цөөн.
4	Телевиз	Дүрс дуу хөдөлгөөний хослолыг таниулах, анхаарал татах өндөр зэрэглэлтэй, хамрах хүрээ нь өргөн	Өндөр үнэ их ачаалалтай, хүмүүст харилцагчаа сонгох боломж их муу, түрхэн зуур өнгөрчихдөг.
5	Шууд маркетинг	Хүмүүст сонгох боломжийг олгодог, уян хатан, өрсөлдөгчийн сурталчилгаа байхгүй, хувийн шинж чанартай.	Харьцангуй өндөр үнэтэй, хэрэгцээ багатай цаас болдог.
6	ФМ, радио	Олон нийтэд хүртээмжтэй, хүн ам зүйн хувьд сонгон хэрэглэх боломжтой, үнэ хямд байж болох талтай.	Зөвхөн дуу авиагаар түгээх, анхаарал татах нь телевизээс бага, түргэн хугацаанд өнгөрчихдөг.
7	Сэтгүүл	Газар зүй хүн ам зүйн хувьд сонгон хэрэглэх боломж өндөр, үнэн бодитой, нэр хүндтэй, хэвлэлийн өндөр чанартайгаас гадна удаан хугацаагаар оршин тогтнодог.	Сурталчилгааны хэрэгслийг худалдан авах сурталчилгаа гарахын хооронд цаг хугацааны ихээхэн тасалдаатай. Хэрэггүй дугаар гардаг. Хамгийн ашигтай гэсэн орон зайд реклам байрлана гэсэн баталгаагүй.

6.3. Бизнесийг өргөжүүлэх боломж

Бидний эрхэлж буй LED гэрлийн бизнес нь дэлхийн хэмжээнд өндөр хөгжсөн. LED технологийг ашиглан зөвхөн ахуйн хэрэглээний LED гэрэл үйлдвэрлэхээс гадна олон төрлийн хэрэглээнд ашиглах боломжтой юм. Дэлхийн хэмжээнд LED технологийг ашиглан ахуйн хэрэглээний LED гэрэл, телевизор, гар утас, компьютер, автомашины гэрэл зэрэг дэлхийн өндөр технологи, үйлдвэрлэлд хэрэглэж байна.

Гэрлийн хэрэглээний онцлогоос хамааран гэрлийн хэлбэр, LED-ийн төрөл хийцээс хамааралаад хэрэглэгдэх зориулалт нь өөр өөр байна. LED гэрлийг ашиглан явган хүний замын гэрлэн дохио, гар чийдэн, машины жижиг гэрлүүд, камерийн ламп, чимэглэлийн

ОРХОН АЙМАГ
АНДЭЭГЧ
ХХК
КАМ01070 4385772

2087103
ПҮОН0230

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ

зэрэг төрөл бүрийн гэрлүүдийг LED аргаар үйлдвэрлэж байна. Мөн ахуйн хэрэглээний цахилгаан бараа, тухайлбал, гар утас, notebook, iPOD, электрон тоглоомонд LED гэрэлтүүлгийг өргөнөөр ашиглах болжээ.

Эдгээр бүтээгдэхүүнүүд нь дэлхийн хүмүүсийн чухал хэрэглээний бүтээгдэхүүн болсон тодийгүй цаашид ч улам хөгжин тэлсээр байна. Манай улсын зах зээлд ч өргөн хэрэглэдэг бүтээгдэхүүнүүд болсон. Ялангуяа гар утас, компьютер, хувийн автомашины хэрэглээ ихээр нэмэгдсэн. Тухайлбал, Монгол улсад 2016 оны жилийн эцсийн байдлаар нийт 841,552 ширхэг тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн байдгаас 90 гаруй хувийг автомашин эзэлдэг[8]. Нэг автомашинд 4 том жижиг гэрэл байдаг гэж үзвэл 3 сая орчим ширхэг гэрлийн хэрэглээний эрэлт хэрэгцээ байгаа нь ахуйн хэрэглээний LED гэрлийн зах зээлтэй ойролцоо байгаа юм. Автомашины гэрлээс гадна гар утас, компьютер болон бусад дээр дурдагдсан бүтээгдэхүүнүүдэд зах зээлийн эрэлт байгаа. Хэдий хэрэглээ өндөр байгаа ч энэхүү зах зээлийг импортын бүтээгдэхүүнээр хангадаг.

Иймд бид Монгол улсад LED гэрлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэн бизнесээ өргөжүүлснээр импортын бараатай өрсөлдөж, зах зээлд өөрийн байр сууриа бэхжүүлэн ажиллахад маш том зах зээл байгааг илтгэж байна. Мөн LED гэрлийн үйлдвэрлэлийг дагасан суурилуулалт, засвар, үйлчилгээний бизнесийг хөгжүүлэх бүрэн боломжтой байна.

[8] *Зам, Тээвэр Хөгжлийн Яам, 2017 оны 02 дугаар сарын 08-ны мэдээ*

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА#01070 4335772

2087103
ПЮН0230

СЭХ
ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
БҮРТГЭВ
№ 01

ДОЛОО. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД

Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-д зааснаар компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно. Мөн хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2-д зааснаар компани өөрийн онцлогтоо тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрэмдээ зааж болно.

Анд-Энерги компанийн хувьд Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-д заасан дараах эрх бүхий албан тушаалтнууд ажиллаж байна.

7.1. Төлөөлөн удирдах зөвлөл

Компанийн дүрэмд зааснаар ТУЗ нь 9 гишүүнтэй, тэдгээрийн 3 нь хараат бус гишүүн байх ёстой. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 03 дугаар сарын 29-ний өдрийнээлжит бус хурлын 02 тоот тогтоолоор ТУЗ-ийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, ТУЗ-ийн 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 01 тоот тогтоолоор ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарыг томилон ажиллуулж байна.

ТУЗ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Компанийн жил бүрийн бизнес төлөвлөгөө, их хэмжээний хэлцлийг батлах;
- Компанийн үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн дүрэм, журмыг батлах;
- ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас зөвшөөрсөн хэмжээнд багтаан тогтоох;
- Компанийн охин, хараат компани, салбар, төлөөлөгчийн газрыг байгуулах болон тэдгээрийг өөрчлөн байгуулах шийдвэр гаргах, дүрмийг батлах, тэдгээрийн ТУЗ-ийн гишүүдийг томилох, гүйцэтгэх захирлыг томилж, түүний эрх хэмжээг тогтоох;
- Компанийн охин, хараат компанийн хувьцааг нэмж гаргах, түүний тоог тогтоох, ногдол ашгийн хэмжээг тогтоож, төлөх журмыг батлах;
- Компанийн охин, хараат компанийн үйл ажиллагаанд хувьцаа эзэмшигчийг төлөөлж оролцох, хувьцаа эзэмшигчийн нэрийн өмнөөс шийдвэр гаргах;
- Компанийн тухай хуулийн 6 дугаар бүлэгт заасан журмын дагуу ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлж хуваарилах.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КАЛ01070 4385772

2007103
ПЮН0230

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга:

1. ТУЗ-ийн дарга Төмөрбатын Барс,
2. ТУЗ-ийн гишүүн Цэнд-Аюушийн Гүррагчаа,
3. ТУЗ-ийн гишүүн Далхаагийн Мөнхбаяр,
4. ТУЗ-ийн гишүүн Ганхуягийн Түвшин,
5. ТУЗ-ийн гишүүн Лувсангийн Итгэлт,
6. ТУЗ-ийн гишүүн Манханы Отгонбаатар,
7. ТУЗ-ийн хараат бус гишүүн Дагвапунцагийн Алтангэрэл,
8. ТУЗ-ийн хараат бус гишүүн Хүрэлцоожийн Баярсайхан,
9. ТУЗ-ийн хараат бус гишүүн Мөнхжаргалын Ганбат,
10. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Баянмандалын Пүрэвдолгор.

Төмөрбатын Барс

Т.Барс нь 1979 онд төрсөн. ШУТИС-ийг “Уул уурхайн цахилгаан, механик тоног төхөөрөмж” мэргэжлээр “Уул уурхайн инженерийн бакалавр” зэрэгтэйгээр 2001 онд төгссөн. Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрт 2001-2003 онд цахилгаанчин, 2003-2011 онд тохируулгын инженер, 2011 оноос одоог хүртэл ахлах инженерээр тус тус ажиллаж байна. Анд-Энерги ХХК-ийг үүсгэн байгуулагчдын нэг бөгөөд 2011-2016 онд Компанийн Гүйцэтгэх захирал, 2017 оны 04 сараас Компанийн ТУЗ-ийн даргаар тус тус сонгогдон ажиллаж байна. ОХУ, ХБНГУ, Иран улсад мэргэжил дээшлүүлсэн бөгөөд 2015 оноос ШУТИС-ийн магистрантурт суралцаж байна.

Цэнд-Аюушийн Гүррагчаа

Ц.Гүррагчаа 1981 онд төрсөн. ШУТИС-ийг 2001 онд “Уул уурхайн цахилгаан, механик тоног төхөөрөмж” мэргэжлээр “Уул уурхайн инженерийн бакалавр” зэрэгтэйгээр, 2010 онд “Уул уурхайн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт” мэргэжлээр “Техникийн ухааны магистр” зэрэгтэйгээр тус тус төгссөн. Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрт 2002-2005 онд цахилгаанчин, 2005-2009 онд тохируулгын инженер, 2009-2012 онд ахлах инженер, 2012-2016 онд цахилгаан механикаар ажилласан. Анд-Энерги ХХК-ийг үүсгэн байгуулагчдын нэг бөгөөд 2014-2016 онд Анд-Энерги ХХК-ийн Ерөнхий инженер, 2017 оноос Гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байна. Орос, англи хэлтэй. 2005 онд ОХУ-ын Свердловск хотын их сургуульд, 2010 онд Сингапурт тус тус мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан.

Далхаагийн Мөнхбаяр

Д.Мөнхбаяр 1976 онд төрсөн. 2003 онд Орхон аймаг дахь Технологийн сургуулийг цахилгаанчин, 2014 онд ШУТИС-ийг “Авто машин ашиглалт, авто аж ахуй” мэргэжлээр “Механик инженерийн бакалавр” зэрэгтэйгээр төгссөн. Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрт 2003 оноос хойш нийт 14 жил цахилгаанчин, цахилгааны инженерээр ажиллаж байна. Цахилгаан тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ мэргэжлээр мэргэшлийн 5 дугаар зэрэгтэй. Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч бөгөөд одоо ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.

АНД ЭНЕРГИ ХХК
64 | "АНД-ЭНЕРГИ" ХХК
ҚА1001070_4385772

Баянхонгор аймаг
Баянбулаг сум
Эрдэнэт Алтай
2007103
ПЮН0230

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01
ДОЛОО. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД

Ганхуягийн Түвшин

Г.Түвшин 1983 онд төрсөн. МУИС-ийг 2005 онд "Электроник" мэргэжлээр "Инженерийн бакалавр" зэрэгтэйгээр төгссөн. Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрт 2005-2009 онд цахилгаанчин, 2009 оноос хойш одоог хүртэл автоматикийн инженерээр ажиллаж байна. ОХУ, БНХАУ-д мэргэжил дээшлүүлсэн. Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч бөгөөд одоо ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.

Лувсангийн Итгэлт

Л.Итгэлт 1971 онд төрсөн. 1991 онд Санхүү эдийн засгийн техникумыг "ХАА-н ня-бо эдийн засагч" мэргэжлээр, 1998 онд СЭЗДС-ийг "Банк санхүүч" мэргэжлээр бакалавр зэрэгтэйгээр тус тус төгссөн. 1991-2003 онд "Алтан сан" Брокер дилерийн компанид дилер, гүйцэтгэх захирлаар, 2003 оноос "Батс ҮЦК" ХХК-д арилжаа эрхэлсэн захирлаар, 2017 оноос Анд-Энерги ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр тус тус ажиллаж байна. Монгол Улсын хөрөнгийн зах зээл дээр тасралтгүй 26 жил ажилласан туршлагатай.

Манханы Отгонбаатар

М.Отгонбаатар 1971 онд төрсөн. СЭЗДС-ийг 1999 онд "Эдийн засагч, бизнес судлаач" мэргэжлээр төгссөн. 1991-1995 онд "Шилийн богд" брокер дилерийн компанид дилерээр, 1995-1998 онд Монсек ХХК-д дилерээр, 1998-2017 онд "Монсек ҮЦК" ХХК-ийн гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байна. Монгол Улсын хөрөнгийн зах зээл дээр тасралтгүй 26 жил ажилласан туршлагатай. 2017 оноос Анд-Энерги ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.

Дагвапунцагийн Алтангэрэл

Д.Алтангэрэл 1970 онд төрсөн. ШУТИС-ийг 1993 онд "Уулын цахилгаан механик" мэргэжлээр төгсөөд уулын байжуулах Эрдэнэт үйлдвэрт инженерээр 9 жил ажилласан. 2005 оноос АЦХ ХХК-ийн захирлаар, 2017 оноос Анд-Энерги ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр тус тус ажиллаж байна.

Хүрэлдоржийн Баярсайхан

Х.Баярсайхан 1979 онд төрсөн. ОХУ-ын Санкт Петербургийн их сургуулийг 2003 онд "Үйлдвэрлэлийн менежмент" мэргэжлээр төгссөнөөс хойш уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрт 12 жил эдийн засагчаар, 2017 оноос Анд-Энерги ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр тус тус ажиллаж байна.

Мөнхжаргалын Ганбат

М.Ганбат 1982 онд төрсөн. Олон улсын эдийн засаг бизнесийн дээд сургуулийг 2002 онд "Олон улсын эдийн засагч" мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн. 2008-2012 онд Орхон аймаг дахь "Хөгжлийн шийдэл" төрийн бус байгууллагад бизнес зөвлөх, 2012 оноос өнөөдрийг хүртэл Орхон аймаг дахь Худалдаа аж үйлдвэрийн танхимын даргаар, 2017 оноос Анд-Энерги ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр тус тус ажиллаж байна.

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.8-д заасан шаардлагын дагуу ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон ТУЗ-ийн гишүүд (М.Ганбатаас бусад) 2017 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Компанийн засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан болно.

ОРХОН
АНД-ЭНЕРГИ
ХХК
КАМ01070 4385772
2687103
ПКОН0230

7.2. Эрх бүхий албан тушаалтан

Компанийн эрх бүхий албан тушаалтнаар дараах нэр бүхий хүмүүс ажиллаж байна. Үүнд:

1.Гүйцэтгэх захирал Цэнд-Аюушийн Гүррагчаа,

2.Үйлдвэрийн мастер Баттулгын Амараа,

3.Менежер Баянмандалын Пүрэвдолгор,

4.Хүний нөөцийн менежер Батцэрэнгийн Тогос-Эрдэнэ,

5.Нягтлан бодогч Чулуунбатын Мөнхсаруул.

Баттулгын Амараа

Б.Амараа 1993 онд төрсөн. Орхон аймаг дахь Технологийн сургуулийг 2015 онд "Цахилгаан системийн автоматжуулалт" мэргэжлээр төгсөөд 2015 оноос Анд-Энерги ХХК-д цахилгаанчин, цахилгааны инженер, үйлдвэрийн мастераар ажиллаж байна.

Баянмандалын Пүрэвдолгор

Б.Пүрэвдолгор 1992 онд төрсөн. Хүмүүнлэгийн ухааны их сургуулийг 2014 онд "Компьютерийн техник хангамж сүлжээний инженер" мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгсөөд 2015 оноос Анд-Энерги ХХК-д менежерээр ажиллаж байна. 2017 оны 04 сараас Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын ажил үүргийг хавсран гүйцэтгэж байна.

Батцэрэнгийн Тогос-Эрдэнэ

Б.Тогос-Эрдэнэ 1987 онд төрсөн. 2008 онд Улаанбаатар хот дахь Газарчин дээд сургуулийг "Олон улсын аялал жуулчлалын менежер" мэргэжлээр, 2009 онд МУИС-ийг "Англи хэлний орчуулагч" мэргэжлээр тус тус бакалаврын зэрэгтэй төгссөн. 2010-2016 онд Эйр транс ХХК-д захиалга хүлээн авагчаар ажиллаж байгаад 2016 оноос Анд-Энерги ХХК-д хүний нөөцийн менежерээр ажиллаж байна. Одоо ШУТИС-ийн Бизнесийн ахисан түвшний сургуульд "Хүний нөөцийн менежмент" мэргэжлээр магистрантурт суралцаж байна.

Чулуунбатын Мөнхсаруул

Ч.Мөнхсаруул 1986 онд төрсөн. Улаанбаатар хот дахь Сутай дээд сургуулийг 2008 онд "Нягтлан бодогч" мэргэжлээр төгсөөд АЦХ ХХК-нд 9 жил мэргэжлээрээ ажилласан. Анд-Энерги ХХК-д 2015 оноос нягтлан бодогчоор ажиллаж байна.

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

НАЙМ. НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ХЯНАЛТЫН БАГЦ ЭЗЭМШИГЧ

2017 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар Компанийн нийт хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшдэг дараах нөлөө бүхий хувьцаа эзэмшигчтэй. Үүнд:

1. Төмөрбатын Барс - 25.0 хувь буюу 12,881,675 ширхэг,
2. Цэнд-Аюушийн Гүррагчаа - 25.0 хувь буюу 12,881,675 ширхэг,
3. Далхаагийн Мөнхбаяр - 25.0 хувь буюу 12,881,675 ширхэг,
4. Ганхуягийн Түвшин - 25.0 хувь буюу 12,881,675 ширхэг.

2015 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн "Хувьцаа худалдах худалдан авах гэрээ"-ний дагуу Х.Баярсайханы эзэмшлийн Анд-Энерги ХХК-ийн 100 ширхэг хувьцааг Д.Мөнхбаяр, Я.Мягмарсүрэнгийн эзэмшлийн Анд-Энерги ХХК-ийн 100 ширхэг хувьцааг Г.Түвшин нар тус тус худалдан авч Компанийн нийт хувьцааны тус бүр 25.0 хувийг эзэмшсэн.

Одоогоор хяналтын багц буюу нийт хувьцааны гуравны нэгээс дээш хувийг эзэмшигч байхгүй. Хувьцаа эзэмшигчдийн хооронд хийгдсэн нэмэлт гэрээ байхгүй.

Компани Бирж дээр үнэт цаасыг нийтэд санал болгон Үнэт цаасны танилцуулгад тусгасан 26,544,058 ширхэг хувьцааг зах зээлд нэмж гаргаснаар Компанийн нийт энгийн хувьцааны тоо 78,070,758 ширхэг болох бөгөөд одоогийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн хувь хэмжээ 66.0 хувь болж буурна.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

ЕС. ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

Хувьцаагаа нийтэд санал болгох хүртэл Компани нэг бүр нь 1 (нэг) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 51,526,700 ширхэг хувьцаа, 51,526,700 төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.

Хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит бус хурлын 01 тоот тогтоолоор Компанийн зарласан хувьцааны тоог 100,000,000 ширхэг болгон нэмэгдүүлсэн бөгөөд хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит бус хурлын 03 тоот тогтоолоор зарласан хувьцаанаас 26,544,058 ширхэг хувьцааг эргэлтэд гарган нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн юм.

Компани одоогоор хувьцаатай хамааралтай өөр төрлийн үнэт цаас гаргаагүй бөгөөд нийтэд хувьцаагаа санал болгон амжилттай арилжаалсан тохиолдолд хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн, эзэмшлийн хувь хэмжээ дараах байдлаар өөрчлөгдөнө (Хүснэгт 26).

Хүснэгт 26. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, эзэмшлийн хувь хэмжээ

Хувьцааны тоо	Хувьцааны эзэмшил	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Эзэмшлийн хувь хэмжээ
51,526,700	Одоогийн хувьцаа эзэмшигчид	51,526,700	66.00
26,544,058	Олон нийтийн эзэмшилд	26,544,058	34.00
78,070,758	Бүгд	78,070,758	100.00

Биржийн Бүртгэлийн журмын 5 дугаар бүлгийн 5.12(1)(а)-д заасны дагуу Биржид бүртгүүлсний дараа Компанийн нийт гаргасан үнэт цаасны 25-аас доошгүй хувийг олон нийт эзэмшсэн байх ёстой.

Дээрх шалгуурыг хангах зорилгоор бид нийт хувьцааны 34.0 хувийг нийтэд санал болгож байгаа бөгөөд цаашид Биржид бүртгэлтэй байх хугацаандаа Бүртгэлийн журмын шаардлагын дагуу нийт хувьцааны 25-аас доошгүй хувийг нийтэд эзэмшүүлэх үүргээ тогтмол хэрэгжүүлэн ажиллах болно.

Хүснэгт 26-д харуулснаар Компани анхдагч зах зээлд 26,544,058 ширхэг хувьцааг нийтэд санал болгон анхдагч зах зээлд бүх хувьцаагаа амжилттай борлуулсан тохиолдолд Компани нийт 1,592,643,480 төгрөгийн эх үүсвэр татах боломж бүрдэх юм.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
68 |-"АНД-ЭНЕРГИ" ХХК
КА#001070 4385772

Бумбат Алтай
2097103
ПЮН0230

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
БҮРТГЭВ

АРАВ. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

Төсөвлөсөн санхүүгийн мэдээллийг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх нь таамаглал, тооцоолол хийхийг шаарддаг бөгөөд энэхүү таамаглал, тооцооллууд нь Компанийн санхүүгийн тайлагналд мөрддөг бодлого, аудитлагдсан сүүлийн санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөр, эзэмшигчдийн өмч зэрэг үзүүлэлтүүдэд суурилан бэлтгэгдсэн. Ирээдүйд гарах бодит үр дүн нь энэхүү Үнэт цаасны танилцуулга дахь тооцооллоос зөрүүтэй байж болно.

Санхүүгийн мэдээлэлд тусгагдсан үзүүлэлтүүд нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр илэрхийлэгдсэн бөгөөд тухайн санхүүгийн үзүүлэлтэд тусгайлан заагаагүй бол бүх үзүүлэлтүүдийг сая төгрөгөөр тоймчлон илэрхийлсэн болно.

10.1. Санхүүгийн тайлангийн хураангуй

Үнэт цаасны танилцуулгын "Хавсралт 2. Мэргэшсэн нягтлан бодогчийн дүгнэлт"-д хамаарах хугацааны Орлогын дэлгэрэнгүй тайлан болон Санхүү байдлын тайлангийн хураангуйг дараах хүснэгтүүдэд харууллаа.

Сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүйг үнэт цаасны танилцуулгын "Хавсралт 2. Мэргэшсэн нягтлан бодогчийн дүгнэлт" болон "Хавсралт 3. Аудитлагдсан санхүүгийн тайлан" хэсгүүдээс харж болно.

Хүснэгт 27. Орлогын дэлгэрэнгүй тайлангийн хураангуй (сая төгрөгөөр), 2014-2016 он

	2014	2015	2016
Борлуулалтын орлого (цэвэр)	120.09	597.99	682.42
Борлуулалтын өртөг	124.64	240.65	384.21
Нийт ашиг (алдагдал)	(4.55)	357.34	298.21
Хүүний орлого	0.07	0.35	0.62
Бусад орлого	0.07	-	-
Борлуулалт маркетингийн зардал	0.97	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	9.09	114.55	128.81
Санхүүгийн зардал	-	-	17.14
Бусад ашиг (алдагдал)	(2.19)	(4.17)	(107.01)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(16.66)	238.97	45.87
Орлогын татварын зардал	-	2.03	2.89
Татварын дараах ашиг (алдагдал)	(16.66)	236.94	42.98

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КАЛЛ01070 4385772

2087103
ПЮН0230

Хүснэгт 28. Санхүүгийн байдлын тайлангийн хураангуй (сая төгрөгөөр) - 2014-2016 он

	2014	2015	2016
Хөрөнгө			
Эргэлтийн хөрөнгө	39.23	342.35	260.02
Эргэлтийн бус хөрөнгө	116.58	115.33	268.15
Нийт хөрөнгийн дүн	155.81	457.68	528.17
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч			
Богино хугацаат өр төлбөр	34.80	40.94	26.30
Урт хугацаат өрийн дүн	69.27	167.69	162.53
Эзэмшигчдийн өмч	51.74	249.05	339.34
Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн	155.81	457.68	528.17

10.2. Үйл ажиллагаа, санхүүгийн нөхцөл байдалд нөлөөлөх хүчин зүйлс

Бидний үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн түүхэн мэдээлэл зэргээс харахад Компанийн бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц хэд хэдэн хүчин зүйлүүд байна. Үүнд:

Түүхий эд материал

LED гэрлийн үйлдвэрлэлийн үндсэн түүхий эдийн дийлэнх хэсгийг импортоор худалдан авдаг бөгөөд гэрээгээр захиалсан түүхий эд материал 7-30 хоногийн дотор ирдэг. Үйлдвэрлэлийг тасралтгүй явуулахын тулд тодорхой хэмжээний түүхий эд материал нөөцөлсөн байх шаардлагатай байдаг тул санхүүгийн тайланд эргэлтийн хөрөнгийн хэмжээ, тэр дундаа түүхий эд материалын үлдэгдэл их дүнтэй харагддаг.

Түүнчлэн PCB зэс хавтан, LED чип, тэжээлийн блок, хөнгөн цагаан гэр болон хуванцар таг зэрэг импортоор авдаг түүхий эдийн хувьд валютын ханшийн эрсдэлд өртөх магадлал их байдаг тул бид цаашдаа ханшийн эрсдэлийг хамгийн бага бөгөөд үйлдвэрлэлийг тасралтгүй жигд явуулахуйц хэмжээнд түүхий эд материалын байлгавал зохих доод хэмжээг тооцоолж ажиллахаар төлөвлөж байна.

Мөн дотооддоо үйлдвэрлэж болох түүхий эд материалыг төслийн хүрээнд өөрсдөө үйлдвэрлэхээр судалж байна. Түүхий эд материалын татан авалттай холбоотой үүсч болох эрсдэлийн тухай дэлгэрэнгүйг Үнэт цаасны танилцуулгын “Эрсдэлийн хүчин зүйл” бүлэгт тусгасан болно.

Үйлдвэрлэл

"Эрдэнэт лед" гэрлийн үйлдвэр нь өдөрт 30 гаруй нэр төрлийн 100-150 ширхэг LED гэрэлтүүлэг үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд гэрлийн үйлдвэрлэлээс олж буй орлого нь нийт орлогын 40-50 хувийг бүрдүүлдэг.

Цаашид үйлдвэрлэлийг өртгөтгөж, ажлын байрыг нэмэгдүүлснээр хоногт үйлдвэрлэх бүтээгдэхүүний гарц нэмэгдэхийн зэрэгцээ түүхий эдийн татан авалтын оновчтой бодлого хэрэгжүүлснээр материалын эргэлт сайжирч, үйлдвэрлэх боломжтой бүтээгдэхүүний хэмжээ 4 дахин нэмэгдэх боломжтой байна. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд боловсон хүчний мэргэшил, чадавх, удирдлагын зөв бодлого чухал нөлөөтэй юм.

Ажил үйлчилгээ

Анд-Энерги ХХК нь анх үүсгэн байгуулагдахдаа үйлдвэрийн автоматжуулалт, цахилгааны угсралт, суурилуулалтын чиглэлээр байгуулагдсан бөгөөд энэ чиглэлээр болон гудамж, зам талбайн, гоёлын гэрэлтүүлэг гэх мэт захиалгат ажлуудыг хийж гүйцэтгэдэг. Жилийн борлуулалтын орлогын 50-60 орчим хувийг ажил үйлчилгээний орлого бүрдүүлдэг хэдий ч бид цаашид гэрлийн үйлдвэрлэлд гол анхаарлаа хандуулж ажиллахаар төлөвлөж байна.

Үнэ ба өртөг

Гэрлийн үйлдвэрийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн нь чанарын хувьд өрсөлдөгч бүтээгдэхүүнүүдээс давуу талтай боловч зах зээлд борлуулах үнэ бусад ижил төрлийн бүтээгдэхүүнтэй харьцуулахад харьцангуй өндөр. Үндэсний үйлдвэрлэлийн, чанартай бүтээгдэхүүнийг илүү хямд үнээр хэрэглэгчдэд хүргэх боломжийн талаар судалж байгаа бөгөөд төслийн санхүүгийн тооцооллын хүрээнд ахуйн зориулалттай жижиг гэрлүүдийн үнийг тодорхой хэмжээнд буулгах боломжтой нь харагдсан. Өртгийн хувьд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг тооцох тогтсон аргачлалгүй, үйлдвэрлэлтэй холбогдон гарсан зардлуудыг борлуулалтын өртөгт хуримтлуулан бүртгэх байдлаар бүртгэл хөтөлж ирсэн бөгөөд цаашид мэргэшсэн нягтлан бодогчтой болж, үйлдвэрлэлийн өртөг тооцох системийг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Нягтлан бодох бүртгэлийн ажилтны мэргэшсэн байдлын талаар Монголын үнэт цаасны биржийн бүртгэлийн шалгууруар шаардсан болно.

Тоног төхөөрөмжийн ашиглалт

Одоогоор үйлдвэрлэлд нэг иж бүрдэл тоног төхөөрөмж ашиглаж байгаа бөгөөд эдгээр тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд үйлдвэрлэл шууд тасалдах магадлалтай юм. Иймд цаашид үйлдвэрлэл тасалдах эрсдэлээс сэргийлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн гарцыг нэмэгдүүлэхийн тулд дахин нэг шугам шинээр нэвтрүүлж, үйлдвэрлэлд ашиглахаар төлөвлөж байна.

Боловсон хүчин

Гэрлийн үйлдвэрлэлд туршлагатай мэргэжлийн боловсон хүчний оролцоо, бүтээмж маш чухал үүрэгтэй бөгөөд гар ажиллагаа ихтэй. Бэлэн бүтээгдэхүүн бий болгох технологийн ажилбарын 60-80 хувийг гар ажиллагаа бий болгож байдаг тул үйлдвэрийн удирдлага ажлын байран дээр дадлагажсан, туршлагатай боловсон хүчнийг тогтвортой ажиллуулах бодлого баримтлан ажиллах шаардлагатай байдаг.

10.3. Орлогын тайлангийн үзүүлэлтүүдийн тайлбар

Борлуулалтын орлого

Борлуулалтын орлого нь үйлдвэрлэсэн LED гэрлийн борлуулалтаас олсон орлого болон ажил үйлчилгээний орлогоос бүрдэнэ. Ажил үйлчилгээний орлого гэдэг нь манай компанийн дагалдах үйл ажиллагаа болох цахилгаан тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалт, үйлдвэрийн автоматжуулалт, цахилгаан, тоног төхөөрөмжийн шугамын сонголт, тооцооллын зөвлөх үйлчилгээ болон гудамж талбай, үйлдвэрлэлийн гэрэлтүүлгийн угсралт суурилуулалтын захиалгат болон тендерийн ажил үйлчилгээний орлого юм.

Хүснэгт 29. Борлуулалтын орлогын задаргаа (сая төгрөгөөр), 2014-2016 он

	2014	2015	2016
Бараа борлуулсны орлого	0.87	298.77	323.33
Ажил, үйлчилгээ борлуулсны орлого	119.22	299.22	359.12
Нийт борлуулалтын орлого	120.09	597.99	682.46
Борлуулалтын буцаалт, хөнгөлөлт, үнийн бууралт (-)	-	-	(0.03)
Цэвэр борлуулалт	120.09	597.99	682.43

Борлуулалтын өртөг

Үйлдвэрлэн борлуулсан LED гэрлэн бүтээгдэхүүний өртөг болон бусад үйлчилгээтэй холбогдолтой зардлуудыг борлуулалтын өртөгт дүнгээр нь шингээн бүртгэж ирсэн. Цаашид бид үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний нэр төрөл болон үзүүлсэн үйлчилгээний төрөл тус бүр дээр өртгийг тусад нь хуваарилан бүртгэж, нэгж бүтээгдэхүүний өртгийг тооцоолж ажиллахаар төлөвлөж байна.

Үйлдвэрлэн борлуулсан бүтээгдэхүүний өртөгт үндсэн болон туслах түүхий эд, материалын зардал, үйлдвэрийн ажилчдын цалин хөлс, хадгалалт, тээврийн зардал, сав баглаа боодол болон ашиглалтын зардлууд шингэж байгаа бөгөөд өртгийн дийлэнх хэсгийг түүхий эд материалын зардал бүрдүүлдэг.

Түүхий эд материал нь импортоос хамаардаг тул олон улсын тээвэр, гааль, татвар, валютын ханшийн эрсдэлд өртөх магадлалтай байдаг. Түүхий эд материалын эрсдэлийн талаар үнэт цаасны танилцуулгын "Эрсдэлийн хүчин зүйлс" бүлэгт тодорхой тусгасан болно.

Нийт ашиг (алдагдал)

Нийт ашиг (алдагдал) нь борлуулалтын орлогоос борлуулалтын өртгийг хассан дүн байна.

Хүүний орлого

Харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдэлд тооцсон болон бусдад олгосон зээл, урьдчилгаанд тооцоолсон бүх төрлийн хүүний орлого хамаарах бөгөөд Анд-Энерги ХХК-ийн хувьд харилцах дансны үлдэгдэлд тооцон банкнаас олгосон хүүний орлого нь санхүүгийн тайланд толилуулагдсан. Компани арилжааны банк болон бусад санхүүгийн байгууллагад бүх төрлийн хадгаламжийн дансгүй болно.

Хүүний орлогыг татвар суутгаагүй нийт дүнгээр нь толилуулна.

Борлуулалт, маркетингийн зардал

Борлуулалт болон маркетинг, сурталчилгааны үйл ажиллагаатай холбоотой гарсан зардлуудыг тусгана. Үүнд борлуулалтын болон маркетингийн ажилчдын цалин хөлс, түүнээс тооцсон ЭМНДШ-ийн зардал, тээвэр, томилолт, даатгал, бичиг хэрэг, шуудан холбооны зардал гэх мэтээр дэлгэрэнгүй тодруулж тайлагнана. Борлуулалт, маркетингийн зардлыг нийт дүнгээр нь толилуулах бөгөөд Анд-Энерги ХХК-ийн хувьд өнгөрсөн хугацаанд борлуулалт маркетингийн зардлыг ерөнхий ба удирдлагын зардлаас тусад нь толилуулаагүй болно.

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01
АРАВ-САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

Ерөнхий ба удирдлагын зардал

Үйлдвэрлэл болон борлуулалт, маркетингийн зардлаас бусад ерөнхий болон удирдлагын шинж чанартай зардлуудыг энэ хэсэгт тайлагнана. Үүнд: захиргааны ажилчдын цалин хөлс, удирдлагын зардал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, мэргэжлийн үйлчилгээний зардал, сургалт хөгжил, судалгаа хөгжүүлэлтийн зардлууд болон томилолт, бичиг хэрэг, шуудан холбоо, даатгал, ашиглалт, тээвэр, шатахуун тослох материал, түрээсийн зардал гэх мэт ерөнхий шинж чанартай зардлууд хамаарна. Ерөнхий ба удирдлагын зардлыг нийт дүнгээр нь толилуулна.

Хүснэгт 30. Ерөнхий ба удирдлагын зардлын задаргаа (сая төгрөгөөр), 2014-2016 он

	2014	2015	2016
Ажиллагчдын цалингийн зардал	-	36.82	47.12
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	-	4.77	5.83
Томилолтын зардал	0.19	33.49	30.73
Бичиг хэргийн зардал	-	0.45	-
Шуудан холбооны зардал	-	0.06	0.44
Мэргэжлийн үйлчилгээний зардал	3.61	-	-
Сургалтын зардал	0.22	-	-
Ашиглалтын зардал	-	0.03	1.09
Засварын зардал	-	0.03	2.08
Элэгдэл, хорогдлын зардал	-	7.49	0.92
Түрээсийн зардал	-	0.10	13.57
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	-	0.19	-
Тээврийн зардал	-	-	0.41
Шатахууны зардал	-	3.39	7.62
Хүлээн авалтын зардал	1.42	-	-
Зар сурталчилгааны зардал	0.28	1.78	0.74
Бусад	0.7	25.39	18.25
Нийт дүн	10.07	114.55	128.81

Санхүүгийн зардал

Бүх төрлийн хүүний зардал, зээлийн шимтгэл гэх мэт зээл авахтай холбоотой үүссэн бусад зардлуудыг санхүүгийн зардлаар тайлагнах бөгөөд Компанийн хувьд урт хугацаат 2 зээлтэй холбоотой хүүний зардлыг санхүүгийн зардлаар тайлагнасан болно.

Бусад ашиг (алдагдал)

Дээр тусгайлан толилуулснаас бусад ашиг (алдагдал)-ийг энэ хэсэгт хамааруулан тайлагнасан. Өөрөөр хэлбэл борлуулалт, маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардлын ангилалд ороогүй бусад зардлууд, тухайлбал, хандив, торгууль алдангийн зардал, найдваргүй авлагын зардал, зочин төлөөлөгчийн зардал зэрэг орно.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА01070 4385772

Татварын өмнөх ашиг

Нийт ашгийн дүн дээр түрээсийн орлого, хүүний орлого, эрхийн шимтгэлийн орлого, ногдол ашгийн орлого болон бусад орлогыг нэмж, түүнээс борлуулалт маркетингийн

2087103
ПЮН0230

зардал, ерөнхий ба удирдлагын зардал, санхүүгийн зардал, бусад зардлыг хасч, бусад олз гарз, ашиг алдагдлыг нэмж (хасч) татварын өмнөх ашгийг тодорхойлно.

Орлогын татварын зардал

Орлогын татварын зардал нь тайлант үеийн татварын зардал болон хойшлогдсон татварын зардал (орлого)-аас бүрдэнэ. Тайлант үеийн татварын зардал гэдэгт нийтлэг болон тусгай хувь хэмжээгээр ногдуулсан ААНОАТ-ын нийт дүн орно.

Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.1.8-д "байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд халгүй техник, тоног төхөөрөмжийг борлуулсан орлого"-ыг татвараас чөлөөлөхөөр заасан. Мөн хуулийн 18.4-д заасны дагуу Засгийн газрын 2013 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 303 тоот тогтоолоор "Байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд халгүй техник, тоног төхөөрөмжийн жагсаалт"-ыг баталсан бөгөөд уг жагсаалтад Анд-Энерги ХХК-ийн үйлдвэрлэн борлуулдаг бүтээгдэхүүн 8541.40.00 БТКУС кодтой "Эрчим хүчний хэмнэлттэй гэрлийн шил (light-emitting diode буюу LED-тай)" хэмээн орсон байна. Иймд Компанийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтын орлого татвараас чөлөөлөгддөг бөгөөд бусад ажил үйлчилгээнээс олсон орлогод орлогын албан татвар ногдуулан төлдөг.

Татварын дараах ашиг

Татвар төлөхийн өмнөх ашгаас орлогын татварын зардлыг хасч татварын дараах ашгийг тодорхойлно.

10.4. Үйл ажиллагааны үр дүн

2016, 2015 оны үйл ажиллагааны үр дүнгийн харьцуулалт

Борлуулалтын орлого

2016 оны санхүүгийн жилд манай цэвэр борлуулалтын орлого өмнөх оныхоос 14.1%-иар өссөн бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалт 8%, ажил үйлчилгээний орлого 20%-иар тус тус өссөн байна. Тайлант 2016 онд бид 323.3 сая төгрөгийн үнийн дүн бүхий 35 төрлийн 13,000 гаруй ширхэг бүтээгдэхүүн борлуулсан бол 9 удаагийн тендерийн ажилд үндсэн болон туслан гүйцэтгэгчээр оролцож, 359.12 сая төгрөгийн ажил үйлчилгээний борлуулалтын орлого олсон байна. Тухайлбал Орхон аймгийн хотын доторх гэрлэн чимэглэл, Орхон аймгийн Говил багийн 100 айлын гудамжны гэрэлтүүлэг, Булган аймгийн Бүрэгхангай сумын төвийн гэрэлтүүлэг, Төв аймгийн Заамар сум болон Тосон, Хайлааст багийн гэрэлтүүлгүүд, Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн агааржуулалтын станцын агаарын машины өдөөлтийн щит шинэчлэх ажил, Металл хайлах зуухны удирдлагын шкафны суурилуулалт зэрэг ажлуудыг дурдаж болно. Харин үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувьд жижиглэн худалдааны дэлгүүрүүдэд байршуулснаас гадна 40 орчим худалдан авагч аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан бүтээгдэхүүн нийлүүлсэн байна.

Борлуулалтын өртөг

Компани үйлдвэрлэн борлуулсан барааны өртгийг нэг бүрчлэн нарийн ангилж бүртгээгүй бөгөөд 2016 онд борлуулсан бүтээгдэхүүний өртөг өмнөх оныхоос 59.7

хувиар өссөн байна. 2015 онд борлуулалтын өртөг нийт дүнгээр 240.65 сая төгрөг байсан бол 2016 онд 384.21 сая болж нэмэгдсэн байна.

Нийт ашиг (алдагдал)

Тайлант жилд нийт ашгийн хэмжээ 298.21 сая төгрөг байсан нь өмнөх жилийн санхүүгийн тайлангаар толилуулсан нийт ашгаас 59.13 сая төгрөгөөр буурсан үзүүлэлт байлаа. Тайлант жилд борлуулалтын орлогын хэмжээ өмнөх оныхоос өссөн ч нийт ашгийн хэмжээ буурсан нь валютын ханшийн өсөлтийг дагаад үйлдвэрийн түүхий эд материалын үнэ, түүний тээвэрлэлтийн болон бусад зардлууд өсч, бүтээгдэхүүний өртөг нэмэгдсэнтэй холбоотой. 2015 оны борлуулалтад эзлэх өртгийн хувь 40.2% байсан бол 2016 онд 56.3% болж өссөн байна.

Хүүний орлого

Компани Худалдаа хөгжлийн банк болон Хаан банкинд төгрөгийн харилцах данстай бөгөөд эдгээр дансдын үлдэгдэлд 2015 онд 0.35 сая төгрөгийн хүү тооцогдож байсан бол 2016 онд 0.62 сая төгрөг болж нэмэгджээ.

Ерөнхий ба удирдлагын зардал

Ерөнхий ба удирдлагын зардал 2016 онд 128.81 сая төгрөг байсан нь өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 12.4%-иар өссөн үзүүлэлттэй байна. Тэр дундаа борлуулалтын болон захиргаа, удирдлагын ажилчдын цалингийн зардал 30 орчим хувиар өссөн байна.

Жижиглэнгийн борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2016 онд Эрдэнэт хотын барилгын материалын төвүүдэд 2 лангуу түрээслэн ажиллуулж байгаатай холбоотой түрээсийн зардал нэмэгдсэн байна.

Санхүүгийн зардал

Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, түүхий эд материал бэлтгэх зорилгоор арилжааны банк болон холбоотой этгээдээс авсан зээлийн хүүний зардлыг тооцоолсон дүнгээр нь буюу 17.14 сая төгрөгийг 2016 онд санхүүгийн зардалд бүртгэж тайлагнав.

Бусад ашиг (алдагдал)

2015 он болон 2016 оны 1 дүгээр улиралд үүссэн борлуулалтын авлага болон бэлтгэн нийлүүлэгчдэд түүхий эд материалын урьдчилгаанд төлсөн нийт 90.13 сая төгрөгийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр найдваргүй авлагад тооцож, данснаас хассан. Өмнөх онд 4.17 сая төгрөгийг бусад зардал, бусад ашиг алдагдлаар тайлагнасан байна.

Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)

2015 оны аудитлагдсан санхүүгийн тайлан дахь татварын өмнөх ашиг 238.97 сая төгрөг байсан бол 2016 онд 45.87 сая болж 5 дахин буурсан. Энэ нь 2016 онд хэдийгээр борлуулалт өмнөх оныхоос нэмэгдсэн ч борлуулалтын өртөг болон бусад зардлууд өссөн, мөн найдваргүй авлагын зардал бүртгэсэнтэй холбоотой.

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

Орлогын татварын зардал

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтаас олсон орлого татвараас чөлөөлөгдөж, ажил үйлчилгээний орлогоос тухайн орлогыг олохтой холбоотой зардлыг хассан дүнгээс орлогын албан татварын зардал тооцож бүртгэсэн бөгөөд 2016 онд орлогын татварын зардал өмнөх оны тооцоолсон зардлаас 42.4%-иар өсөж, 2.89 сая төгрөгийг татварт төвлөрүүлсэн байна.

2015, 2014 оны үйл ажиллагааны үр дүнгийн харьцуулалт

Борлуулалтын орлого

"Эрдэнэт лед" гэрлийн үйлдвэр 2014 оны 09 дүгээр сард нээлтээ хийж, үндсэн үйлдвэрлэл 2015 оноос тогтворжиж эхэлсэн байна. 2014 онд цөөн тооны гэрэл үйлдвэрлэн борлуулж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтаас 0.87 сая төгрөг олсон бол 2015 онд гэрлийн борлуулалтын орлого 298.77 сая төгрөг болж өссөн байна.

Ажил үйлчилгээний орлогын хувьд 2014 онд Ачит-ихт ХХК-ийн гүйцэтгэсэн Эрдэнэт үйлдвэрийн гэрээт ажилд туслан гүйцэтгэгчээр оролцсоноос гадна Орхон аймгийн Баян-Өндөр сумын төв замын гэрлэн чимэглэлийн засвар үйлчилгээ, Эрдэнэт үйлдвэрийн захиргааны төв байрны хурлын заалны гэрэлтүүлгийн ажлуудыг гүйцэтгэж 119.22 сая төгрөгийн ажил үйлчилгээний орлого олжээ. Харин 2015 онд АЦХ ХХК Эрдэнэт үйлдвэрт гэрээгээр хийсэн ажилд туслан гүйцэтгэгчээр оролцсоноос гадна Бүрэгхангай, Заамар сумдын төвийн гэрэлтүүлгийн ажил, Говил багийн гэрэлтүүлгийн засвар шинэчлэлийн ажил, Эрдэнэт хот доторх тэмдэг тэмдэглэгээний ажлуудыг хийж гүйцэтгэн, 299.22 сая төгрөгийн орлого олсон байна.

Борлуулалтын өртөг

2014 оны аудитлагдсан санхүүгийн тайланд борлуулалтын өртгийг 124.64 сая төгрөгөөр тайлагнасан бөгөөд энэ өртөг нь ерөнхийдөө тайлант онд гүйцэтгэсэн ажил үйлчилгээний өртөг юм. Харин 2015 оны борлуулалтын өртөг 240.65 сая төгрөг болж өмнөх оны өртгөөс даруй 2 дахин нэмэгдсэн байна.

Нийт ашиг (алдагдал)

2015 оны санхүүгийн тайлан дахь нийт ашиг 357.34 сая төгрөг буюу борлуулалтын ахиуц ашиг нь 59.7% байсан бол 2014 онд нийт алдагдал 4.55 сая төгрөг байжээ.

Хүүний орлого

2014 онд банкин дахь харилцах дансны үлдэгдэлд тооцсон хүүний орлого 0.07 сая төгрөг байсан бол 2015 онд 0.35 сая төгрөг болж өссөн байна.

Ерөнхий ба удирдлагын зардал

Компани 2014 онд ерөнхий удирдлагын ба борлуулалт маркетингийн зардалд 10.07 сая төгрөг тайлагнасан бол 2015 онд 114.55 сая төгрөг болж нэмэгдсэн байна. Компани 2014 оны сүүлийн улиралд гэрлийн үйлдвэрийн үйл ажиллагааг туршилтаар эхлүүлж, 2015 онд албан ёсоор ашиглалтанд оруулсантай холбоотойгоор ерөнхий удирдлагын ба борлуулалт маркетингийн зардал 2014 болон 2015 онд харьцангуй ялгаатай байжээ. 2015 оны ерөнхий удирдлагын болон борлуулалт маркетингийн зардлыг бүтцээр нь авч

ОРХОН АЙМАГ
ХХК
78 | "АНД-ЭНЕРГИ" ХХК
КА:101070_4385772
2087103
ПЮН0230

үзвэл нийт зардлын 36.3%-ийг цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 29.2%-ийг томилолтын зардал бүрдүүлсэн байна.

Бусад ашиг (алдагдал)

2014 онд 2.19 сая төгрөгийн 2015 онд 4.17 сая төгрөгийн зардлыг бусад ашиг алдагдлаар тайлагнасан байна.

Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)

2014 оны аудитлагдсан санхүүгийн тайланд татварын өмнөх цэвэр алдагдал 16.66 сая төгрөгөөр тайлагнасан нь тайлант онд үйлдвэр байгуулах, туршилтын үйлдвэрлэл явуулах гэх мэт үйл ажиллагааны зардал их байсантай холбоотой.

2015 онд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа жигдэрч, харилцагчдаас захиалга авч эхэлснээс гадна гэрэлтүүлгийн ажлууд мөн нэмэгдэж татварын өмнөх цэвэр ашгийн хэмжээ 238.97 сая төгрөг болсон байна.

Орлогын татварын зардал

2014 онд татвар ногдох орлого байхгүй тул орлогын татварын зардал тооцоолоогүй, харин 2015 онд 2.03 сая төгрөгийн орлогын албан татварын зардал тооцсон байна.

10.5. Ажлын капитал

Дараах хүснэгтэд манай өнгөрсөн 3 жилийн аудитлагдсан санхүүгийн тайлангуудын эргэлтийн хөрөнгө болон богино хугацаат өр төлбөрийг харуулсан бөгөөд эдгээр үзүүлэлтүүдээс Компанийн ажлын капиталын үзүүлэлт ямар байгааг харах боломжтой.

Хүснэгт 31. Ажлын капитал (сая төгрөгөөр), 2014-2016 он

	2014	2015	2016
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	11.88	57.41	64.90
Дансны авлага ба бусад авлага	0.57	124.22	37.15
Бараа материал	26.20	95.70	146.38
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0.58	65.02	11.59
Дүн	39.23	342.35	260.02
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	-	-	-
Татварын өглөг	2.10	40.94	25.24
Богино хугацаат зээл	30.00	-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	2.70	-	1.05
Дүн	34.80	40.94	26.30
Цэвэр эргэлтийн хөрөнгө	4.43	301.41	233.72

Манай компанийн өнгөрсөн 3 жилийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдэд үндэслэн ажлын капиталыг тооцоолж үзэхэд ажлын капитал буюу цэвэр эргэлтийн хөрөнгө эерэг утгатай байгаа нь Компани бүх богино хугацаат өр төлбөрөө бүрэн барагдуулах боломжтойг харуулж байна.

2014 онд үйлдвэрлэл дөнгөж эхэлж байсан хэдий ч ажлын цэвэр капитал 4.43 сая төгрөг байсан бол 2015 онд үйлдвэрийн үйл ажиллагаа жигдэрснээс гадна ажил үйлчилгээний орлого өмнөх оныхоос 2 дахин нэмэгдсэнтэй холбоотойгоор эргэлтийн хөрөнгө нэмэгдэж, үүнийг даган ажлын цэвэр капитал 301.41 сая төгрөг болж өссөн байна.

2015 оны санхүүгийн тайланд тайлагнасан эргэлтийн хөрөнгийг бүтцээр нь авч үзвэл 36.3% нь дансны авлага болон бусад авлага, 27.9% нь бараа материал, 19.0% нь бэлтгэн нийлүүлэгчдэд өгсөн түүхий эд материалын урьдчилгаа төлбөр, 16.7%-ийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө бүрдүүлж байжээ. Харин богино хугацаат өр төлбөр нь татварын өр бөгөөд үүнээс 85.9% нь НӨАТ-ын өглөг байна.

2016 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдэд үндэслэн тооцсон цэвэр эргэлтийн хөрөнгийн дүн 233.72 сая төгрөг болж өмнөх оны үзүүлэлтээс 22.5% буюу 67.69 сая төгрөгөөр буурсан байна. Ажлын цэвэр капиталын энэхүү бууралт нь 2016 онд бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн материалын урьдчилгаа болон дансны авлагын зарим хэсэг нь эргэн цуглуулагдах найдваргүй болж, 90.13 сая төгрөгийн авлага данснаас хасагдсантай холбоотой.

10.6. Мөнгөн гүйлгээний мэдээлэл

Өнгөрсөн 3 жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан дахь мөнгөн гүйлгээний тайлангийн хураангуй дараах байдалтай байна.

Хүснэгт 32. Мөнгөн гүйлгээний тайлангийн хураангуй (сая төгрөгөөр), 2014-2016 он

	2014	2015	2016
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(114.06)	(6.72)	126.45
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(66.73)	(5.99)	(77.31)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	109.16	58.24	(41.64)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(71.63)	45.53	7.50
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	83.50	11.87	57.40
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11.87	57.40	64.90

Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн 2014, 2015, 2016 онд (114.06) сая, (6.72) сая болон 126.45 сая төгрөг байна.

2014 онд үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн 114.06 сая төгрөгийн гарах урсгалтай гарсан бөгөөд үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн 82.23 сая төгрөг, мөнгөн зарлагын дүн 196.29 сая төгрөг байжээ. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого нь харилцагчдаас хүлээн авсан борлуулалтын орлого байсан бол мөнгөн зарлагын дийлэнх хэсэг нь буюу 64.2% нь бараа материал худалдан авахад төлсөн мөнгө байна.

2015 онд үндсэн үйл ажиллагаанаас 299.46 сая төгрөгийн орлоготой ажиллаж, 306.18 сая төгрөг зарцуулсан байна. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлагыг

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭЭ
АРАВ. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ
№ 7

бүтцээр нь авч үзвэл 37.7% нь бараа материал худалдан авахад төлсөн мөнгө, 12.1% нь ажилчдад олгосон цалин хөлс, 3.8%-ийг татвар, нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө, мөн 3 орчим хувийг хүүний төлбөрт төлсөн мөнгө бүрдүүлж байжээ.

2016 онд үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого 854.97 сая болж, өмнөх оныхоос 2.8 дахин өссөн нь борлуулалтын орлогын өсөлт болон өмнөх жилийн борлуулалтаас үүссэн авлагын зарим хэсгийг цуглуулсантай холбоотой. Тайлант жилд үндсэн үйл ажиллагааны мөнгөн зардал 728.52 сая төгрөг болсон нь өмнөх оныхоос 2.4 дахин өссөн үзүүлэлт байна. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зардлын 18.8% нь бараа материал худалдан авахад төлсөн мөнгө, 14.4% нь татвар, нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө, 9.5% нь ажилчдад олгосон цалин хөлс бүрдүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн 2014, 2015, 2016 онд (66.73) сая, (5.99) сая болон (77.31) сая төгрөг байна.

2014 онд хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого 55.26 сая төгрөг, мөнгөн зардал нь 121.99 сая төгрөг байсан. Тухайн онд гэрлийн үйлдвэрийн тоног төхөөрөмж болон бусад үндсэн хөрөнгийг олж бэлтгэхэд 116.38 сая төгрөг төлсөн бөгөөд үйлдвэрийн тоног төхөөрөмж авах зорилгоор үүсгэн байгуулагчдын оруулсан 49.93 сая төгрөгийг санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний хэсэгт бус хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлогоор тайлагнаж, хараат бус аудитор баталгаажуулсан байна.

2015 онд үндсэн хөрөнгө олж эзэмшихэд 5.99 сая төгрөг зарцуулсан бөгөөд хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн (5.99) сая төгрөгөөр тайлагнасан.

Харин 2016 онд 77.31 сая төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө олж бэлтгэсэн нь аудитлагдсан санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайланд тусгагдсан байна.

Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн 2014, 2015, 2016 онд тус тус 109.16 сая, 58.24 сая болон (41.64) сая төгрөг байна.

Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн 2014 онд 113.89 сая төгрөг байсан бөгөөд үүний 113.22 сая төгрөг нь тайлант онд авсан зээл, өрийн үнэт цаастай холбоотой. Тухайн жилийн аудитлагдсан санхүүгийн байдлын тайланд тусгагдсанаар Компани жилийн эцэст 69.26 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөр, 30.0 сая төгрөгийн богино хугацаат зээлтэй гэж тайлагнасан. Дээрх урт хугацаат өр төлбөр нь тухайн үеийн гүйцэтгэх захирал асан Т.Барсаас авсан зээл бөгөөд уг зээлийн дүнд хэлцэл байгуулаагүй 2016 оныг хүргэсэн байна.

2015 онд Худалдаа хөгжлийн банкнаас авсан 100.0 сая төгрөгийн зээлийн дүнгээр санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого тодорхойлогдсон бол тайлант жилийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан 36.02 сая төгрөгийн ногдол ашиг, бусад санхүүгийн үйл ажиллагаатай мөнгөн зарлага гэх мэт нийт 41.76 сая төгрөгийн мөнгө зарлага тайлагнасан байна.

2016 онд санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн (41.64) сая төгрөг бөгөөд энэ нь зээлийн төлбөрт төлсөн мөнгө болон найдваргүйд тооцож данснаас хассан авлагатай холбоотой.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА01070 4385772
2087103
ПЮН0230
БҮРТГЭЛИЙН БАРИМТ БИЧИГ

Мөнгөн гүйлгээний тайлангийн бүх цэвэр мөнгөн гүйлгээний дүн үйлдвэрийн үйл ажиллагаа жигдэрсний дараа буюу 2015, 2016 онд эерэг утгатай, тэр дундаа өрийн болон өмчийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан мөнгөн орлогогүй 2016 оны төлөөт мөнгөн урсгал 7.5 сая төгрөг байгаагаас харахад цаашид үйлдвэрлэлийн тоо хэмжээг нэмэгдүүлж, борлуулалтыг дэмжсэнээр чөлөөт мөнгөн урсгалыг нэмэгдүүлж, Компанийн хувьцаа эзэмшигчдэд ашиг хуваарилах, эсвэл үйлдвэрийг дахин капиталжуулах боломж байгааг харуулж байна.

10.7. Дансны авлага, бусад авлага

Дансны авлага нь зээлээр эсвэл дараа тооцоогоор борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил үйлчилгээний орлого болон цуварсан төлбөрийн нөхцөлтэйгөөр байгуулсан гэрээний үлдэгдэл төлбөрийн дүнг харуулж байна.

Хүснэгт 33. Дансны ба бусад авлага (сая төгрөгөөр), 2014-2016 он

	2014	2015	2016
Дансны авлага	-	123.92	37.06
Татвар, ЭМНДШ-ийн авлага	0.29	0.29	-
Бусад богино хугацаат авлага	0.28	-	0.09
Авлагын дүн	0.57	124.22	37.15

2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад Компанитай өр, авлагын тооцоо үүсгэсэн этгээдүүдтэй тулган баталгаажуулалт хийсэн бөгөөд аудитлагдсан санхүүгийн тайланд тусгагдсан авлага нь баталгаажуулсан, бодитой оршин байгаа авлага юм.

Санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн дансны авлага нь Монгол Улсын Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу 10%-ийн НӨАТ шингэсэн дүн болно.

10.8. Холбоотой талуудын ажил гүйлгээ

Компанийг шууд эсвэл хамтран хянадаг, Компанийн үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг, эсвэл эрх бүхий албан тушаалтан буюу удирдах ажилтныг Компанитай холбоотой этгээд гэх бөгөөд холбоотой этгээд болон Компани хооронд аливаа нөөц, ажил үйлчилгээ, үүрэг хариуцлага шилжүүлсэн тохиолдолд холбоотой талуудын ажил гүйлгээ гэж үзнэ.

Анд-Энерги ХХК нь өнгөрсөн 3 жилийн хугацаанд холбоотой талтай хийсэн сонирхлын зөрчилтэй 1 хэлцэлтэй. Холбоотой талтай хийсэн ажил гүйлгээ нь харилцан тохиролцсон нөхцөлөөр хийгдсэн. Тодруулбал үйлдвэрт шаардлагатай тоног төхөөрөмж, түүхий эд материалыг татан авах зорилгоор 2014 онд Компанийн хувьцаа эзэмшигч бөгөөд гүйцэтгэх захирал асан Т.Барсаас 70 сая төгрөг авч ашигласан бөгөөд үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчид харилцан итгэлцлийн үндсэн дээр дээрх дүнд ямар нэг гэрээ хэлцэл байгуулаагүй. 2016 онд Хувьцаа эзэмшигчдийн хурлын 05 тоот тогтоолоор Гүйцэтгэх захирал Т.Барстай хийх тооцооны үлдэгдэл дүн болох 65,885,342 төгрөгөөр зээлийн гэрээ байгуулах эрх олгосны дагуу жилийн 11.4 хувийн хүүтэй, 2 жилийн хугацаатай, үндсэн төлбөрийг хугацааны эцэст барагдуулах нөхцөлтэй зээлийн гэрээ байгуулсан байна.

СЗХ
он сар
БҮРТГЭВ
№ 01

10.9. Зээл

Компани үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдан авах, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор авсан 2 төрлийн зээлийн гэрээтэй.

Хүснэгт 34. Урт хугацаат өр төлбөр (сая төгрөгөөр), 2014-2016 он

	2014	2015	2016
Урт хугацаат зээл	-	100.00	96.64
Бусад урт хугацаат өр төлбөр	69.27	67.69	65.89
Урт хугацаат өрийн дүн	69.27	167.69	162.53

2014 онд үйлдвэрийн тоног төхөөрөмж, түүхий эд материал худалдан авахад зориулж Гүйцэтгэх захирал Т.Барсаас жилийн 8 хувийн хүүтэй, 20 жилийн хугацаатай, 70 сая төгрөгийн зээл авч ашигласан. 2014, 2015 оны санхүүгийн тайланд дээрх нөхцөлөөр тооцоолон зээлийн төлбөр болон хүүний зардлыг санхүүгийн тайланд тусгасан. 2016 онд зээлийн нөхцөлийг өөрчлөн, жилийн 11.4 хувийн хүүтэй, 2 жилийн хугацаатай, үндсэн төлбөрийг хугацааны эцэст хийх нөхцөлтэйгөөр зээлийн гэрээг албажуулан баталсан байна. Зээлийн үндсэн төлбөрийг хугацааны эцэст мөнгөөр төлөх эсвэл Компанийн энгийн хувьцааг тухайн үеийн зах зээлийн үнээс 10 хувь хямдруулсан үнээр тооцон, өр төлбөрийн дүнд эзэмшүүлж болох нөхцөлтэй гэрээ байгуулсан байна.

2015 оны 08 дугаар сард Худалдаа хөгжлийн банкнаас 100.00 сая төгрөгийг гэрлийн үйлдвэрийн өргөтгөл, тоног төхөөрөмж, түүхий эд материал худалдан авах зорилгоор 39 сарын хугацаатай зээлсэн. Уг зээл нь Монгол Улсын Хөгжлийн банкны эх үүсвэртэй зээл бөгөөд жилийн 9 хувийн хүүтэй. Уг зээл нь зээлийн эх үүсвэр өөрчлөгдсөн тохиолдолд зээлийн хүү өөрчлөгдөж, Худалдаа хөгжлийн банкны үндсэн зээлийн хүүгээр тооцогдох нөхцөлтэй бөгөөд одоогоор Хөгжлийн банкны эх үүсвэртэй үргэлжилж байгаа болно.

Бид Компанийн ирээдүйн үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн боловсруулсан энэхүү Үнэт цаасны танилцуулгын төсөвлөсөн санхүүгийн үзүүлэлт, ашгийн таамаглал гэх мэт санхүүгийн тооцооллуудад дээрх зээлүүдийн эргэн төлөлтийг үндсэн гэрээний нөхцөлийн дагуу төсөвлөн тооцоолсон болно.

10.10. Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Компанийн санхүүгийн үндсэн хэрэгслүүд нь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, дансны ба бусад авлага, дансны ба бусад өглөг болон урт хугацаат зээлээс бүрддэг. Компани үйл ажиллагаагаа санхүүжүүлэхийн тулд дээрх санхүүгийн хэрэгслүүдийг эзэмшдэг бөгөөд арилжаалах болон санхүүгийн хамгаалалт хийх зорилгоор аливаа санхүүгийн хэрэгсэл эзэмшдэггүй болно.

Санхүүгийн хэрэгсэлтэй холбоотой үндсэн эрсдэлүүдийг хүүний эрсдэл, гадаад валютын эрсдэл, төлбөрийн чадварын эрсдэл болон хүүний эрсдэл гэж ангилж үздэг. Санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлогын тухай Үнэт цаасны танилцуулгын Эрсдэлийн хүчин зүйлс хэсгээс дэлгэрүүлж харах боломжтой.

10.11. Болзошгүй өр төлбөр

"Эрдэнэт лед" гэрлийн үйлдвэр нь өөрийн үйлдвэрлэн борлуулсан бүтээгдэхүүнд 6-24 сарын баталгаат хугацаа олгодог. Барааны чанарын баталгаанд урьдчилсан нөөц

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ
ХХК
КА01010704395772

үүсгэж бүртгэдэггүй бөгөөд үйлдвэрлэлийн бууруугаас үүссэн доголдол, гэмтэлтэй бүтээгдэхүүнийг засварлах, шинээр солих үедээ тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрдөг.

10.12. Хөрөнгө оруулалтын зардал

Хөрөнгө оруулалтын зардал нь гэрлийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг өргөтгөх, үйл ажиллагаанд шаардлагатай материаллаг баазыг бий болгохтой холбоотой худалдан авалтууд байдаг. Өнгөрсөн 3 жилийн хугацаанд хөрөнгө оруулалтын зардлын эх үүсвэр дараах байдалтай байсан.

Хүснэгт 35. Хөрөнгө оруулалтын мэдээ (сая төгрөгөөр), 2014-2016 он

	2014	2015	2016
Газрын сайжруулалт	-	-	3.90
Өөрийн хөрөнгөөр		-	3.90
Барилга байгууламж	87.95	-	12.00
Өөрийн хөрөнгөөр	13.95	-	12.00
Банкны зээлээр	70.00	-	-
Бусад эх үүсвэр	4.00	-	-
Машин тоног төхөөрөмж	27.12	1.78	14.48
Өөрийн хөрөнгөөр	27.12	1.78	14.48
Тээврийн хэрэгсэл	-	-	34.23
Өөрийн хөрөнгөөр	-	-	34.23
Тавилга, эд хогшил	1.30	1.65	7.85
Өөрийн хөрөнгөөр	0.70	1.65	7.85
Төсөл хөтөлбөр, хандив	0.60	-	-
Компьютер, бусад хэрэгсэл	-	2.80	3.07
Өөрийн хөрөнгөөр	-	2.80	3.07
Хөрөнгө оруулалтын дүн	116.38	6.23	75.54

Бидний тооцоолсон үйлдвэрийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн өртөг нь бүх тээвэр, гааль, татвар хураамжууд, бусад зардлууд орсон үнэ буюу шууд үйлдвэрлэл эхлэхэд бэлэн болгох хүртэлх бүх зардлыг шингээсэн үнэ болно. Дараах хүснэгтэд IPO-оор татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөөг харууллаа.

АРАВ. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

Хүснэгт 36. IPO-оор татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт (сая төгрөгөөр)

Хөрөнгө оруулалтын зардлын төрөл	Төсөвт өртөг
Үйлдвэрийн барилга, дэлгүүрийн засвар, тохижилт	775.00
Үйлдвэрийн тоног төхөөрөмж	254.91
Тугалга түрхэгч машин	12.93
LED өрөгч машиг	57.48
Гагнуурын машин	40.23
Конвейр	9.20
PCB хавтангийн хөрөө	4.60
Гэрэл шалгах шугам	45.98
Гэрлийн техник тодорхойлох лаборатори	40.23
Техникийн үзүүлэлт тодорхойлох стенд	1.15
Угсралтын ширээ	43.11
Бусад тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл	252.08
CNC лазер машин	83.65
CNC нугалагч машин	35.85
Лист нугалагч машин	18.25
Лист хайчлагч машин	14.37
Хагас автомат гагнуурын машин	1.79
Хэмжүүрийн болон гар багажууд	11.95
Нүх ухагч трактор	28.74
Крантай машин	57.48
Эргэлтийн хөрөнгө	147.82

10.13. Ашгийн таамаглал

Бид Компанийн бизнес болон стратеги төлөвлөгөөндөө үндэслэн дунд хугацааны ашгийн таамаглалыг хийсэн бөгөөд ашгийн таамаглал, төсөвлөсөн санхүүгийн мэдээллийг 2016 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг суурь болгон авч хийсэн болно.

Ашгийн таамаглалыг хийхдээ үйлдвэр цаашид тогтвортой, тасралтгүй үйл ажиллагаа явуулна гэсэн үндсэн төсөөлөлд үндэслэсэн бөгөөд үйлдвэрлэл, борлуулалтыг тогтмол нэмэгдүүлэх зарчмаар бэлтгэсэн болно.

Компанийн ирээдүйн 5 жилийн үйлдвэрлэл, борлуулалт, ашгийн таамаглалыг Үнэт цаасны танилцуулгын “Хавсралт 1. Төсөвлөсөн санхүүгийн мэдээлэл” хэсэгт дэлгэрэнгүй тайлбарласан.

10.14. Төсөвлөсөн цэвэр хөрөнгийн тохиргоо тайлан

Монголын үнэт цаасны биржийн Бүртгэлийн журмын 9.12 9.13-д заасны дагуу бид төсөвлөсөн цэвэр хөрөнгийн тохиргоо тайланг Биржийн Гүйцэтгэх захирлын 2016 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 11/16 тоот тушаалаар батлагдсан загварын дагуу бэлтгэлээ. Төсөвлөсөн цэвэр хөрөнгийн тохиргоо тайлан нь энэхүү танилцуулгын “Хавсралт 3. Аудитлагдсан санхүүгийн тайлан”-гийн 2016 оны үзүүлэлт болон “Хавсралт 1. Төсөвлөсөн санхүүгийн мэдээлэл” хэсэгт дурдагдсан тоон үзүүлэлтүүдэд үндэслэсэн бөгөөд уг тооцоолол нь урьдчилан төсөвлөсөн тооцоолол тул заавал ийм байх ёстой гэсэн утгыг илэрхийлэхгүй болохыг анхаарна уу.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КАМ01070 4388772

Бумбат Алтан
2037103
ПҮОН0230

Хүснэгт 37. Төсөвлөсөн цэвэр хөрөнгийн тохиргоо тайлан

	2016 оны 12 сарын 31-ны байдлаар компанийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах цэвэр биет хөрөнгө [1]	Нэмэх: Олон нийтэд хувьцаа санал болгосноос олох цэвэр орлого [2]	Компанийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах цэвэр биет хөрөнгийн төсөвлөсөн дүн	Нэгж хувьцаанд ногдох төсөвлөсөн цэвэр биет хөрөнгийн дүн [3]
	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	төгрөг
Хувьцааны санал болгох үнийг 60 төгрөгөөр тооцоход	339.34	1,472.08	1,811.48	23.20
Хувьцааны санал болгох үнийг 65 төгрөгөөр тооцоход	339.34	1,596.84	1,936.18	24.80

Тайлбар:

(1) Компанийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах цэвэр биет хөрөнгийн нэгтгэсэн дүнг 2016 оны 12 сарын 31-нээр харуулж байна.

(2) Нэгж хувьцааны санал болгох үнийг 60 болон 65 төгрөгөөр тооцоолж, олон нийтэд санал болгон арилжаалснаас орж ирэх мөнгөн орлогоос андеррайтерийн болон бусад холбогдох зардлыг хассан цэвэр орлогын хэмжээ.

(3) IPO-оор 26,544,058 ширхэг энгийн хувьцаа нэмж гүйлгээнд гаргасан гэж үзвэл нэгж хувьцаанд ногдох төсөвлөсөн цэвэр биет хөрөнгийн нэгтгэсэн дүнг харуулж байна.

10.15. Хөрөнгийн үнэ цэнэ

Анд-Энерги ХХК нь 2016 оны санхүүгийн тайланг толилуулахаас өмнө хөндлөнгийн үнэлгээний Далайван Аудит ХХК-аар хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн бөгөөд дахин үнэлэгдсэн хөрөнгийн зах зээлийн өнөөгийн үнэ цэнэ 268.15 сая төгрөг байсан.

Хөрөнгийн дахин үнэлгээний тайланг Үнэт цаасны танилцуулгад хавсаргасан болно.

10.16. Ногдол ашиг

Компанийн ногдол ашиг хуваарилах бодлогын талаар танилцуулгын өмнөх хэсэгт дурдсан бөгөөд ногдол ашгийн тооцооллын тухай Үнэт цаасны танилцуулгын "Хавсралт 1. Төсөвлөсөн санхүүгийн мэдээлэл"-ийн "3. Нэгж хувьцаанд ногдох ашгийн төсөөлөл" хэсэгт дэлгэрэнгүй тайлбарласан болно.

АРВАН НЭГ. ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Компанийн санхүүгийн тайланд бүртгэлтэй, хөнгөлөлттэй үнээр хувьцаанд хөрвөх нөхцөлтэй өр төлбөрийн хөрвүүлэлтийг тооцоолохгүйгээр, андеррайтер, нийцүүлэгчийн болон бусад шимтгэл, хураамжийг хассаны дараа 1,465.2 сая төгрөгийг хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлэх боломжтой гэж үзэж байна. Компанийн хувьцааг олон нийтэд анх удаа нээлттэй санал болгон арилжсанаар татан төвлөрүүлэх хөрөнгийг "Эрдэнэт лед" гэрлийн үйлдвэрийн үйл ажиллагааг өргөжүүлэх үндсэн чиглэлд зарцуулахаар төлөвлөж байгаа бөгөөд хөрөнгө оруулалтын зарцуулалтыг дараах байдлаар төлөвлөж байна. Үүнд:

- Татан төвлөрүүлсэн хөрөнгийн 50 гаруй хувийг үйлдвэрийн барилга байгууламж байгуулах, худалдаа, үйлчилгээний чиглэлээр талбай худалдан авч, тохижуулах ажилд зарцуулна. Тухайлбал үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлж өргөтгөх зорилгоор Орхон аймагт 1500 метр квадрат талбай бүхий 3 давхар үйлдвэрийн барилга барихад 700.0 сая төгрөг, маркетинг идэвхжүүлэлтийн ажлыг нэмэгдүүлж, борлуулалтыг дэмжих, түгээлтийн сувгаа нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хотод 1-2 дэлгүүр тохижуулж, Эрдэнэт LED брэндийн showroom бий болгоход 75.0 сая төгрөгийг тус тус зарцуулахаар төлөвлөв.
- Бүтээгдэхүүний гарц, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх багц тоног төхөөрөмж, бүтээмж нэмэгдүүлж, гар ажиллагаатай хөдөлмөрийг хөнгөвчлөх шинэ төрлийн тоног төхөөрөмж болон гэрэлтүүлгийн угсралт суурилуулалт, үйлчилгээний ажилд шаардагдах тээврийн хэрэгсэл, бусад тоног төхөөрөмжийн худалдан авалт, тээвэрлэлт, суурилуулалтанд нийт хөрөнгө оруулалтын 35 орчим хувийг зарцуулахаар төлөвлөж байна.
- Компанийн хувьцааг олон нийтэд санал болгон арилжсанаас босгосон орлогын 12-15 хувийг эргэлтийн хөрөнгө бүрдүүлэхэд ашиглана. Өөрөөр хэлбэл гэрлийн үйлдвэрлэлийг тасралтгүй жигд явуулахын тулд шаардагдах түүхий эдийн нөөцийг байнга бэлэн байлгах, түүхий эдийн татан авалтыг боломжит их хэмжээгээр цөөн удаа хийснээр нэгж бүтээгдэхүүний өртгийг бууруулах бодлого баримтлан ажиллахаар төлөвлөж байгаатай холбоотой.

IPO хийх замаар татан төвлөрүүлэх хөрөнгө оруулалт бодит байдалд бидний таамаглаж байгаагаас зөрж болох бөгөөд бидний төсөвлөсөн дүнгээс багассан тохиолдолд бид дээрх зарцуулалтын төлөвлөгөөнд уян хатан байдлаар хувь тэнцүүлэн шингээх, төлөвлөснөөс илүү хэмжээний хөрөнгө оруулалт татаж чадсан тохиолдолд түүхий эд материалын нөөцийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн гар ажиллагааг хөнгөвчлөхөд шаардагдах жижиг төхөөрөмж, багаж хэрэгслүүдийг худалдан авахад зарцуулах болно.

Бидний тооцооллоор нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 47.8 хувийг үйлдвэрийн барилга барихад, 5.1 хувийг нэрийн дэлгүүр, showroom байгуулахад зарцуулах бөгөөд үйлдвэрийн барилгын ашиглалтын тухай энэхүү танилцуулгын “Бүлэг 6. Бизнес” хэсгээс дэлгэрэнгүй харж болно.

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Харин үйлдвэрийн шугамыг нэмэгдүүлэх иж бүрэн тоног төхөөрөмжийг LED гэрлийн үйлдвэрийн тоног төхөөрөмж үйлдвэрлэгч БНХАУ-ын SHENZHEN LEADSMT TECHNOLOGY компаниас худалдан авахаар урьдчилсан тохиролцоонд хүрээд байна. SHENZHEN LEADSMT TECHNOLOGY компани нь 2000 оноос хойш үйлдвэрлэлийн автомат тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, автоматжуулалтын үйлчилгээг олон улсын үйлдвэрлэгчдэд үзүүлж ирсэн бөгөөд тус компанийн үйлдвэрлэж буй тоног төхөөрөмжүүд нь олон улсын чанарын стандартад нийцсэн албан ёсны гэрчилгээ бүхий төхөөрөмжүүд юм. Эрдэнэт LED брэндийн гэрлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний чанар, стандартыг сайжруулах зорилгоор үйлдвэрлэлд нэвтрүүлэх зарим тоног төхөөрөмжийн үнийн саналыг нийлүүлэгчээс ирүүлсэн байна.

Бид үйлдвэрийн түүхий эдийн заавал байлгах нөөц бүрдүүлж, үйлдвэрлэлийг тасралтгүй явуулах, түүхий эд материалын татан авалтыг цөөн удаа, их хэмжээгээр татан авснаар бүтээгдэхүүний өртгийг хэмнэх бодлого баримтлан ажиллахаар төлөвлөж байгаа бөгөөд энэ хүрээнд 215.0 сая орчим төгрөгийн түүхий эдийг татан авч үйлдвэрлэлд ашиглахаар төлөвлөөд байна. Нэгж бүтээгдэхүүний өртөг, түүхий эд материалын татан авалтын талаар энэхүү танилцуулгын “Санхүүгийн мэдээлэл”, "Хавсралт 7. Бусад. Үйлдвэрийн шинэ шугамын үнийн санал" бүлгүүдээс дэлгэрүүлж харах боломжтой.

1. Тугалга түрхдэг машин (LED printer)

Хэмжих нэгж:	ширхэг	Худалдан авах гэрээний үнэ дээр гааль, НӨАТ тооцсон үнэ болон тоног төхөөрөмжийн тээвэрлэлт, угсралт, суурилуулалтын зардал тооцсон нийт үнэ:	12.93 сая төг.



2. LED өрөгч машин

Хэмжих нэгж:	ширхэг	Худалдан авах гэрээний үнэ дээр гааль, НӨАТ тооцсон үнэ болон тоног төхөөрөмжийн тээвэрлэлт, угсралт, суурилуулалтын зардал тооцсон нийт үнэ:	57.48 сая төг.
Шаардлагатай тоо хэмжээ:	1		



3. Гагнуурын машин

Хэмжих нэгж:	ширхэг	Худалдан авах гэрээний үнэ дээр гааль, НӨАТ тооцсон үнэ болон тоног төхөөрөмжийн тээвэрлэлт, угсралт, суурилуулалтын зардал тооцсон нийт үнэ:	40.23 сая төг.
Шаардлагатай тоо хэмжээ:	1		



4. Конвейр

Хэмжих нэгж:	ширхэг	Худалдан авах гэрээний үнэ дээр гааль, НӨАТ тооцсон үнэ болон тоног төхөөрөмжийн тээвэрлэлт, угсралт, суурилуулалтын зардал тооцсон нийт үнэ:	2.30 сая төг.
Шаардлагатай тоо хэмжээ:	4		



5. PCB хавтангийн хөрөө

Хэмжих нэгж:	ширхэг	Худалдан авах гэрээний үнэ дээр гааль, НӨАТ тооцсон үнэ болон тоног төхөөрөмжийн тээвэрлэлт, угсралт, суурилуулалтын зардал тооцсон нийт үнэ:	4.60 сая төг.
Шаардлагатай тоо хэмжээ:	1		



6. Гэрэл шалгах шугам (12м)

Хэмжих нэгж:	ширхэг	Худалдан авах гэрээний үнэ дээр гааль, НӨАТ тооцсон үнэ болон тоног төхөөрөмжийн тээвэрлэлт, угсралт, суурилуулалтын зардал тооцсон нийт үнэ:	45.98 сая төг.
Шаардлагатай тоо хэмжээ:	1		



7. Гэрлийн техник тодорхойлдог лаборатори - LED spectrometer

Хэмжих нэгж:	багц	Худалдан авах гэрээний үнэ дээр гааль, НӨАТ тооцсон үнэ болон тоног төхөөрөмжийн тээвэрлэлт, угсралт, суурилуулалтын зардал тооцсон нийт үнэ:	40.23 сая төг.
Шаардлагатай тоо хэмжээ:	1		



8. Гэрлийн параметр тодорхойлох стенд

Хэмжих нэгж:	ширхэг	Худалдан авах гэрээний үнэ дээр гааль, НӨАТ тооцсон үнэ болон тоног төхөөрөмжийн тээвэрлэлт, угсралт, суурилуулалтын зардал тооцсон нийт үнэ:	1.15 сая төг.
Шаардлагатай тоо хэмжээ:	1		



9. Угсралтын ширээ (40м)

Хэмжих нэгж:	багц	Худалдан авах гэрээний үнэ дээр гааль, НӨАТ тооцсон үнэ болон тоног төхөөрөмжийн тээвэрлэлт, угсралт, суурилуулалтын зардал тооцсон нийт үнэ:	43.11 сая төг.
Шаардлагатай тоо хэмжээ:	1		



Хүснэгт 38. Худалдан авах бусад тоног төхөөрөмжийн үнийн санал

Тоног төхөөрөмжийн нэр	Зориулалт	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
CNC лазер машин	Өнгөт хавтан болон нимгэн төмрөөр гэрлэн үсэг, лого зэрэг гоёлын гэрлийн корпус зүсч бэлтгэх.	1 ширхэг	83.65	83.65
CNC машин		1 ширхэг	35.85	35.85
Лист нугалагч машин	Нимгэн төмөр нугалах, хайчлах, төмөр бэлдэц хийх, гагнах	1 ширхэг	18.25	18.25
Лист хайчлагч машин		1 ширхэг	14.37	14.37
Хагас автомат гагнуурын машин		1 ширхэг	1.79	1.79
Хэмжүүрийн болон гар багажууд	Гэрэлтүүлэг угсрах үед ашигласнаар бүтээмж, гарц нэмэгдэнэ.	1 ширхэг	11.95	11.95
Нүх ухагч трактор	Гудамж, автозамын гэрэлтүүлэг, цахилгаан дамжуулах шугамын ажил хийхэд ашиглана.	1 ширхэг	28.74	28.74
Крантай машин		1 ширхэг	57.48	57.48

Бид үйлдвэрийн түүхий эдийн заавал байлгах нөөц бүрдүүлж, үйлдвэрлэлийг тасралтгүй явуулах, түүхий эд материалын татан авалтыг цөөн удаа, их хэмжээгээр татан авснаар бүтээгдэхүүний өртгийг хэмнэх бодлого баримтлан ажиллахаар төлөвлөж байгаа бөгөөд энэ хүрээнд 215.0 сая орчим төгрөгийн түүхий эдийг татан авч үйлдвэрлэлд ашиглахаар төлөвлөөд байна. Нэгж бүтээгдэхүүний өртөг, түүхий эд материалын татан авалтын талаар энэхүү танилцуулгын "Санхүүгийн мэдээлэл" бүлгээс дэлгэрүүлж харах боломжтой.

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

АРВАН ХОЁР. ХАРИЛЦАН ХАМААРАЛТАЙ ХЭЛЦЭЛ

"Монголын үнэт цаасны биржийн бүртгэлийн журам"-ын 1 дүгээр бүлгийн 1.03 дугаар зүйл буюу "Нэр томьёоны тайлбар" хэсэгт зааснаар:

- "харилцан хамааралтай хэлцэл" гэж хамаарал бүхий этгээдтэй байгуулсан хэлцлийг;
- "хамаарал бүхий этгээдүүд" гэж
  a) үнэт цаас гаргагчийн, эсхүл түүний охин компанийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч,
  b) сүүлийн 12 сард үнэт цаас гаргагч, эсхүл түүний охин компанийн ТУЗ-ийн гишүүн байсан этгээд,
  c) (a) болон (b)-д заасан этгээдтэй холбоотой этгээдийг болон үнэт цаас гаргагчийн охин болон хараат компанийг;
- "холбоотой этгээд" гэж:

  o хувь хүний тухайд
  a) тухайн этгээдийн эхнэр, нөхөр, 18 нас хүрээгүй төрүүлсэн болон үрчилж авсан хүүхэд, эсхүл дагавар хүүхэд (тус бүр "гэр бүлийн гишүүн" гэх);
  b) тухайн этгээд эсхүл түүний гэр бүлийн гишүүнтэй байгуулсан хөрөнгө итгэмжлэх гэрээнд заасан хязгаарын хүрээнд үнэт цаасыг итгэмжлэн удирдах үйл ажиллагаа хэрэгжүүлэх эрхтэй этгээд;
  c) (a) болон (b) хэсэгт заасан этгээдийн дангаар эсхүл хамтран хяналтын багцыг нь шууд болон шууд бусаар эзэмшдэг компани, түүний охин компани;
  d) тухайн этгээдтэй хамтран амьдрагч, түүний хүүхэд, дагавар хүүхэд, эцэг эх, хойд эцэг эх, ах, хойд ах, эгч, хойд эгч;
  e) (d) хэсэгт заасан этгээдийн дангаар эсхүл хамтран хувьцааных нь 50-иас дээш хувийг шууд болон шууд бусаар эзэмшдэг компани, түүний охин компанийг;

  o компанийн тухайд
  a) түүний толгой компани, охин компани, зэргэлдээ компани;
  b) тухайн компанитай байгуулсан хөрөнгө итгэмжлэх гэрээнд заасан хязгаарын хүрээнд үнэт цаасыг итгэмжлэн удирдах үйл ажиллагаа хэрэгжүүлэх эрхтэй этгээд;
  c) (a) болон (b) хэсэгт заасан этгээд дангаар эсвэл хамтран хяналтын багцыг нь шууд эсвэл шууд бусаар эзэмшдэг компани, түүний охин компанийг;
- "нөлөө бүхий хувьцаа эзэмшигч" гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.29-д заасан этгээд буюу тухайн компанийн гаргасан саналын эрхтэй

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
90 | "АНД-ЭНЕРГИ" ХХК
КА#01070 4385772

Бумбат Алтан
2087103
ПЮН0230

нийт хувьцааны тав болон түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт эзэмшиж байгаа болон тэдгээрийн саналын эрхийг хууль болон гэрээнд заасны дагуу хэрэгжүүлж байгаа иргэн хуулийн этгээдийг тус тус ойлгоно.

Манай компани Бүртгэлийн журамд тодорхойлсон хамаарал бүхий этгээдтэй дараах харилцан хамааралтай хэлцлийг хийсэн болно.

Зээлийн гэрээ

- Харилцан хамааралтай этгээд: Орхон аймгийн Баян-Өндөр сумын Хүрэнбулаг баг, 4 дүгээр хороолол, 14 дүгээр байрны 109 тоот хаягт оршин суугч Монгол Улсын иргэн Төмөрбат овогтой Барс.
- Хамаарал: Компанийн нийт хувьцааны 25 хувийг эзэмшигч нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн дарга.
- Хамааралтай хэлцэл: Иргэний хуулийн 281 дүгээр зүйлийг үндэслэн байгуулсан ЗГ-02/2016 дугаар бүхий "Зээлийн гэрээ".
- Хэлцлийн үнийн дүн, хугацаа, төлбөрийн нөхцөл: 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан Зээлийн гэрээний дагуу Компани 65,885,342 төгрөгийг 2 жилийн хугацаатай сарын 0.95, жилийн 11.4 хувийн хүүтэйгээр иргэн Т.Барсаас зээлээр авсан. Зээлийн хүүний төлбөрт сар бүр 665,000 төгрөгийг тухайн сарын сүүлийн ажлын өдөр, үндсэн төлбөр 65,885,342 төгрөгийг 2018 оны 12 сарын 26-ны өдөр тус тус төлөх үүрэг хүлээсэн. Компанийн зүгээс аливаа зээлийн барьцаа баталгаа гаргаагүй, харилцан итгэлцэл дээр суурилан гэрээ байгуулсан.
- Хэлцэл хийх шалтгаан, үндэслэл: Компанийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилготой.
- Хэлцэлд тусгасан нэмэлт нөхцөл: Зээлдүүлэгч зээлийн гэрээний хүчинтэй хугацаанд зээлийн дүнгээр, эсвэл зээлийн зарим хэсгийг Компанийн энгийн хувьцаанд хөрвүүлэх эрхтэй. Мөн зээлийн гэрээний хугацаа дууссан боловч Компани зээлийн төлбөрийг бүрэн төлж чадаагүй тохиолдолд Зээлдүүлэгч үлдэгдэл төлбөрийн дүнгээр тооцон зээлийн өрийг Компанийн энгийн хувьцаанд хөрвүүлэх эрхтэй. Зээлдүүлэгч зээлийн үндсэн болон хүүний төлбөрийг Компанийн энгийн хувьцаанд хөрвүүлэх тохиолдолд нэгж энгийн хувьцааны хөрвөх үнийг тухайн үеийн энгийн хувьцааны зах зээлийн үнээс 10 хувиар хямдруулан тооцохоор гэрээнд тусгасан.
- Хэлцлийн хэрэгжилт: Зээлийн гэрээний дагуу 2017 оны эхний улирлын хүүний төлбөрийг хугацаанд нь бүрэн төлсөн. Зээлийн буцаан төлөлттэй холбоотой аливаа зөрчил маргаан, төлбөр хожимдуулсан асуудал гараагүй.

Одоогоор дээрх хэлцлээс өөр хамаарал бүхий этгээдтэй хийсэн болон цаашид хийхээр төлөвлөж буй харилцан хамааралтай хэлцэл байхгүй.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КАМ01070 4385772

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

АРВАН ГУРАВ. АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

АНДЕРРАЙТЕР:	"БУМБАТ-АЛТАЙ ҮЦК" ХХК
АЛБАН ЁСНЫ ХАЯГ:	УЛААНБААТАР ХОТ, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 4-Р ХОРОО САМБУУГИЙН ГУДАМЖ, 16Б БАЙР, 402 ТООТ
ХОЛБОО БАРИХ УТАС:	7011-2166 9996-8989
ЦАХИМ ХАЯГ:	bumbataltai_21@yahoo.com

Андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д заасны дагуу Анд-Энерги ХХК-тай 2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр байгуулсан 01 тоот гэрээний үндсэн дээр Компанийн 26,544,058 ширхэг энгийн хувьцааг зохицуулалттай зах зээлд нийтэд санал болгоход мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө оруулагчдад танилцуулах, захиалга авах, анхдагч зах зээлд худалдан борлуулах, анхдагч зах зээлд худалдагдаагүй үлдсэн хувьцааг худалдан авах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулна. Андеррайтер нь анхдагч зах зээлд худалдан борлуулах болон захиалга авах үйл ажиллагааг явуулахдаа 3-аас доошгүй тооны брокер, дилер, андеррайтерийн компанитай гэрээ байгуулж хамтран ажиллах бөгөөд Компанитай байгуулсан гэрээний дагуу авах ажлын хөлсний тодорхой хувийг гэрээгээр хамтрагч компаниудын ажлын хөлсөнд тооцон олгох эрхтэй. Андеррайтер болон гэрээт брокер, дилерийн компаниуд нь Компанийн олон нийтэд санал болгож буй энгийн хувьцааг анхдагч зах зээл дээр хөрөнгө оруулагчдад санал болгон борлуулахдаа нэгж хувьцааны дээд үнийг 65 төгрөг, доод үнийг 60 төгрөг байхаар төлөвлөж байгаа бөгөөд олон нийтэд танилцуулж, захиалга авч эхэлснээс хойш анхдагч зах зээл дээр тогтох үнийг дээр заасан дээд доод үнийн хязгаарын хүрээнд дахин шинэчлэх ажиллагаа явагдаж болохыг Компанийн хөрөнгө оруулагч, эрх бүхий албан тушаалтнуудад танилцуулж ойлгуулсан болно.

Андеррайтер болон гэрээт брокер, дилерийн компаниуд нь Компанийн анхдагч зах зээлд санал болгон хувьцаа гаргах бизнесийн төслийн үнэлгээг хамгийн сайн мэдэх санхүүгийн зуучлагчдын хувьд нийтэд санал болгон гаргаж буй нийт 26,544,058 ширхэг энгийн хувьцааг бүрэн борлуулах үүрэг хүлээж байгаа бөгөөд анхдагч зах зээлд 250-аас доошгүй тооны хөрөнгө оруулагч хувьцааг худалдан авсан боловч нийтэд санал болгосон тооноос бага хэмжээний захиалга ирсэн тохиолдолд үлдэгдэл хувьцааг өөрсдийн хөрөнгөөр худалдан авах үүрэг хүлээсэн болно.

Анхдагч зах зээлд Компанийн нийтэд санал болгон гаргаж буй 26,544,058 ширхэг хувьцааг 250-аас доошгүй хөрөнгө оруулагчдад борлуулах шаардлагаас даван хувьцааны эрэлт ихэссэн, андеррайтер, гэрээт брокер, дилерийн компаниуд нь

хоёрдогч зах зээл дээр Компанийн энгийн хувьцааны арилжаанд зах зээл үүсгэгчээр ажиллах нөхцөлт гэрээтэй тохиолдолд Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын эзэмшиж буй энгийн хувьцаанаас тодорхой хугацааны турш Компанийн хувьцааны ханшийг тогтворжуулахын тулд гэрээгээр авч нийлүүлэлт хийж болно.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу Анд-Энерги ХХК-ийн анхдагч зах зээлд хөрөнгө оруулагчдад санал болгож буй 26,544,058 ширхэг хувьцааны андеррайтераар 3/41 тоот тусгай зөвшөөрөл бүхий "Бумбат-Алтай ҮЦК" ХХК ажиллаж байгаа бөгөөд ерөнхий андеррайтертай хамтран ажиллах брокер, дилерийн компаниуд нь 3/04 тоот тусгай зөвшөөрөл бүхий "Булган брокер ҮЦК" ХХК, 3/03 тоот тусгай зөвшөөрөл бүхий "Батс ҮЦК" ХХК, 3/20 тоот тусгай зөвшөөрөл бүхий "Дэлгэрхангай секюритиз ҮЦК" ХХК, 3/26 тоот тусгай зөвшөөрөл бүхий "Монсек ҮЦК" ХХК болно. Андеррайтер болон хамтран ажиллах брокер, дилерийн компаниуд нь Анд-Энерги ХХК-ийн нийтэд санал болгож буй 26,544,058 ширхэг энгийн хувьцааг анхдагч зах зээлд СЗХ-ны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-д заасан "захиалгын бүртгэл", "анхдагч зах зээлийн арилжаа"-ны аргын дагуу "Монголын үнэт цаасны биржийн арилжааны журам"-ын 5 дугаар бүлгийн 5.6-д заасан аргачлалаар үнэ тогтоон хуваарилах болно.

Үнэт цаас гаргагчийн санал болгосон үнээр худалдах:

- Арилжааг эхлүүлснээс хойш арван минутын турш андеррайтертай урьдчилан тохиролцож захиалгын бүртгэлд бүртгэгдсэн этгээдийн үнэт цаас гаргагчийн нийт гаргасан үнэт цаасны 5 хувь буюу түүнээс дээш хэмжээний үнэт цаас авах захиалгыг оруулна. Захиалгын хэмжээ нийт гаргаж буй үнэт цаасны хэмжээнээс давсан тохиолдолд өндөр үнэтэй, үнэ тэнцсэн тохиолдолд цаг хугацааны хувьд өмнө өгсөн захиалга түрүүлж биелнэ.
- Өмнөх үе дуусмагц үнэт цаасны гаргагчийн нийт гаргасан үнэт цаасны 5 хувь буюу түүнээс дээш хэмжээний үнэт цаас авах захиалгыг оруулна. Энэ үед зах зээлийн авах захиалга оруулах бөгөөд захиалгыг үнэт цаас гаргагчийн анхлан санал болгосон үнээр биелүүлнэ. Энэ үе 20 минутаас илүүгүй хугацаанд үргэлжлэх ба нийт авах захиалгын хэмжээ зарах захиалгын хэмжээнээс давсан тохиолдолд хувь тэнцүүлэх зарчмаар биелнэ.

Тэнцвэрт үнийн аргаар худалдах:

- Өмнөх үе дуусмагц тэнцвэрт үнийн аргаар арилжааг зохион байгуулна. Энэ үеийн үргэлжлэх хугацаа биелэх боломжит үнэт цаас дуусах хүртэл үргэлжлэх ба нэг цагаас илүүгүй байна. Биелэх боломжит үнэт цаасны хэмжээ нэг лотоос бага хэмжээнд хүрэх хүртэл сондгой захиалгыг бүртгэхгүй. Энэ үед үнэт цаасны 5 хувьд хүрээгүй боловч захиалгын бүртгэлд бүртгэгдсэн захиалгыг оруулна. Мөн нөхцөлт авах захиалгыг оруулж болно. Энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгасан нийтэд санал болгох үнийг арилжааны системийн "жишиг үнэ"-ээр тооцож арилжааны системээр дамжуулан худалдан авах санал болгож буй хөрөнгө оруулагчдад "жишиг үнэ"-ээс (+/-5%) тооцож үнийн санал оруулах боломжийг олгох ба үүний дараа хамгийн их хувьцаа зарагдах боломжит "үнэ"-ийг систем тооцон гаргаж "тэнцвэрт үнийн аргаар худалдах арга"-ын дагуу хуваарилна.
- Өмнөх үе дуусахад зарагдаагүй үнэт цаас үлдвэл андеррайтерийн гэрээнд заасны дагуу андеррайтер болон андеррайтертай гэрээ байгуулсан үнэт цаасны компаниуд үнэт цаас гаргагчийн санал болгосон үнээр үлдэгдэл үнэт цаасыг худалдан авна.

Андеррайтер болон гэрээт брокер, дилерийн компаниуд нь анхдагч зах зээлд олон нийтэд санал болгож буй Анд-Энерги ХХК-ийн 26,544,058 ширхэг энгийн хувьцааг хөрөнгө оруулагчдад санал болгох, "Үнэт цаасны бүртгэлийн бичиг баримт"-д тусгагдсан бизнес төслийн талаар танилцуулах танилцуулгын зардлыг өөрсдийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх бөгөөд энэхүү зардлыг Компанийн хувьцааг борлуулсан орлогоос "Андеррайтерийн гэрээ"-нд заасан шимтгэлийн хувь хэмжээнд орсонд тооцно.

Андеррайтер компанийн олон нийтэд санал болгож буй энгийн хувьцааны захиалга авах хугацааг 2017 оны 08 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн ажлын 6 өдөр байхаар тооцоолж байгаа болно. Анхдагч зах зээлийн захиалгыг андеррайтер болон гэрээт брокер, дилерийн компаниудын ажлын байрны хаягаар эсвэл тухайлан тогтоосон хаягаарх байранд ажлын өдрүүд болон ажлын цагаар мэргэжлийн брокеруудаар захиалгын маягтаар авах бөгөөд энэхүү саналуудыг үндэслэн олон нийтэд санал болгох үнийн саналыг шинэчлэн тогтоож болно. Энэхүү шинэчлэн тогтоосон "үнэ" нь энэхүү бүлэгт тодотгосон олон нийтэд санал болгох хамгийн дээд үнэ болон хамгийн доод үнээс хэтэрч болохгүй гэж тогтов.

Андеррайтер анхдагч зах зээл дээр нийтэд санал болгож буй компанийн энгийн 26,544,058 ширхэг хувьцааны захиалга авах хугацааг хамгийн багадаа ажлын 5 хоног байхаар тооцоолж байна. Энэхүү хугацаанд нийт санал болгож буй хувьцааны анхдагч зах зээлд санал болгож буй "үнэ" нь "Үнэт цаасны бүртгэлийн бичиг баримт"-д тусгасан анхны үнэ байна. Санал болгож буй үнээр 51%-аас дээш саналын эрхтэй энгийн хувьцааг олон нийтэд санал болгох 250-аас доошгүй тооны хөрөнгө оруулагчид худалдан авсан тохиолдолд захиалга амжилттай явагдсан гэж тооцох бөгөөд захиалга авах хугацааг дахин ажлын 5-аас доошгүй хоногоор сунгаж болно. Хугацааг сунгасан тохиолдолд анхдагч зах зээл дээр санал болгож буй "үнэ"-ийг шинэчлэн тогтоохгүй.

Андеррайтер болон гэрээт брокер, дилерийн компаниудын анхдагч зах зээлд захиалга авахаар тогтоосон хугацаанд олон нийтэд санал болгож буй 26,544,058 ширхэг энгийн хувьцааны 50% хүрэхгүй саналын эрхийн захиалга хийгдсэн тохиолдолд захиалга авах хугацааг дахин ажлын 10-аас доошгүй хоногоор сунгаж болно. Хугацааг сунгасан тохиолдолд анхдагч зах зээлд дээр санал болгож буй "үнэ"-ийг шинэчлэн тогтоож болох бөгөөд энэхүү үнэ нь нийтэд санал болгохоор "Үнэт цаасны бүртгэлийн бичиг баримт"-д тооцоолсон "дээд үнэ" болон "доод үнэ"-ийн хязгаараас хэтэрч болохгүй.

АНДЕРРАЙТЕР БОЛОН ГЭРЭЭТ БРОКЕР, ДИЛЕРИЙН КОМПАНИУД АНД-ЭНЕРГИ ХХК-ИЙН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОЖ БУЙ 26,544,058 ШИРХЭГ ЭНГИЙН ХУВЬЦААГ САНАЛ БОЛГОЖ ТАНИЛЦУУЛАХ БОЛОН ЗАХИАЛГА АВАХ ХУГАЦАА НЬ "ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА"-Д ЗААСАН ХУВААРИЙН ДАГУУ ЯВАГДАХ БОЛНО.

АРВАН ДӨРӨВ. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Компани нь бие даасан тайлан тэнцэлтэй, харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хариуцлага хүлээх, хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж түүнийг захиран зарцуулах эрх нь Монгол Улсын Иргэний болон Компанийн тухай хууль, Компанийн дүрмээр хязгаарлагддаг, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр үйл ажиллагааг явуулж байна.

Бид Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хуулиудын хүрээнд Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлд заасны дагуу нягтлан бодох бүртгэлээ хөтлөн, санхүүгийн тайлан гаргах үүрэг хүлээдэг.

Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд болохын хувьд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу орлого, татвараа өөрөө тодорхойлж, албан татвараа сайн дураар төлдөг. Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.1.8 дугаар заалт, Засгийн газрын 2013 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 303 дугаар тогтоолоор батлагдсан жагсаалтын дагуу Компанийн үйлдвэрлэж буй “8541.40.00” БТКУС-ын кодтой “Эрчим хүчний хэмнэлттэй гэрлийн шил”-ний үйлдвэрлэл болон борлуулалтаас олсон орлого нь орлогын албан татвараас чөлөөлөгддөг. Харин цахилгаан тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, гэр ахуй, хөнгөн үйлдвэр, хүнд үйлдвэрийн автоматжуулалт, цахилгаан щитны угсралт, гудамж талбай, албан газрын гэрэлтүүлгийн ажил гэх мэт ажил үйлчилгээний орлогод орлогын албан татвар ноогдоно.

Манай Компани цахилгааны угсралт, суурилуулалт, автоматжуулалтын чиглэлээр анх байгуулагдсан бөгөөд 2014 оны 9 дүгээр сард LED гэрлийн үйлдвэрийг ашиглалтанд оруулж, өнөөдрийн байдлаар LED гэрэл үйлдвэрлэхээс гадна цахилгаан тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, гэр ахуйн, хөнгөн үйлдвэр, хүнд үйлдвэрийн автоматжуулалт, цахилгаан щитны угсралт, гудамж талбай, албан газрын гэрэлтүүлгийн ажил зэрэг ажил үйлчилгээ үзүүлдэг.

Дээрх үйл ажиллагааны хүрээнд Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7.1-д заасны дагуу холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авах ёстой. Эрчим хүчний тухай хуулийн 6.1.6-д заасны дагуу Эрчим хүчний яамны “...0.4-10.0 кВ хүртэлх цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар угсралт, түүний туршилт, тохируулга, дагалдах үйлчилгээ”-ний тусгай зөвшөөрөл 2014 оны 4 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн 1 жилийн хугацаатай олгогдсон бөгөөд 2015 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгагдсан.

“Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, Холбоо дохиолол, интернет сүлжээ гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт”-ын тусгай зөвшөөрөл нь одоогоор сунгагдаагүй байна. Монгол Улсын Иргэний хуулийн 451-453 дугаар зүйл, Банкны тухай хуулийн 10 дугаар зүйл, Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийг тус тус үндэслэн Компани нь 2015 оны 08 дугаар сарын 07-

ны өдрийн №3Г-RCC2015072708-1 дугаар бүхий Зээлийн гэрээг Худалдаа хөгжлийн банктай байгуулсан. Энэхүү зээлийн гэрээний хавсралтад дурдсан эргэн төлөлтийн хуваарийн дагуу Компани нь уг зээлийг 2019 оны 02 дугаар сарын 05-ны өдөр төлж барагдуулах бөгөөд зээлийн хүү жилийн 0.9 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн жилийн хүү 21.6 хувь байгаа юм. Дээрх гэрээг дагалдан №БГ – RCC2015072708-1-1 орон сууц барьцаалсан гэрээ, №БГ – RCC2015072708-1-2 орон сууц барьцаалсан гэрээ, №БГ – RCC2015072708-1-3 өмчлөх эрхтэй газар барьцаалсан гэрээ, 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн №3Г – RCC2015072708-1-5 зээлийн хугацааг шинэчлэн тогтоосон гэрээг тус тус байгуулсан.

Компани нь захиргаа аж ахуйгаас гадна үйлдвэрлэлийн түвшинд боловсон хүчин, мэргэжилтэй ажилчдыг ажиллуулдаг ба энэ нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 4.1.1-д заасан хөдөлмөрийн харилцаа үүсэх нөхцөл тул Хөдөлмөрийн тухай хууль бүхэлдээ үйлчлэхээс гадна Хөдөлмөрийн тухай хуулийн 46.1, 46.2, Нийгмийн даатгалын тухай хуулийн 15-р зүйл, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 4.1.4-т тус тус заасанчлан нийгмийн даатгалын шимтгэл, орлогын албан татварыг төлөхтэй холбоотой хууль, тэдгээрийн заалтуудыг дагаж мөрддөг. Мөн Компанийн бизнесийн үйл ажиллагаа түүний онцлогоос хамаарч дээр дурдсан хөдөлмөрийн хуулиас гадна үйлдвэрлэлийн түвшинд Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 4.1.1, 4.1.4, 4.1.9 дэх заалтуудыг үндэслэн уг хуулийн үйлчлэлд хамаарагдана.

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 23.1-д "...хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувьцаат компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчилж болно" гэж зааснаар өөрийн үйл ажиллагааг тэлж зах зээлийн эрэлт, хэрэгцээнд суурьлан Компанийг өргөжүүлэн хөгжүүлэх, дотоодын зах зээлээс гадна үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийг гадаадад экспортлох зорилгоор хязгаарлагдмал хариуцлагатай компаниас хувьцаат компани болох зорилт тавин Монголын үнэт цаасны бирж ХХК-д Үнэт цаас гаргагчаар бүртгүүлэхээр ажиллаж байна.

Компанийн хэлбэрийг хувьцаат компани болгон өөрчилснөөр дээр дурдсан хуулиудын үйлчлэл хэвээр үргэлжлэх бөгөөд харин нэмж Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ болон МҮЦБ-ийн холбогдох дүрэм журмууд үйлчилж эхэлнэ. МҮЦБ дээр үнэт цаас гаргагчаар бүртгүүлж өөрийн компанийн хувьцааг нийтэд санал болгоход Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.2-т заасан зааснаас бусад бүх этгээд Компанийн нийтэд санал болгож буй хувьцаанаас худалдан авах эрхтэй.

Үүнээс гадна үнэт цаас гаргаж хөрөнгө босгосноор өөрийн бизнесийг өргөжүүлэх төслийг хэрэгжүүлэх боломж нээгдэх бөгөөд энэхүү бизнесийн төсөл нь зохиогчийн эрх, оюуны өмчийн хувьд Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 7.1.1, 26.1.8-д тус тус заасанчлан зохиогчийн болон оюуны өмчийн эрхийг тогтоолгох, эзэмших Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас оюуны өмчийн эрхийг баталгаажуулах, хамгаалуулахад чиглэгдсэн дагаж мөрдөхөөр заасан дүрэм журмууд мөрдөж ажиллана. Мөн бүтээгдэхүүн үйлдвэрлэхтэй холбоотой тоног төхөөрөмж, түүхий эдийн импорт, бараа бүтээгдэхүүний экспорт нь Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, конвенц, Монгол Улсын Гаалийн тухай хуулийн 3.1.14 тарифын бус хязгаарлалтад хамрагдах бараа, бүтээгдэхүүн, түүхий эдийг экспортлох, импортлохтой холбоотой үүсэх харилцаа мөн уг хуулийн бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэхэд баримтлах зарчим, гаалийн бүрдүүлэлт зэрэг бүлгүүдийг мөрдөж ажиллана.

АРВАН ТАВ. ҮНЭТ ЦААСЫГ НИЙТЭД САНАЛ БОЛГОХ

Энэ танилцуулга нь Анд-Энерги ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагчдад зориулагдсан болно.

15.1. Биржийн бүртгэлийн шалгуур шаардлагын хөнгөлөлт, чөлөөлөлт

Компанийн зүгээс бүртгэлийн урьдчилсан шалгууруас чөлөөлөгдөх хүсэлтээ Биржид хүргүүлэн, Бирж 2017 оны 02 дугаар сарын 13-ны өдөр холбогдох шалгууруас чөлөөлсөн болно.

Бүртгэлийн журмын 5.07(1)(b), 5.07(2)(b), 5.07(3)(b)

Бүртгэлийн журмын тавдугаар бүлэг нь үнэт цаас, үнэт цаас гаргагчид тавигдах шаардлагыг тодорхойлж байгаа бөгөөд уг бүлгийн 5.07(1)(b), 5.07(2)(b) болон 5.07(3)(b)-д заасны дагуу сүүлийн санхүүгийн гурван жилийн хугацаанд үнэт цаас гаргагч компанийн удирдлагын багийн дийлэнх нь тогтвортой ажилласан байх шаардлагатай байдаг. 2011 онд Т.Барс, Ц.Гүррагчаа нар Анд-Энерги ХХК-ийг үүсгэн байгуулж, үйл ажиллагааг нь хамтран удирдан зохион байгуулж ирсэн бөгөөд сүүлийн гурван жилийн хугацаанд Т.Барс, 2016 оны 12 дугаар сараас хойш Ц.Гүррагчаа Компанийн гүйцэтгэх захирлаар тус тус томилогдон ажилласныг харгалзан Бирж бидний гаргасан хүсэлтийн дагуу дээрх шаардлагуудаас чөлөөлсөн.

Бүртгэлийн журмын 5.20, 13.07, 13.16, 13.21

Бүртгэлийн журмын 13 дугаар бүлгээр бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, ТУЗ-ийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх хороод, нарийн бичгийн даргад тавигдах шаардлага, үүрэг хариуцлага, үйл ажиллагаатай холбоотой үүсэх харилцааг зохицуулсан байдаг. Уг бүлгийн 13.07, 13.16, 13.21-д заасны дагуу үнэт цаас гаргагчийн ТУЗ нь гурваас доошгүй хараат бус гишүүнтэй байх, аудит болон цалин урамшууллын хороотой байх шаардлагатай. Мөн Бүртгэлийн журмын 5.20-д заасны дагуу журмын 13.25-д заасан нөхцөлийг хангасан нарийн бичгийн даргатай байхыг шаарддаг. Бирж Анд-Энерги ХХК-ийг одоогоор хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэртэй байгааг харгалзан үзэж, “Компанийн тухай” хуулийн 75.2 заалтыг үндэслэн Бүртгэлийн журмын 13.07, 13.21-д заасан ТУЗ хараат бус гишүүнтэй байх, цалин урамшууллын хороотой байх, журмын 13.25-д заасан нарийн бичгийн даргатай байх зэрэг шалгууруас чөлөөлүүлэх хүсэлтийг Бүртгэлийн баримт бичгийн эцсийн төсөл ирүүлэх хүртэлх хугацаанд зөвшөөрөн хүлээн авч, холбогдох шаардлагуудаас чөлөөлсөн болно.

Компани нь хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит бус хурлын 02 тоот тогтоолоор ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг, ТУЗ-ийн 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 01 тоот тогтоолоор ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга нарыг тус тус томилсон. Мөн Компанийн тухай хуулийн 75.8-д заасан шаардлагын дагуу ТУЗ-ийн гишүүд болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар 2017 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Компанийн засаглалын чиглэлээр гэрчилгээ

олгох сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан болно. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүнийг ТУЗ-ийн 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 02 тоот тогтоолоор, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг ТУЗ-ийн 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 03 тоот тогтоолоор тус тус батлсан.

15.2. Үнэт цаасыг нийтэд санал болгох арга

Нийтэд санал болгож буй үнэт цаасны тоо:	26,544,058 ширхэг
Нийтэд санал болгож буй үнэт цаасны хэлбэр:	Биет бус
Нийтэд санал болгож буй үнэт цаасны нэрлэсэн үнэ:	1 төгрөг

Компанийн энгийн хувьцааны 34.0 хувь буюу 26,544,058 ширхэг хувьцааг нийтэд санал болгож байгаа бөгөөд СЗХ-ны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4.4.2-д заасны дагуу үнэт цаасыг нийтэд танилцуулах ажиллагаа дууссаны дараа СЗХ-ноос холбогдох зөвшөөрлийг авсаны үндсэн дээр анхдагч зах зээлд дараах арга хэлбэрээр байршуулна.

- Захиалгын бүртгэлийн арга: Компанийн ТУЗ-ийн 2017 оны 04 сарын 03-ны өдрийн 04 тоот тогтоолоор нийтэд санал болгон худалдах нэгж энгийн хувьцааны дээд үнийг 65 төгрөгөөр тогтоосон бөгөөд Монголын үнэт цаасны биржийн арилжааны гишүүн үнэт цаасны компаниудаар дамжуулан захиалгыг бүртгэхдээ дээрх үнийн хязгаарт багтаан захиалгыг хүлээн авна. Захиалгын бүртгэлийн үед ирүүлсэн харилцагчдын нийт захиалгыг Монголын үнэт цаасны биржийн арилжааны журмын 5.6.1.1, 5.6.2.1-д заасны дагуу хуваарилна. Дэлгэрэнгүйг "Андеррайтерийн үйл ажиллагаа" бүлгээс харна уу.
- Анхдагч зах зээлийн арилжаа: Захиалгын бүртгэлийн үед ирсэн захиалгын тоо хэмжээ нийтэд санал болгосон үнэт цаасны тоо хэмжээнээс бага байх тохиолдолд үлдэгдэл хувьцааг Монголын үнэт цаасны биржийн арилжааны журмын 5.6.1.2, 5.6.2.1-д заасны дагуу анхдагч зах зээлд санал болгосон үнээр худалдах арга болон тэнцвэрт үнийн аргаар арилжина. Дэлгэрэнгүйг "Андеррайтерийн үйл ажиллагаа" бүлгээс харна уу.

Үнэт цаасыг нийтэд санал болгох үйл ажиллагааг Монголын үнэт цаасны биржийн гишүүн андеррайтер, брокер дилерийн "Бумбат-Алтай ҮЦК" ХХК хариуцан гүйцэтгэнэ. СЗХ-ны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4.4.8 дахь заалтын дагуу нийтэд санал болгох үнэт цаасыг 1000 ширхэгээр багцлан нийт 26,544 ширхэг багцыг худалдах бөгөөд багцад орохгүй 58 ширхэг хувьцааг андеррайтер худалдан авна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгыг Анд-Энерги ХХК болон МҮЦБ-ийн албан ёсны вэб сайтаас, Анд-Энерги ХХК-ийн Орхон аймаг дахь төв оффис, андеррайтер "Бумбат-Алтай ҮЦК" ХХК болон МҮЦБ-ийн гишүүн үнэт цаасны компаниудад хүрэлцэн очиж, хэвлэмэл хэлбэрээр танилцах боломжтой бөгөөд Компанийн нийтэд санал болгон худалдах үнэт цаасны захиалгыг МҮЦБ-ийн гишүүн үнэт цаасны компаниудаар дамжуулан өгч болно. МҮЦБ-ийн гишүүдийн жагсаалтыг http://www.msx.mn/menu?id=29 холбоосоор харна уу.

Үнэт цаасыг нийтэд санал болгох үйл ажиллагаа амжилттай хэрэгжсэн тохиолдолд Компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлд бүртгэгдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан, хуульд заасан хугацаанд багтаан хуралдуулна.

АРВАН ЗУРГАА. НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

"Монголын үнэт цаасны биржийн бүртгэлийн журам"-ын 9 дүгээр бүлгийн 9.06-д, *"Шинээр өргөдөл гаргагч нь бүртгэлийн баримт бичиг ирүүлэхээс өмнөх сүүлийн 3 жилийн хугацаанд томоохон хэмжээний бизнес, компани худалдан авсан бөгөөд тус хэлцэл нь их хэмжээний хэлцэл эсхүл их хэмжээний худалдан авалт байх тохиолдолд тухайн компани эсвэл бизнесийг худалдан авах хүртэлх, бүртгэлийн баримт бичиг ирүүлэхээс өмнөх сүүлийн 3 жилийн хугацааны санхүүгийн мэдээлэл (худалдан авахаас өмнөх үеийн санхүүгийн мэдээлэл)-ийг бүртгэлийн баримт бичигт тусгана. Тус санхүүгийн мэдээллийг шинээр өргөдөл гаргагчийн баримталдаг нягтлан бодох бүртгэлийн бодлогод нийцүүлэн боловсруулж мэргэшсэн нягтлан бодогчийн дүгнэлтийн тайлбар хэсэгт тусгах эсвэл тусад нь дүгнэлт хэлбэрээр гаргана"* гэж заасан.

Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1-д *"хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл (компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй)"*-ийг их хэмжээний хэлцэлд тооцохоор заасан байна.

Манай компанийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар балансын активын нийт дүн 155,811,600 (нэг зуун тавин таван сая найман зуун арван нэгэн мянга зургаан зуун) төгрөг байсан бөгөөд энэхүү активын дүнгийн 25.0 хувиас буюу 38,952,900 (гучин найман сая есөн зуун тавин хоёр мянга есөн зуун) төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 хэлцлийг 2015 онд хийсэн. Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн хурлын 01 тоот тогтоолыг үндэслэн 2015 оны 07 дугаар 06-ны өдөр ДБЧЭ ХХК-тай 74,415,000 төгрөгийн үнийн дүн бүхий "Бүтээгдэхүүн нийлүүлэх тухай гэрээ", хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн хурлын 02 тоот тогтоолыг үндэслэн Худалдаа хөгжлийн банкны Эрдэнэт салбартай 100,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий "Зээлийн гэрээ" тус тус байгуулсан бөгөөд дээрх хэлцлүүд нь Компанийн тухай хуульд заасан их хэмжээний хэлцэлд тавигдах шаардлагыг хангасан болно.

Харин 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар балансын активын нийт дүн 457,685,367 (дөрвөн зуун тавин долоон сая зургаан зуун наян таван мянга гурван зуун жаран долоон) төгрөг байсан бөгөөд энэхүү активын дүнгийн 25.0 хувиас буюу 114,421,341 (нэг зуун арван дөрвөн сая дөрвөн зуун хорин нэгэн мянга гурван зуун дөчин нэгэн) төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хэлцэл 2016 онд хийгдээгүй.

Мөн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар балансын активын нийт дүн 579,440,303 (таван зуун далан есөн сая дөрвөн зуун дөчин мянга гурван зуун гурван) төгрөг байгаа бөгөөд энэхүү дүнгийн 25.0 хувиас буюу 144,860,075 (нэг зуун дөчин дөрвөн сая найман зуун жаран мянга далан таван) төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хэлцэл хийгдээгүй.

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 31

Үнэт цаасыг нийтэд санал болгох үйл ажиллагаанд оролцогч байгууллагууд

Үнэт цаасыг нийтэд санал болгох үйл ажиллагаанд дараах мэргэжлийн байгууллагууд хамтран оролцсон болно.

Андеррайтер

Бид Монголын үнэт цаасны биржийн гишүүн "Бумбат-Алтай ҮЦК" ХХК-ийг андеррайтераар сонгон хамтран ажиллаж байна.

Бумбат-Алтай ҮЦК нь 1995 онд брокер дилерийн үйл ажиллагаа явуулах чиглэлээр байгуулагдсан бөгөөд СЗХ-ны 2011 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн №145 тоот тогтоолоор үнэт цаасны зах зээлд брокер дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгасан. Мөн СЗХ-ны 2016 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн №120 тоот тогтоолоор андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж олгосон.

Хууль зүйн дүгнэлт гаргасан байгууллага

Манай үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх дүгнэлтийг өмгөөллийн "Цогт энд Нандин" ХХН гүйцэтгэсэн бөгөөд СЗХ-ны 2016 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 206 тоот тогтоолоор тус нөхөрлөлийг үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө өгөх хуулийн этгээдээр бүртгэсэн байна.

Аудитын дүгнэлт гаргасан байгууллага

Компанийн 2016 оны санхүүгийн мэдээлэл үнэн зөв эсэх аудитын дүгнэлтийг "Од бүртгэл аудит" ХХК гэрээний дагуу гүйцэтгэсэн. СЗХ-ны 2016 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 121 тоот тогтоолоор "Од бүртгэл аудит" ХХК-ийг үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэх шийдвэр гарсан байна. Компанийн 2014, 2015 оны санхүүгийн мэдээлэл үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх аудитын дүгнэлтийг "Бэйкер Тилли Далайван Аудит" (хуучин нэрээр), "Далайван аудит" ХХК гүйцэтгэсэн бөгөөд СЗХ-ны 2012 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 259 тоот тогтоолоор тус компанийг үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэсэн байна.

Хөрөнгийн үнэлгээ хийсэн байгууллага

Компанийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг "Далайван аудит" ХХК гүйцэтгэсэн. СЗХ-ны 2012 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 261 тоот тогтоолоор тус компанийг үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх үнэлгээний компаниар бүртгэх шийдвэр гарсан байна.

СЗХ-ны тогтоолын хуулбартай "Хавсралт 7. Бусад" хэсгээс танилцана уу.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
00 | "АНД-ЭНЕРГИ" ХХК
КА01070 4385772

Бумбат Алтан
2087103
ПЮН0230

ХАВСРАЛТ 1. ТӨСӨВЛӨСӨН САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

1. Төсөвлөсөн санхүүгийн тайлан

МҮЦБ-ийн Бүртгэлийн журмын Бүлэг IX-өөр шаардсаны дагуу бид дунд хугацааны бизнес төлөвлөгөө, Компанийн хөгжлийн стратеги төлөвлөлтөндөө үндэслэн 2017-2021 оны төсөвлөсөн санхүүгийн мэдээллийг бэлтгэсэн бөгөөд төсөвлөсөн санхүүгийн мэдээллийн үзүүлэлтүүдийн суурь нь 2016 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд болно.

Төсөвлөсөн санхүүгийн мэдээлэл хэсэг дэх мэдээ, тайлангууд нь Компанийн хувьцаа эзэмшигч, удирдлага бидний өөрсдийн боловсруулсан төсөв бөгөөд АУДИТЛАГДААГҮЙ төсөвлөсөн санхүүгийн мэдээлэл гэдгийг анхаарна уу.

Төсөвлөсөн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компани цаашид тогтвортой өсөлтийн зарчмаар, тасралтгүй үйл ажиллагаа явуулна гэсэн төсөөлөөр бэлтгэсэн бөгөөд төсөвлөсөн санхүүгийн байдлын тайлан, төсөвлөсөн орлого, үр дүнгийн тайлан, төсөвлөсөн мөнгөн урсгалын тайлангаас бүрдэнэ.

Төсөвлөсөн санхүүгийн тайлангууд нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр илэрхийлэгдсэнээс гадна сая төгрөгөөр тоймчлон илэрхийлэгдсэн болно.

Төсөвлөсөн санхүүгийн тайланд гадаад валютаар илэрхийлэгдсэн үзүүлэлтүүдийг төгрөгт хөрвүүлэхдээ төсөвлөсөн санхүүгийн мэдээллийг бэлтгэсэн сүүлийн огноо болох 2017 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн Монгол банкны зарласан ханшаар хөрвүүлэн тооцсон болно. Үүнд:

1 ам.доллар = 2,404.89 төгрөг

1 юань = 349.2 төгрөгөөр тус тус тооцоолов.

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Төсөвлөсөн санхүүгийн байдлын тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Т	Төсөвлөсөн дүн /сая төгрөгөөр/				
		2017	2018	2019	2020	2021
ХӨРӨНГӨ						
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	(1)	141.45	330.99	831.46	1,616.45	2,857.20
Авлага		-	-	-	-	-
Бараа материал	(2)	341.41	572.06	707.98	707.54	442.12
Бусад эргэлтийн хөрөнгө		11.59	11.59	11.59	11.59	11.59
Эргэлтийн хөрөнгийн дүн		494.45	914.64	1,551.03	2,335.58	3,310.91
Үндсэн хөрөнгө	(3)	1,441.00	1,414.86	1,314.53	1,206.82	1,099.11
Биет бус хөрөнгө		-	-	-	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		1,441.00	1,414.86	1,314.53	1,206.82	1,099.11
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		1,935.46	2,329.50	2,865.55	3,542.39	4,410.02
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ						
Татварын өр	(4)	12.00	14.40	17.28	20.74	24.88
Бусад богино хугацаат өр төлбөр		1.06	1.06	1.06	1.06	1.06
Богино хугацаат өрийн дүн		13.06	15.46	18.34	21.80	25.94
Урт хугацаат өр төлбөр	(5)	65.89	-	-	-	-
Урт хугацаат зээл	(6)	54.48	8.29	-	-	-
Урт хугацаат өрийн дүн		120.37	8.29	-	-	-
Өр төлбөрийн нийт дүн		133.43	23.75	18.34	21.80	25.94
Эздийн өмч						
Өмч -Хувийн	(7)	51.52	51.52	51.52	51.52	51.52
Өмч-Хувьцаат	(8)	26.54	26.54	26.54	26.54	26.54
Нэмж төлөгдсөн капитал	(9)	1,445.54	1,445.54	1,445.54	1,445.54	1,445.54
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	(10)	73.37	73.37	73.37	73.37	73.37
Эздийн өмчийн бусад хэсэг		-	-	-	-	-
Хуримтлагдсан ашиг	(11)	205.05	708.78	1,250.24	1,923.62	2,787.10
Эздийн өмчийн дүн		1,802.03	2,305.76	2,847.21	3,520.60	4,384.07
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		1,935.46	2,329.50	2,865.55	3,542.39	4,410.02

Тайлбар:

(1) Жил бүрийн эцэст Компанид байх чөлөөт мөнгөний үлдэгдэл. Дэлгэрэнгүйг Хавсралт 2-ын 1.3 дахь хэсэг буюу Төсөвлөсөн мөнгөн гүйлгээний тайлангийн хэсгээс харж болно.

(2) Гэрлийн үйлдвэрийн бараа материал нь түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн болон бусад хангамжийн материал, бага үнэтэй түргэн элэгдэл зүйлсээс бүрдэнэ.

	2017	2018	2019	2020	2021
Түүхий эд, материал	130.31	173.75	183.97	183.97	183.97
Бэлэн бүтээгдэхүүн	183.76	371.46	496.60	496.60	231.61
Сав баглаа боодол	17.50	17.50	18.53	18.53	18.53
Хангамжийн материал	9.84	9.35	8.88	8.43	8.01
Дүн	341.41	572.06	707.98	707.54	442.12

Бид үйлдвэрлэлийг түүхий эдийн тасалдлаас шалтгаалсан зогсолтгүйгээр, байнга үргэлжлүүлж байх бодлого барьж байгаа бөгөөд энэ хүрээнд үйлдвэрлэлд шаардлагатай түүхий эдийн нөөцийн 15-20 хувийг байнга бэлэн байлгахаар тооцоолж байна.

Цаашид зөвхөн захиалга орж ирсэн тохиолдолд үйлдвэрлэл явуулах бус, байнгын тасралтгүй ажиллагаатай үйлдвэрлэл явуулахаар тооцоолж байгаа бөгөөд үйлдвэрийн тоног төхөөрөмжийн хүчин чадал, ажиллагсдын хөдөлмөрийн норм, бүтээмжид үндэслэн тооцоолсон үйлдвэрлэлийн нийт хүчин чадлын 85-90 хувийг ашиглаж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 80-аас дээш хувийг борлуулах зорилготой ажиллана. Үүнтэй холбоотойгоор тодорхой хэмжээний бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэлтэй байна. Бараа материалын төсөвлөсөн үлдэгдэл 2021 онд өмнөх оныхоос буурсан нь борлуулалтын хувь хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой.

(3) Нэмэлт хувьцаа гаргалтаас төвлөрсөн мөнгөн хөрөнгөөр Компанийн үндсэн хөрөнгө дараах байдлаар нэмэгдэнэ. Үүнд:

	Анхны өртөг
Барилга байгууламж	775.0
Машин тоног төхөөрөмж	420.77
Тээврийн хэрэгсэл	86.22
Дүн	1,281.99

Нэмэлт хувьцааны санхүүжилтээр худалдан авах хөрөнгийн задаргаа, дэлгэрэнгүй танилцуулгыг Үнэт цаасны танилцуулгын “Бизнесийн үйл ажиллагаа” болон “Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт” бүлэгт тусгасан болно.

	2017	2018	2019	2020	2021
Үндсэн хөрөнгө/ өртгөөр					
Газрын сайжруулалт	16.04	16.04	16.04	16.04	16.04
Барилга байгууламж	936.98	936.98	936.98	936.98	936.98
Машин тоног төхөөрөмж	471.30	471.30	471.30	471.30	471.30
Тээврийн хэрэгсэл	27.00	113.22	113.22	113.22	113.22
Тавилга эд хогшил	24.09	24.09	24.09	24.09	24.09
Компьютер бусад хэрэгсэл	13.94	13.94	13.94	13.94	13.94
Эцсийн үлдэгдэл	1,489.35	1,575.57	1,575.57	1,575.57	1,575.57
Хуримтлагдсан элэгдэл					
Барилга байгууламж	16.30	63.15	110.00	156.85	203.70
Машин тоног төхөөрөмж	13.43	60.56	107.69	154.82	201.95
Тээврийн хэрэгсэл	3.83	15.15	26.47	37.79	49.12
Тавилга эд хогшил	5.99	8.40	10.81	13.22	15.63
Компьютер бусад хэрэгсэл	8.80	13.44	6.07	6.07	6.07
Эцсийн үлдэгдэл	48.35	160.70	261.04	368.75	476.46
Дансны цэвэр дүн	1,441.00	1,414.87	1,314.53	1,206.82	1,099.11

Компани үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох шулуун шугамын аргыг ашигладаг бөгөөд Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасан хувь хэмжээгээр элэгдүүлэн бүртгэдэг.

(4) Манай үйлдвэрийн үйлдвэрлэн борлуулж буй LED гэрлийн борлуулалт нь Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.1.8 дахь заалтын дагуу албан татвараас чөлөөлөгдөх орлого юм. Харин цахилгааны шугамын засвар үйлчилгээ, автоматжуулалт зэрэг үйлчилгээний ажлын орлого нь албан татвар ногдох орлого тул энэхүү орлогыг олохтой холбогдон гарсан зардлыг хассан дүнгээс тооцоолон орлогын татварын зардлыг төсөвлөн бүртгэсэн болно. Татвар ногдуулалт, татварын чөлөөлөлттэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг Үнэт цаасны танилцуулгын “Хууль тогтоомжийн зохицуулалт” бүлгээс дэлгэрүүлж харна уу.

(5) "Эрдэнэт лед" гэрлийн үйлдвэрийн үйл ажиллагаанд шаардлагатай эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас олгосон зөвшөөрлийг үндэслэн тухайн үеийн гүйцэтгэх захирал асан Т.Барсаас 65.89 сая төгрөгийг 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдөр авсан. Зээлийн хугацаа 2 жил, жилийн хүү нь 11.4 хувь бөгөөд үндсэн төлбөрийг хугацааны эцэст бөөн дүнгээр нь төлөх, эсвэл үлдэгдэл төлбөрийг Компанийн энгийн хувьцааны тухайн үеийн зах зээлийн үнэ ханшаас 10 хувиар хямдруулсан үнээр хувьцаанд хөрвүүлэн эзэмшүүлэх нөхцөлтэй. Бид төсөвлөсөн санхүүгийн тайланг бэлтгэхдээ зээлийн төлбөрийг хугацааны эцэст бэлэн мөнгөөр төлөх боломжтой хэмээн тооцооллыг хийсэн бөгөөд өрийг хувьцаагаар солих эсэх асуудал нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудал байна.

(6) Компани LED гэрлийн үйлдвэрийн өргөтгөл, тоног төхөөрөмж, түүхий эд материал авах зориулалтаар 2015 оны 08 дугаар сарын 07-ны өдөр Худалдаа хөгжлийн банкнаас Хөгжлийн банкны эх үүсвэртэй, жилийн 9 хувийн хүүтэй 3 жилийн хугацаатайгаар авсан. Зээл нь эхний 12 сарын хугацаанд зөвхөн хүүний төлбөрийг төлж, үлдсэн хугацаанд үндсэн төлбөрийг хуваарийн дагуу төлөх нөхцөлтэй бөгөөд 2017 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар энэхүү зээлийн үлдэгдэл 96.65 сая төгрөг байсан. Банкны зээлийг 2017-2019 онд хуваарийн дагуу төлж барагдуулахаар төсөвлөсөн санхүүгийн тайланд тусгасан болно.

(7) IPO хийж нэмэлт хувьцаа гаргахын өмнөх сүүлийн санхүүгийн тайлангаар (2016 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон) Компани нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 5,152,670 (таван сая нэг зуун тавин хоёр мянга зургаан зуун дал) ширхэг энгийн хувьцаатай байсан. 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 03 тоот тогтоолоор Компанийн хувьцааг 1:10 харьцаагаар хувааж, нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 1 төгрөг болгон бууруулж, гаргасан хувьцааны тоог 51,526,700 (тавин нэгэн сая таван зуун хорин зургаан мянга долоон зуу) болгож нэмэгдүүлсэн байна.

(8) Бид үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа өргөжүүлж, шинэ тоног төхөөрөмж авах, үйлдвэрлийн байр барих зориулалтаар гүйлгээнд гаргасан энгийн хувьцааны 51.5%-тай тэнцэх хэмжээний буюу 26,544,058 (хорин зургаан сая таван зуун дөчин дөрвөн мянга тавин найм) ширхэг хувьцааг Монголын үнэт цаасны биржээр дамжуулан олон нийтэд нээлттэйгээр санал болгон худалдахаар төлөвлөж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор хувьцаат капиталаарх өмч нэрлэсэн үнээр буюу 26.54 сая төгрөгөөр нэмэгдэж бүртгэгдэнэ. Нэмэлт хувьцаа гаргасны дараа Компанийн үүсгэн байгуулагчдын болон бусад хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн хувь 66:34 харьцаатай болно.

(9) Бид төсөвлөсөн санхүүгийн тооцооллыг хийхдээ Компанийн хувьцааг нэг бүрийг нь 60-65 төгрөгөөр зах зээлд санал болгох боломжтой гэж үзэж байгаа бөгөөд энэ тооцооллоор хувьцаа гаргахтай холбоотой СЗХ-ны зохицуулалтын хөлс, андеррайтерийн шимтгэл, нийцүүлэгчдийн хөлс зэргийг хассанаар 1,445.54 сая төгрөгийн нэмж төлөгдсөн капитал бүртгэгдэнэ. Үнэт цаас гаргахтай холбоотой зардлын хувьд бид МҮЦБ-ийн шийдвэрээр бүртгэлийн хураамжаас эхний удаад чөлөөлөгдсөн гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

(10) IPO хийхээс өмнө бид Компанийн өмчлөлд байгаа эд хөрөнгийн зах зээлийн үнийг тодорхойлж, санхүүгийн тайлан бүртгэлд бүртгэх зорилгоор аудит, нягтлан бодох бүртгэлийн зөвлөгөө, үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллага болон Далайван аудит ХХК-ийн Орхон аймаг дах салбараар хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн бөгөөд хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл болох 73.37 сая төгрөгөөр хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэн бүртгэсэн. Далайван аудит ХХК-аас ирүүлсэн үнэлгээний тайланг бүртгэлийн баримт бичгийн хавсралтаас харна уу.

(11) Төсөвлөсөн орлого, үр дүнгийн тайлангаарх татварын дараах цэвэр ашиг (алдагдал)-ийн дүнгээр тохируулагдсан жил бүрийн хуримтлагдсан ашгийн дүн. Компанийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэх асуудал нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу ТУЗ-ийн бүрэн эрхийн асуудал байдаг тул бид энэхүү төсөвлөсөн санхүүгийн тайланд ногдол ашиг зарлах тухай тооцооллыг огт оруулаагүй орхисон болно.

Төсөвлөсөн орлого, үр дүнгийн тайлан

Төсөвлөсөн орлого, үр дүнгийн тайлан бэлтгэх үндсэн суурь нь гэрлийн үйлдвэрийн үйлдвэрлэлийн болон борлуулалтын тоо хэмжээ, бүтээгдэхүүний өртгийн тооцоо болон бусад орлого, зардлын төсөв юм. "Эрдэнэт лед" гэрлийн үйлдвэрийн нийт хүчин чадлыг автомат машинуудыг технологийн хүчин чадал болон ажилчдын хөдөлмөр зарцуулалт, бүтээмжид үндэслэн тооцоолсон бөгөөд үйлдвэрийн өргөтгөл хийхээс өмнө бид бүрэн хүчин чадлаар ажиллахад жилд дунджаар 50 мянга орчим ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой байсан бол үйлдвэрлэлд шинэ тоног төхөөрөмжүүдийг нэвтрүүлж, ажлын байрыг нэмэгдүүлснээр үйлдвэрийн нийт хүчин чадал 4 дахин нэмэгдэх тооцооллыг хийгээд байна. Өнгөрсөн хугацаанд бид захиалга орж ирсэн нөхцөлд үйлдвэрлэл явуулах зарчмаар ажилласнаас гадна үйлдвэрийн ажилчдыг гудамжны гэрэлтүүлэг, автоматжуулалтын зэрэг бусад үйлчилгээний ажилд ажиллуулдаг байснаас шалтгаалан үйлдвэрийн хүчин чадал ашиглалтын хувь маш бага хэмжээтэй байсан. Цаашид бид ахуйн хэрэглээний жижиг гэрлийн үйлдвэрлэлд анхаарлаа хандуулж, илүү хямд үнээр, олон тооны, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах бодлого баримтална.

ҮЗҮҮЛЭЛТ	Т	Төсөвлөсөн дүн /сая төгрөгөөр/				
		2017	2018	2019	2020	2021
Борлуулалтын орлого (цэвэр)	(1)	1,036.21	2,358.11	2,547.65	3,007.40	3,608.87
Борлуулалтын өртөг	(2)	510.60	1,063.65	1,126.22	1,324.96	1,589.96
Нийт ашиг (алдагдал)		525.61	1,294.46	1,421.43	1,682.43	2,018.92
Борлуулалт маркетингийн зардал	(3)	144.79	237.11	276.05	313.61	359.57
Ерөнхий ба удирдлагын зардал	(4)	378.21	538.92	586.32	674.29	770.47
Санхүүгийн зардал	(5)	-	0.30	0.33	0.40	0.52
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		2.61	518.13	558.74	694.12	888.36
Орлогын татварын зардал	(6)	12.00	14.40	17.28	20.74	24.88
Татварын дараах ашиг (алдагдал)		(9.39)	503.73	541.46	673.38	863.48

Тайлбар:

(1) Анд-Энерги ХХК-ийн нийт борлуулалтын орлого нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтын орлого болон бусад үйлчилгээний орлогоос бүрдэнэ. Үйлчилгээний орлого гэж гудамжны болон гоёлын гэрэлтүүлэг, үйлдвэрийн болон бусад автоматжуулалтын ажлууд гэх мэт захиалгат ажлын орлогуудыг ойлгоно. Бид нэмэлт хувьцааны санхүүжилтээр татан төвлөрүүлсэн хөрөнгөөр гэрлийн үйлдвэртээ хөрөнгө оруулалт хийж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байгаа тул үүнтэй холбоотойгоор нийт борлуулалтын орлогод эзлэх үйлчилгээний орлогын хувь буурах хандлагатай байгаа бол үйлдвэрлэсэн гэрлийн борлуулалтын хувьд цаашид тогтмол өсгөж, үндэсний брэндийг олон нийтэд таниулснаар зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэх стратеги барьж ажиллана.

2017 оны сүүлийн хагас жилд татан төвлөрүүлсэн хөрөнгөөр үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүлэх, тоног төхөөрөмжийн худалдан авалтыг хийж, суурилуулах, улмаар туршилтын үйлдвэрлэлийг эхлүүлж, 2018 оноос үйлдвэрлэлийн технологийн шинэчилсэн горимоор ажиллаж, үйлдвэрлэлийн тоо хэмжээг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хувьд ахуйн хэрэглээний буюу жижиг чийдэнгийн үйлдвэрлэлд төвлөрч, том оврын буюу гудамжны гэрэл, прожектор, таазны гэрлүүдийг цөөн тоогоор үйлдвэрлэхээр төлөвлөж байна.

Бүтээгдэхүүний нэр төрөл	Үйлдвэрлэлийн нийт хүчин чадал /ширхэгээр/	
	Одоо байгаа	Ирээдүйд
T8 Led гэрэл 18вт	10,500	62,500
E 27 Led чийдэн 9вт	14,000	49,000
Нүдэн гэрэл 5вт	21,000	37,500
Гудамжны гэрэл 100вт	656	1,500
Прожектор 100вт	656	1,250
Таазны гэрэлтүүлэг 160вт	525	750
Дүүжин таазны гэрэлтүүлэг 48вт	750	1,250
Үйлдвэрлэх боломжтой бүтээгдэхүүний тоо хэмжээ	48,088	153,750

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 21

Нийт үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалтын хувийг жил бүр тодорхой хэмжээгээр нэмэгдүүлж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тодорхой хувийг борлуулахаар орлогын таамаглалыг хийсэн.

	2017	2018	2019	2020	2021
Үйлдвэрийн хүчин чадал ашиглалтын хувь	85%	85%	85%	90%	90%
Борлуулалтын хувь	80%	85%	90%	100%	120%

Гэрлийн үйлдвэрлэлийн гар ажиллагаанд зарцуулах хугацааг тодорхой хэмжээнд хэмнэх конвейр, угсралтын ширээ болон бусад цахилгаан багаж хэрэгслүүдийг авч суурилуулснаар нэгж бүтээгдэхүүний өртөг тодорхой хэмжээнд буурах боломжтой болж байгаа тул бид жижиг гэрлийн борлуулах үнийг одоо зах зээлд борлуулж байгаа үнээс 10-15 хувиар хямдруулж, борлуулалтыг дэмжих зорилготой байна.

Орлогын төрөл /бүтээгдэхүүнээр/	Борлуулалтын орлогын таамаглал /сая төгрөгөөр/				
	2017	2018	2019	2020	2021
Үйлдвэрлэлийн орлого	736.21	1,998.11	2,115.65	2,489.00	2,986.79
T8 Led гэрэл 18вт	91.04	575.74	609.61	717.19	860.63
E 27 Led чийдэн 9вт	89.01	331.01	350.48	412.34	494.80
Нүдэн гэрэл 5вт	145.66	276.36	292.61	344.25	413.10
Гудамжны гэрэл 100вт	139.81	339.54	359.51	422.96	507.55
Прожектор 100вт	110.80	224.25	237.44	279.34	335.21
Таазны гэрэлтүүлэг 160вт	126.24	191.61	202.88	238.68	286.42
Дүүжин таазны гэрэлтүүлэг 48вт	33.66	59.61	63.11	74.25	89.10
Үйлчилгээний орлого	300.00	360.00	432.00	518.40	622.08
Борлуулалтын орлогын дүн	1,036.21	2,358.11	2,547.65	3,007.40	3,608.87

(2) LED гэрлийн өртөгт үйлдвэрийн ажилчдын цалин хөлс, түүнтэй холбоотой ЭМНДШ-ийн зардал, үндсэн болон туслах түүхий эд материалууд, үйлдвэрийн ашиглалтын зардлууд болон сав баглаа боодлын өртөг орно. Үйлдвэрийн үндсэн түүхий эд нь PCB зэс хавтан, LED чип, тэжээлийн блок болон корпусаас бүрдэнэ. Бид үйлдвэрийн түүхий эдийн техникийн тодорхойлолтуудыг өөрсдөө боловсруулан, БНХАУ, Тайванийн төрөлжсөн үйлдвэрүүдэд захиалгаар хийлгэдэг. Цаашид түүхий эдийн татан авалтын давтамжийг бууруулж, нэг удаагийн татан авалтын хэмжээг нэмэгдүүлснээр түүхий эдийн үнэ буурч, улмаар бидний бүтээгдэхүүний нэгжийн өртөг буурах боломжтой болж байгаа юм. Мөн манай үйлдвэр нь ус, дулааны асуудлаа гүний худаг, нам даралтын зуух зэргээр шийдсэн тул үйлдвэрлэлтэй холбоотой ашиглалтын зардал харьцангуй бага байна.

Нэгж бүтээгдэхүүний өртгийн тооцоог дараах хүснэгтэд харуулаа.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КАМ01070 4385772

БҮРТГЭЛИЙН БАРИМТ БИЧИГ | 107

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

СЭХ он сар өдөр БҮРТГЭВ № 01

Зардлын төрөл				T8 Led гэрэл /120см/	E27 Led чийдэн 9Вт	Нүдэн гэрэл 5W	Гудамжны гэрэл 100Вт	Прожектор 100Вт	Таазны гэрэл 160W /JC-G007/	Дүүжин таазны гэрэлтүүлэг /48W/
ШМ	PCB хавтан	Тоо ширхэг		1	1	1	-	-	-	6
		Нэгж үнэ	CNY	1.1	0.5	0.3	-	-	-	0.7
			MNT	386	163	104	-	-	-	237
		Нийт үнэ		386	163	104	-	-	-	1,425
	Тэжээлийн блок	Тоо ширхэг		1	1	1	2	2	1	2
		Нэгж үнэ	CNY	4.9	3.6	2.8	68.0	68.0	178.0	4.9
			MNT	1,694	1,257	960	23,743	23,746	62,157	1,694
		Нийт үнэ		1,694	1,257	960	47,491	47,491	62,157	3,387
	LED чип	Тоо ширхэг		96	18	10	2	2	4	288
		Нэгж үнэ	CNY	0.0	0.1	0.1	15.0	15.0	12.0	0.0
			MNT	16	34	34	5,238	5,238	4,190	16
		Нийт үнэ		1,542	616	342	10,476	10,476	16,762	4,626
	Хөнгөн цагаан корпус хуванцар таг	Тоо ширхэг		1	1	1	1	1	1	1
		Нэгж үнэ	CNY	3.7	4.7	7.2	148.8	72.3	136.0	30.6
			MNT	1,276	1,632	2,523	51,944	25,230	47,491	10,685
		Нийт үнэ		1,276	1,632	2,523	51,944	25,230	47,491	10,685
ШХ	Цалин хөлс			1,119	746	497	2,176	2,176	2,487	2,291
ҮНЗ	Туслах материал			600	414	382	579	579	638	1,079
	ЭМНДШ			146	97	65	283	283	323	298
	ТЭМ-ийн тээвэр, бусад			550	408	431	11,049	8,378	12,705	2,120
	Ашиглалтын зардал /цахилгаан/			14	12	10	1,098	1,318	2,510	1,130
	Сав, баглаа боодол			510	740	510	4,419	3,351	5,082	848
Нэгж бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өртөг				7,836	6,085	5,824	129,515	99,281	150,156	27,890

Бүтээгдэхүүний өртгийн тооцоонд түүхий эд материалын үнийг бидний хамтран ажилладаг байгууллагуудаас ирүүлсэн шинэчилсэн үнийн саналд үндэслэн тооцооллоо. Шууд хөдөлмөрийн зардлын хувьд үйлдвэрийн ажилчдын тогтмол цалин хөлсийг үйлдвэрлэх бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэгж бүтээгдэхүүнд зарцуулах гар болон автомат ажиллагааны ач холбогдол зэргийг тооцоолсны үндсэн дээр хуваарилан тооцсон болно.

"Эрдэнэт лед" гэрлийн үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн онцлог, бүтэц зохион байгуулалт, үйлдвэрлэлийн технологитой холбоотойгоор үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг тооцох ажлын захиалгын аргыг ашиглах нь тохиромжтой гэж үзэж байна.

Түүхий эд материал болон бусад бараа материалыг байнгын системээр бүртгэх бөгөөд материалын зарцуулалтын өртөг тооцох FIFO аргыг ашиглана.

(3) Борлуулалт маркетингийн зардалд борлуулалтын менежер, дэлгүүрийн худалдагч, маркетингийн менежер гэх мэт борлуулалтын ажилчдын үндсэн болон нэмэгдэл цалин хөлс, түүнд хамаарах ЭМНДШ-ийн зардал болон дэлгүүрүүдийн түрээс,

АНД-ЭНЕРГИ ХХК 108 Д "АНД-ЭНЕРГИ" ХХК КА:4001070 4355772

2087103 ПЮН0230

маркетинг сурталчилгааны зардлуудыг хамааруулан төсөвлөв. Борлуулалтын албанд маркетингийн менежер 2, борлуулалтын менежер 2, хангамжийн менежер 1, худалдагч 4 гэсэн орон тоотойгоор ажиллахаар төлөвлөж байгаагаас гадна Улаанбаатар хот бусад орон нутагт гэрээт борлуулагчдыг ажиллуулж, борлуулалтын шимтгэл төлөхөөр тооцоолсон болно.

Борлуулалтыг дэмжих маркетингийн үйл ажиллагааны төлөвлөгөөний тухай уг танилцуулгын "Бизнесийн үйл ажиллагаа" бүлгээс дэлгэрүүлэн харж болно.

Борлуулалт, маркетингийн зардлын төсөв
/сая төгрөгөөр/

	2017	2018	2019	2020	2021
Цалин хөлс	49.53	100.84	125.85	144.39	167.34
ЭМНДШ-ийн зардал	6.44	13.11	16.36	18.77	21.75
Түрээсийн зардал	6.00	13.20	14.52	15.97	17.57
Гэрээт борлуулагчийн шимтгэл	-	39.96	42.31	49.78	59.74
Маркетинг, сурталчилгааны зардал	82.82	70.00	77.00	84.70	93.17
Дүн	144.79	237.11	276.05	313.61	359.57

(4) Ерөнхий ба удирдлагын зардалд захиргааны ажилтнууд болон ТУЗ-ийн гишүүдийн цалин хөлс, гэрээт ажилчдын цалин хөлс болон байгууллагын төлөх ЭМНДШ-ийн зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл, томилолт, холбоо, бичиг хэрэг, шатахуун тослох материалын зардал зэрэг ерөнхий шинжтэй зардлуудыг төсөвлөснөөс гадна үйлдвэрийн өргөтгөлийн ажлын хэрэгжүүлэх явцад гарч болзошгүй, урьдчилан таамаглах боломжгүй зардлуудыг борлуулалтын тодорхой хувиар тооцоолон төсөвлөсөн болно.

Компанийн хүний нөөцийн төлөвлөгөөний дагуу ирэх 5 жилд удирдлага, санхүү, хүний нөөц, бичиг хэрэг, аж ахуйн чиглэлээр 8 орон тоотой ажиллахаар төлөвлөж цалингийн зардлын төсөвлөлөө. Мөн ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга, ТУЗ-ийн гишүүд болон хараат бус гишүүдийн цалин хөлсний төсвийг удирдлагын зардалд, тендерийн болон бусад ажилд туслахаар орон тооны бус, гэрээт ажилчдын цалин хөлсийг тооцон төсөвлөсөн болно. ЭМНДШ-ийн зардлын хувьд байгууллагын төлөх ЭМНДШ-ийн зардлыг цалин хөлсний 13%-иар тооцон төсөвлөв.

Компани үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох шулуун шугамын аргыг ашигладаг бөгөөд хөрөнгийн ашиглалтын хугацаанд үндэслэн элэгдлийн зардлыг төсөвлөсөн ба шинээр худалдан авах тоног төхөөрөмж, барилга байгууламжийн ашиглалтыг 2018 оноос бүрэн эхлүүлнэ хэмээн үзэж, элэгдлийг 2018 оноос тооцоолсон болно.

2017 онд тоног төхөөрөмж, түүхий эдийн худалдан авалт хийх гэрээ хэлцэл байгуулах, худалдан авалт хийх зорилгоор томилолтын зардлыг харьцангуй өндөр төсөвлөв.

Компани одоогоор 2 төрлийн урт хугацаат зээлийн гэрээтэй байгаа бөгөөд эдгээр гэрээтэй холбоотой зээлийн хүүний зардлыг ерөнхий удирдлагын зардлын хэсэгт тусгалаа.

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Ерөнхий ба удирдлагын зардлын төсөв
/сая төгрөгөөр/

	2017	2018	2019	2020	2021
Цалин хөлс	65.94	74.18	83.42	91.76	100.94
Удирдлагын зардал	20.80	34.32	37.75	41.53	45.68
Гэрээт ажилчдын цалин хөлс	15.00	18.00	21.60	25.92	31.10
ЭМНДШ-ийн зардал	12.77	15.69	17.73	19.78	22.10
Элэгдлийн зардал	22.91	112.36	100.34	107.71	107.71
Ашиглалтын зардал	2.00	4.00	4.80	5.76	6.91
Бичиг хэрэг, хэвлэл, материал	6.06	2.49	2.67	2.86	3.08
Харилцаа холбоо	1.00	1.10	1.21	1.33	1.46
Томилолтын зардал	15.00	4.00	4.40	4.84	5.32
Шатахуун тослох материал, сэлбэг хэрэгслийн зардал	8.00	8.80	9.68	10.65	11.71
Аж ахуй, засвар үйлчилгээ	1.00	1.10	1.21	1.33	1.46
Зээлийн хүүгийн зардал	13.00	6.91	-	-	-
Төлөвлөөгүй бусад зардал	194.72	255.96	301.51	360.82	432.98
Дүн	378.21	538.92	586.32	674.29	770.47

(5) Бид хувьцаагаа МҮЦБ-д бүртгүүлэн, олон нийтэд арилжаалах бөгөөд тус биржийн Бүртгэлийн журамд заасны дагуу биржийн бүртгэлийн хураамжид Компанийн үнэт цаасны зах зээлийн үнэлгээний 0.01 хувьтай тэнцэх хэмжээний хураамж төлнө.

(6) Өмнөх хэсэгт дурдсанчлан бид зөвхөн гудамжны болон гоёлын гэрэлтүүлэг, үйлдвэрийн болон цахилгаан төхөөрөмжийн автоматжуулалт зэрэг гэрээт болон үйлчилгээний ажлаас олсон орлогод татвар ногдуулан төлнө.

Төсөвлөсөн мөнгөн гүйлгээний тайлан

Төсөвлөсөн мөнгөн гүйлгээний тайлан нь үндсэн үйл ажиллагааны төсөвлөсөн мөнгөн гүйлгээ, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны төсөвлөсөн мөнгөн гүйлгээ, санхүүгийн үйл ажиллагааны төсөвлөсөн мөнгөн гүйлгээнээс бүрдэнэ. Төсөвлөсөн мөнгөн гүйлгээний тайлангийн үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг төсөвлөхдөө шууд бус аргаар тооцоолон төсөвлөв.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
110 Д "АНД-ЭНЕРГИ"-ХХК
КА01070 4385772

2097103
ПЮН0230

ҮЗҮҮЛЭЛТ	Төсөвлөсөн дүн /сая төгрөгөөр/				
	2017	2018	2019	2020	2021
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Цэвэр ашиг	(9.39)	503.73	541.46	673.38	863.48
(+) Элэгдлийн зардал	22.91	112.36	100.34	107.71	107.71
(+) Авлагын бууралт	37.16				
(-) Авлагын өсөлт					
(+) Бараа материалын бууралт				0.44	265.41
(-) Бараа материалын өсөлт	195.03	230.65	135.92		
(+) Богино хугацаат өрийн өсөлт		2.40	2.88	3.46	4.15
(-) Богино хугацаат өрийн бууралт	13.24				
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(157.59)	387.83	508.76	784.99	1,240.75
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Мөнгөн орлогын дүн (+)	-	-	-	-	-
Хүлээн авсан хүүний орлого	-	-	-	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	1,195.77	86.22	-	-	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,195.77	86.22	-	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(1,195.8)	(86.22)	-	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Мөнгөн орлогын дүн (+)	1,592.64	-	-	-	-
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,592.64	-	-	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	162.73	112.08	8.29	-	-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	42.17	112.08	8.29	-	-
Төлсөн ногдол ашиг	-	-	-	-	-
Бусад - Хувьцаа гаргалттай холбоотой зардалд төлсөн	120.56	-	-	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,429.91	(112.08)	(8.29)	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	76.55	189.54	500.47	784.99	1,240.75
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	64.90	141.45	330.99	831.46	1,616.45
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	141.45	330.99	831.46	1,616.45	2,857.20

Тайлбар:

(1) Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний төсвийг шууд бус аргаар боловсруулаа. Энэ арга нь орлогын тайлангийн татварын дараах цэвэр ашгийг үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол, бусад мөнгөн бус зүйлс болон санхүүгийн байдлын

тайлангийн эргэлтийн хөрөнгө, богино хугацаат өр төлбөрийн өөрчлөлтөөр тохируулан илэрхийлдэг арга юм.

(2) Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээнд нэмэлт хувьцааны санхүүжилтээр худалдан авах үндсэн хөрөнгийн төлбөрт төлөх мөнгөн дүн тусгагдсан байна. Эндээс харахад нэмэлт хувьцааны санхүүжилтээр төвлөрсөн мөнгөн хөрөнгөөс 1,282.0 сая төгрөгийг үндсэн хөрөнгө худалдан авахад зарцуулах нь харагдаж байна.

(3) 2017 онд хувьцаа гаргалтаас 1,592.6 сая төгрөг хүлээн авахаар тооцоолж байгаа бөгөөд хувьцаа гаргалттай холбоотой зардалд 120.6 сая төгрөгийг төлж, урт хугацаат зээлийн төлөлтөнд 2017-2019 онд 162.5 сая төгрөгийг төлөхөөр "Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ" хэсэгт тооцоолсон байна.

2. Төсөвлөсөн санхүүгийн тайлангийн харьцааны үзүүлэлтүүд

Ирэх 5 жилийн хугацаанд Компанийн татварын дараах цэвэр ашиг 500.0 сая төгрөгөөс 860.0 сая төгрөг болж өсөх бөгөөд ахиуц ашгийн түвшин 5 жилийн дундаж нь 20.5 хувь байна.

Бид Компанийн энгийн хувьцааны зах зээлийн үнийг ногдол ашиг болон Компанийн өсөлтөд тулгуурлан үнэлэх суурь үнэлгээний аргаар таамаглан тооцсон болно. Уг тооцоонд нэгж хувьцаанд ногдох ашгийг тооцохдоо нэгж хувьцаанд олгох боломжит ашиг (EPS)-ийн 5 хувиар тооцоолов.

Хувьцааны зах зээлийн үнийг таамаглах энэхүү үнэлгээг Валтер, Гордон нарын загварыг ашиглан хийсэн бөгөөд энэхүү хоёр загвар нь утгын хувьд ижилхэн боловч тавигдах нөхцөлөөрөө ялгардаг. Тиймээс бид хорогдуулалт болон хувьцааны өртгийн хувь тогтмол байх нөхцөл шаарддаг Валтерын загварыг сонгож тооцлоо.

Харин хувьцааны дансны үнийн хувьд эзэмшигчдийн өмчийн дүнг эргэлтэнд гаргасан энгийн хувьцааны тоонд харьцуулах замаар гаргасан бөгөөд бидний таамагласан хувьцааны зах зээлийн үнэ болон төсөвлөсөн санхүүгийн мэдээлэлд тулгуурлан тооцоолсон хувьцааны дансны үнийн харьцаа дараах байдалтай байна.



СЗХ он сар өдөр БҮРТГЭВ № 01
ОРХОН АЙМАГ АНД-ЭНЕРГИ ХХК 112-| "АНД-ЭНЕРГИ" ХХК КА#01070 4385772
Бумбат Алтан 2087103 ПЮН0230

Дээрх аргаар тооцоолсон зах зээлийн үнийг нэгж хувьцаанд ногдох ашигт харьцуулсан харьцаа буюу P/E харьцаа нь дундажаар 5.97 байна.

	Хөрөнгө оруулалтын харьцаанууд		
	Үзүүлэлтийн нэгж	Товч утга	Үр дүн
Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж	Хувь	ROE	19.44
Төслийн дотоод өгөөж	Хувь	IRR	21.12
Цэвэр өнөөгийн үнэ цэнэ	Сая төгрөг	NPV	35.03
Хөрөнгө оруулалтыг нөхөх хугацаа	Жил	PBP	4.93

Хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх хугацаа (PBP)-г 20 хувийн хүүний түвшинд хорогдуулсан мөнгөн урсгалаар нь тооцоолоход 4.9 жил болсон бөгөөд 5 жилээр тооцсон төслийн цэвэр өнөөгийн үнэ цэнэ (NPV) нь эерэг 35.03 сая төгрөг буюу энэ төсөл дунд хугацаанд амжилттай хэрэгжих боломжтой гэсэн дүгнэлтэнд хүрч байна.

3. Нэгж хувьцаанд ногдох ашгийн төсөөлөл

Нэгж хувьцаанд ногдох ашгийн таамаглал нь аудитлагдаагүй тооцоолол бөгөөд Компанийн удирдлагын боловсруулан баталсан ашгийн таамаглал, төсөвлөсөн санхүүгийн мэдээлэлд үндэслэсэн тооцоолол юм.

	Т	2017	2018	2019	2020	2021
Энгийн хувьцаанд хуваарилах боломжит ашиг (сая төгрөг)	(1)	14.59	616.57	642.26	781.54	971.61
Эргэлтэнд гаргасан энгийн хувьцааны тоо (сая ширхэг)	(2)	78.064	78.064	78.064	78.064	78.064
Нэгж хувьцаанд ногдох ашиг (төгрөгөөр)		0.19	7.90	8.23	10.01	12.45

Тайлбар:

(1) Төсөвлөсөн орлого, үр дүнгийн тайлангийн татварын дараах цэвэр ашгийн дүн дээр элэгдлийн зардлыг нэмсэн дүн.

Төсөвлөсөн орлого, үр дүнгийн тайлангийн үзүүлэлтүүдийг энэхүү танилцуулгын "Аудитлагдсан санхүүгийн тайлан"-гийн үзүүлэлтүүдэд үндэслэн, Компанийн удирдлагын боловсруулан баталсан ашгийн таамаглалын үр дүнд гаргаж авсан болно.

(2) Тухайн тайлангийн жилийн эцэст эргэлтэнд байх энгийн хувьцааны тоо.

Бид энэхүү тооцооллыг энгийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй өр төлбөрийн хөрвүүлэлтийг хэрэгжүүлэхгүй, зээлийг мөнгөн хөрөнгөөр барагдуулахаар тооцоолон хийсэн бөгөөд ирэх 5 жилийн хугацаанд эргэлтэнд байгаа буюу гаргасан энгийн хувьцааны тоонд өөрчлөлт орохгүй, IPO хийх үеэр 26,544,058 ширхэг энгийн хувьцаа эргэлтэнд гаргана гэсэн төсөөллөөр тооцооллыг хийсэн болно.

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

ХАВСРАЛТ 2. МЭРГЭШСЭН НЯГТЛАН БОДОГЧИЙН ДҮГНЭЛТ

1. ТАНИЛЦУУЛГА

1.1. Мэргэшсэн нягтлан бодогчийн дүгнэлт гаргагчийн танилцуулга

Дүгнэлт гаргагч Жаргалсайхан овогтой Болортуяа нь 2008 онд СЭЗДС-ийн өдрийн хөтөлберийг Нягтлан бодох бүртгэлээр мэргэжсэн, Бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй төгссөн.

- Мэргэшсэн нягтлан бодогчийн гэрчилгээний дугаар №12122879
- ММНБИ-ийн Удирдах зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 01 тоот тогтоолоор мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхийн гэрчилгээ авснаас гадна 2011 онд МҮЦАЭХ, СЗХ-ноос хамтран зохион байгуулсан сургалтанд хамрагдаж Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх авсан.
- Үнэт цаасны зах зээл, бараа таваарын биржид нягтлан бодогч мэргэжлээрээ 9 дэх жилдээ ажиллаж байна.

  Холбоо барих и-мэйл: bolortuya.j@gmail.com.

1.2. Компанийн мэдээлэл

1.2.1. Компанийн танилцуулга

Анд-Энерги ХХК нь 2011 онд цахилгааны угсралт, суурилуулалт, автоматжуулалтын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, тусдаа санхүүгийн тайлан бэлтгэдэг, хязгаарлагдмал хариуцлагатай компани. Компанийн хувьцаа эзэмшигчид ижил тэнцүү хэмжээгээр (тус бүр 25%) хувь эзэмшдэг Монгол Улсын 4 иргэнээс бүрдэнэ.

Анд-Энерги ХХК нь байгуулагдсан цагаас хойш цахилгаан тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, хүнд болон хөнгөн үйлдвэрийн автоматжуулалт, цахилгаан щитны угсралт, гудамж талбайн гэрэлтүүлгийн ажлыг Эрчим хүчний яам болон Барилга, хот байгуулалтын яамнаас авсан тусгай зөвшөөрлүүдийн үндсэн дээр хийж гүйцэтгэж ирсэн. Улмаар 2014 онд "Эрдэнэт Лед" гэрлийн үйлдвэрийг ашиглалтанд оруулж, LED гэрлийн үйлдвэрлэлийг дотооддоо эхлүүлсэн бөгөөд одоогоор 10 гаруй аймагт бүтээгдэхүүнээ нийлүүлж байна.

Өөрийн үйл ажиллагаа явуулдаг нутаг дэвсгэр болон ойролцоох аймаг, сумын гудамж болон зам талбайн гэрэлтүүлгийн ажлуудыг хийж гүйцэтгэснээс гадна Эрдэнэт үйлдвэрийн ган бөөрөнцөгийн цехийн иж бүрэн автоматжуулалт, Ачит-Ихт ХХК-ийн өргөх насосны 6кВ-ын хөдөлгүүр дээрх вакум таслуур суурилуулж автоматжуулах зэрэг томоохон ажлуудыг хийсэн байна.

Компанийн үндсэн үйл ажиллагаа нь LED гэрэл гэрэлтүүлгийн үйлдвэрлэл, гадаад худалдаа, цахилгаан тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, үйлдвэрлэлийн

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА101070 4385772

2087103
ПЮН0230

автоматжуулалт бөгөөд дээрх чиглэлээр мэргэшсэн баг бүрдүүлэн, 14 хүнийг ажлын байраар ханган ажиллаж байна.

Компанийн зарласан хувьцааны тоо 100,000,000 ширхэг бөгөөд одоогоор нэг бүр нь 1 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 51,526,700 ширхэг энгийн хувьцааг гүйлгээнд гаргасан, 26,544,058 ширхэг хувьцааг нийтэд санал болгох замаар нэмж гаргах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсан байна.

1.2.2. Аудит хийсэн компанийн мэдээлэл

№	Аудитын компанийн нэр	Үүсгэн байгуулагдсан огноо, хаяг	Хамрах хугацаа	Аудитын дүгнэлт, зөвлөмжийн товч агуулга
1	"Бэйкер Тилли Далайван-Аудит" ХХК-ийн Орхон аймаг дахь салбар	1998/04/01 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Монгол ардын намын байр 1 дүгээр давхар 103 тоот	2014/01/01-2014/12/31	Зөрчилгүй санал дүгнэлттэй, зөвлөмж өгөөгүй
2	"Далайван-Аудит" ХХК-ийн Орхон аймаг дахь салбар	1998/04/01 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртбулаг баг, "Зохимж" ХХК-ийн байр 3 дугаар давхар 303 тоот	2015/01/01-2015/12/31	Зөрчилгүй санал дүгнэлттэй, зөвлөмж өгөөгүй
3	"Од бүртгэл-Аудит" ХХК	2008/01/03 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж, Цэлмэг Таур 701 тоот	2016/01/01-2016/12/31	Зөрчилгүй санал дүгнэлттэй. Бараа материал, орлого болон өртгийн бүртгэлийн хувьд анхаарвал зохих хэд хэдэн асуудалд зөвлөмж өгсөн.

1.2.3. Толгой болон охин, хараат компани

Анд-Энерги ХХК нь толгой болон охин, хараат компанигүй болно.

1.3. МНБД-ийн хамрах хүрээ

Мэргэшсэн нягтлан бодогчийн дүгнэлтийг Анд-Энерги ХХК-иас ирүүлсэн 2014, 2015, 2016 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгон гаргасан, аудитлагдсан жилийн санхүүгийн тайланд үндэслэн, Монголын үнэт цаасны биржийн Бүртгэлийн журмын бүлэг IX-д шаардсаны дагуу бэлтгэлээ.

Компани нь Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгж болохын хувьд Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, түүнд хамаарах бусад багц хуулиуд, Аудитын тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм журмын дагуу санхүүгийн тайлан бэлтгэж толилуулдаг.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу компанийн нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг гүйцэтгэх удирдлага хүлээх бөгөөд

мөн хуулийн 8.4-т заасны дагуу санхүүгийн тайлангийн үнэн зөвийг гүйцэтгэх удирдлага хариуцна.

Анд-Энерги ХХК нь Мэргэшсэн нягтлан бодогчийн дүгнэлтэд хамаарч буй хугацааны жилийн санхүүгийн тайлангуудыг жил бүр хараат бус, хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулан, дүгнэлт гаргуулж авсан бөгөөд Мэргэшсэн нягтлан бодогчийн дүгнэлт нь аудитлагдсан санхүүгийн тайлангийн мэдээлэлд үндэслэн боловсруулагдсан тул аудитлагдсан санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн үнэн зөв, алдаагүй илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт гаргагч МНБ хариуцлага хүлээхгүй.

2. САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1. Санхүүгийн байдлын тайлангийн харьцуулсан үзүүлэлтүүд

ҮЗҮҮЛЭЛТ		2014	2015	2016
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	(А1)	11.88	57.41	64.90
Дансны авлага ба бусад авлага	(А2)	0.57	124.22	37.15
Бараа материал	(А3)	26.20	95.70	146.38
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	(А4)	0.58	65.02	11.59
Эргэлтийн хөрөнгийн дүн		39.23	342.35	260.02
Үндсэн хөрөнгө	(А5)	116.58	115.33	268.15
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		116.58	115.33	268.15
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		155.81	457.68	528.17
Дансны өглөг ба бусад богино хугацаат өр төлбөр	(А6)	34.80	40.94	26.30
Зээл ба урт хугацаат өр төлбөр	(А7)	69.27	167.69	162.53
Өр төлбөрийн нийт дүн		104.07	208.63	188.83
Эздийн өмч				
Өмч -Хувийн	(А8)	1.00	1.00	51.52
Нэмж төлөгдсөн капитал		50.52	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	(А9)	-	-	73.38
Эздийн өмчийн бусад хэсэг		-	10.90	-
Хуримтлагдсан ашиг	(А10)	0.22	237.15	214.44
Эздийн өмчийн дүн		51.74	249.05	339.34
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		155.81	457.68	528.17

Зэрэгцүүлсэн санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамт уншина уу.

2.2. Орлогын дэлгэрэнгүй тайлангийн харьцуулсан үзүүлэлтүүд

ҮЗҮҮЛЭЛТ		2014	2015	2016
Борлуулалтын орлого (цэвэр)	(Б1)	120.09	597.99	682.42
Борлуулалтын өртөг	(Б1)	124.64	240.65	384.21
Нийт ашиг (алдагдал)		(4.55)	357.34	298.21
Хүүний орлого	(Б2)	0.07	0.35	0.62
Бусад орлого	(Б2)	0.07	-	-
Борлуулалт маркетингийн зардал		0.97	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	(Б3)	9.09	114.55	128.81
Санхүүгийн зардал	(Б4)	-	-	17.14
Бусад ашиг (алдагдал)	(Б5)	(2.19)	(4.17)	(107.01)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		(16.66)	238.97	45.87
Орлогын татварын зардал	(Б6)	-	2.03	2.89
Татварын дараах ашиг (алдагдал)		(16.66)	236.94	42.98

Зэрэгцүүлсэн санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамт уншина уу.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КД:2901070 4355772
118 | "АНД-ЭНЕРГИ" ХХК

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

2.3. Өмчийн өөрчлөлтийн тайлангийн харьцуулсан үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Өмч	Халаас-ны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагд-сан ашиг	Нийт дүн
2014 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	1.00	-	-	-	-	-	28.88	29.88
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	(16.66)	(16.66)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	50.52	-	50.52
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	(12.00)	(12.00)
2014 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1.00	-	-	-	-	50.52	0.22	51.74
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	236.94	236.94
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	(39.62)	-	(39.62)
2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1.00	-	-	-	-	10.90	237.16	249.06
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	39.62	(65.70)	(26.08)
Залруулсан үлдэгдэл	1.00	-	-	-	-	50.52	171.46	222.98
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	42.98	42.98
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	73.38	-	-	-	73.38
Өмчид гарсан өөрчлөлт	50.52	-	-	-	-	(50.52)	-	-
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	51.52	-	-	73.38	-	-	214.44	339.34

Зэрэгцүүлсэн санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамт уншина уу.

ТҮРТГЭВ
№ 01

2.4. Мөнгөн гүйлгээний тайлангийн харьцуулсан үзүүлэлтүүд

ҮЗҮҮЛЭЛТ	2014	2015	2016
Мөнгөн орлогын дүн (+)	82.23	299.46	854.97
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	82.16	299.46	769.69
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-	0.02
Бусад мөнгөн орлого	0.07	-	85.26
Мөнгөн зарлагын дүн (-)	196.29	306.18	728.52
Ажиллагчдад төлсөн	16.71	36.94	69.20
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	0.46	9.68	21.00
Бараа материал худалдан авахад төлсөн	126.03	115.50	137.14
Ашиглалтын зардалд төлсөн	1.72	1.19	2.34
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	0.27	5.71	9.07
Хүүний төлбөрт төлсөн	3.68	9.06	17.14
Татварын байгууллагад төлсөн	17.02	2.05	83.62
Бусад мөнгөн зарлага	30.40	126.05	389.01
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(114.06)	(6.72)	126.45
Мөнгөн орлогын дүн (+)	55.26	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаалт	5.33	-	-
Эзэмшигчдийн өмчийг нэмэгдүүлсэн	49.93	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	121.99	5.99	77.31
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	116.38	5.99	77.31
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	5.61	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(66.73)	(5.99)	(77.31)
Мөнгөн орлогын дүн (+)	113.89	100.00	-
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	113.22	100.00	-
Төрөл бүрийн хандив	0.60	-	-
Хүү ба урамшууллын орлого	0.07	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	4.73	41.76	41.64
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	4.73	1.57	5.16
Төлсөн ногдол ашиг	-	36.02	-
Бусад	-	4.17	36.48
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	109.16	58.24	(41.64)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(71.63)	45.53	7.50
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	83.50	11.87	57.40
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11.87	57.40	64.90

Зэрэгцүүлсэн санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамт уншина уу.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЙЛБАР

Санхүүгийн байдлын тайлангийн харьцуулсан үзүүлэлтийн тайлбар

(А1) Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь компанийн эзэмшлийн буюу компани захиран зарцуулах эрхтэй, дотоодын арилжааны банкинд байршуулсан болон касст бэлэн байгаа мөнгөн хөрөнгөөс бүрдэнэ. Компани нь арилжааны банк болон бусад хадгаламжийн байгууллагад байршуулсан хадгаламжийн дансгүй.

	2014	2015	2016
Касс дахь мөнгө	9.84	40.28	0.74
Банкин дахь мөнгө	2.03	17.12	64.16
Нийт дүн	11.87	57.40	64.90

(А2) Дансны авлага ба бусад авлага

Зээлээр борлуулсан бараа, үзүүлсэн үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэхийн дүнгээр дансны авлага үүсгэн бүртгэнэ. Авлагыг нэхэмжилсэн буюу хүлээн авахаар тооцсон цэвэр боломжит үнэ цэнээр нь бүртгэдэг. Найдваргүй авлагыг урьдчилан нөөц байгуулдаггүй бөгөөд хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрлөөр найдваргүйд тооцсон авлагыг нэрлэсэн үнээр нь данснаас шууд хасаж, тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

	Дансны авлага		
	2014	2015	2016
Эхний үлдэгдэл	-	-	123.92
Нэмэгдсэн	-	191.67	162.37
Хасагдсан:	-	67.75	249.24
Үүнээс: Төлөгдсөн	-	67.75	64.16
Найдваргүй болсон	-	-	22.70
Эцсийн үлдэгдэл	-	123.92	37.06

	Татвар, НДШ-ийн авлага		
	2014	2015	2016
ААНОАТ-ын авлага	0.29	0.29	-
НӨАТ-ын авлага	-	-	-
НДШ-ийн авлага	-	-	-
Нийт дүн	0.29	0.29	-

	Бусад богино хугацаат авлага		
	2014	2015	2016
Холбоотой талаас авах авлага	-	0.28	-
Ажилчдаас авах авлага	0.28	-	0.09
Ногдол ашгийн авлага	-	-	-
Хүүний авлага	-	-	-
Богино хугацаат авлага	-	-	-
Бусад талуудаас авах авлага	-	-	-
Нийт дүн	0.28	0.28	0.09

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

АНД-ЭНЕРГИ ХХК
120 | "АНД-ЭНЕРГИ" ХХК

2087103
ПЮН0230

(А3) Бараа материал

Бараа материалын бүртгэлийн байнгын систем ашигладаг. Бараа материалыг зориулалт, шинж чанараар нь үйлдвэрлэлд ашиглах үндсэн болон туслах түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн, хангамжийн материал гэх мэтээр ангилан бүртгэх ёстой ч Компани өмнөх жилүүдэд бүх төрлийн материалыг нэгтгэн түүхий эд материалаар тайлагнасан нь аудитын дүгнэлтээр баталгаажсан. Үүнд тухайн үеийн хөндлөнгийн аудитын байгууллагаас санал зөвлөмж өгөөгүй байна. Харин 2016 оны тооллогын дүнд үндэслэн бараа материалын дансанд бүртгэлтэй материал, үнэ бүхий зүйлсийг дахин ангилж, түүхий эд материал, бэлэн бүтээгдэхүүн, хангамжийн материал гэсэн дансдад ангилж бүртгэсэн байна.

	Түүхий эд материал		
	2014	2015	2016
Эхний үлдэгдэл	-	26.20	95.71
Нэмэгдсэн	57.21	292.77	364.72
Хасагдсан	31.01	223.26	381.06
Эцсийн үлдэгдэл	26.20	95.71	79.36

	Бэлэн бүтээгдэхүүн		
	2014	2015	2016
Эхний үлдэгдэл	-	-	-
Нэмэгдсэн	-	-	355.35
Хасагдсан	-	-	299.24
Эцсийн үлдэгдэл	-	-	56.11

	Хангамжийн материал		
	2014	2015	2016
Эхний үлдэгдэл	-	-	-
Нэмэгдсэн	-	-	13.73
Хасагдсан	-	-	2.83
Эцсийн үлдэгдэл	-	-	10.90

(А4) Урьдчилж төлсөн зардал/тооцоо

Төрөл	2014	2015	2016
Урьдчилж төлсөн зардал	-	-	-
Урьдчилж төлсөн түрээс, даатгал	-	-	-
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа төлбөр	0.59	65.02	-
Нийт дүн	0.59	65.02	-

2015 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгон гаргасан санхүүгийн тайланд түүхий эд материалын нийлүүлэгчид өгсөн материалын урьдчилгаа болох 65.02 сая төгрөг бүртгэгдсэн байсан бөгөөд материалыг 2016 онд хүлээн авсан. 2016 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайланд аливаа урьдчилгаа төлбөр тайлагнагдаагүй болно.

(А5) Үндсэн хөрөнгө

Компани 2016 онд өөрийн эзэмшиж, ашиглаж байгаа үндсэн хөрөнгөд хөндлөнгийн үнэлгээчнээр үнэлгээ хийлгэж, дахин үнэлсэн өртгөөр үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Мөн санхүүгийн тайлангийн аудитын явцад зарим төрлийн хөрөнгийг дахин ангилж бүртгэсэн байна.

	Газрын сайжруулалт		
	2014	2015	2016
Хөрөнгийн өртөг			
Эхний үлдэгдэл			
(+) Худалдаж авсан	-	-	3.90
(+) Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	0.14
Үндсэн хөрөнгө дахин ангилсан	-	-	12.00
Эцсийн үлдэгдэл	-	-	16.04
Хуримтлагдсан элэгдэл			
Эхний үлдэгдэл	-	-	-
(+) Байгуулсан элэгдэл	-	-	-
(-)	-	-	-
Эцсийн үлдэгдэл	-	-	-
Дансны цэвэр дүн	-	-	16.04
Эхний үлдэгдэл	-	-	-
Эцсийн үлдэгдэл	-	-	16.04

	Барилга байгууламж		
	2014	2015	2016
Хөрөнгийн өртөг			
Эхний үлдэгдэл	-	87.95	87.95
(+) Өөрөө үйлдвэрлэсэн	75.81	-	-
(+) Худалдаж авсан	12.14	-	13.48
(+) Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	72.55
Үндсэн хөрөнгө дахин ангилсан	-	-	(12.00)
Эцсийн үлдэгдэл	87.95	87.95	161.98
Хуримтлагдсан элэгдэл			
Эхний үлдэгдэл	-	-	4.40
(+) Байгуулсан элэгдэл	-	4.40	2.83
(+) Дахин үнэлгээгээр нэмэгдсэн	-	-	2.19
(-) Данснаас хасагдсан хөрөнгийн элэгдэл	-	-	1.21
Эцсийн үлдэгдэл	-	4.40	8.20
Дансны цэвэр дүн	87.95	83.55	153.78
Эхний үлдэгдэл	-	87.95	83.55
Эцсийн үлдэгдэл	87.95	83.55	153.78

Машин тоног төхөөрөмж			
	2014	2015	2016
Хөрөнгийн өртөг			
Эхний үлдэгдэл	-	27.12	28.91
(+) Худалдаж авсан	27.12	1.78	14.48
(+) Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	8.14
Үндсэн хөрөнгө дахин ангилсан	-	-	(1.00)
Эцсийн үлдэгдэл	27.12	28.91	50.53
Хуримтлагдсан элэгдэл			
Эхний үлдэгдэл	-	-	2.76
(+) Байгуулсан элэгдэл	-	2.76	3.37
(+) Дахин үнэлгээгээр нэмэгдсэн	-	-	2.26
Эцсийн үлдэгдэл	-	2.76	8.39
Дансны цэвэр дүн	27.12	26.15	42.15
Эхний үлдэгдэл	-	27.12	26.15
Эцсийн үлдэгдэл	27.12	26.15	42.15

Тээврийн хэрэгсэл			
	2014	2015	2016
Хөрөнгийн өртөг			
Эхний үлдэгдэл	-	-	-
(+) Худалдаж авсан	-	-	27.00
Үндсэн хөрөнгө дахин ангилсан	-	-	-
Эцсийн үлдэгдэл	-	-	27.00
Хуримтлагдсан элэгдэл			
Эхний үлдэгдэл	-	-	-
(+) Байгуулсан элэгдэл	-	-	1.12
Эцсийн үлдэгдэл	-	-	1.12
Дансны цэвэр дүн	-	-	25.88
Эхний үлдэгдэл	-	-	-
Эцсийн үлдэгдэл	-	-	25.88

Тавилга, эд хогшил			
	2014	2015	2016
Хөрөнгийн өртөг			
Эхний үлдэгдэл	-	1.30	2.96
(+) Өөрөө үйлдвэрлэсэн	-	-	-
(+) Худалдаж авсан	0.70	1.65	13.85
(+) Үнэ төлбөргүй авсан	0.60	-	-
(+) Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	7.28
Эцсийн үлдэгдэл	1.30	2.96	24.10
Хуримтлагдсан элэгдэл			
Эхний үлдэгдэл	-	-	0.22
(+) Байгуулсан элэгдэл	-	0.22	1.06
(+) Дахин үнэлгээгээр нэмэгдсэн	-	-	2.30
Эцсийн үлдэгдэл	-	0.22	3.58
Дансны цэвэр дүн	1.30	2.74	20.51
Эхний үлдэгдэл	-	1.30	2.74
Эцсийн үлдэгдэл	1.30	2.74	20.51

Компьютер, дагалдах хэрэгсэл			
	2014	2015	2016
Хөрөнгийн өртөг			
Эхний үлдэгдэл	0.20	0.20	3.00
(+) Худалдаж авсан	-	2.80	9.53
(-)	-	-	1.41
Эцсийн үлдэгдэл	0.20	3.00	13.94
Хуримтлагдсан элэгдэл			
Эхний үлдэгдэл	-	-	0.11
(+) Байгуулсан элэгдэл	-	0.11	1.87
(+) Дахин үнэлгээгээр нэмэгдсэн	-	-	2.17
Эцсийн үлдэгдэл	-	0.11	4.15
Дансны цэвэр дүн	0.20	2.95	9.79
Эхний үлдэгдэл	-	0.2	2.89
Эцсийн үлдэгдэл	0.20	2.95	9.79

(А6) Дансны өглөг ба бусад богино хугацаат өр төлбөр

Өр төлбөрийг нэхэмжилсэн дүн эсвэл төлөхөөр хүлээгдэж буй дүнгээр нь, ЭМНДШ, ХХОАТ, ААНОАТ зэрэг татварын өр төлбөрийг тооцоолсон дүнгээр нь бүртгэдэг.

	Татварын өр		
	2014	2015	2016
ААНОАТ өр	-	-	2.59
НӨАТ-ын өр	2.10	35.18	20.59
ХХОАТ-ын өр	-	2.16	2.06
Бусад татварын өр	-	3.60	-
Нийт дүн	2.10	40.94	25.24

	Бусад богино хугацаат өр		
	2014	2015	2016
Богино хугацаат зээл	30.00	-	-
Бусад богино хугацаат өглөг	2.70	2.70	1.05
Нийт дүн	32.70	2.70	1.05

(А7) Зээл ба урт хугацаат өр төлбөр

Анд-Энерги ХХК нь үйлдвэрийн өртгөтгөл хийх, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагаанд шаардлагатай эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх, түүхий эд материал худалдан авах зорилгоор арилжааны банк болон хувь хүнээс авсан 2 төрлийн зээлийг урт хугацаат өр төлбөрөөр ангилан бүртгэсэн.

	2014	2015	2016
Урт хугацаат зээл	-	100.00	96.64
Бусад урт хугацаат өр төлбөр	69.27	67.69	-
Холбоотой талд өгөх өглөг	-	-	65.89
Нийт дүн	69.27	167.69	162.53

Зөвөл 1. Хөгжлийн банкны санхүүжилтээр Худалдаа хөгжлийн банкнаас авсан урт хугацаат зээл: Гэрлийн үйлдвэрийн өргөтгөл, тоног төхөөрөмж, түүхий эд материал худалдан авах зорилгоор 2015 оны 08 дугаар сард Худалдаа хөгжлийн банкнаас Монгол Улсын Хөгжлийн банкны эх үүсвэртэй, жилийн 9 хувийн хүүтэй зээлийг 39 сарын хугацаатай авсан. Уг зээл нь зээлийн эх үүсвэр өөрчлөгдсөн тохиолдолд зээлийн хүү өөрчлөгдөж, Худалдаа хөгжлийн банкны үндсэн зээлийн хүүгээр тооцогдох нөхцөлтэй. Одоогоор зээл нь Монгол Улсын Хөгжлийн банкны эх үүсвэртэй хэвээр үргэлжилж байгаа болно.

Зөвөл 2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр хувьцаа эзэмшигч бөгөөд гүйцэтгэх захирал Т.Барсаас авсан урт хугацаат зээл: Компани 2014 онд үйлдвэрийн тоног төхөөрөмж, түүхий эд материал худалдан авахдаа Компанийн үүсгэн байгуулагч, тухайн үеийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Т.Барсаас жилийн 8 хувийн хүүтэй, 20 жилийн хугацаатай, 70.0 сая төгрөгийн зээл авч ашигласан байна. Өнгөрсөн хугацаанд энэ зээлтэй холбоотойгоор зээлийн гэрээ байгуулаагүй, зээлийн үндсэн болон хүүний төлбөрт сар бүр тодорхой хэмжээний дүнг төлж байсан бөгөөд 2016 онд зээлийн үлдэгдэл дүнд тохируулан иргэн Т.Барстай зээлийн гэрээг шинээр байгуулсан байна. Шинээр байгуулсан гэрээгээр зээлийн хугацааг 2 жил болгон бууруулж, жилийн хүүг 11.4 хувь болгон нэмэгдүүлсэн бөгөөд зээлийн үндсэн төлбөрийг хугацааны эцэст барагдуулах нөхцөлийг Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор зөвшөөрч баталгаажуулсан байна.

(А8) Хувь нийлүүлсэн хөрөнгө

Анд-Энерги ХХК нь анх нэг бүр нь 10,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 100 ширхэг энгийн хувьцаатай, Монгол Улсын 4 иргэн хувь тэнцүүлэн хувьцааг эзэмшихээр дүрэмдээ тусган үүсгэн байгуулагдсан. 2014, 2015 оны аудитлагдсан жилийн санхүүгийн тайланд хувь нийлүүлсэн хөрөнгө дээрх байдлаар бүртгэгдсэн.

2016 оны 10 дугаар сард хувьцааг нэг бүрийг нь 1:1000 харьцаагаар хувааж, Компанийн энгийн хувьцааны нэрлэсэн үнийг 10 төгрөг, гүйлгээнд гаргасан тоо хэмжээг 100,000 ширхэг болгон өөрчилсөн.

Мөн оны 11 дүгээр сард Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 04 тоот тогтоолоор нэмж 5,052,670 ширхэг энгийн хувьцааг эргэлтэнд гаргаснаар хувьцааны тоо 5,152,670 ширхэг, хувьцаат капиталын дүн 51.53 сая төгрөг болж нэмэгдсэн байна.

(А9) Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл

Үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа, Компанийн үндсэн хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлж, санхүү бүртгэлд шинэчлэн бүртгэх зорилгоор 2016 онд хөндлөнгийн үнэлгээний байгууллага болох Далайван Аудит ХХК-аар хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн.

	2014	2015	2016
Эхний үлдэгдэл	-	-	-
Нэмэгдсэн дүн	-	-	73.38
Дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-	73.38
Дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын буцаалт	-	-	-
Хасагдсан дүн	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-
Дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз	-	-	-
Эцсийн үлдэгдэл	-	-	**73.36**

(А10) Хуримтлагдсан ашиг

	2014	2015	2016
Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг	-	0.21	237.15
Алдааны залруулга			(65.69)
Тайлант үеийн цэвэр ашиг	(16.66)	236.94	42.98
Хуримтлагдсан ашгийн дүн	0.21	237.15	214.44

Орлогын дэлгэрэнгүй тайлангийн харьцуулсан үзүүлэлтийн тайлбар

(Б1) Борлуулалтын орлого болон өртөг

Компанийн борлуулалтын орлого нь үйлдвэрлэсэн LED гэрлийн борлуулалтын орлого болон гэрэлтүүлэг, автоматжуулалтын болон бусад үйлчилгээний орлогоос бүрдэнэ. Гэрлийн борлуулалт нь борлуулалтын үнээр буюу нэхэмжилсэн дүнгээр, үйлчилгээний орлого нь гэрээний дүнгээр илэрхийлэгдэнэ.

"Эрдэнэт лед" гэрлийн үйлдвэр нь 2014 оноос үйлдвэрлэл явуулж эхэлсэн бөгөөд 2014 онд 120.09 сая, 2015 онд 597.99 сая, 2016 онд 682.43 сая төгрөгийн борлуулалт тус тус хийсэн байна. Бидэнд ирүүлсэн аудитлагдсан санхүүгийн тайлан, санхүүгийн анхан шатны баримт бүртгэлээс үзэхэд Компани 2014, 2015 онд борлуулалтын орлогыг үйлдвэрлэл, үйлчилгээгээр нь ангилж бүртгээгүй, нэхэмжилсэн бөөн дүнгээр нь орлогод хүлээн зөвшөөрч бүртгэж ирсэн бөгөөд анхан шатны баримтад тулгуурлан орлогыг дахин ангилахад 2014 онд нийт орлогын 0.7 хувь, 2015 онд 50.0 хувийг гэрлийн борлуулалтын орлого бүрдүүлж байна. Харин 2016 оны нийт борлуулалтын орлогын 47.3 хувийг үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалт, 52.7 хувийг бусад үйлчилгээний орлого бүрдүүлж байна.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА7301070 4355772
126 | "АНД-ЭНЕРГИ" ХХК

2087103
ПЮН0230

	Борлуулалтын орлого		
	2014	2015	2016
Бараа борлуулсны орлого:	0.87	298.77	323.33
LED гэрлийн борлуулалт	0.87	298.77	323.33
Ажил, үйлчилгээ борлуулсны орлого:	119.22	299.22	359.12
Гэрэлтүүлгийн ажил	119.22	299.22	312.68
Бусад ажил үйлчилгээ	-	-	46.44
Нийт борлуулалтын орлого	120.09	597.99	682.46
Борлуулалтын буцаалт, хөнгөлөлт, үнийн бууралт (-)	-	-	(27.37)
Цэвэр борлуулалт	120.09	597.99	682.43

Анд-Энерги ХХК-ийн "Эрдэнэт лед" гэрлийн үйлдвэр нь одоогоор 30 гаруй нэр төрлийн LED гэрэл, гэрэлтүүлгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг тооцох системгүй, үйлдвэрлэл болон үйлчилгээ, засварын ажилтай холбоотой гарсан бүх зардлуудыг бүтээгдэхүүний өртөгт хуваарилдаг. Цаашид бүтээгдэхүүний төрөл тус бүр дээр болон захиалгат ажил бүр дээр захиалгат ажлын картаар өртгийг тус бүрт нь бүртгэхээр төлөвлөж байгаагаа гүйцэтгэх удирдлага мэдэгдсэн.

	2014	2015	2016
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	124.64	240.65	384.21

(Б2) Хүүний болон бусад орлого

Компани нь Худалдаа хөгжлийн банк болон Хаан банкинд төгрөгийн харилцах данстай бөгөөд эдгээр дансны үлдэгдэлд тооцсон хүүний орлогыг бусад орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

	2014	2015	2016
Бусад орлого	0.07	-	-
Хүүний орлого	-	0.35	0.62
Ханшийн зөрүүгийн олз	-	0.41	-
Нийт дүн	-	0.76	0.62

(Б3) Ерөнхий удирдлагын ба борлуулалт маркетингийн зардал

Компани нь үйлдвэрлэл, үйлчилгээний өртөгт хуваарилж буй зардлуудаас бусад ерөнхий шинжтэй зардлуудыг ерөнхий удирдлагын зардалд бүртгэдэг. Борлуулалт маркетингийн зардлыг ерөнхий ба удирдлагын зардлаас тусад нь толилуулдаггүй.

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

	2014	2015	2016
Ажиллагчдын цалингийн зардал	-	36.82	47.12
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	-	4.77	5.83
Томилолтын зардал	0.19	33.49	30.73
Бичиг хэргийн зардал	-	0.45	-
Шуудан холбооны зардал	-	0.06	0.44
Мэргэжлийн үйлчилгээний зардал	3.61	-	-
Сургалтын зардал	0.22	-	-
Ашиглалтын зардал	-	0.03	1.09
Засварын зардал	-	0.03	2.08
Элэгдэл, хорогдлын зардал	-	7.49	0.92
Түрээсийн зардал	-	0.10	13.57
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	-	0.19	-
Тээврийн зардал	-	-	0.41
Шатахууны зардал	-	3.39	7.62
Хүлээн авалтын зардал	1.42	-	-
Зар сурталчилгааны зардал	0.28	1.78	0.74
Бусад	0.7	25.39	18.25
Нийт дүн	10.07	114.55	128.81

Эрх бүхий албан тушаалтнуудад 2014 онд олгосон цалин хөлс, бусад орлого

Эрх бүхий албан тушаалтан		Цалин хөлс	ЭМНДШ	Ногдол ашиг
Т.Барс	Гүйцэтгэх захирал/ үүсгэн байгуулагч	-	-	-
Ц.Гүррагчаа	Ерөнхий инженер/ үүсгэн байгуулагч	-	-	-
Д.Мөнхбаяр	Ерөнхий инженер/ үүсгэн байгуулагч	-	-	-
Г.Түвшин	Ерөнхий инженер/ үүсгэн байгуулагч	-	-	-
Ч.Мөнхсаруул	Гэрээт нягтлан бодогч	-	-	-
Нийт дүн		-	-	-

Эрх бүхий албан тушаалтнуудад 2015 онд олгосон цалин хөлс, бусад орлого

Эрх бүхий албан тушаалтан		Цалин хөлс	ЭМНДШ	Ногдол ашиг
Т.Барс	Гүйцэтгэх захирал/ үүсгэн байгуулагч	1.2	0.15	-
Ц.Гүррагчаа	Ерөнхий инженер/ үүсгэн байгуулагч	3.2	0.42	-
Д.Мөнхбаяр	Ерөнхий инженер/ үүсгэн байгуулагч	1.2	0.15	-
Г.Түвшин	Ерөнхий инженер/ үүсгэн байгуулагч	1.2	0.15	-
Ч.Мөнхсаруул	Гэрээт нягтлан бодогч	1.44	0.18	-
Нийт дүн		8.24	1.06	-

Эрх бүхий албан тушаалтнуудад 2016 онд олгосон цалин хөлс, бусад орлого

Эрх бүхий албан тушаалтан		Цалин хөлс	ЭМНДШ	Ногдол ашиг
Т.Барс	Гүйцэтгэх захирал/ үүсгэн байгуулагч	2.40	0.31	8.89
Ц.Гүррагчаа	Ерөнхий инженер/ үүсгэн байгуулагч	12.07	1.57	7.76
Д.Мөнхбаяр	Ерөнхий инженер/ үүсгэн байгуулагч	2.40	0.31	9.41
Г.Түвшин	Ерөнхий инженер/ үүсгэн байгуулагч	2.40	0.63	9.95
Ч.Мөнхсаруул	Гэрээт нягтлан бодогч	4.94	0.31	-
Нийт дүн		24.21	3.12	36.02

(Б4) Санхүүгийн зардал

Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүдийн тайлбарын Зээл ба урт хугацаат өр төлбөр хэсэгт тайлбарласан урт хугацаат өр төлбөрүүдийн хүүний зардлыг санхүүгийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

	2014	2015	2016
Зээлийн хүүгийн зардал	-	-	17.14
Урт хугацаат банкны зээлийн хүү	-	-	6.10
Бусад зээлийн хүү	-	-	11.04
Нийт дүн	-	-	17.14

(Б5) Бусад зардал

Өмнөх онд үүссэн 90.13 сая төгрөгийн авлагыг цуглуулах боломжгүй гэж үзэн, 2016 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 06 тоот тогтоолоор данснаас хассан байна.

	2014	2015	2016
Хандивын зардал	-	-	5.14
Найдваргүй авлагын зардал	-	-	90.13
Борлуулалт	-	-	22.70
Бусад	-	-	67.43
Бусад	-	-	11.74
Нийт дүн	-	-	107.01

(Б6) Орлогын татварын зардал

Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.1.8 болон 18.4 дэх заалтуудын дагуу Анд-Энерги ХХК-ийн үйлдвэрлэн борлуулж буй LED гэрэл, түүний борлуулалтын орлого нь татвараас чөлөөлөгдөх орлого юм. Иймд гэрэлтүүлгийн болон бусад ажил үйлчилгээний орлого нь дээрх хуулийн дагуу татвар ногдох орлого тул эдгээр орлогыг олохтой холбогдон гарсан зардлыг хассан дүнгээс ААНОАТ-ын тухай хуульд заасан хувь хэмжээгээр орлогын татвар ногдуулан төлж байна.

	2014	2015	2016
Тайлант үеийн орлогын татварын зардал		2.03	2.89
Орлогын татварын зардал (орлого) – ын нийт дүн		2.03	2.89

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО

Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т "Аж ахуйн нэгжийн, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасан ч Анд-Энерги ХХК нь одоогоор нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж мөрдөөгүй байна. Иймд энэ хэсэгт Компанийн санхүүгийн тайлан бэлтгэхдээ баримталдаг зарчим, санхүүгийн тайлангийн чухал ач холбогдолтой үзүүлэлтүүдийг бүртгэл тайланд тусгахад баримтлах бодлогыг Компанийн удирдлага болон нягтлан бодогчтой хийсэн уулзалт ярилцлагын дүгнэлт, аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэн товч тайлбарлалаа.

4.1. Мөрдөх стандарт

Компанийн санхүүгийн тайлангуудыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс батлан гаргасан СТОУС-уудын дагуу бэлтгэж, тайлагнасан.

4.2. Санхүүгийн тайлан бэлтгэсэн суурь

Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу нягтлан бодох бүртгэлээ аккруэль сууриар хөтөлдөг бөгөөд зарим үндсэн хөрөнгөөс бусад зүйлсийн хувьд түүхэн өртөгт үндэслэн бүртгэдэг. Түүхэн өртөг гэдэг нь аливаа хөрөнгийг худалдан авах үед төлсөн эсвэл солилцсон зүйлсийн бодит үнэ цэнэ байдаг. Үндсэн хөрөнгийн хувьд бодит үнэ цэнээр нь буюу дахин үнэлсэн үнэлгээгээр хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

Санхүүгийн тайланг Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт бүлэх төгрөгөөр бэлтгэн толилуулах бөгөөд гадаад валютаар илэрхийлэгдсэн ажил гүйлгээг ажил гүйлгээ гарсан өдрийн Монгол банкны зарласан албан ханшаар хөрвүүлэн тайлагнана.

4.3. Санхүүгийн тайлангийн элементүүдийн үнэлгээ

Үнэлгээ гэдэг нь санхүүгийн тайлан дахь элементүүдийн тухайн үед борлуулж болох зах зээлийн мөнгөн дүнг тодорхойлж, түүний үндсэн дээр тухайн элементүүдийг хүлээн зөвшөөрч, санхүүгийн тайланд тусгах үйл ажиллагаа юм.

Компани санхүүгийн тайлан бэлтгэхэд мөрдөх гол суурь нь анхны өртөг буюу түүхэн өртөг байх боловч энэ аргыг санхүүгийн тайлангийн дараах элементүүдийн хувьд үнэлгээний бусад сууриудтай хослуулан сонгож хэрэглэнэ. Үүнд:

- Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө - нэрлэсэн үнээр;
- Богино хугацаат хөрөнгө оруулалт - өртгөөр;
- Авлага - цэвэр боломжит үнээр;
- Бараа материал - түүнийг худалдан авахад гарсан зардал буюу боловсруулалтын өртгөөр;
- Урьдчилж төлсөн зардал - түүхэн өртгөөр;
- Үндсэн хөрөнгө - анхны өртгөөр;
- Өр төлбөрийг төлөх ёстой буюу нэхэмжилсэн эсвэл тооцоолсон дүнгээр тус тус бүртгэнэ.

4.4. Бараа материал

Бараа материалыг анх өртгөөр нь бүртгэж, өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь тайлагнадаг. Бараа материалын өртгийг эхэлж авсныг эхэлж зарлагадах аргаар тооцоолдог.

4.5. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анхны өртгөөр нь бүртгэнэ. Дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү гаргахгүй байх үүднээс тайлант үе бүрийн эцэст хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлуулахаар хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэнэ. Газраас бусад үндсэн хөрөнгийн өртөг эсвэл дахин үнэлсэн дүнгээс тэдгээрийн үлдэгдэл өртгийг хассан дүнг шулуун шугамын аргаар, ашиглалтын хугацаанд нь элэгдүүлдэг.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа:

Газар	Элэгдүүлэхгүй
Барилга байгууламж	40 жил
Тоног төхөөрөмж	10 жил
Тавилга эд хогшил	10 жил
Тээврийн хэрэгсэл	10 жил
Компьютер дагалдах хэрэгсэл	3 жил

Үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасах, зарж борлуулах зэргээс үүсэх ашиг алдагдлыг худалдан борлуулсан үнэ болон хөрөнгийн дансны үнийн зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг алдагдалд хаана.

4.6. Орлого хүлээн зөвшөөрөлт

Орлогыг харилцагчаас хүлээн авсан болон хүлээн авах зүйлийн бодит үнэ цэнээр нь хэмжиж бүртгэнэ. Орлогыг тооцоолж буй борлуулалтын буцаалт, хөнгөлөлтийг хассан цэвэр дүнгээр нь бүртгэдэг.

4.7. Зардал хүлээн зөвшөөрөлт

Орлого, үр дүнгийн тайланд зардлыг чиг үүргийнх нь дагуу ангилан тайлагнадаг. Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт борлуулсан бараа бүтээгдэхүүнтэй шууд холбоотой зардлууд багтдаг. Харин үйл ажиллагааны зардалд ерөнхий ба удирдлагын, борлуулалт, маркетингийн зардлууд хамаарна.

4.8. Шинэ болон шинэчлэгдсэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд

Тайлант жилд хэрэгжиж эхэлсэн шинэчлэгдсэн СТОУС болон шинэ тайлбарууд

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС)-ын зөвлөлөөс гаргасан 2016 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн СТОУС-ын өөрчлөлтүүдийг 2016 онд хэрэгжүүлсэн.

Хэрэгжиж эхэлсэн хугацаа	Шинэчлэгдсэн СТОУС болон өөрчлөлтүүд
2016 оны 01-р сарын 01	НББОУС 16 болон НББОУС 41-д хийгдсэн нэмэлт өөрчлөлт-Хөдөө аж ахуй
	СТОУС 11-д хийгдсэн нэмэлт өөрчлөлт-Хамтарсан үйл ажиллагааны хувь оролцоог олж эзэмших үеийн нягтлан бодох бүртгэл
	НББОУС 16 болон НББОУС 38-д хийгдсэн нэмэлт өөрчлөлт-Элэгдэл ба хорогдлын зохистой аргачлалын ангилал
	НББОУС 1-д хийгдсэн нэмэлт өөрчлөлт-Санхүүгийн тайлангийн толилуулга
	НББОУС 27-д хийгдсэн нэмэлт өөрчлөлт-Тусдаа санхүүгийн тайлан дахь өмчийн арга
	СТОУС 10, СТОУС 12 ба НББОУС 28-д хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүд-Хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгж, Нэгтгэсэн тайлан бэлтгэхээс чөлөөлсөн нөхцөлүүд
	СТОУС-ын 2012-оос 2014 оны мөчлөгт хийгдсэн Жилийн шинэчлэлүүд

Дээр дурдсан стандартууд нь нягтлан бодох бүртгэлийн бодлогод томоохон өөрчлөлт үзүүлээгүй бөгөөд Компанийн санхүүгийн тайлагналд нөлөө үзүүлээгүй болно.

Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй стандартууд

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэх үед батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд болон тайлбаруудыг доор жагсаасан болно. Эдгээр стандартууд

болон өөрчлөлтүүд нь Компанийн санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхээр бол Компани тэдгээрийг хэрэгжиж эхлэхээр заасан үеэс нь эхлэн дагаж мөрдөнө.

Хэрэгжих хугацаа	Шинэ стандартууд болон өөрчлөлтүүд
2017 оны 01-р сарын 01	НББОУС 7- д хийгдсэн өөрчлөлт-Тодруулга
	НББОУС 12-д хийгдсэн өөрчлөлт-Хэрэгжээгүй алдагдлаас хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрөх
2018 оны 01-р сарын 01	СТОУС 9-Санхүүгийн хэрэгсэл
	СТОУС 15-Худалдан авагчтай байгуулсан гэрээнээс олох орлого
	СТОУС 2-д хийгдсэн өөрчлөлт-Хувьцаанд суурилсан төлбөрийн хэмжилт болон ангилал
	СТОУТХ 22-Гадаад валютын гүйлгээ ба урьдчилгаа
	НББОУС 40-д хийгдсэн өөрчлөлт-Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн шилжүүлэлт
	СТОУС 4-д хийгдсэн өөрчлөлт-СТОУС 9-ийн хэрэгжүүлэхтэй холбоотой СТОУС 4 Даатгалын гэрээ
	СТОУС 15-д хийгдсэн тайлбар-Худалдан авагчай байгуулсан гэрээнээс олох орлого
	СТОУС 16-Түрээс

5. БУСАД

5.1. МНБД гаргахаас өмнөх 1 жилийн хугацааны мэдээлэл

Хөрөнгийн үнэлгээ

Хөрөнгийн дансны үнэ, бодит үнэ цэнийн хоорондын зөрүүг бага байлгах үүднээс хараат бус үнэлгээний Далайван аудит ХХК-аар 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр Компанийн өмчлөлд байгаа барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, компьютер дагалдах хэрэгсэл зэрэг бүх төрлийн хөрөнгөнд дахин үнэлгээ хийлгэсэн. Дахин үнэлгээний тайлангаар үнэлэгдсэн хөрөнгийн үнэ цэнэ нь 268.15 сая төгрөг. Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээгээр анхны өртөг 82.29 сая төгрөгөөр нэмэгдэж, хуримтлагдсан элэгдэл нь 8.9 сая төгрөгөөр тохируулагдсан.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт

Компани Монголын үнэт цаасны бирж дээр хувьцаагаа олон нийтэд санал болгон арилжаалж, хөрөнгө татах замаар үйлдвэрээ өргөжүүлэх хэтийн зорилттой байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор сүүлийн тайлант жилд буюу 2016 онд хувь нийлүүлсэн хөрөнгөд хэд хэдэн өөрчлөлтийг хийж нэмэгдүүлсэн байна. Үүнд:

- Компани анх үүсгэн байгуулагдахдаа Монгол Улсын 4 иргэний хувь оролцоотой, нэг бүр нь 10,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 100 ширхэг энгийн хувьцаатай байсныг Хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн хурлын 03 тоот тогтоолоор нэг бүрийг нь 1:1000 харьцаагаар хувааж, гаргасан хувьцааны тоог 100,000 ширхэг, нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 10 төгрөг болгон өөрчилсөн.
- "Эрдэнэт лед" гэрлийн үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдан авах зорилгоор 2014 онд үүсгэн байгуулагчдын оруулсан 50.53 сая төгрөгийг 2014 болон 2015 оны санхүүгийн жилүүдэд эзэмшигчдийн өмчийн бусад хэсэгт тайлагнаж ирсэн бөгөөд энэ дүнгээр хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх тухай шийдвэр

гарсан. Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2016 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 04 тоот тогтоолоор нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5,052,670 ширхэг энгийн хувьцаа нэмж гаргасан байна.

Дээрх өөрчлөлтүүдийн дүнд Компани нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 5,152,670 ширхэг гаргасан энгийн хувьцаатай болж, хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн 51.53 сая төгрөг болсон байна. Компанийн гаргасан хувьцааны тоо хэмжээ, нэрлэсэн үнэ болон үүсгэн байгуулагчдын хувь оролцоонд орсон өөрчлөлтүүдийг Компанийн дүрэмд тусган, Улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлтүүдийг оруулсан болно.

Холбоотой талаас авсан зээл (Сонирхлын зөрчилтэй хэлцэл)

Үйлдвэрийн үйл ажиллагаанд шаардлагатай мөнгөн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор 2014 онд тухайн үеийн Гүйцэтгэх захирал Т.Барсаас 70.0 сая төгрөгийг жилийн 8 хувийн хүүтэйгээр тооцон авсан бөгөөд зээлийн хүү болон үндсэн төлбөрт сар бүр 0.6 сая төгрөгийг төлж явсан бөгөөд тухайн үед уг зээлтэй холбоотой ямар нэг гэрээ хэлцэл байгуулаагүй.

2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 05 тоот тогтоолоор Гүйцэтгэх захирал Т.Барсаас авсан зээлийн үлдэгдэл дүн болох 65.9 сая төгрөгийг жилийн 11.4 хувийн хүүтэйгээр Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах зөвшөөрлийг олгосон. Энэхүү тогтоолын хүрээнд ЗГ-02/16 тоот зээлийн гэрээ байгуулж албажуулсан бөгөөд гэрээний үндсэн төлбөрийг хугацааны эцэст барагдуулах, хүүний төлбөрийг сар бүр төлөхөөр 2 жилийн хугацаатай, жилийн 11.4 хувийн хүүтэй гэрээ байгуулсан.

Зээлийн үндсэн төлбөрийг хугацааны эцэст мөнгөөр төлөх эсвэл Компанийн энгийн хувьцааг тухайн үеийн зах зээлийн үнээс 10 хувь хямдруулсан үнээр тооцон, өр төлбөрийн дүнд эзэмшүүлж болох нөхцөлтэй. Гэхдээ өрийг хувьцаанд хөрвүүлэх тохиолдолд Монгол Улсын Компанийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу хөрвүүлэлтийг хэрэгжүүлнэ.

Гүйцэтгэх удирдлага

2016 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр Гүйцэтгэх захирал Т.Барсыг үүрэгт ажлаас нь чөлөөлж, Хувьцаа эзэмшигч бөгөөд ерөнхий инженер Ц.Гүррагчааг гүйцэтгэх захирлаар томилсон байна.

5.2. МНБД гаргаснаас хойш 6 сарын хугацаанд гарч болзошгүй үйл явдлын таамаглал

Үйлдвэрийн өргөтгөл хийх шийдвэр

Компанийн үүсгэн байгуулагч, үйлдвэрийн удирдлага үйлдвэрээ өргөжүүлэх, бүтээгдэхүүний нийлүүлэлтээ нэмэгдүүлэх зорилгоор Монголын үнэт цаасны биржээр дамжуулан хөрөнгө оруулалт татаж, үйлдвэрийн тоног төхөөрөмж, барилга байгууламж, хүчин чадлыг нэмэгдүүлэхээр шийдвэрлэн холбогдох ажлуудыг хийж эхлээд байна. Энэ хүрээнд Монголын үнэт цаасны биржид хүсэлтээ гарган, тус биржийн Бүртгэлийн журмаар шаардсан зарим төрлийн шаардлагуудаас чөлөөлүүлэн, андеррайтер, нийцүүлэгч нартай гэрээ байгуулж, Үнэт цаасны бүртгэлийн баримт бичиг боловсруулах, Монголын үнэт цаасны биржийн бүртгэлийн шалгуур шаардлагын дагуу холбогдох ажлуудыг хийж эхлээд байна. Төлөвлөгөө ёсоор 2017 оны нэгдүгээр хагаст багтаан хувьцаагаа олон нийтэд нээлттэй арилжаалж, хөрөнгө оруулалт татах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт

Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн хурлын 01 тоот тогтоолоор Компанийн энгийн хувьцааг 1:10 харьцаагаар хувааж, нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 1 төгрөг, гаргасан хувьцааны тоог 51,526,700 ширхэг болгон өөрчилсөн. Мөн оны 03 дугаар сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 03 тоот тогтоолоор Компанийн хэлбэрийг өөрчлөн хязгаарлагдмал хариуцлагатай компаниас хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэх, Компанийн зарласан хувьцааны тоог 100,000,000 ширхэг болгон нэмэгдүүлэх, мөн нэмж 26,544,058 ширхэг энгийн хувьцаа эргэлтэнд гаргахаар шийдвэрлэсэн байна.

Удирдлагын тогтолцоо

Монголын үнэт цаасны биржийн Бүртгэлийн шалгуур, Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу Анд-Энерги ХХК нь Төлөөлөн Удирдах Зөвлөлтэй байх шийдвэр гарган Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2017 оны 02 тоот тогтоолоор батламжлан томилсон. Компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд 6 гишүүн, 3 хараат бус гишүүнийг томилж улмаар ТУЗ-ийн 2017 оны 01 болон 02 тоот тогтоолуудаар ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга нарыг томилж, ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулж, тэдгээрийн бүрэлдэхүүнийг томилсон байна.

5.3. Бусад шаардлагатай мэдээлэл

Үүрэг, амлалтууд

- 2015 оны 08 дугаар сард Худалдаа хөгжлийн банкнаас авсан зээлийн барьцаанд Монгол Улсын иргэн Ч.Саруулчимэг, Хувьцаа эзэмшигч Т.Барс нарын үл хөдлөх хөрөнгийг барьцаалж, БГ-RCC2015072708-3 тоот гэрээ байгуулсан. Зээлийн гэрээний дагуу үндсэн зээл болон хүү, нэмэгдүүлсэн хүүний төлбөр төлөгдөөгүй тохиолдолд дээрх үл хөдлөх хөрөнгөөр зээлийн үүргийг хангуулах заалттай.
- Хувьцаа эзэмшигч Т.Барстай байгуулсан Зээлийн гэрээний 2.5 болон 2.7 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2016 оны 05 тоот тогтоолын дагуу зээлийн өрийг Компанийн энгийн хувьцаанд хөрвүүлэх боломжтой. Хэрэв хөрвүүлсэн тохиолдолд хувьцааны хөрвөх үнийг зах зээлийн үнээс 10 хувиар хямдруулан тооцохоор хэлцэл байгуулсан.

Нөөц сан, болзошгүй өр төлбөр

"Эрдэнэт лед" гэрлийн үйлдвэр нь бүтээгдэхүүн нийлүүлэх, худалдах худалдан авах гэрээний дагуу нийлүүлсэн бараа, үзүүлсэн үйлчилгээндээ чанарын баталгаа олгодог. Баталгаат хугацаа нь бүтээгдэхүүний онцлог, гүйцэтгэсэн ажлын шинж чанараас хамааран 24 хүртэлх сарын хугацаатай байдаг.

Нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн ажилын чанарын баталгаанд урьдчилан нөөц үүсгэж бүртгэдэггүй бөгөөд үйлдвэрлэлийн буруугаас үүссэн доголдол, гэмтэлтэй бүтээгдэхүүнийг засварлах, шинээр солих үедээ тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрдөг.

Эрсдэл

Анд-Энерги ХХК нь эрсдэлийн удирдлагын албан ёсны бодлого байхгүй ч удирдлага, зохион байгуулалтын бүтцийг сайжруулах, бүтээгдэхүүний чанар стандартад хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд хөндлөнгийн

аудит хийлгэх зэргээр эрсдэлийн удирдлагыг сайжруулах ажлуудыг хийж байна. Бидний ажигласнаар Компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болох дараах санхүүгийн эрсдэлүүд байна. Үүнд:

Хүүний эрсдэл

Одоогоор Компани арилжааны банкнаас авсан зээлтэй бөгөөд уг зээлийн хүү нь хувьсах магадлалтай. Зээлийн хүүний хувьсах нөхцөл нь Компаниас хамааралгүйгээр төрийн байгууллагын шийдвэртэй хамааралтай тул уг эрсдэлийг хөрөнгө оруулагчид тооцоолж байх нь зүйтэй.

Гадаад валютын эрсдэл

"Эрдэнэт лед" үйлдвэрт ашиглаж буй түүхий эд материалын дийлэнхийг БНХАУ-аас импортлон авдаг. Өнгөрсөн хугацаанд түүхий эд материалын худалдан авалтыг Монгол Улсын иргэнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр хийж байсан бөгөөд энэ тохиолдолд ханшийн эрсдэлд өртөх нь харьцангуй бага байсан. Цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлж, гадны түншүүдтэйгээ хамтын ажиллагааны гэрээ байгуулж, түүхий эдийн татан авалтын давтамжийг цөөрүүлж, нэг удаагийн татан авалтын тоо хэмжээг нэмэгдүүлснээр нэгж бүтээгдэхүүний өртгийг хямдруулах бодлоготой ажиллаж байгаа. Үүнтэй холбоотойгоор валютын ханшийн хэлбэлзлээс хамаарсан эрсдэлд өртөх магадлалтай.

Үйлдвэрийн хүчин чадлын эрсдэл

Үйлдвэр одоогоор LED гэрлийн үйлдвэрлэлийн нэг шугамтай ажиллаж байгаа бөгөөд үйлдвэрийн тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлийг засварлах хугацаанд орлуулах техник тоног төхөөрөмж байхгүй тул үйлдвэрлэл тасалдах эрсдэлтэй. Иймд энэ эрсдэлээс зайлсхийх үүднээс үйлдвэрийн нэмэлт шугам шинээр авахаар төлөвлөж байна.

ХАВСРАЛТ 3-А



“ОД БҮРТГЭЛ АУДИТ”

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АНД–ЭНЕРГИ

ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

2016 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болгосон
Санхүүгийн тайлангийн аудит



Улаанбаатар хот

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

АГУУЛГА

БАЙГУУЛЛАГЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ....1
ЗАХИРЛУУДЫН БОЛОН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ....2
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН....3-7
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН....8
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН....9
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН....10
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН....11
ТОДРУУЛГА 1. БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ....12
ТОДРУУЛГА 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО....12-13
ТОДРУУЛГА 3. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО....13
ТОДРУУЛГА 4. БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ....14
ТОДРУУЛГА 5. ЕРӨНХИЙ, УДИРДЛАГА БА БОРЛУУЛАЛТЫН ЗАРДАЛ....14-15
ТОДРУУЛГА 6. БУСАД ОРЛОГО....15
ТОДРУУЛГА 7. БУСАД ЗАРДАЛ....16
ТОДРУУЛГА 8. САНХҮҮГИЙН ЗАРДАЛ....16
ТОДРУУЛГА 9. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР....16-17
ТОДРУУЛГА 10. ҮНДСЭН ХӨРӨНГӨ....17-18
ТОДРУУЛГА 11. БИЕТ БУС ХӨРӨНГӨ....19
ТОДРУУЛГА 12. БАРАА МАТЕРИАЛ....19
ТОДРУУЛГА 13. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ БА БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ....19
ТОДРУУЛГА 14. ДАНСНЫ АВЛАГА....20
ТОДРУУЛГА 15. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХОРОНГО....20
ТОДРУУЛГА 16. ЭНГИЙН ХУВЬЦАЛ БА ЭЗДИЙН ӨМЧИЙН БУСАД ХЭСЭГ....20-21
ТОДРУУЛГА 17. УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР....21-22
ТОДРУУЛГА 18. ДАНСНЫ БОЛОН БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР....22
ТОДРУУЛГА 19. ХОЛБООТОЙ ТАЛУУД....23
ТОДРУУЛГА 20. ҮҮРЭГ, АМЛАЛТУУД....23
ТОДРУУЛГА 21. НӨӨЦ, САН, БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР....23-24
ТОДРУУЛГА 22.СЕГМЕНТИЙН МЭДЭЭЛЭЛ....24
ТОДРУУЛГА 23.ГАДААД ВАЛЮТААРХ АЖИЛ ГҮЙЛГЭЭ....24
ТОДРУУЛГА 24.ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА....25-26
ТОДРУУЛГА 25.БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ....27

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА1001070 4995772

СӨХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 11

БАЙГУУЛЛАГЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Байгууллагын нэр	"АНД-ЭНЕРГИ" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	2011015075
Регистр	4385772
Гүйцэтгэх удирдлага	Гүйцэтгэх захирал Ц.Гүррагчаа
Ерөнхий нягтлан бодогч	Нягтлан бодогч Ч.Мөнхсаруул
Үйл ажиллагааны чиглэл	LED гэрэл, гэрэлтүүлгийн үйлдвэрлэл, худалдаа
Хувьцаа эзэмшигчид	Монгол улсын 4 иргэн
Байнгын хаяг	Баян замын 3-6, Уртын гол баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг Монгол улс Утас 95101020
Харилцагч банкууд	Худалдаа хөгжлийн банк Хаан банк
Аудиторууд	"Од бүртгэл Аудит" ХХК Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчид

ОД БҮРТГЭЛ АУДИТ -1-

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА:101070 4385772

СӨХ
он сар өдөр
№ 01

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн тайланг бэлтгэх болон батлах талаарх

УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ

Манай компанийн санхүүгийн тайлангийн 2016 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн ба шударгаар илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх зорилгоор хийгдэж буй санхүүгийн тайлангийн аудитын ажилтай холбогдуулан санхүүгийн тайлантай холбоотой компанийн удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь илэрхийлэх зорилгоор дараах мэдэгдлийг хийж байна.

"АНД-ЭНЕРГИ" ХХК-ийн удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу үнэн зөв, шударгаар илэрхийлэх нь бидний үүрэг хариуцлага гэдгийг бид хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд дотоод хяналтын талаар хариуцлага хүлээдэг удирдлага болон бусад удирдах ажилтнуудтай холбоотой залилан эсвэл санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэх залилантай холбоотой нөхцөл байдал үүсээгүй болно.

Бид эдгээр санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

Компанийн удирдлагаас 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланг зөвшөөрч батлав.

Ц.ГҮРРАГЧАА
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.МӨНХСАРУУЛ
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА9101070 4385772

ОД БҮРТГЭЛ АУДИТ -2-

он сар өдөр
БҮРТГЭВ

ОД БҮРТГЭЛ-АУДИТ

БАТАЛГААЖУУЛАЛТ, АУДИТ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"АНД–ЭНЕРГИ" ХХК-ИЙН
ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДЭД

Санхүүгийн Тайлангийн Аудитын Тайлан

Дүгнэлт

Бид, "Анд–Энерги" ХХК-ийн (цаашид компани гэх) 2016 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулга, тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь компанийн 2016 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу, бүх материаллаг зүйлийг хамруулан, үнэн шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн *Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага* хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол Улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигдаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигдаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

ОД БҮРТГЭЛ АУДИТ -3-

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КАЛ01070 4385772

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

Аудитын Гол Асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитад хамгийн их ач холбогдолтой, нөлөө бүхий асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба эдгээр асуудлын талаар тусад нь дүгнэлт гаргаагүй.

- Хувь нийлүүлэгчдийн 2016 оны тогтоолоор хувьцааны жижигрүүлэлт хийж, нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5,052.7 мянган ширхэг хувьцаог нэмж гаргасан.
- Худалдаа хөгжлийн банкнаас 2015 оны 8 дугаар сард "Лед гэрлийн үйлдвэрийн өргөтгөл, тоног төхөөрөмж, түүхий эд материал худалдан авах" зориулалтаар Монгол Улсын Хөгжлийн банкны эх үүсвэртэй зээл авсан. Зээлийн хугацаа 39 сар, зээлийн хүү жилийн 9%. Зээлийн эх үүсвэр солигдсон тохиолдолд зээлийн хүү, хугацаа өөрчлөгдөнө.
- Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 303 тоот тогтоолоор батлагдсан "Байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол хаягдлыг багасгах, байгальд халгүй техник тоног төхөөрөмж"-ийн жагсаалтад багтсан Эрчим хүчний хэмнэлттэй гэрлийн шил (light-emitting diode буюу LED-тай)-ийг үйлдвэрлэж, борлуулдаг тул Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.1.8 дахь заалтын дагуу борлуулалтын орлого нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чолоологддог.
- Компани нь үйлдвэрлэлтэй холбоотой зардлуудыг бэлэн бүтээгдэхүүн, борлуулсан бүтээгдэхүүний өртөгт хуваарилдаг бөгөөд үйлдвэрлэлийн бус зардлуудыг ерөнхий ба удирдлага, борлуулалтын зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнадаг. Түүхий эд материал, бэлэн бүтээгдэхүүний төрөл тус бүрийн нэгжийн өртгийг давтан тооцоолоогүй болно.

Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаа зөрчилгүй

ОД БҮРТГЭЛ АУДИТ -4-

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КАМ01070 4385772

СӨХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 11

санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах, өөрийн дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргахад байдаг. Ул үндэслэлтэй нотолгоо нь баталгааны өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгддэг аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг цаг ямагт илрүүлж байна гэсэн амлалт өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залиланғаас эсвэл алдаанаас үүсч болох ба дангаараа юмуу нийлээд материаллаг болж эдгээр алдаа нь санхүүгийн тайлангууд дээр суурилан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай гэж үзсэн үед материаллаг буруу илэрхийллийг авч үзнэ.

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн үнэлэмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залиланғаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КАМ01070 4385772

ОД БҮРТГЭЛ АУДИТ -5-

СЗХ
ӨМ САР ӨДӨР
БҮРТГЭВ
№ 04

үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг. учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.

- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үл үндэслэл, удирдлагын хийсэн тооцоолол болон холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог.
- Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, тодруулга, бүтэц, агуулга нь санхүүгийн тайлангуудаа үнэн зөв толилуулах шаардлагаа хангахуйц байдлаар үндсэн ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын явцад илэрсэн гол гол асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан.

ОД БҮРТГЭЛ АУДИТ -6

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА01010704385772

Тайлангийн хэрэглээ

Энэ тайлан нь Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргасан бөгөөд бусад этгээдэд зориулагдаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Энэхүү хараат бус аудиторын тайлан дахь аудитын үр дүнг хариуцах гэрээт ажлын партнер нь захирал У.Оюунаа болно.

ОД БҮРТГЭЛ АУДИТ ХХК

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ У.ОЮУНАА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж
Үндэсний соёл амралтын хүрээлэн 7/3 байр, 7 давхар 701 тоот.
Утас: 976-70150013, И-мэйл: info@odburtgel.mn
2017/04/17

СЗХ он сар өдөр БҮРТГЭВ № 01

"АНД-ЭНЕРГИ" ХХК

Аудитлагдсан санхүүгийн байдлын тайлан 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр

/мянган төгрөгөөр/

	ТОД	2015.12.31	2016.12.31
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	15	57,401.67	64,903.84
Дансны авлага	14	123,924.88	37,061.76
Татвар, НДШ – ийн авлага	13	299.80	-
Бусад авлага	13	-	94.98
Бараа материал	12	95,706.48	146,378.91
Урьдчилж төлсөн зардал	13	65,021.46	11,586.88
Эргэлтийн хөрөнгийн дүн		**342,354.30**	**260,026.36**
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	10	115,331.07	268,145.55
Биет бус хөрөнгө	11	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		**115,331.07**	**268,145.55**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		**457,685.37**	**528,171.91**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
Өр төлбөр			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг		-	-
Цалингийн өглөг		-	-
Татварын өр	18	40,936.52	25,242.40
НДШ - ийн өглөг		-	-
Банкны богино хугацаат зээл		-	-
Бусад өглөг	18	-	1,054.32
Богино хугацаат өр төлбөрийн дүн		**40,936.52**	**26,296.72**
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл	17	167,692.12	162,530.71
Урт хугацаат өр төлбөрийн дүн		**167,692.12**	**162,530.71**
Өр төлбөрийн нийт дүн		**208,628.64**	**188,827.43**
Эздийн өмч			
Өмч		1,000.00	51,526.76
- Хувийн	16	1,000.00	51,526.76
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	16	-	73,377.04
Эздийн өмчийн бусад хэсэг	16	10,903.60	-
Хуримтлагдсан ашиг	16	237,153.13	214,440.68
Эздийн өмчийн дүн		**249,056.73**	**339,344.48**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		**457,685.37**	**528,171.91**
		-	-

ОД БҮРТГЭЛ АУДИТ -8-

ОРХОН АЙМАГ АНД-ЭНЕРГИ ХХК КА01070 4385772

ОН САР ӨДӨР
БҮРТГЭВ
№ 31

"АНД-ЭНЕРГИ" ХХК

Аудитлагдсан орлогын дэлгэрэнгүй тайлан 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр

/мянган төгрөгөөр/

	ТОД	өмнөх үе	тайлант үе
Борлуулалтын орлого (нэвэр)	3	**597,992.81**	**682,429.91**
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	4	240,649.11	384,214.34
Нийт ашиг (алдагдал)		**357,343.70**	**298,215.57**
Түрээсийн орлого		-	-
Хүүний орлого	6	348.74	621.51
Бусад орлого	6	-	-
Санхүүгийн зардал	8	-	17,140.83
Борлуулалт, маркетингийн зардал	5	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	5	114,545.35	128,812.94
Гадаад валютын ханшийн эөрүүний олз (гарз)		-	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-	-
Бусад ашиг (алдагдал)	7	(4,170.99)	(107,013.25)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		**238,976.10**	**45,870.06**
Орлогын татварын зардал	9	2,034.87	2,894.99
Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		236,941.23	42,975.07
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)			
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		**236,941.23**	**42,975.07**
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)			

ОД АУДИТ ХХК

ОД БҮРТГЭЛ АУДИТ -9-

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА/01070 4385772

АНД-ЭНЕРГИ ХХК ОРХОН АЙМАГ КД.9901070 4385772

УНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

"АНД-ЭНЕРГИ" ХХК

Аудитлагдсан өмчийн өөрчлөлтийн тайлан 2016 оны 12 сарын 31-ний өдрөөр /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нөөц	Өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Дүн
2015.12.31-ний үлдэгдэл	1,000.00	-	-	10,903.60	237,153.13	249,056.73
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				39,623.16	(65,687.53)	(26,064.36)
Залруулагдсан үлдэгдэл	**1,000.00**	**-**	**-**	**50,526.76**	**171,465.60**	**222,992.36**
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					42,975.07	42,975.07
Гаргасан хувьцаа	50,526.76			(50,526.76)		-
Бусад дэлгэрэнгүй орлого			73,377.04			73,377.04
Зарласан ногдол ашиг						-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						-
2016.12.31-ний үлдэгдэл	**51,526.76**	**-**	**73,377.04**	**-**	**214,440.67**	**339,344.48**

ОД БҮРТГЭЛ АУДИТ -10-

СЭХ ОН САР БҮРТГЭВ №01

"АНД-ЭНЕРГИ" ХХК

Аудитлагдсан мөнгөн гүйлгээний тайлан 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр

/мянган төгрөгөөр/

	өмнөх үе	тайлант үе
1.Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	**299,465.58**	**854,977.91**
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	299,465.58	769,689.06
Даатгалын нөхөөрөөс хүлээн авсан мөнгө	-	19.63
Буцаан авсан албан татвар	-	-
Бусад мөнгөн орлого	-	-
Бусад	-	85,269.22
Мөнгөн зарлагын дүн	**306,186.14**	**728,524.00**
Ажилчдад олгосон мөнгө	36,942.88	69,201.07
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	9,684.79	20,995.03
Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	115,501.48	137,137.98
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	1,194.19	2,344.01
Түрээ шатахуун,тээврийн хөлс,сэлбэг	5,705.34	9,072.26
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	-	-
Татварын байгууллагад төлсөн мөнгө	2,050.00	83,620.57
Хүүний төлбөрт төлсөн мөнгө	9,060.78	17,140.83
Бусад мөнгөн зарлага	126,046.68	389,012.25
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	**(6,720.57)**	**126,453.91**
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны		
Худалдаж авсан үндсэн хөрөнгө	(5,987.00)	(77,309.74)
Бусдад олгосон зээл мөнгөн урьдчилгаа	-	-
Бусдад олгосон зээл мөнгөн урьдчилгааны	-	-
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	**(5,987.00)**	**(77,309.74)**
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн		
Зээлийн төлөлт	(1,573.88)	(5,161.40)
Авсан зээл	100,000.00	-
Хувьцаа өмчийн үнэт цаас гаргаснаас олсон орлого	-	-
Төлсөн ногдол ашиг	(36,021.00)	
Хүүгийн орлого	-	-
Бусад	(4,170.99)	(36,480.61)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	**58,234.14**	**(41,642.01)**
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**45,526.57**	**7,502.17**
Мөнгөний эхний үлдэгдэл	**11,875.10**	**57,401.67**
Мөнгөний эцсийн үлдэгдэл	**57,401.67**	**64,903.84**
	-	-

ОД БҮРТГЭЛ АУДИТ -11-

ОРХОН АЙМАГ АНД-ЭНЕРГИ ХХК КА01010 4385772

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

"АНД–ЭНЕРГИ" ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулга 2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

1. БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

"Анд-Энерги" ХХК нь 2011 оны 5 дугаар сард үүсгэн байгуулагчдын шийдвэрээр байгуулагдан, 2011 оны 5 дугаар сард Монгол улсын Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, 2011015075 дугаартай 84669 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ авсан. Байгууллагын регистрийн дугаар 4385772.

Нийт хувьцааг Монгол Улсын иргэн Т.Барс, Ц.Гүррагчаа, Г.Түвшин, Д.Мөнхбаяр нар хувь тэнцүү буюу тус бүр 25%-ийг эзэмшдэг.

Үйл ажиллагааны чиглэл нь байгальд халгүй техник болох лед гэрлийг үйлдвэрлэж, борлуулдаг. Түүнчлэн лед гэрлийг ашиглан цахилгаан бага зарцуулдаг байгальд ээлтэй технологи бүхий тасалгааны болон гадна талбайн гэрэлтүүлгийн ажлыг гүйцэтгэдэг бөгөөд Монгол Улсын Эрчим хүчний яамнаас 2015 оны 4 дүгээр сард үйл ажиллагаа эрхлэх 1149/15, Барилга хот байгуулалтын яамнаас 2014 оны 3 дугаар сард БУ35-27І/І4 тоот тусгай зөвшөөрөл авсан.

Гүйцэтгэх захирлаар нь Ц.Гүррагчаа ажиллаж байна

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО

2.1. Тайлан бэлтгэх үндэслэл

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Хороо ("НББОУСХ")-ноос гаргаж, мөрдүүлсэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС") болон НББОУСХ-ны Тайлбарын Байнгын Хорооноос гаргасан тайлбарын дагуу бэлтгэгдсэн байна. Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Монгол улсын Сангийн яамнаас батлагдсан заавар журам, Монгол улсад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг мөн дагаж мөрдсөн болно.

Санхүүгийн тайлангууд нь Монгол улсын валют болох төгрөгөөр илэрхийлэгдэж, түүхэн өртгийн зарчмын дагуу бэлтгэгдсэн.

2.2. Үйл ажиллагааны тасралтгүй зарчим

Санхүүгийн тайлангууд нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилагдан бэлтгэгдсэн бөгөөд компанийн үйл ажиллагаа тасалдах нөхцөл ажиглагдаагүй.

Компани нь 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 214,440.7 мянган төгрөгийн хуримтлагдсан ашигтай ба 26,296.7 мянган төгрөгийн богино хугацаат өр

ОД БҮРТГЭЛ АУДИТ -12-

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА01010 4385772

СӨХ БҮРТГЭВ №.11

төлбөртэй ажилласан ба энэ нь эргэлтийн хөрөнгөөс 10 дахин бага байна. Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ нь 126,453.9 мянган төгрөгийн орох урсгалтай байсан.

2.3. Нягтлан бодох бүртгэлд бодлогод орсон өөрчлөлтүүд

Шинээр болон нэмэлт өөрчлөлт бүхий стандартууд: 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон дараах СТОУС-уудаас бусад нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь өмнөх санхүүгийн жилийнхтэй ижил байна. Үүнд:

• НББОУС 1 Нэмэлт өөрчлөлт	*Толилуулгын санаачлага*
• НББОУС 16 ба НББОУС 41 Нэмэлт өөрчлөлт	*Ходоо аж ахуй: Эх ургамал*
• НББОУС 27 Нэмэлт өөрчлөлт	*Тусдаа санхүүгийн тайлан – Өмчийн арга*
• СТОУС 15 Нэмэлт өөрчлөлт	*Хүчин төгөлдөр мөрдөгдөх хугацаа*
• СТОУС 10 ба НББОУС 28	*Хүчин төгөлдөр мөрдөгдөх хугацаа*

Дээр дурдсан стандартууд нь нягтлан бодох бүртгэлийн бодлогод томоохон өөрчлөлт үзүүлээгүй бөгөөд компанийн санхүүгийн тайлагналд нөлөө үзүүлээгүй.

Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд: Энэхүү санхүүгийн тайланг гаргасан өдөр дараах стандартууд болон тайлбарууд батлагдаж гарсан боловч хэрэгжиж эхлээгүй байсан. Үүнд:

• СТОУС 9	*Санхүүгийн хэрэглүүр*
• СТОУС 10 ба НББОУС 28	*Хөрөнгө оруулагч, хараат компани болон хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоо*
• СТОУС 15	*Харилцагчидтай байгуулсан гэрээний орлого*
• СТОУС 16	*Түрээс*
• СТОУС 12 Нэмэлт өөрчлөлт	*Орлогын албан татвар*

3. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

Аж ахуйн нэгж нь ажил гүйлгээний эцсийн өгөөжийг хүртэх магадлалтай, орлогын дүнг бодитой тооцон гаргах боломжтой ба хөрөнгийг нэмэгдүүлж, өр төлбөрийг багасгаж байвал орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Үндсэн үйл ажиллагааны орлого нь лед гэрэл борлуулалт, гэрэлтүүлгийн ажил болон бусад үйлчилгээний орлогоос бүрдэж байна.

ОД БҮРТ...ЛТ АУДИТ -13-

ОРХОН АЙМАГ АНД-ЭНЕРГИ ХХК КА01070 4385772

САХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

	Тайлант үе /мян.төг/
LED гэрлийн борлуулалт	323,334.56
Гэрэлтүүлгийн ажил	312,684.20
Бусад ажил, үйлчилгээ	46,438.52
Үнийн бууралт	(27.37)
Цэвэр борлуулалтын орлого	**682,429.91**

Тайлант жилийн нийт борлуулалтын 47% нь Лед гэрлийн худалдаа, 46% нь тасалгааны болон гадна талбайн гэрэлтүүлгийн ажил, үлдсэн 7%-ийг засвар үйлчилгээ гэх мэт бусад ажлын орлогоос бүрдэж байна.

4. БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ

Компани нь үйлдвэрлэлтэй хамаарах зардлууд болох үйлдвэрийн ажилчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэл, түүхий эд материалын зардал болон бусад үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлыг бэлэн бүтээгдэхүүн, борлуулсан бүтээгдэхүүний өртөгт хуваарилдаг.

	Тайлант үе /мян.төг/
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	384,214.34
Нийт дүн	**384,214.34**

Бэлэн бүтээгдэхүүний өртгийн тайланг сар бүр хөтлөн явуулдаг бөгөөд бэлэн бүтээгдэхүүний худалдаа, гэрэлтүүлгийн ажил, засвар үйлчилгээний өртгийг тус бүрт нь толилуулахгүйгээр нэгтгэж санхүүгийн тайланд толилуулсан.

5. ЕРӨНХИЙ УДИРДЛАГА БА БОРЛУУЛАЛТЫН ЗАРДАЛ

Эдийн засгийн үр өгөөжийг бууруулж, өр төлбөрийг нэмэгдүүлж байвал зардал гэж үзнэ. Гарсан зардал ба олсон орлогын хоорондох шууд хамаарлыг үндэслэн орлогын тайланд зардлыг хүлээн зовшөөрнө. Зардлыг төлсөн, эсвэл төлөхөөр хүлээгдэж байгаа мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн нэрлэсэн үнэ буюу бодит дүнгээр нь хэмжинэ. Гадаад валютаар гарсан зардлыг тухайн үеийн албан ханшаар хөрвүүлж, бүртгэнэ.

ОД БҮРТГЭЛ АУДИТ -14-

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА9301070 4385772

"АНД-ЭНЕРГИ" ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулга 2016 оны 12-р сарын 31-ний одроор дууссавар болсон

Зардлын ангилал	Тайлант үе /мян.төг/
Цалингийн зардал	47,124.12
Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	5,827.96
Албан татвар, хураамж толборийн зардал	-
Засвар үйлчилгээний зардал	2,078.00
Ашиглалтын зардал	1,085.91
Албан томилолтын зардал	30,732.92
Тээврийн зардал	409.48
Элэгдэл, хорогдлын зардал	922.72
Зар сурталчилгааны зардал	742.94
Шуудан холбооны зардал	444.60
Шатахууны зардал	7,624.97
Сургалтын зардал	380.00
Бичиг хэргийн зардал	710.00
Мэргэжлийн үйлчилгээний зардал	1,930.00
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	346.00
Хүлээн авалтын зардал	1,020.00
Түрээсийн зардал	13,572.00
Хангамжийн зардал	996.00
Бусад зардал	2,865.32
Нийт зардлын дүн	**28,812.94**

6. БУСАД ОРЛОГО

	Тайлант үе /мян.төг/
Хүүний орлого	621.51
Нийт орлогын дүн	**621.51**

Худалдаа хөгжлийн банк, Хаан банкны харилцах дансны хүүгийн үлдэгдэлд тооцсон хүүгийн орлогыг бусад орлогоор хүлээн зөвшөөрсөн.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КАМ01070 4385772

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ

7. БУСАД ЗАРДАЛ

		Тайлант үе /мян.төг/
Ханлиын зардал		5,140.62
Пайдваргүй авлагын зардал:		90,127.80
- Борлуулалт	22,699.37	
- Бусад	67,428.43	
Бусад		11,744.84
Нийт зардлын дүн		**107,013.25**

2015 оноос 2016 оны 1-р улиралд үүссэн харилцагчаас авах борлуулалтын авлага, бэлтгэн нийлүүлэгчид өгсөн худалдан авалтын урьчилгааг нэхэмжилж авах, цуглуулах боломжгүй болсон тул найдваргүй авлагаар тооцсон. Дээрх авлагыг хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор данснаас хасаж, тайлант үеийн зардлаар бүртгэсэн.

8. САНХҮҮГИЙН ЗАРДАЛ

	Тайлант үе /мян.төг/
Зээлийн хүүгийн зардал	17,140.83
- Урт хугацаат зээлийн хүү /Банкны зээл/	6,100.00
- Бусад зээлийн хүү	11,040.83
Нийт зардлын дүн	**17,140.83**

9. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР

	Тайлант үе /мян.төг/
Тайлант жилийн үр дүнд суурилсан орлогын албан татварын зардал	2,894.99
Нийт зардлын дүн	**2,894.99**

Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн 18.1.8 дахь заалт "байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд халгүй техник, тоног төхөөрөмжийг борлуулсан орлогыг албан татвараас чөлөөлнө" гэж заасан. Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 303 тоот тогтоолоор батлагдсан "Байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол хаягдлыг багасгах, байгальд халгүй техник тоног төхөөрөмж"-ийн жагсаалтад багтсан Эрчим хүчний хэмнэлттэй гэрлийн шил (light-

ОД БҮРТГЭЛ АУДИТ -16-

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КАЛ01070 4385772

БҮРТГЭВ

emitting diode буюу LED-тай)-ийг үйлдвэрлэж, борлуулдаг тул борлуулалтын орлого нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөгддөг.

Туслах үйлдвэрлэл, ажил үйлчилгээний борлуулалтын орлого, түүнд хамаарах борлуулсан бүтээгдэхүүний өртгийн цэвэр дүнд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ногдуулж, зардлаар хүлээн зөвшөөрдөг.

10. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийг анхны өртөгөөр нь хүлээн зөвшөөрөх бөгөөд анхны өртөгт худалдан авсан үнэ, тухайн хөрөнгийг ашиглах байршилд суурилуулах, бэлтгэх ажлын зардлууд багтдаг. Анх хүлээн зөвшөөрсний дараа үеэс анхны өртөгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнийн бууралтыг хассан дүнгээр цэвэр дүнгээр толилуулдаг. Үндсэн хөрөнгийн өдөр тутмын үйлчилгээний зардлыг тухайн зардал гарсан тайлант үеийн орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Үндсэн хөрөнгийг худалдан борлуулснаас үүсэх олз, гарзыг дансны үнийг борлуулсан үнэтэй харьцуулах байдлаар тодорхойлж, орлого, үр дүнгийн тайланд хөрөнгө борлуулсны олз, гарзаар бүртгэдэг.

Татварын хуулиар тогтоосон ашиглах хугацаанд суурилан шулуун шугамын аргаар үндсэн хөрөнгийн элэгдлийг байгуулдаг.

Үндсэн хөрөнгийг анх удаа дахин үнэлснээс бий болсон нэмэгдлийг санхүүгийн байдлын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайланд "Дахин үнэлгээний нэмэгдэл" дансанд хуримтлуулан бүртгэж, бусад дэлгэрэнгүй орлогоор толилуулдаг.

[16] Бакалаврын дипломны дугаар: 22019. Монгол улсын Техникийн Их сургуулиас 2001 оны 06 сарын 25-ны өдөр олгосон.
Монгол улсын шинжлэх ухаан, технологийн их сургуулиас 2010 оны 06 сарын 23-ны өдөр олгосон Е20104346 тоот Магистрын диплом.
[17] 2011 оны 05 сарын 16-ны өдрийн Компани-ийг үүсгэн байгуулах 01 тоот тогтоол.
[18] "Улаанбаатар тунхлэл 2016" үзэсгэлэнгээс 2016 оны 09 сарын 12-ны өдөр "Орчин үеийн технологитой бүтээгдэхүүн" өргөмжлөл, цом олгосон.
[19] "Эрдэнэт тунхлэл 2016" үзэсгэлэнгээс 2016 оны 10 сарын 09-ний өдөр "Дэвшилтэт технологитой бүтээгдэхүүн" өргөмжлөл, цом олгосон.
[20] Орхон аймгийн Уртын гол багийн Засаг дарга А.Баясгалангийн 2016 оны 12 сарын 17-ны өдөр олгосон өргөмжлөл.
[21] Орхон аймгийн Баян-Өндөр сумын Нийгмийн даатгалын хэлтсээс олгосон Ц. Гуррагчаагийн 0174563 (9010376 тоот дэвтрийн үргэлжлэл) тоот нийгмийн даатгалын дэвтрийн 1, 26, 27 дахь тал.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
"АНД-ЭНЕРГИ" ХХК
КАЗ01070 4395772

23. ТҮЗ-ийн гишүүн[22], ТҮЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны гишүүн[23] Г.Түвшин нь элетроникийн инженер мэргэжилтэй[24].

24. Г.Түвшин нь Компанийн ТҮЗ-ийн гишүүн, Цалин урамшууллын хорооны гишүүнээр ажиллахаас гадна 2011 оноос хойш Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн Цахилгаан хөтлүүр, автоматикийн хэсэгт автоматикийн инженерээр[25] ажиллаж байна.

25. Г.Түвшин нь компанийн засаглалын сургалтад хамрагдаж 2017 оны 04 сарын 15-ны өдөр 0430505 дугаартай гэрчилгээ авсан.

***Далхаагийн Мөнхбаяр** - ТҮЗ-ийн гишүүн, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн*

26. ТҮЗ-ийн гишүүн[26], ТҮЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороны гишүүн[27] Д.Мөнхбаяр нь авто машин ашиглалт, авто аж ахуйн инженер мэргэжилтэй[28].

27. Д.Мөнхбаяр нь Компанийн ТҮЗ-ийн гишүүн, Нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр ажиллахаас гадна 2010 оноос хойш Эрдэнэт Үйлдвэр ХХК-д цахилгаан засварчнаар[29] ажиллаж байна.

28. Д.Мөнхбаяр нь компанийн засаглалын сургалтад хамрагдаж 2017 оны 04 дугаар сарын 15-ны өдөр 0430504 дугаартай гэрчилгээ авсан.

***Манханы Отгонбаатар** - ТҮЗ-ийн гишүүн*

29. ТҮЗ-ийн гишүүн[30] М.Отгонбаатар нь Бизнес судлаач-эдийн засагч мэргэжилтэй[31] бөгөөд Компанийн 2017 оны 03 сарын 29-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн эзлжит бус хурлын 02 тоот тогтоолоор ТҮЗ-ийн гишүүнээр сонгогдсон.

30. М.Отгонбаатар нь Компанийн ТҮЗ-ийн гишүүнээр ажиллахаас гадна 1992 оноос хойш "Шилийн богд брокерийн пүүс"-д дилер, "Монсек ХХК"-д захирлаар[32] ажиллаж байна.

---

[22] "Анд Энерги" ХХК-ийн 2017 оны 03 сарын 29-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн эзлжит бус хурлын 02 тоот тогтоолын 1 дүгээр зүйл.
[23] Тус компанийн ТҮЗ-ийн 2017 оны 04 сарын 03-ны өдрийн 02 тоот тогтоолын 3 дугаар зүйл.
[24] Дипломны дугаар: D200515905. Монгол улсын их сургуулийн Мэдээлэл технологийн сургуулиас 2005 оны 06 сарын 20-ны өдөр олгосон.
[25] Орхон аймгийн Баян-Өндөр сумын Нийгмийн даатгалын хэлтсээс 2011 оны 01 сарын 01-ны өдөр олгосон 0339421(1140-66666 тоот дэвтрийн үргэлжлэл) тоот нийгмийн даатгалын дэвтрийн 1, 26, 27 дахь тал.
[26] "Анд Энерги" ХХК ийн 2017 оны 03 сарын 29-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн эзлжит бус хурлын 02 тоот тогтоолын 1 дүгээр зүйл.
[27] Тус компанийн 2017 оны 04 сарын 03-ны өдрийн 02 тоот ТҮЗ-ийн тогтоолын дагуу ТҮЗ-ийн дэргэд байгуулагдсан нэр дэвшүүлэх хорооны даргаар томилогдон ажиллаж байна.
[28] Дипломны дугаар D201336518. Шинжлэх ухаан технологийн их сургуулиас 2014 оны 01 сарын 22-ны өдөр олгосон.
[29] Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс 2010 оны 03 сарын 15-ны өдөр олгосон Д.Мөнхбаярын 000058937 (135145 тоот дэвтрийн үргэлжлэл) тоот нийгмийн даатгалын дэвтрийн 1, 26, 27 дахь тал
[30] "Анд Энерги" ХХК-ийн 2017 оны 03 сарын 29-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн эзлжит бус хурлын 02 тоот тогтоолын 1 дүгээр зүйл.
[31] Дипломны дугаар: 9903872. Санхүү эдийн засгийн дээд сургуулиас 1999 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр олгосон.
[32] Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс 1995 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр олгосон М.Отгонбаатарын 243870 тоот нийгмийн даатгалын дэвтрийн 1, 22, 23 дахь тал.

СӨХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

31. М.Отгонбаатар нь компанийн засаглалын сургалтад хамрагдаж 2013 оны 05 сарын 23-ны өдөр 0930031 дугаартай гэрчилгээ авсан.

Лувсангийн Итгэлт *ТУЗ-ийн гишүүн*

32. ТУЗ-ийн гишүүн Л.Итгэлт нь хөдөө аж ахуйн нягтлан бодогч, банк санхүүч мэргэжилтэй. Компанийн 2017 оны 03 сарын 29-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 02 тоот тогтоолоор ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсон.

33. Л. Итгэлт нь 1991-2003 оны хооронд Алтан сан брокер диллерийн компанид гүйцэтгэх захирал, дилерээр ажиллаж байгаад 2003 оноос БАТС ҮЦК-д дилер, арилжаа эрхэлсэн захирлаар ажиллаж байна.

34. Л. Итгэлт нь компанийн засаглалын сургалтад хамрагдаж 2017 оны 04 сарын 15-ны өдөр 0430509 дугаартай гэрчилгээ авсан байна.

Дагвапунцагийн Алтангэрэл - *ТУЗ-ийн хараат бус гишүүн, Цалин урамшууллын хорооны дарга, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн*

35. ТУЗ-ийн хараат бус гишүүн[33], ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны дарга, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн[34] Д.Алтангэрэл нь уул уурхайн цахилгаан механик, тоноглол ашиглалтын мэргэжилтэй[35] бөгөөд 2008 оноос хойш "АЦХ" ХХК-ийн гүйцэтгэх захирал албан тушаалд[36] ажиллаж байна.

36. Д.Алтангэрэл нь Компанийн 2017 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 02 тоот тогтоолоор төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр, тус компанийн ТУЗ-ийн 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 02 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны дарга, Нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр тус тус сонгогдсон байна.

37. Д.Алтангэрэл нь компанийн засаглалын сургалтад хамрагдаж 2017 оны 04 сарын 15-ны өдөр 0430508 дугаартай гэрчилгээ авсан байна.

Хүрэлцоожийн Баярсайхан - *ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны гишүүн*

38. ТУЗ-ийн хараат бус гишүүн[37], ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн[38] Х.Баярсайхан нь эдийн засагч мэргэжилтэй[39] бөгөөд 2010 оноос хойш Эрдэнэт

---

[33] Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2017 оны 03 сарын 29-ний өдрийн 02 тоот тогтоолоор ТУЗ-ийн хараат бус гишүүдээр сонгогдсон.
[34] Компанийн ТУЗ-ийн 2017 оны 04 сарын 03-ны өдрийн 02 тоот тогтоолоор томилсон.
[35] Бакалаврын дипломны дугаар: 14123. Политехникийн дээд Техникийн их сургуулиас 1993 оны 05 дугаар сарын 01-ны өдөр олгосон. Магистрын дипломны дугаар: Е14123. Монгол улсын Шинжлэх ухаан технологийн их сургуулиас 2008 оны 06 дугаар сарын 04-ны өдөр олгосон.
[36] Орхон аймгийн Баян-Өндөр сумын Нийгмийн даатгалын хэлтсээс 2008 оны 05 сарын 01-ний өдөр олгосон Д.Алтангэрэлийн 000280823 тоот нийгмийн даатгалын дэвтрийн 1, 26, 27 дахь тал.
[37] Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2017 оны 03 сарын 29-ний өдрийн 02 тоот тогтоолоор ТУЗ-ийн хараат бус гишүүдээр сонгогдсон.
[38] Компанийн ТУЗ-ийн 2017 оны 04 сарын 03-ны өдрийн 02 тоот тогтоолоор томилсон.
[39] Дипломны дугаар: ДИС 0020272. Г.В. Плехановийн нэрэмжит Санкт Петербургийн Уул уурхайн институт (Техникийн их сургууль)-иас 2003 оны 6 сарын 30-ны өдөр олгосон.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК

КАМ01070 4385772

ОН САР ӨДӨР
БҮРТГЭВ
№ 01

Үйлдвэр ХХК-ийн Баяжуулах үйлдвэрийн эдийн засгийн товчоонд тэргүүлэх эдийн засагч албан тушаалд[40] ажиллаж байна.

39. Х.Баярсайхан нь Компанийн 2017 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 02 тоот тогтоолоор төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр, тус компанийн ТУЗ-ийн 2017 оны 04 сарын 03-ны өдрийн 02 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны гишүүнээр тус тус сонгогдсон байна.

40. Х.Баярсайхан нь компанийн засаглалын сургалтад хамрагдаж 2017 оны 04 сарын 15-ны өдөр 0430507 дугаартай гэрчилгээ авсан байна.

***Мөнхжаргалын Ганбат** - ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны болон Цалин урамшууллын хорооны гишүүн*

41. ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны болон Цалин урамшууллын хорооны гишүүн М.Ганбат нь олон улсын эдийн засагч мэргэжилтэй[41].

42. М.Ганбат нь Компанийн 2017 оны 03 сарын 29-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 02 тоот тогтоолоор ТУЗ-ийн хараат бус гишүүнээр, тус компанийн ТУЗ-ийн 2017 оны 04 сарын 03-ны өдрийн 02 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны болон Цалин урамшууллын хорооны гишүүнээр тус тус сонгогдсон байна.

43. Энэ хууль зүйн дүгнэлт гарах өдрийн байдлаар М. Ганбат нь компанийн засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ аваагүй байна.

***Баянмандалын Пүрэвдолгор** - ТУЗ-ийн нарийн бичгийн дарга*

44. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга[42] Б.Пүрэвдолгор нь компьютерийн техник хангамж, сүлжээний мэргэжилтэй[43]. Б.Пүрэвдолгор нь Компанид 2015 оноос эхлэн чанарын менежерээр[44] ажиллаж байгаа бөгөөд тус компанийн ТУЗ-ийн 2017 оны 04 сарын 03-ны өдрийн 01 тоот тогтоолоор ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар томилогдсон.

45. Б.Пүрэвдолгор нь компанийн засаглалын сургалтад хамрагдаж 2017 оны 04 сарын 15-ны өдөр 0430510 дугаартай гэрчилгээ[45] авсан байна.

Эрх бүхий албан тушаалтнууд хуульд заасан шаардлагад нийцсэн байдлын талаар

---

[40] Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс олгосон Х.Баярсайханы 000043111 (9206787 тоот дэвтрийн үргэлжлэл) тоот нийгмийн даатгалын дэвтрийн 1, 26-28 дахь тал.
[41] Дипломны дугаар: D200310676. Олон улсын эдийн засаг Бизнесийн дээд сургуульиас 2003 оны 05 сарын 21-ний өдөр олгосон.
[42] Компанийн ТУЗ-ийн 2017 оны 04 сарын 03-ны өдрийн 01 тоот тогтоолоор ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар томилогдсон байна.
[43] Дипломны дугаар: D201420385. Хүмүүнлэгийн ухааны их сургууль, Мэдээлэл харилцааны менежментийн сургуулиас 2014 оны 06 сарын 12-ны өдөр олгосон.
[44] Орхон аймгийн Баян-Өндөр сумын Нийгмийн даатгалын хэлтсээс 2015 оны 11 сарын 01-ны өдөр олгосон 1129917 тоот нийгмийн даатгалын дэвтрийн 1-4, 26, 27 дахь тал.
[45] Компанийн засаглалын үндэсний зөвлөлөөс олгосон.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА#01070 4385772

46. Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар нь Компанийн хууль болон Компанийн засаглалын кодекст заасан эрх бүхий албан тушаалтны шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр авч үзвэл:

КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА					
№	Шаардлага / Нэрс	**Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг эсэх** (КтХ-ийн 84.3.1)	**Ял шийтгэл эдэлж байгаа эсэх** (КтХ-ийн 84.3.2)*	**Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан эсэх** (КтХ-ийн 75.8)	**Хувь хүн байх** (КтХ-ийн 77.3, 83.2, 83.3)
1.	**Т. Барс** (ТУЗ-ын дарга)	Үгүй	Үгүй*	Тийм	Тийм
2.	**Д. Мөнхбаяр** (ТУЗ-ийн гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм	Тийм
3.	**М. Отгонбаатар** (ТУЗ-ийн гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм	Тийм
4.	**Г. Түвшин** (ТУЗ-ийн гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм	Тийм
5.	**Л. Итгэлт** (ТУЗ-ийн гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм	Тийм
6.	**Д. Алтангэрэл** (ТУЗ-ийн хараат бус гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм	Тийм
7.	**Х. Баярсайхан** (ТУЗ-ийн хараат бус гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм	Тийм
8.	**М. Ганбат** (ТУЗ-ийн хараат бус гишүүн)	Үгүй	Үгүй*	Үгүй	Тийм
9.	**Ц. Гүррагчаа** (ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал)	Үгүй	Үгүй*	Тийм	Тийм
10.	**Б. Пүрэвдолгор** (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга)	Үгүй	Үгүй*	Тийм	-

* Монгол Улсын Хууль зүйн сайдын 2013 оны 01 сарын 31-ний өдрийн А/12 тоот тушаалын 4 дүгээр хавсралтад заасны дагуу Ял шийтгэлтэй эсэх лавлагааг өмгөөллийн нөхөрлөлд олгодоггүй тул Компанийн тухай хуулийн КтХ-ийн 84.3.2-т заасан Ял шийтгэл эдлээгүй байх шаардлагыг ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн дарга нар хангаж байгаа эсэхийг тэдний гаргаж өгсөн мэдүүлэг, баталгаагаар үндэслэж дүгнэв.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангасан байдлын талаар

47. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүд нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах нэмэлт шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр авч үзвэл:

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
240 Г "АНД-ЭНЕРГИ" ХХК
КАЛ01070 4385772

СЭХ он сар өдөр № 01

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД ТАВИГДАХ НЭМЭЛТ ШААРДЛАГА

№	Нэрс / Шаардлага	Х. Баярсайхан (ТУЗ-ийн хараат бус гишүүн)	М. Ганбат (ТУЗ-ийн хараат бус гишүүн)	Д. Алтангэрэл (ТУЗ-ийн хараат бус гишүүн)
1.	Өөрөө, эсхүл компанийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй байх (КтХ-ийн 79.1.1)	Тийм**	Тийм**	Тийм**
2.	Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанид болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, сүүлийн 3 жилийн хугацаанд аливаа ажил, албан тушаал эрхэлж байгаагүй байх (КтХ-ийн 79.1.2, КЗК-ийн 5.2.4)	Тийм**	Тийм**	Тийм**
3.	Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн албан хашдаггүй байх (КтХ-ийн 79.1.3)	Тийм**	Тийм**	Тийм**
4.	Компанитай бизнесийн гэрээ хэлцэл байгуулаагүй байх, тийм холбоогүй байх (КтХ-ийн 79.1.4, КЗК-ийн 5.2.4)	Тийм**	Тийм**	Тийм**
5.	Сүүлийн 5 жилд компанид нэгдмэл сонирхолтой этгээд болж байгаагүй байх (КЗК-ийн 5.2.4)	Тийм**	Тийм**	Тийм**
6.	Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдэд зөвлөх үйлчилгээ үзүүлдэггүй байх (КЗК-ийн 5.2.4)	Тийм**	Тийм**	Тийм**
7.	Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдийн ханган нийлүүлэгч ба харилцагч биш байх (КЗК-ийн 5.2.4)	Тийм**	Тийм**	Тийм**
8.	Компани эсвэл түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй үйлчилгээ үзүүлэх гэрээ хийгээгүй байх (КЗК-ийн 5.2.4)	Тийм**	Тийм**	Тийм**
9.	Компанийн ТУЗ, гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, дотоод аудитын ажилтны нэгдмэл сонирхолтой этгээд биш байх (КЗК-ийн 5.2.4)	Тийм**	Тийм**	Тийм**
10.	Хувьцаа эзэмшигч эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдийн ойрын хамаатан биш байх (КЗК-ийн 5.2.4)	Тийм**	Тийм**	Тийм**

** Компанийн тухай хуулийн 79.1.1-79.1.4 зүйл, Компанийн засаглалын кодексийн 5.2.4 –т заасан ТУЗ-ийн харааг бус гишүүнд тавигдах шаардлагыг тус компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүд хангаж байгаа эсэхийг тэдний гаргаж өгсөн мэдүүлэг, баталгааг үндэслэж дүгнэв.

ОРХОН АЙМАГ АНД-ЭНЕРГИ ХХК КА101070 4305772

Дүгнэлт

48. Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын бидэнд ирүүлсэн нотлох баримтуудаас үзэхэд ТУЗ-ийн дарга Т.Барс, ТУЗ-ийн гишүүн Ц.Гүррагчаа (гүйцэтгэх захирал), Д.Мөнхбаяр, Г.Түвшин, Д.Алтангэрэл, Л.Итгэлт, Х.Баярсайхан, М.Ганбат, М.Отгонбаатар, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М. Пүрэвдолгор нар нь удирдах чадвар, дадлага туршлагын хувьд Компанийн засаглалын кодекст тавьсан шаардлагыг хангана гэж үзэх үндэслэлтэй байна.

49. ТУЗ-ийн дарга Т.Барс, ТУЗ-ийн гишүүн Ц.Гүррагчаа, Д.Мөнхбаяр, Г.Түвшин, Д.Алтангэрэл, Л.Итгэлт, Х.Баярсайхан, М. Отгонбаатар нар нь Компанийн тухай хуулийн 75.8, 77.3, 84.3.1, 84.3.2* зүйлд тус тус заасан шаардлагыг хангаж байна. Түүнчлэн, ТУЗ-ийн дарга Т.Барсыг Компанийн тухай хууль 78.1, Компанийн дүрмийн 11.3-т нийцүүлэн ТУЗ-ийн гишүүдийн дотроос сонгосон байна.

50. ТУЗ-ийн гишүүн М.Ганбат нь Компанийн тухай хуулийн 77.3, 84.3.1, 84.3.2* зүйлд тус тус заасан шаардлагыг хангаж байна. ТУЗ-ийн гишүүн М.Ганбат нь Компанийн тухай хуулийн 75.8-т заасны дагуу компанийн засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ авах шаардлагатай.

51. Гүйцэтгэх захирал Ц.Гүррагчаа нь Компанийн тухай хуулийн 83.2, 83.3 зүйлд заасан гүйцэтгэх захиралд тавигдах шаардлагыг хангасан байна.

52. Бидэнд ирүүлсэн баримтуудаас үзэхэд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Пүрэвдолгор нь Компанийн тухай хуулийн 75.8, 84.3.1, 84.3.2* зүйл, Компанийн засаглалын кодексийн 5.9.2-т заасан "дээд боловсролтой байх", "нарийн бичгийн даргын үүрэг хариуцлагыг гүйцэтгэхэд шаардлагатай ажлын туршлага", "мэргэжлийн ур чадвартай байх", "холбогдох хууль тогтоомжийн талаар мэдлэгтэй байх" шаардлагуудыг хангасан гэж дүгнэх боломжтой байна. Компанийн засаглалын кодексийн 5.9.2-т заасан ТУЗ-ийн нарийн бичиг нь "Компанитай нэгдмэл сонирхолгүй, компанийн томоохон хувьцаа эзэмшигчдээс хараат бус этгээд байх" гэж заасан тул Компани хувьцаагаа олон нийтэд санал болгосны дараа Б.Пүрэвдолгорыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргаас эсхүл түүнийг тус компанид одоо эрхэлж байгаа ажлаас нь (чанарын менежер) чөлөөлөх шаардлагатай.

53. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн Х.Баярсайхан, М.Ганбат, Д.Алтангэрэл нар нь Компанийн тухай хуулийн 79.1.1-79.1.4** зүйл, Компанийн засаглалын кодексийн 5.2.4** –т заасан ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг хангасан байна.

-oOo-

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
"АНД-ЭНЕРГИ" ХХК

ГУРАВ. КОМПАНИЙН ДҮРЭМ, БУСАД ДОТООД ЖУРМУУД, ТҮҮНЧЛЭН ХОЛБОГДОХ ДҮРЭМ, ЖУРМЫН ТӨСЛҮҮД ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦСЭН ЭСЭХ ТАЛААРХ ДҮГНЭЛТ

Үндэслэсэн баримт бичиг

54. Компанийн дүрэм, бусад дотоод журмууд, түүнчлэн холбогдох дүрэм, журмын төслүүд хууль тогтоомжид нийцсэн эсэх талаарх дүгнэлтийг дор дурдсан баримт бичигт үндэслэн гаргасан болно:

- Компанийн дүрэм (2017.03.20)
- Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам (2017.04.03)
- Ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах журам (2017.04.03)
- Хувьцааг эргүүлэн худалдаж авах журам (2017.04.03)
- Эрсдэлийн удирдлагын журам (2017.04.03)
- Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны үйл ажиллагааны журам (2017.04.03)
- Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам (2017.04.03)
- Хөдөлмөрийн дотоод журам (2017.01.26)
- Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасны олголт ба ашиглалтын журам (2017.01.26)
- Сайн саналын системийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам (2017.01.02)
- Компанийн ажилтнуудад сарын ажлын гүйцэтгэлээр шагналт цалин олгох журам (2017.01.02)
- "Анд Энерги" Хувьцаат Компанийн дүрмийн төсөл
- Мэдээллийн үйл ажиллагааны журмын төсөл

Компанийн дүрэм

55. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 01 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар Компанийн одоогийн мөрдөгдөж буй дүрмийг (цаашид "Дүрэм" гэнэ) батлсан байна. Дүрэм нь нийт 20 бүлэг, 20 зүйл, 124 дэд зүйлтэй бөгөөд Компанийн эрх, үүрэг, үйл ажиллагааны чиглэл, хувьцаа эзэмшигчдийн эрх зүйн байдлыг тогтоох, Компанийн удирдлага, түүний эрх хэмжээ, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны чиг үүргийг тодорхойлох, Компанийн засаглал, нягтлан бодох бүртгэл, хяналт, мэдээллийн үндсэн зарчим, Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг зохицуулах зорилготой байна[46].

56. Дүрмийн 2.1-т Компанийн оноосон нэрийг тусгасан, 3.3-т Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон нь Компанийн тухай хуулийн 16.2.1, 16.2.6 зүйлд тус тус нийцсэн байна.

57. Дүрмийн 7-р бүлэг, 8.2-т Компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг заасан байгаа

[46] Компанийн дүрмийн 1.1 зүйл.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА01070 4385772

нь Компанийн тухай хуулийн 16.2.2, 30.5, 33.1 зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

58. Дүрмийн 8-р бүлэгт заасан хувьцаа эзэмшигчдийн эрх, 10-р бүлэгт заасан хувьцаа эзэмшигчдийн хурлын холбогдох заалтууд нь Компанийн тухай хуулийн 34, 38, 46-47 зүйл болон холбогдох бусад зохицуулалт, Компанийн засаглалын кодексийн 2.1, 2.2.1-2.2.9-т заасан хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах заалтуудад нийцэж байна. Түүнчлэн 10-р бүлгийн хувьцаа эзэмшигчдийн хурал түүний зохион байгуулалт, явагдах журам зэргийг зохицуулсан зүйлүүд нь Компанийн тухай хуулийн 59-74 зүйлд заасан журамд нийцэж байна.

59. Дүрмийн 11.1-т Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог 9 байхаар заасан нь Компанийн тухай хуулийн 16.2.4, 75.2 зүйлд "компанийн дүрэмд ... төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог заавал тусгана", Компанийн засаглалын кодексийн 5.2.2-т заасан "ТУЗ-ийн гишүүдийн тоо сондгой байх" шаардлагад нийцсэн байна.

60. Дүрмийн 15.1-д Компанийн эрх бүхий албан тушаалтнуудыг жагсааж бичсэн нь Компанийн тухай хуулийн 84.1, 84.2 зүйлд "Компани өөрийн онцлогтоо тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрэмдээ заасан байна" гэж заасан шаардлагад нийцсэн байна.

61. Дүрмийн 17.1-д компанийн санхүүгийн жилийн эхлэх, дуусах хугацааг тусгасан нь Компанийн хуулийн 95.3 зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

62. Түүнчлэн Дүрмийн компанийн үнэт цаас нэмж гаргах, худалдах болон эргүүлэн авах, хувьцаа төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх, шийдвэр гаргах журам, гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээ, их хэмжээний хэлцэлтэй холбоотой асуудлууд, компанийн санхүү, татвар, компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг зохицуулсан заалтууд нь Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексын холбогдох заалтад нийцсэн байна.

63. Компани нь Дүрмийг нийт хувьцаа эзэмшигчдийн саналаар баталсан байх тул Компанийн тухай хуулийн 17.1-д нийцсэн ба Компанийн тухай хуулийн 17.9-д заасны дагуу дүрмийг 2017 оны 04 сарын 25-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болсон байна.

Компанийн засаглалын журмууд

64. ***Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам.*** Компанийн ТУЗ нь өөрийн үйл ажиллагаог Компанийн засаглалын кодекст нийцүүлэх зорилгоор нийт 13 бүлэг, 13 зүйл, 74 дэд зүйлтэй Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг батлан мөрдүүлж байна. Тус журамд ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн, ТУЗ-ийн үндсэн чиг үүрэг, бүрэн эрхийг тухайлан заахаас гадна ТУЗ-ийн дарга, гишүүн, хараат бус гишүүн, нарийн бичгийн даргыг сонгох журам, тэдэнд тавигдах шаардлага, тэдгээрийн ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой эдлэх эрх, хүлээх үүрэг, ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагаог дүгнэх журам, ТУЗ-ийн хурлын зар хүргэх журам, ТУЗ-ийн шийдвэр, түүнийг гаргах журмын зохицуулалтыг нарийвчлан тодорхойлсон байна. Түүнчлэн ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн бүрэлдэхүүний тухай зохицуулалт оруулсан байна.

Энэхүү Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам нь Компанийн тухай хуулийн 76.1.1-76.1.18 зүйлд тодорхойлсон ТУЗ-ийн бүрэн эрхийн зааглууд мөн хуулийн 80.4 зүйлд "ТУЗ нь үйл ажиллагааныхаа журмыг тогтоож батална" гэж заасан хуулийн шаардлагад нийцэж байна. Түүнчлэн Компанийн засаглалын кодексийн 5.2.2-т заасан "ТУЗ-ийн гишүүдийн тоо сондгой байх", 5.2.3-т заасан "ТУЗ-ийн гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байх", 5.4.2-т заасан "ТУЗ-ийн гишүүн ХЭХ-д заавал биечлэн оролцож, хувьцаа эзэмшигчдийн асуултанд хариулт өгдөг үүрэгтэй байх", 5.1.4-т заасан "Компани нь ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн тэдгээрийг дүгнэх, урамшуулах, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдэд тавих шаардлага, ТУЗ-ийн хурал түүнтэй холбоотой асуудлууд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, ТУЗ-ийн хороодын үйл ажиллагаа гэх мэт асуудлыг зохицуулсан ТУЗ-ийн үйл ажиллагааны журамтай байх" шаардлагууд болон холбогдох бусад шаардлагыг бүрэн хангасан байна.

65. ***Ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах журам.*** Компанийн ТУЗ нь Компанийн хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын эрх ашиг, санхүүгийн ашигт үйл ажиллагааг хангах, хөрөнгө оруулах сонирхлыг хамгаалах, Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекст нийцүүлэн компанийн жилийн ашгийг зөв зохистой хуваарилах зорилгоор нийт 4 бүлэг, 4 зүйл, 15 дэд зүйлтэй Ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах журмыг батлан хувьцаа эзэмшигчдэд танилцуулан, мөрдөж байна. Тус журамд Компанийн ногдол ашиг хуваарилах бодлогыг тодорхойлсноос гадна ногдол ашиг хуваарилах нөхцөл, ногдол ашиг төлөх хэлбэр, ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргах хугацаа, түүнд тусгах мэдээлэл, ногдол хуваарилах шийдвэр гарсан тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээ зэргийг зохицуулсан байна.

Энэхүү Ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах журам нь Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл, журамд нийцсэн байхаас гадна тус хуулийн 76.1.12 (ТУЗ-аас ногдол ашиг төлөх журмыг тодорхойлох), Компанийн засаглалын кодексийн 2.2.2-т заасан компани ногдол ашгийн бодлоготой байх, ногдол ашиг тодорхойлох журамтай байх зэрэг шаардлагыг хангасан байна.

66. ***Хувьцааг эргүүлэн худалдаж авах журам.*** Компанийн ТУЗ-өөс Компанийн хувьцааг өөрөө болон хувьцаа эзэмшигчид худалдаж авах нөхцөл, журмыг зохицуулах зорилгоор нийт 4 бүлэг, 4 зүйл, 18 дэд зүйлтэй Хувьцааг эргүүлэн худалдаж авах журмыг батлан мөрдүүлж байна.

Тус журамд Компани өөрийн гаргасан энгийн хувьцаа, энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг эргүүлэн худалдаж авах нөхцөл, хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх, хувьцаа эзэмшигчдийн хурлаас тодорхой шийдвэр гарсан тохиолдолд уг асуудлаар эсрэг саналтай байсан эсхүл уг шийдвэрийг гаргахад оролцоогүй хувьцаа эзэмшигчид хүсвэл өөрийн хувьцааг худалдан авахыг компаниас шаардах тодорхой нөхцлүүдийг тодорхойлж, эдгээртэй холбоотойгоор Компанийн хувьцааг эргүүлэн худалдан авахад хориглох зүйлс, журмыг зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлага зэргийг зохицуулсан байна.

Энэхүү Хувьцааг эргүүлэн худалдаж авах журам нь Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйл "Үнэт цаас эргүүлэн худалдаж авах", 52 дугаар зүйл "компани өөрийн үнэт цаасыг эргүүлэн авах нөхцөл", 53 дугаар зүйл "Хувьцаа эзэмшигчийн шаардлагаар компани хувьцаагаа эргүүлэн худалдаж авах", 54 дүгээр зүйл

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА001070 4385772

"Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журам" болон Компанийн засаглалын кодексийн 2.2.6-д заасан хувьцааг эргүүлэн худалдан авахыг шаардах эрхэд нийцсэн байна.

67. ***Эрсдэлийн удирдлагын журам.*** Компанийн ТУЗ нь тус компанийн стратеги төлөвлөлт, үйлдвэрлэл, менежментийн үйл явцад гарсан болон гарч болох эрсдэл, үүнийг удирдах арга хэмжээг зохицуулах зорилгоор нийт 4 бүлэг, 4 зүйл, 19 дэд зүйлтэй Эрсдэлийн удирдлагын журам батлан мөрдүүлж байна. Уг журмаар Компанид эрсдэл учруулж болзошгүй гадаад (түүхий эдийн үнэ, зах зээлийн тогтворгүй байдал, хэрэглэгчийн бараа худалдан авах чадамжийн өөрчлөлт, валютын ханшийн эрсдэл г.м), дотоод (маркетинг, борлуулалт, стратегийн алдаатай бодлогоос үүдэлтэй эрсдэл, үйлдвэрлэлийн доголдол, гэнэтийн осол г.м) хүчин зүйлсийг тодорхойлж, үүссэн болон үүсч болзошгүй эрсдэлийг үнэлж дүн шинжилгээ хийх, нөлөөллийг тодорхойлох ажиллагаа, үүссэн эрсдэлийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнчлэн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэгч этгээдийг тодорхойлсон байна.

Энэхүү Эрсдэлийн удирдлагын журам нь Компанийн засаглалын кодексийн 5.1.3 (ТУЗ эрсдэлийн удирдлагад хяналт тавих), 9.1 (ТУЗ гадаад, дотоод бүх эрсдэлийг эрсдэлийн менежментээр хангах), 9.2 (гарах эрсдэлийг тодорхойлж үнэлэн дүн шинжилгээ хийх, түүний нөлөөлөл, авч хэрэгжүүлэх арга хэмжээг ТУЗ батлах), 9.3 (эрсдэлийн удирдлагын журам боловсруулж, мөрдүүлэх)-д тус тус заасан шаардлагад нийцсэн байна.

68. ***Төлөвлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны үйл ажиллагааны журам.*** Компанийн ТУЗ нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны үйл ажиллагаа, эрх үүрэгтэй холбогдох харилцааг зохицуулах зорилгоор нийт 4 бүлэг, 4 зүйл, 15 дэд зүйлтэй Төлөвлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны үйл ажиллагааны журмыг батлан мөрдүүлж байна. Энэхүү журмаар аудитын хорооны бүрэлдэхүүн, гишүүдэд тавигдах шаардлага, тэднийг томилох ажиллагаа, тус хорооны хурал хуралдах журам, хурлаас гарах шийдвэр, тэмдэглэл, хорооны эрх, үүрэг, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулсан байна.

Энэхүү журам нь Компанийн тухай хуулийн 81.1 дүгээр зүйлд ТУЗ шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн дэргэд тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороо байгуулж болно, Компанийн засаглалын кодексийн 5.5.4-т аудитын хорооны дарга хараат бус гишүүн байх, 5.7.1, 5.7.2-т аудитын хороо нь компанийн санхүүгийн тайлан гаргах ажиллагаа, аудитын үйл ажиллагаа, эрсдлийн удирдлагын үйл ажиллагаа зэрэгт хяналт тавьж, үр дүнг үндэслэн ТУЗ-д зөвлөмж гаргах, хөндлөнгийн аудитыг нэр дэвшүүлэх зэрэг үүрэг гүйцэтгэдэг байхыг шаардсан шаардлагад нийцсэн байна.

69. ***Төлөвлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам.*** Компанийн ТУЗ нь ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагаа, эрх үүрэгтэй холбогдох харилцааг зохицуулах зорилгоор нийт 4 бүлэг, 4 зүйл, 17 дэд зүйлтэй Төлөвлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журмыг батлан мөрдүүлж байна. Энэхүү журмаар цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүн, гишүүдэд тавигдах шаардлага, тэднийг

томилох ажиллагаа, тус хорооны хурал хуралдах журам, хурлаас гарах шийдвэр, сар тэмдэглэл, хорооны эрх, үүрэг, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулсан байна.

Энэхүү журам нь Компанийн тухай хуулийн 81.1 зүйлд ТУЗ шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн дэргэд тодорхой асуудал эрхэлсэн байгууллага болон түр хороо байгуулж болно, Компанийн засаглалын кодексийн 5.5.4-т цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хорооны дарга хараат бус гишүүн байх, 5.6.2-т Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх системийг боловсруулж, батлах зэрэг үүрэг гүйцэтгэдэг байхыг шаардсан шаардлагад нийцсэн байна.

Хөдөлмөрийн дотоод журмууд

70. ***Хөдөлмөрийн дотоод журам.*** Компанийн гүйцэтгэх захирал нь хөдөлмөр зохион байгуулалт, ажил олгогч ба ажилтны эрх, үүрэг, хариуцлагатай холбогдох харилцааг зохицуулах зорилгоор нийт 14 бүлэг, 55 зүйлтэй Хөдөлмөрийн дотоод журмыг батлан мөрдүүлж байна. Энэ журмаар хөдөлмөрийн удирдлага, зохион байгуулалт, хөдөлмөрийн гэрээ байгуулах нөхцөл, журам, ажил олгогч болон ажилтны эрх, үүрэг, сахилгын зөрчил, хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл, журам, ажил амралтын цаг, цалин хөлс, урамшууллын тогтолцоо, албан томилолт, сургалтын журам, дотоод хяналт, шалгалтын үйл ажиллагааг зохицуулсан байна.

Энэхүү журам нь Хөдөлмөрийн тухай хуулийн 80.2, 130.1 зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

71. ***Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасны олголт ба ашиглалтын журам.*** Компанийн гүйцэтгэх захирал нь ажлын онцлог, мэргэжлийн онцлогт тохирсон тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг ажилтанд олгох, норм, зохистой хэрэглээтэй холбогдох харилцааг зохицуулсан нийт 6 бүлэг 15 зүйлтэй нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасны олголт ба ашиглалтын журам батлан мөрдүүлж байна. Энэ журмаар ажлын хувцас болон толгой, нүд, хөл, гар, сонсголын эрхтэн, амьсгалын эрхтэн хамгаалах болон уналтаас хамгаалах хэрэгслийг хэрэглэх шаардлага, журам, нэг бүрийн хэрэгслийн стандартад тавих хяналт, хэрэглээний горим, нэг бүрийн хэрэгсэл, ажлын хувцасны жагсаалт, ашиглалтын хугацаа, норм зэрэг харилцааг зохицуулсан байна.

Энэхүү журам нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15.3 зүйлд заасан "тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн нэр, төрөл, эдэлгээний хугацаа бүхий жагсаалт баталж мөрдүүлэх", 27.3.5 зүйлд заасан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг ажилтанд олгох, норм, чанар, зохистой хэрэглээнд хяналт тавих", 28.1.6 зүйлд заасан "ажил олгогч ажлын байрны онцлогтоо нийцсэн дүрэм, заавар, журам батлаж, мөрдүүлэх" шаардлагуудыг хангасан байна.

72. ***Сайн саналын системийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам.*** Компанийн гүйцэтгэх захирал нь ажилтнуудын идэвх санаачилгыг нэмэгдүүлэх, тэдний оролцоотойгоор ажлын байрны орчин нөхцөл, техник, технологийн ашиглалт болон ажлын арга барилыг сайжруулах зэрэг чиглэлээр ажилтнуудаас гаргаж буй саналыг хүлээн авах, үнэлэх, шалгаруулж, урамшуулахад чиглэсэн харилцааг зохицуулах зорилгоор 8 бүлэг, 15 зүйлтэй Сайн саналын системийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам баталж мөрдүүлж байна. Энэхүү журмаар сайн саналын хөтөлбөрийн зохион

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КАЗ01070 4385772

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

байгуулалт, саналыг гаргах болон үнэлэх журам, саналыг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, урамшуулал, идэвхжүүлэлтийн журмыг зохицуулсан байна.

Энэхүү журам нь Хөдөлмөрийн тухай хуулийн 80.2, 130.1 зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

73. ***Компанийн ажилтнуудад сарын ажлын гүйцэтгэлээр шагналт цалин олгох журам.*** Компани нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, сарын төлөвлөгөөт үзүүлэлтийг биелүүлэхэд ажилтнуудын оруулсан хувь нэмэрт тохирсон шагналт цалинг сар бүр олгох зорилгоор 5 бүлэг, 11 зүйлтэй Компанийн ажилтнуудад сарын ажлын гүйцэтгэлээр шагналт цалин олгох журам батлан мөрдүүлж байна. Энэхүү журмаар шагналт цалин олгох нөхцөл, журам, шагналт цалингийн хэмжээ, хариуцлагатай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Энэ журам нь Хөдөлмөрийн тухай хуулийн 48.3.4 зүйлд заасан шагнал урамшуулал, түүнийг олгох нөхцөл журамд нийцүүлэн баталсан байна. Мөн Компанийн Хөдөлмөрийн дотоод журмын 8.1 зүйлд заасан шагнал урамшууллыг олгох журмын хүрээнд батлагдсан байна.

Батлахаар төлөвлөж буй дүрэм, журмын төслүүд

74. Компани нэмж гаргасан хувьцаагаа олон нийтэд Биржээр дамжуулан худалдаж хувьцаат компани болсон тохиолдолд баталж мөрдүүлэхээр Компанийн ТУЗ-өөс дор дурдсан дүрэм, журмын төслийг боловсруулсан нь Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекст нийцсэн байна. Үүнд:

- ***"Анд Энерги" Хувьцаат Компанийн дүрмийн төсөл***: Энэхүү дүрмийн төсөл (цаашид "Дүрмийн төсөл" гэнэ) нь нийт 20 бүлэг, 20 зүйл, 127 дэд зүйлтэй бөгөөд тус компанийн эрх, үүрэг, үйл ажиллагааны чиглэл, хувьцаа эзэмшигчдийн эрх зүйн байдлыг тогтоох, компанийн удирдлага, түүний эрх хэмжээ, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны чиг үүргийг тодорхойлох, компанийн засаглал, нягтлан бодох бүртгэл, хяналт, мэдээллийн үндсэн зарчим, компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг зохицуулах зорилготой байна.

  Дүрмийн төслийн 2.1-т компанийн оноосон нэрийг тусгасан, 3.3-т компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон нь Компанийн тухай хуулийн 16.2.1, 16.2.6 зүйлд тус тус нийцсэн байна.

  Дүрмийн төслийн 7-р бүлэгт компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг заасан байгаа нь Компанийн тухай хуулийн 16.2.2, 30.5, 33.1 зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

  Дүрмийн төслийн 8-р бүлэгт заасан хувьцаа эзэмшигчдийн эрх, 10-р бүлэгт заасан хувьцаа эзэмшигчдийн хурлын холбогдох заалтууд нь Компанийн тухай хуулийн 34, 38, 46, 47 зүйл болон холбогдох бусад зохицуулалт, Компанийн засаглалын кодексийн 2.1, 2.2.1-2.2.9-т заасан хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах заалтуудад нийцэж байна. Түүнчлэн 10-р бүлгийн хувьцаа эзэмшигчдийн хурал түүний зохион байгуулалт, явагдах журам зэргийг

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК

КАМ01070 4385772

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

зохицуулсан зүйлүүд нь Компанийн тухай хуулийн 59-74 зүйлд заасан журамд нийцэж байна.

Дүрмийн төслийн 11.1-т Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог 9 байхаар заасан нь Компанийн тухай хуулийн 16.2.4, 75.2 зүйлд "компанийн дүрэмд ... төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо-г заавал тусгана", Компанийн засаглалын кодексийн 5.2.2-т заасан "ТУЗ-ийн гишүүдийн тоо сондгой байх" шаардлагад нийцсэн байна.

Дүрмийн төслийн 15.1-д компанийн эрх бүхий албан тушаалтнуудыг жагсааж бичсэн нь Компанийн тухай хуулийн 84.1, 84.2 зүйлд "компани өөрийн онцлогтоо тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрэмдээ заасан байна" гэж заасан шаардлагад нийцсэн байна.

Дүрмийн төслийн 17.1-д компанийн санхүүгийн жилийн эхлэх, дуусах хугацааг тусгасан нь Компанийн хуулийн 95.3 зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

Дүрмийн төслийн 17.3-т "аудитын байгууллагаар аудит хийлгэхээр" заасан нь Компанийн хуулийн 94.2 зүйлд (Хувьцаат компани дүрэмдээ аудитын байгууллагыг заавал ажиллуулахаар заах) заасан шаардлагад нийцэж байна.

Түүнчлэн тус дүрмийн төсөлд компанийн үнэт цаас нэмж гаргах, худалдах болон эргүүлэн авах, хувьцаа төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх, шийдвэр гаргах журам, гүйцэтгэгч удирдлагын эрх хэмжээ, их хэмжээний хэлцэлтэй холбоотой асуудлууд, компанийн санхүү, татвар, компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг зохицуулсан заалтууд нь Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексийн холбогдох заалтад нийцсэн *байна.*

- ***Мэдээллийн үйл ажиллагааны журмын төсөл.*** Компанийн ТУЗ-өөс эрх бүхий байгууллагууд, хөрөнгө оруулагч болон хувьцаа эзэмшигчдэд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх зорилгоор нийт 6 бүлэг, 6 зүйл, 21 дэд зүйлтэй Мэдээллийн үйл ажиллагааны журмын төслийг боловсруулсан байна.

  Тус журмын төсөлд нийтэд мэдээлэх мэдээллийн төрлийг нийтэд тогтмол хүргэх мэдээлэл, тухай бүр мэдээлэх мэдээлэл гэж хоёр ангилан, төрөл тус бүрт хамаарах мэдээллийн хэлбэрүүдийг тодорхойлж, уг мэдээллийг нийтэд мэдээлэх болон Хороо, Биржид хүргүүлэх давтамж хугацаа, хэлбэр, журмын хэрэгжилтийг хангах, хариуцах албан тушаалтныг тодорхойлж, олон нийтэд мэдээлсэн мэдээллийн баримт бичгийг хадгалах журам, мэдээллийг нээлттэй болгоход тавигдах хязгаарлалт, хориглох зүйлс, хүлээх хариуцлага зэргийг зохицуулсан байна.

  Энэхүү Мэдээллийн үйл ажиллагааны журмын төсөл нь Компанийн тухай хуулийн 95.2, 98 зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 79.1, Санхүүгийн зохицуулах хорооноос батлагдсан "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам"-ын зохицуулалтад нийцэхээс гадна Компанийн засаглалын кодексийн 7.3.1-7.3.5-т заасан шаардлагыг бүрэн хангасан байна.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА#01070 4385772

Дүгнэлт

75. Компанийн дүрэм нь Компанийн тухай хуулийн 16.2, 30.5, 33.1, 75.2, 84.1, 95.3 зүйл, Компанийн засаглалын кодекст заавал тусгахаар заасан зүйлийг бүрэн агуулсан бөгөөд холбогдох бусад зүйл, заалтад агуулгын хувьд бүрэн нийцсэн байна.

76. Компанийн компанийн засаглалын журмууд нь Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексийн холбогдох зохицуулалтад нийцсэн байна.

77. Компанийн хөдөлмөрийн дотоод журмууд нь Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох зохицуулалтад нийцсэн байна.

78. Компани нэмж гаргасан хувьцаагаа олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсон тохиолдолд баталж мөрдүүлэхээр Компанийн ТУЗ-өөс боловсруулсан Хувьцаат Компанийн дүрмийн төсөл, Мэдээллийн үйл ажиллагааны журмын төсөл нь Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексийн холбогдох зохицуулалтад нийцсэн байна. Үүнээс гадна, тус компани хувьцаат компани болсон тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам, Төлөөлөн удирдах зөвлөлийн ёс зүйн кодекс, Хөндлөнгийн аудитыг томилох үйл ажиллагааг зохицуулсан дотоод журмуудыг Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, батлаж мөрдүүлэх шаардлагатай.

-oOo-

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК

СЗХ он сар өдөр БҮРТГЭВ № 01

ДӨРӨВ. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЧУХАЛ АЧ ХОЛБОГДОЛ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ ХЭЛЦЭЛ НЬ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦСЭН ЭСЭХ ТАЛААРХ ДҮГНЭЛТ

Үндэслэсэн баримт бичиг

79. Компани нь 2014 оны 06 дугаар сарын 28-ны өдрөөс 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдөр хүртэл хугацаанд иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан дараах 51 гэрээг ирүүлсэн байна.

Зээлийн гэрээ

- Худалдаа хөгжлийн банкны Эрдэнэт салбар (ХХБ) болон Компанийн хооронд 2015 оны 08 дугаар сарын 07-ны өдөр байгуулагдсан ЗГ-RCC2015072708-1 тоот Зээлийн гэрээ, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулсан 2015 оны 11 сарын 06-ны өдрийн Зээлийн нэмэлт гэрээ
- АЦХ ХХК болон Компанийн хооронд 2016 оны 06 дугаар сарын 08-ны өдөр байгуулагдсан Зээлийн гэрээ

Ажил гүйцэтгэх гэрээнүүд

- Ачит Ихт ХХК болон Компанийн хооронд 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдөр байгуулагдсан Ажил гүйцэтгэх гэрээ
- Сутайн Цэнд ХХК болон Компанийн хооронд 2014 оны 06 дугаар сарын 28-ны өдөр байгуулагдсан Ажил гүйцэтгэх гэрээ
- Эрдэнэт үйлдвэр ХХК болон Компанийн хооронд 2015 оны 02 дугаар сарын 03-ны өдөр байгуулагдсан Барилгын засварын ажил гүйцэтгэх гэрээ
- Улз гол ХХК болон Компанийн хооронд 2016 оны 06 дугаар сарын 03-ны өдөр байгуулагдсан Ажил гүйцэтгэх гэрээ
- Улз гол ХХК болон Компанийн хооронд 2015 оны 06 дугаар сарын 24-ний өдөр байгуулагдсан Ажил гүйцэтгэх гэрээ
- ТД Лед ХХК болон Компанийн хооронд 2015 оны 12 дугаар сарын 07-ны өдөр байгуулагдсан Ажил гүйцэтгэх гэрээ
- Эрдэнэт хивс ХХК болон Компанийн хооронд 2015 онд байгуулагдсан Ажил гүйцэтгэх гэрээ
- Компани болон Монголын үндэсний олон нийтийн радио телевиз нарын хооронд 2016 оны 06 дугаар сарын 08-ны өдөр байгуулагдсан Хамтран ажиллах гэрээ
- Компани болон Энержи Комплекс ХХК нарын хооронд 2016 оны 06 дугаар сарын 15-ны өдөр байгуулагдсан Хамтран ажиллах гэрээ
- АЦХ ХХК болон Компанийн хооронд 2015 оны 08 дугаар сарын 20-ны өдөр байгуулагдсан Ажил гүйцэтгэх гэрээ
- Гаүли ҮЦК ХХК болон Компанийн хооронд 2016 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр байгуулагдсан Ажил гүйцэтгэх гэрээ, Харилцан нууц хадгалах гэрээ
- Дондовжан ХХК болон Компанийн хооронд 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдөр байгуулагдсан 02/16 тоот Ажил гүйцэтгэх гэрээ
- Ховилтой Эх ХХК болон Компанийн хооронд 2016 оны 06 дугаар сарын 14-ний өдөр байгуулагдсан Ажил гүйцэтгэх гэрээ
- Дондовжан ХХК болон Компанийн хооронд 2016 оны 06 дугаар сарын 27-ны өдөр байгуулагдсан 01/16 тоот Ажил гүйцэтгэх гэрээ

ОРХОН АЙМАГ АНД-ЭНЕРГИ ХХК КА/101070 4355772

- Энх Орд Эрдэнэс ХХК болон Компанийн хооронд 2016 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр байгуулагдсан Гүний өрөмдмөл худаг, усны хайгуулын ажил гүйцэтгэх гэрээ
- Рос-Импорт ХХК болон Компанийн хооронд 2016 оны 10 дугаар сарын 04-ний өдөр байгуулагдсан Ажил гүйцэтгэх гэрээ

Бүтээгдэхүүн нийлүүлэх, худалдах худалдан авах гэрээ

- Компани болон ДБЧЭ ХХК нарын хооронд 2015 оны 07 дугаар сарын 06-ны өдөр байгуулагдсан Бүтээгдэхүүн нийлүүлэх тухай гэрээ
- Компани болон Орконтех ХХК нарын хооронд 2015 оны 07 дугаар сарын 20-ны өдөр байгуулагдсан 7 тоот Бүтээгдэхүүн нйилүүлэх тухай гэрээ
- Компани болон Х-Даб ХХК нарын хооронд 2015 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр байгуулагдсан 4 тоот Бүтээгдэхүүн нийлүүлэх тухай гэрээ
- Компани болон Бумбат даваа ХХК нарын хооронд 2015 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр байгуулагдсан 16/2015 тоот Бүтээгдэхүүн нийлүүлэх тухай гэрээ
- Компани болон Энержи Комплекс ХХК нарын хооронд 2015 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр байгуулагдсан 17/2015 тоот Бүтээгдэхүүн нийлүүлэх тухай гэрээ
- Компани болон ТД Лед ХХК нарын хооронд 2015 оны 10 дугаар сарын 12-ны өдөр байгуулагдсан 15/08 тоот Хамтран ажиллах, ажил гүйцэтгэх, бараа нийлүүлэх гэрээ
- Компани болон Улаанбаатар төмөр зам нийгэмлэг нарын хооронд 2015 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр байгуулагдсан ХХ/15/224 тоот Бэлтгэн нийлүүлэх тухай гэрээ
- Компани болон Орхон цогцолбор сургууль нарын хооронд 2015 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр байгуулагдсан 11/2015 тоот Бүтээгдэхүүн нийлүүлэх тухай гэрээ
- Компани болон Сонгинохангай ХХК нарын хооронд 2016 оны 03 дугаар сарын 18-ны өдөр байгуулагдсан 02 тоот Бүтээгдэхүүн нийлүүлэх тухай гэрээ
- Компани болон Сонгинохангай ХХК нарын хооронд 2016 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр байгуулагдсан 03 тоот Бүтэгдэхүүн нийлүүлэх тухай гэрээ
- Компани болон Сонгинохангай ХХК нарын хооронд 2016 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр байгуулагдсан 04 тоот Бүтэгдэхүүн нийлүүлэх тухай гэрээ
- Компани болон Ора Металл ХХК нарын хооронд 2016 оны 05 дугаар сарын 05-ны өдөр байгуулагдсан 05/16 тоот Бүтэгдэхүүн нийлүүлэх тухай гэрээ
- Компани болон Хорих 439-р анги нарын хооронд 2016 оны 05 дугаар сарын 27-ны өдөр байгуулагдсан 06/16 тоот Бүтэгдэхүүн нийлүүлэх тухай гэрээ
- Компани болон Алтайн торх ХХК нарын хооронд 2016 оны 06 дугаар сарын 17-ны өдөр байгуулагдсан 2016/б/109 тоот Худалдах, худалдан авах гэрээ
- Компани болон Талын торх ХХК нарын хооронд 2016 оны 06 дугаар сарын 17-ны өдөр байгуулагдсан 2016/б/110 тоот Худалдах, худалдан авах гэрээ
- Компани болон Хангайн торх ХХК нарын хооронд 2016 оны 06 дугаар сарын 17-ны өдөр байгуулагдсан 2016/б/107 тоот Худалдах, худалдан авах гэрээ
- Компани болон Наран торх ХХК нарын хооронд 2016 оны 06 дугаар сарын 17-ны өдөр байгуулагдсан 2016/б/108 тоот Худалдах, худалдан авах гэрээ
- Компани болон Шунхлай Трейдинг ХХК нарын хооронд 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдөр байгуулагдсан Т/633 тоот Худалдах, худалдан авах гэрээ

- Компани болон Шунхлай говь ХХК нарын хооронд 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдөр байгуулагдсан Т/106 тоот Худалдах, худалдан авах гэрээ
- Компани болон Шунхлай Петролиум ХХК нарын хооронд 2016 оны 10 дугаар сарын 24-ний өдөр байгуулагдсан ОР/01 тоот Худалдах, худалдан авах гэрээ
- Компани болон Гашуун сухайт авто зам ХХК нарын хооронд 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр байгуулагдсан 08/2016 тоот Худалдах, худалдан авах гэрээ
- Компани болон Шунхлай Петролиум ХХК нарын хооронд 2016 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр байгуулагдсан ОР-02 тоот Худалдах, худалдан авах гэрээ
- Компани болон Эйон ХХК нарын хооронд 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдөр байгуулагдсан 09/2016 тоот Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ
- Компани болон Монхангай Трейд ХХК нарын хооронд 2016 оны 12 дугаар сарын 07-ны өдөр байгуулагдсан УБ/09 тоот Бүтээгдэхүүн нийлүүлэх тухай гэрээ
- Компани болон Одод ХХК нарын хооронд 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдөр байгуулагдсан УБ/10 тоот Бүтээгдэхүүн нийлүүлэх тухай гэрээ

Түрээсийн гэрээ

- Иргэн Л.Ганбат болон Компанийн хооронд 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдөр байгуулагдсан Түрээсийн гэрээ
- Дэл цахир ХХК болон Б.Пүрэвдолгор нарын хооронд 2016 оны 08 дугаар сарын 15-ны өдөр байгуулагдсан Ажлын байр түрээслэх гэрээ

80. Дээрх гэрээнүүдээс Компанийн үндсэн үйл ажиллагаанд хамаарах, ач холбогдолтой дараах гэрээнүүд хууль тогтоомжид нийцэж буй эсэх талаар дараах дүгнэлтийг хийлээ:

Зээлийн гэрээ, тэдгээрийн үүргийн гүйцэтгэлийн хангахтай холбоотой гэрээнүүдийн талаарх дүгнэлт

81. ***Худалдаа хөгжлийн банкны Эрдэнэт салбар (Зээлдүүлэгч) болон Компани (Зээлдэгч) нарын хооронд 2015 оны 08 дугаар сарын 07-ны өдөр байгуулагдсан ЗГ-RCC2015072708-1 тоот Зээлийн гэрээ, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулсан 2015 оны 11 сарын 06-ны өдрийн Зээлийн нэмэлт гэрээ***

Гэрээний мэдээлэл:

- Зээлийн дүн: 100,000,000 төгрөг
- Жилийн хүү: 9 хувь
- Зээлийн хугацаа: 39 сар (2015.11.06 - 2019.02.06)
- Зээлийн зориулалт: Лед гэрлийн үйлдвэрийн өргөтгөл, тоног төхөөрөмж, түүхий эд материал худалдан авах
- Зээлийн эх үүсвэр: Монгол Улсын Хөгжлийн банкны эх үүсвэртэй
- Нэмэгдүүлсэн хүү: үндсэн хүүний 20 хувь
- Хариуцлага: Зээлийн гэрээний хугацаа дуусахад Зээлдэгч төлбөрөө бүрэн барагдуулаагүй, гэрээнд заасан үндэслэлээр гэрээ хугацаанаасаа өмнө цуцлагдсан тохиолдолд барьцааны зүйлийг захиран зарцуулах журмаар худалдан борлуулж зээл, хүү, нэмэгдүүлсэн хүүний төлбөрийг барагдуулна.

СЗХ он сар өдөр БҮРТГЭВ
ОРХОН АЙМАГ АНД-ЭНЕРГИ ХХК КА#01070 4385772

СЗХ
он сар өдөр
№ 01

- Барьцаа, баталгаа: Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор дараах гэрээ хэлцлүүд зээлдүүлэгч (ХХБ) болон барьцаалуулагч, баталгаа гаргагчдын хооронд байгуулагдсан. Үүнд:

  1) ХХБ болон Т.Барс нарын хооронд 2015 оны 08 дугаар сарын 07-ны өдөр байгуулагдсан БГ-RCC2015072708-1-1 тоот Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийн барьцааны гэрээ
  2) ХХБ болон иргэн Г.Саруулчимэг нарын хооронд 2015 оны 08 дугаар сарын 07-ны өдөр байгуулагдсан БГ-RCC2015072708-1-2 тоот Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийн барьцааны гэрээ
  3) ХХБ болон Д.Мөнхбаяр нарын хооронд 2015 оны 08 дугаар сарын 07-ны өдөр байгуулагдсан БГ-RCC2015072708-1-3 тоот Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийн барьцааны гэрээ
  4) ХХБ болон Т.Барс нарын хооронд 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдөр байгуулагдсан ЗБ/RCC170221004-1-4 тоот Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийн барьцааны гэрээ
  5) ХХБ болон Т.Барс нарын хооронд 2015 оны 08 дугаар сарын 07-ны өдөр байгуулагдсан ЗГ-RCC2015072708-1-1 тоот Баталгааны гэрээ
  6) ХХБ болон Ц.Гүррагчаа нарын хооронд 2015 оны 08 дугаар сарын 07-ны өдөр байгуулагдсан ЗГ-RCC2015072708-1-2 тоот Баталгааны гэрээ
  7) ХХБ болон Д.Мөнхбаяр нарын хооронд байгуулагдсан ЗГ-RCC2015072708-1-4 тоот Баталгааны гэрээ

Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал:

Энэхүү гэрээг талууд бичгээр байгуулан эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж баталгаажуулсан байгаа нь Иргэний хуулийн 62.1-т заасан "хэлцлийг төлөөлөгчөөр дамжуулан хийх", тус хуулийн 451.2-т заасан "зээлийн гэрээг бичгээр байгуулах" шаардлагуудыг хангасан байна.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 21.4-т заасны дагуу Зээлдүүлэгч нь гэрээний зүйл болох 100,000,000 төгрөгийг Компанид 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр шилжүүлжээ.

Энэхүү Зээлийн гэрээ нь Компанийн тухай хуулийн 87.1-д заасан их хэмжээний хэлцэлд хамаарч байх тул Компанийн тухай хуулийн 88.1-т заасны дагуу гэрээ байгуулах шийдвэрийг Анд-Энерги ХХК-ийн хувьцаа эзэмшигчид санал нэгтэйгээр гаргасан байх шаардлагатай.

Компаний Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар ХХБ-аас 100,000,000 төгрөгийг, жилийн 9 хувийн хүүтэй, 39 сарын хугацаатай зээлэх асуудлыг хэлэлцэж санал нэгтэйгээр дэмжиж, 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдөр 02 тоот "Их хэмжээний хэлцэл хийх тухай" тогтоол гаргасан байгаа нь Компанийн тухай хууль болон Иргэний хуульд нийцсэн байна.

Гэрээнд зээлийн дүн, үндсэн хүү, нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ, зээлийн хугацаа, зориулалт, зээл төлөх хэлбэр, эргэн төлөлтийн хуваарь, зээлдэгч болон зээлдүүлэгчийн эрх, үүрэг, талуудын хүлээх хариуцлага, баталгаа ба мэдэгдэл, гэрээ дуусгавар болох цуцлах нөхцөл, журам, маргаан шийдвэрлэх заалтуудыг тусгасан байх ба эдгээр нөхцөлүүд нь Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК

КАЛ01070 4305772

мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

- 2015 оны 06 сарын 18-ны өдөр Компани нь Булган аймгийн Бүрэгхангай сумын Засаг даргын тамгын газартай Ажил гүйцэтгэх №01 тоот гэрээг байгуулжээ. Тус гэрээ нь Иргэний хууль болон Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан шаардлагад нийцсэн байна. Компани нь дээрх гэрээний хүрээнд 67 ширхэг гэрэлтүүлгийн шонгийн угсралт, суурилуулалт, 3 хайрцаг удирдлагын хэлхээний угсралт, суурилуулалт, асаалтын өмнөх автоматжуулалт, тохируулга, 87 ширхэг Лед гэрлийн угсралт, суурилуулалт, 3060 метр кабелийн угсралтын ажлыг тус тус хийж гүйцэтгэжээ. Уг ажлыг 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн №01/2015 тоот улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авахыг зөвшөөрсөн байна. Иймд Компанийг дээрх гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлсэн гэж дүгнэх боломжтой байна. Тус гэрээний 11.1-т зааснаар гэрээт ажлыг дүгнэснээс хойш 3 жилийн хугацаанд ашиглалтын бууруугаас шалтгаалаагүй аливаа доголдол, гэмтлийг Компани өөрийн зардлаар засах үүрэг хүлээсэн байна.

- 2015 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Компани нь Орхон аймгийн Засаг даргын тамгын газартай БЗА-129/15 тоот "Говил багийн гэрэлтүүлэгийн засвар шинэчлэлтийн ажлын захиалагч гүйцэтгэгчийн хооронд байгуулсан хэлцлийн гэрээ"-г байгуулжээ. Тус гэрээ нь Иргэний хууль болон Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан шаардлагад нийцсэн байна. 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн ХББЗА 05/15 тоот улсын комиссын актаар Компанийн хийж гүйцэтгэсэн Говил багийн гэрэлтүүлгийн засвар шинэчлэлтийн ажлыг ажиглалтад оруулахаар шийдвэрлэсэн байна. Иймд Компанийг дээрх гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлсэн гэж дүгнэх боломжтой байна. Дээрх ажлын гэрээний 4.11-т зааснаар хийсэн ажлын чанарын баталгаат хугацааг 3 жил байхаар талууд тохиролцжээ.

2016 он

- 2016 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Компани нь Орхон аймгийн Засаг даргын тамгын газартай БЗА-53/16 тоот "Орон сууцны 3-р хороололд шинээр гэрэлтүүлэг тавих ажлын захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан, хэлцлийн гэрээ"-г байгуулжээ. Тус гэрээ нь Иргэний хууль болон Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан шаардлагад нийцсэн байна. 2016 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн БЗА-16/16 тоот улсын комиссын актаар Компанийн хийж гүйцэтгэсэн Орхон аймгийн Баян-Өндөр сумын Орон сууцны 3-р хороололд шинээр гэрэлтүүлэг тавих ажлыг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн байна. Иймд Компанийг дээрх гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлсэн гэж дүгнэх боломжтой байна. Дээрх ажлын гэрээний 4.11-т зааснаар хийсэн ажлын чанарын баталгаат хугацааг 3 жил байхаар талууд тохиролцжээ.

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

- 2016 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Компани нь Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газартай БЗА-91/16 тоот "Говил багийн 100 айлын гудамжны гэрэлтүүлэгийн үлдэгдэл ажлын захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан ажлын гэрээ"-г байгуулжээ. Тус гэрээ нь Иргэний хууль болон Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан шаардлагад нийцсэн байна. Дээрх гэрээний дагуу Компанийн хийж гүйцэтгэсэн ажлыг 2016 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 14/16 тоот улсын комиссын актаар ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн байна. Иймд Компанийг дээрх гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлсэн гэж дүгнэх боломжтой байна. Дээрх ажлын гэрээний 4.10-т зааснаар хийсэн ажлын чанарын баталгаат хугацааг 3 жил байхаар талууд тохиролцжээ.

- 2016 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Компани нь Улаанбаатар хотын Захирагчийн албатай ЗАА-ИБХ-16/40 тоот "Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн агааржуулах станцын 750 агаарын машины өдөөлтийн щит шинэчлэх ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулсан байна. Тус гэрээ нь Иргэний хууль болон Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан шаардлагад нийцсэн байна. Дээрх ажлын Техникийн тайланд туссан Угсралт, сууриалуулалт, автоматжуулалт, тохируулгын ажлыг хүлээлцэх №01/2016 тоот актад Гүйцэтгэгч талаас гарын үсэг зурсан байна.

- 2016 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Компани нь Орхон аймгийн Засаг даргын тамгын газартай БЗА-114/16 тоот "Хотын доторхи гэрлэн чимэглэлийн ажлын захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулжээ. Тус гэрээ нь Иргэний хууль болон Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан шаардлагад нийцсэн байна. Дээрх гэрээний дагуу Компанийн хийж гүйцэтгэсэн хотын доторхи гэрлэн чимэглэлийн ажлыг 2016 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн БЗА-16/067 тоот улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна. Иймд Компанийг дээрх гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлсэн гэж дүгнэх боломжтой байна. Дээрх ажлын гэрээний 4.10-т зааснаар хийсэн ажлын чанарын баталгаат хугацааг 3 жил байхаар талууд тохиролцжээ.

- 2016 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Орхон аймгийн Засаг даргын тамгын газартай ОР-73/2016 тоот "ТП-213 дэд станцын 0.4 кВ-д 4 иж бүрдэл ЩО-70 нийлүүлэх гэрээ"-г байгуулжээ. Тус гэрээ нь Иргэний хууль болон Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан шаардлагад нийцсэн байна. Дээрх гэрээний хүрээнд Компанийн хийж гүйцэтгэсэн ТП-213 дэд станцын 4 иж бүрдлийг тоног төхөөрөмжийг бүрэн нийлүүлж дууссан талаар талууд 2016 оны 7 сарын 18-ны өдөр тоног төхөөрөмж хүлээн авсан комиссын актыг үйлдэжээ. Иймд Компанийг дээрх гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлсэн гэж дүгнэх боломжтой байна. Дээрх ажлын гэрээний 4.4-д зааснаар тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгснөөс хойш 1 жилийн хугацааны чанарын баталгааг Компани гаргасан байна.

-oOo-

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ
ХХК

СЭХ
ОН СӨР
БҮРТГЭВ
№ 01

АРАВ. КОМПАНИЙН ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАГДСАН МЭДЭЭЛЭЛ НЬ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БАРИМТААР НОТЛОГДОЖ БАЙГАА ЭСЭХ ТАЛААРХ ДҮГНЭЛТ

Үндэслэсэн баримт бичиг

146. Компанийн үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх талаарх дүгнэлтийг дараах баримтуудад үндэслэж гаргасан болно. Үүнд:
    - Компанийн Үнэт цаасны танилцуулга,
    - Дүгнэлтийн 1-9 дүгээр хэсгийн "Үндэслэсэн баримт бичиг" гэсэн хэсэгт дурьдагдсан баримт бичгүүд,
    - Компанийн 2017 оны 05 сарын 05-ны өдрийн 110 тоот "тодорхойлолт гаргах тухай" албан бичиг,
    - Бумбат Алтай ҮЦК ХХК-ийн 2017 оны 05 сарын 05-ны өдрийн 5/56 тоот "тодорхойлолт гаргах тухай" албан бичиг,
    - Од Бүртгэл Аудит ХХК-ийн 2017 оны 05 сарын 05-ны өдрийн 17/69 тоот "тодорхойлолт гаргах тухай" албан бичиг.

Үнэт цаасны танилцуулга

147. Компанийн нэмж гаргасан 26,544,058 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгохтой холбогдуулан Компанийн андеррайтераар сонгогдсон Бумбат Алтай ҮЦК ХХК-иас Компанийн Үнэт цаасны танилцуулгыг бэлтгэжээ. Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хараат бус аудитын дүгнэлтийг Од Бүртгэл Аудит ХХК, үнэлгээний тайланг Далай Ван Аудит ХХК-ийн Орхон аймаг дахь салбар тус тус хийж гүйцэтгэсэн байна. Бумбат Алтай ҮЦК ХХК болон Од Бүртгэл Аудит ХХК нар нь хүчин төгөлдөр баримтуудад үндэслэн Үнэт цаасны танилцуулга, хараат бус аудитын дүгнэлтийг бэлтгэсэн талаарх тодорхойлолтыг 2017 оны 05 сарын 05 өдөр Өмгөөллийн Цогт энд Нандин ХХН-д гаргаж өгчээ.

Дүгнэлт

148. Бидний зүгээс Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээллүүд нь хуульд нийцсэн хүчин төгөлдөр баримтуудад үндэслэсэн эсэхийг шалгаж үзэхэд тэдгээр баримтууд нь хуурамч эсхүл хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэл илрээгүй. Иймд Компанийн үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтуудад үндэслэсэн байна.

Энэхүү хууль зүйн дүгнэлтийг зөвхөн Компанийн Монгол Үнэт Цаасны Биржид үнэт цаас гаргах үйл ажиллагаанд зориулан гаргасан бөгөөд, өөр зорилгоор ашиглах буюу зөвшөөрөлгүйгээр бусдад тараахгүй байхыг хүсье.

ӨМГӨӨЛИЙН ЦОГТ ЭНД НАНДИН ХХН-ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ


ӨМГӨӨЛИЙН ЦОГТ ЭНД НАНДИН ХХН

Б.НАНДИНЧИМЭГ

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА5001070 4395772

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

ХАВСРАЛТ 6. ЧИЙДЭНГИЙН ЧАНАРТ ХИЙСЭН ТУРШИЛТ БОЛОН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА



ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК

ҮАМ101070 4335772

СӨХ
БҮРТГЭВ
№ 31

АГУУЛГА

I. Тайлангийн цар хүрээ 2
II. Аюулгүй байдлын судалгаа 2
III. Туршилт болон харьцуулсан судалгаа 3
IV. Бүтээгдэхүүний давуу ба сул тал 13
V. Үр дүн 13
VI. Дүгнэлт болон Цаашид Хөгжүүлэх Зүйлс 13

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КД2401070_4385772

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 11

I. Тайлангийн цар хүрээ

Энэхүү судалгааны ажлын тайлангаар Анд Энерги ХХК-н Эрдэнэт Лэд брэндийн чийдэнгийн үйлдвэрийн лэд чийдэн (E14, E27, ба T8)-гүүд болон гудамжны гэрэлтүүлэгний гэрлийн үйлдвэрлэл, ажиллагаа, чанарт хийсэн дүн шинжилгээ, мөн бусад өрсөлдөгч чийдэнгүүдтэй харьцуулсан судалгааны үр дүнг танилцуулна.

Миний бие Эрдэнэт хотод 3 хоногийн турш ажилласан хугацаандаа үйлдвэрийн байр, агуулах, нэрийн барааны дэлгүүр, лэд гэрэл хэрхэн, ямар шат дамжлагаар хийгдэж буй байдалтай танилцлаа. Мөн Анд-Энерги ХХК-ийн гүйцэтгэсэн гудамжны гэрэлтүүлэгүүд, E14, E27 төрлийн лэд гэрэл болон T8 төрлийн урт гэрэл хэрэглэж буй 3 айл өрх, 10 албан газраар орж бүтээгдэхүүний чанар, ажиллагаа, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авсан.

Туршилтанд Эрдэнэт Лэд брэндийн 12 чийдэн, 2 нүдэн чийдэн, 2 урт чийдэн, бусад брэнд (Opple, Barom, FSL, Efficient LED, LED, GP, KMONG, QML)-ийн 14 ширхэг буюу нийт 30 ширхэг чийдэн ашигласан болно.

II. Аюулгүй байдлын судалгаа

Фотобиологийн аюулгүй байдлын судалгаа – Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө

Фотобиологийн аюулгүй байдлыг хангахын тулд IEC/EN 62471 стандартын дагуу лэд гэрлийг үйлдвэрлэсэн байдаг. Энэхүү стандартыг хангаснаар тухайн лэд гэрлээс цацарч буй гэрэл (цахилгаан соронзон долгион) нь хүний бие (арьс болон нүд)-д аюулгүй гэж үздэг. Эрдэнэт Лэд брэндийн хувьд БНХАУ-н Шенжэн хотод үйл ажиллагаа явуулдаг Шү-Юү оптоэлектроникийн компанийн Тайваны эпистар фирмийн чип ашигласан XY-10WW, XY-20WW, XY-30WW, XY-40WW, XY-50WW, XY-80WW, XY-100WW зэрэг маркийн гэрлэн диод (LED) ашиглаж үйлдвэрлэдэг нь тогтоодсон. Доорх зурагт харуулав. Эдгээр гэрлэн диодууд нь фотобиологийн аюулгүй ажиллагааг хангасан байдаг нь VDE Testing and Certification Institute-ээс олгосон фотобиологийн аюулгүй байдлын тестийн тайлангаар (GSTG140828048, GSTG140828047, CSTG140828049) баталгаажиж байна. Иймд Анд-Энерги ХХК-ийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн нь хүний бисд хоргүй гэж үзэж байна.





Аюулгүй байдал, ажиллагаа – Ашиглалтын явцад гарсан асуудлууд

Т8 гэрлийг 6 сараас 1.5 жил хэрэглэж буй 4 хэрэглэгчидээс нэг гомдол ирсэн. Уг хэрэглэгч нь Эрдмин ХХК-н ажилтан бөгөөд, 1 жилийн өмнө Т8 загварын гэрлийг үйлдвэртээ

ӨМНӨГОВЬ АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
282 ГҮ "АНД-ЭНЕРГИ" ХХК
КА/001070 4385772

СЭХ
он сар
БУРТГЭВ
№ 01

суурилуулаад асаах гэтэл хүчтэй чимээ гарч чийдэн буудаж цахилгааны пускатэл буусан гэж хэлсэн. Шалтгааныг нягталж үзэхэд тус гэрлийн тэжээлийн холболтыг буруу хийсэн байжээ. Өөр аюулгүй ажиллагааны асуудал гараагүй болно. Харин E14, E27 төрлийн чийдэн хэрэглэж буй хэрэглэгчидээс ирсэн гомдол нилээд байсан.

Асуудал 1: Нүдэн чийдэн буюу бүтүү бүрхүүлэн дотор хийсэн лэд гэрлүүдийн 30% нь шатдаг, анивчдаг, мөн заримдаа асдагүй бөгөөд хэсэг хугацааны дараа асчихсан байдаг.

Шалтгаан: Лэд гэрлийг бүтүү бүрхүүлэнд хийсэн үед гэрлэн диод дулаанаа хангалттай гадагшлуулж чадахгүйн улмаас гэрлэн диод шатдаг.


Асуудал2: Хоёрдугаар сард үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүний чанарт доголдол үүсч хэвийн үсийнхээс олон тооны чийдэн эвдэрсэн.

Шалтгаан: Тэжээлийн блокийн сонголтыг буруу хийсэн. Цаашид түүхий эдийн сонголтыг хийхдээ эхлээд туршилт байдлаар цөөхөн худалдан авч хэрэглэж үзэн чанарын дүгнэлт хийсний дараа олноор захиалах нь зүйтэй.

III. Туршилт болон харьцуулсан судалгаа

Цахилгаан хэрэглээ

Чийдэнгүүдийн цахилгаан хэрэглээг тооцохдоо вольтметер болон амперметер ашиглаж чийдэн тус бүрийн цахилгааны хэрэглээг хэмжихдээ зураг харуулсан байдлаар туршилт хийлээ. Вольтметерээр цахилгаан тэжээлийн хүчдэлийг харин амперметрээр чийдэнгээр урсах гүйдэлийг хэмжиж дараа нь W=U*I томьёогоор цахилгаан хэрэглээ буюу чийдэнгийн чадлыг тооцлоо.




Чийдэнгийн цахилгаан хэрэглээ буюу чадлыг тооцохдоо чийдэн тус бүрийг гурваас доошгүй удаа асааж хэрэглэж буй хүчдэл болон гүйдэлийг хэмжин доорх хүснэгтэнд дундаж хүчдэл, дундаж чадал, болон 220В-д хэрэглэх чадлыг хувьчлан тооцож олсоныг харуулаа. Учир нь туршилтын үед цахилгаан тэжээл 230-245В-н хооронд хэлбэлзэж байсан тул чийдэнгийн 220В-т хэрэглэх чадлыг инхүү хувьчилж олсон болно.

Үүний дараа 220В-д хэрэглэх бодит болон нэрлэсэн чадал хоорондын зөрүүг тооцож үр дүнг доорх хүснэгтээр харуулаа. Эндээс зарим чийдэнгийн бодит хэрэглэж буй чадал нь нэрлэсэн чадалдаа хүрэхгүй байхад зарим нь нэрлэсэн чадалаасаа илүү их чадал хэрэглэж байгааг харж болно.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КАМ01070 4333772

Төрөл	Нэр	Нэрлэсэн Чадал (Вт)	Бодит Чадал (Вт)	Дундаж Хүчдэл (В)	220В-д хэрэглэх бодит чадал (Вт)	Бодит болон нэрлэсэн чадлын зөрүү (%)
LED-E27	ERDENET_White_12	12	14.13	241	12.9	7.5
	ERDENET_Black_1 year	12	16.46	240	15.1	25.7
	BAROM_12	12	13.25	238	12.2	2.1
	Efficient LED_12	12	11.62	238.6	10.7	-10.7
	LED_9	9	11.43	242.66	10.4	15.1
	ERDENET_9	9	11.77	239.66	10.8	20.0
	BAROM_8	8	12.73	239	11.7	46.5
	FSL_7	7	13.05	237.3	12.1	72.8
	ERDENET_7	7	8.02	240.06	7.3	5.0
	Opple_7	7	6.39	237	5.9	-15.3
	LED_5	5	4.79	239.66	4.4	-12.1
	ERDENET_Black_5	5	6.53	238.66	6.0	20.4
	ERDENET_White_5	5	6.22	239	5.7	14.5
	GP_3	3	4.72	240	4.3	44.2
LED-E14	GP candle_3	3	5.31	241.3	4.8	61.4
	ERDENET candle_3	3	3.04	240.6	2.8	-7.3
Сүүн чийдэн	KMONG_20	20	8.17	245.3	7.3	-63.4
	KMONG_60	60	13.76	241.3	12.5	-79.1
	QML_20	20	8.73	245	7.8	-60.8
Улайсдаг чийдэн	FSL_100	100	108.3	237.6	100.3	0.3
	FSL_60	60	66.9	237.3	62.0	3.4
Нүдэн	ERDENET_3	3	3.31	242.6	3.0	0.1
Урт чийдэн	T8_9	9	17.26	243	15.6	73.6
	T8_18	18	22.03	243	19.9	10.8

Графикт Эрдэнэт Лэд брэндийн чийдэнгүүдийг цэнхэр өнгөөр тодрууж харуулсан байна.



Хэмнэлт

Хэмнэлтийг тооцохдоо эхлээд улайсдаг чийдэнгийн гэрэлтэлтийн шулууныг олж, дараа нь гэрэлтэлтийн шулууныг олохдоо 100Вт болон 60Вт-н улайсдаг чийдэнгийн гэрэлтэлт болох 2 цэг (60Вт, 236Лм; 100Вт, 472Лм)-ийг ашиглалаа. Шулууны томьёо болон шулууны графикийг дорооос харна уу.

$$y=5.9x-118 \quad (1)$$

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
284 "АНД-ЭНЕРГИ" ХХК
KAK01070 4385772

СЗХ
БҮРТГЭВ
№ 01



Үүний дараа туршилтаар хэмжиж олсон гэрэлтэлтийн утгыг (1) илэрхийллийн *y* хувьсагчид орлуулж х буюу чийдэн тус бүрийн улайсдаг чийдэнтэй дүйцэх чадлыг тооцож олсон. Эцэст нь дүйцэх чадал болон бодит чадал хоёрын харьцааг тооцож олсоноор чийдэн тус бүрийн санхүүгийн хэмнэлтийг олох боломжтой болсон. Чийдэн тус бүрийн 1 сарын хэмнэлт болон бусад дэлгэрэнгүйг доорх хүснэгтээс харна уу.

Жич: 1 сарыг 30 хоногоор, өдөрт 8 цаг асах, мөн 1КВт цагийг 100 төгрөгөөр тооцсон болно.

Төрөл	Нэр	Чадал (Вт)	Бодит Чадал (Вт)	Гэрэлтэлт (Лм)	Дүйцэх чадал (Вт)	Хэмнэлт (дахин)	1 сарын цахилгааны төлбөр ба хэмнэлт (Өдөрт 8 цаг асах, 1КВт.Ц=100Төг, 30 хоног)					
							Дүйц. (1 гэрэл)	Бодит (1 гэрэл)	Хэмнэлт (Төг)	Дүйц. (10 гэрэл)	Бодит (10 гэрэл)	Хэмнэлт (Төг)
LED-E27	ERDENET_White_12	12	12.9	752	147.5	11.4	3539.0	310.4	3228.5	35389.8	3104.4	32285.5
	ERDENET_Black_1 year	12	15.1	786	153.2	10.2	3677.3	360.5	3316.8	36772.9	3605.2	33167.7
	BAROM_12	12	12.2	650	130.2	10.6	3124.1	294.7	2829.3	31240.7	2947.2	28293.4
	Efficient LED_12	12	10.7	517	107.6	10.0	2583.1	258.3	2324.7	25830.5	2583.1	23247.5
	LED_9	9	10.4	302	71.2	6.9	1708.5	247.6	1460.9	17084.7	2476.1	14608.7
	ERDENET_9	9	10.8	516	107.5	9.9	2579.0	260.5	2318.5	25789.8	2605.0	23184.8
	BAROM_8	8	11.7	359	80.8	6.9	1940.3	281.2	1659.1	19403.4	2812.1	16591.3
	FSL_7	7	12.1	411	89.7	7.4	2151.9	290.8	1861.1	21518.6	2907.9	18610.7
	ERDENET_7	7	7.3	367	82.2	11.2	1972.9	176.2	1796.7	19728.8	1761.5	17967.3
	Opple_7	7	5.9	344	78.3	13.2	1879.3	142.4	1736.9	18793.2	1423.7	17369.5
	LED_5	5	4.4	177	50.0	11.4	1200.0	105.3	1094.7	12000.0	1052.6	10947.4
	ERDENET_Black_5	5	6.0	337	77.1	12.8	1850.8	144.5	1706.4	18508.5	1444.7	17063.8
	ERDENET_White_5	5	5.7	346	78.6	13.7	1887.5	137.8	1749.7	18874.6	1377.7	17496.9
	GP_3	3	4.3	148	45.1	10.4	1082.0	104.0	978.0	10820.3	1040.4	9779.9
LED-E14	GP candle_3	3	4.8	136	43.1	8.9	1033.2	116.1	917.1	10332.2	1160.9	9171.3
	ERDENET candle_3	3	2.8	105	37.8	13.6	907.1	66.7	840.4	9071.2	667.0	8404.2
Сүүн чийдэн	KMONG_20	20	7.3	156	46.4	6.3	1114.6	176.9	937.7	11145.8	1769.2	9376.6
	KMONG_60	60	12.5	342	78.0	6.2	1871.2	301.8	1569.4	18711.9	3018.0	15693.8
	QML_20	20	7.8	156	46.4	5.9	1114.6	188.9	925.7	11145.8	1889.1	9256.7
Улайсдаг чийдэн	FSL_100	100	100.3	472	100.0	1.0	2400.0	2400.0	0.0	24000.0	24000.0	0.0
	FSL_60	60	62.0	236	60.0	1.0	1440.0	1440.0	0.0	14400.0	14400.0	0.0


ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КАЛ01070 4385772

Нүдэн	ERDENET_3	3	3.0	256	63.4	21.1	1521.4	72.1	1449.3	15213.6	7210	14492.5
Урт чийдэн	T8_9	9	15.6	662	132.2	8.5	3172.9	373.3	2799.6	31726.8	3742.8	27996.0
	T8_18	18	19.9	1176	219.3	11.0	5263.7	478.5	4785.2	52637.3	4785.2	47852.1

Сарын хэмнэлтэд үндэслэн сүүн болон лэд гэрлийн эргэн төлөгдөх хугацааг тооцож олсныг доорх хүснэгтээс харна уу.

	Нэр	Чадал (Вт)	Хэмнэлт (дахин)	Үнэ (Төг)	1 сард хэмнэх хэмнэлт (Төг)	Эргэн Төлөгдөх Хугацаа (сар)
1	KMONG_60	60	6.2	3500	1569.4	2.2
2	Efficient LED_12	12	10.0	6000	2324.7	2.6
3	KMONG_20	20	6.3	2500	937.7	2.7
4	FSL_7	7	7.4	5000	1861.1	2.7
5	QML_20	20	5.9	2500	925.7	2.7
6	BAROM_12	12	10.6	10000	2829.3	3.5
7	ERDENET_White_5	5	13.7	7700	1749.7	4.4
8	ERDENET_White_12	12	11.4	15000	3228.5	4.6
9	BAROM_8	8	6.9	8000	1659.1	4.8
10	ERDENET_9	9	9.9	12100	2318.5	5.2
11	ERDENET candle_3	3	13.6	4400	840.4	5.2
12	ERDENET_7	7	11.2	10000	1796.7	5.6
13	LED_9	9	6.9	8181	1460.9	5.6
14	LED_5	5	11.4	6635	1094.7	6.1
15	Opple_7	7	13.2	11999	1736.9	6.9
16	GP_3	3	10.4	9900	978.0	10.1
17	GP candle_3	3	8.9	9900	917.1	10.8

Хэмнэлтийн утгыг график байдлаар харвал



ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
286 | "АНД-ЭНЕРГИ" ХХК
ҮАМ01070 4385772

СЗХ
ОУ
БҮРТГЭЛ
№ 01

Мөн эргэн төлөгдөх хугацааг графикаас харна уу.



Халалт



Улайсдаг, сүүн болон лэд гэрлүүдийн халалтыг хэмжихдээ чийдэн тус бүрийг 1 цагийн хугацаанд тасралттүй асааж хэмжилтийг Cheerman брэндийн инфра-улаан туяаны термометрээр 5 сек, 10 сек, 30 сек, 1 минут, 2 минут, 5 минут, 10 минут, 30 минут, болон 1 цаг тутамд чийдэнгийн хамгийн халуун цэгт хэмжилт хийсэн. Хэмжилт хийх үед тасалгааны температур 24-25°C градусын хооронд хэлбэлзэж байлаа. Хэмжилтийн үр дүнг доорх хүснэгтээр харууллаа. Мөн ижил чадалтай чийдэнгүүдийн харьцаг графикаар графикаар үзүүлэв.


Хэмжилтийн үр дүнг доорх хүснэгтээр харууллаа.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ
ХХК
КАМ01070 4395772

СЗХ
ОН САР ӨДӨР
БҮРТГЭВ
№ 01

Д/д	Нэр	Хугацаа (сек)									
		0	5	10	30	60	120	300	600	1800	3600
1	ERDENET_White_12	25	26	27.2	27	28	29.9	34	39	50	52
2	ERDENET_Black_12	25	26	26	26.5	27.6	29.5	32	36	46.5	48
3	BAROM_12	26	26	26.7	27	30	34	48.9	66	82	84
4	LED_9	26	26	26.2	26.5	26.5	28	31.2	34.3	39.5	40
5	ERDENET_9	26	26	26.5	27	28.2	32	34.8	41.1	52.8	54
6	BAROM_8	25	26	26.7	29	37.8	34	48	57	67	68
7	Opple_7	27	27	27.5	30	35.5	40	49.6	53.6	54	60
8	FSL_7	27	27	27.3	28	31.6	35	43.1	46	51.3	53.2
9	ERDENET_7	27	27	27	28	29	31.6	38	42.7	56.2	58.4
10	LED_5	26	26	26.1	26.4	27.4	32	36.5	40.9	45	43
11	ERDENET_Black_5	26	26	26.8	27	28.6	31	36.5	43.5	53	55
12	ERDENET_White_5	26	26	27	27.6	29.8	33	41	49	58	60.5
13	GP candle_3	26	26	28	30	32.7	40	51	59	63	67
14	ERDENET candle_3	26	26	27	29.2	32	37	41	47	52	56
15	FSL_100	29	45	70	111	157	203	210	210	210	210
16	FSL_60	28	35	44	80	123	180	185	185	185	185

Дараах графикуудаар асалтын хугацаа болон температурыг нарийвчлан харуулав.



Жин


ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КАМ01070 4385772

СЗХ
ОН САР ӨДӨР
БҮРТГЭВ
№ 01

Туршилтанд хэрэглэсэн бүх чийдэнгүүдийн жинг доорх хүснэгтээс харна уу. Эндээс харахад 5Вт-н чийдэнгүүдийн хувьд хөнгөн байна, харин бусад чадлын хувьд Эрдэнэт Лэд брэндийн чийдэн хүнд байна.


Төрөл	Нэр	Чадал (Вт)	Жин (гр)
LED-E27	ERDENET_Black_12	12	277
	ERDENET_White_12	12	252
	BAROM_12	12	100
	Efficient LED_12	12	90
	ERDENET_9	9	187
	LED_9	9	108
	BAROM_8	8	54
	ERDENET_7	7	111
	FSL_7	7	50
	Opple_7	7	50
	LED_5	5	84
	ERDENET_Black_5	5	79
	ERDENET_White_5	5	64
	ERDENET candle_3	3	35
LED-E14	GP_3	3	26
	GP candle_3	3	24
Сүүн чийдэн	KMONG_60	60	67
	KMONG_20	20	48
	QML_20	20	48
Улайсдаг чийдэн	FSL_100	100	26
	FSL_60	60	25

График дээр Эрдэнэт Лэд брэндийн гэрлийн жинг улбар шараар тодруулсан байна.



Гэрэлтэлт

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА#01070 4388772



Чийдэнгүүдийн гэрэлтэлтийг хэмжихдээ TES брэндийн люкс хэмжигч ашиглан люкс метерийн мэдрүүр болон чийдэнгийн хооронд хоёр ширхэг А4 бичгийн цаасны зай буюу 60 см зай байсан. Мэдрэгчийг чийдэнгийн гэрэл шууд тусахаар хажуу тийш харуулан тавьсан. Хэмжилтийг харанхуй өрөөнд хийсэн тул люкс метерийн мэдрэгч дээр эвхсэн чийдэнгээс цацрах гэрлийн туяа туссан ба хэмжилт хийж байх үеийн цахилгаан хүчдэлийг хэмжиж гэрэлтэлтийг нормчлоход ашиглалаа.

Хүснэгтээс чийдэнгүүдийн гэрэлтэлтийн нормчлогдсон утгыг харж болно. Хүснэгтэд гэрэлтэлт бусад гэрлүүдээс хэдэн хувиар их бага байгааг хувиар харуулсан болно.

Төрөл	Нэр	Чадал (Вт)	Гэрэлтэлт (Люмен)	Илүү (%)
LED-E27	ERDENET_White_12	12	752	15.7
	ERDENET_Black_12 color	12	786	21
	BAROM_12	12	650	
	Efficient LED_12	12	517	
	LED_9	9	302	
	ERDENET_9	9	516	70.8
	BAROM_8	8	359	
	FSL_7	7	411	
	ERDENET_7	7	367	-12.7
	Opple_7	0	344	
	LED_5	5	177	
	ERDENET_Black_5	5	337	90.4
	ERDENET_White_5	5	346	95.5
	GP_3	3	148	
LED-E14	GP candle_3	3	136	
	ERDENET candle_3	3	105	-29.7
Сүүн чийдэн	KMONG_20	20	156	
	KMONG_60	60	342	
	QML_20	20	156	
Улайсдаг чийдэн	FSL_100	100	472	
	FSL_60	60	236	
Нүдэн	ERDENET_3	3	256	
Урт чийдэн	T8_9	9	662	
	T8_18	18	1176	

Үнийн харьцуулалт

Чийдэнгийн үнийг 100 айл, Номин супермаркет, Гүүд Прайс сүлжээ дэлгүүрээс авсан болно. Хүснэгтэд лэд чийдэнгийн үнийг харуулсан байна.

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
290 "АНД-ЭНЕРГИ" ХХК
4385772

СЗХ
ОН САР
БҮРТГЭГДСЭН
№ 21











Өрсөлдөгч лэд чийдэнтэй харьцуулахад Эрдэнэт Лэд брэндийн бүтээгдэхүүний үнэ мэдэгдэхүйц өндөр байгаа нь харагдаж байна. Иймээс чанар болон дотоодын үйлдвэрлэгч гэдэг давуу талаа ашиглан өрсөлдөх нь зүйтэй.

Харин улайсдаг чийдэнгээс 10 дахин , сүүн чийдэнгээс 3 дахин үнэтэй байна.

Хүснэгтэд чийдэн бүрийн чадал, худалдан авсан газар, үнийг харуулав.

Төрөл	Нэр	Дэлгүүр	Үнэ (Төг)
LED-E27	ERDENET_12		15,000.00
	BAROM_12	100 айл	10,000.00
	Efficient LED_12	100 айл	6,000.00
	GP_10.5	Гүүд прайс	16,500.00
	LED_9	Номин Супермаркет	8,181.00
	ERDENET_9		12,100.00
	BAROM_8	100 айл	8,000.00
	FSL_7	100 айл	5,000.00
	ERDENET_7		10,000.00
	Opple_7	Номин Супермаркет	11,999.00
	LED_5	Номин Супермаркет	6,635.00
	ERDENET_5		7,700.00
	GP_3	Гүүд прайс	9,900.00
LED-E14	GP candle_3	Гүүд прайс	9,900.00
	ERDENET candle_3		4,400.00
Сүүн чийдэн	GP_20	Гүүд прайс	8,900.00
	GP_15	Гүүд прайс	7,900.00
	Philips_20	Номин Супермаркет	7,999.00
	Philips_15	Номин Супермаркет	7,299.00
	Philips_12	Номин Супермаркет	7,299.00

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КАЙ01070 4385772

	Philips_8	Номин Супермаркет	6,999.00
	Philips_5	Номин Супермаркет	6,999.00
	KMONG_60	100 айл	3,500.00
	KMONG_20	100 айл	2,500.00
	QML_20	100 айл	2,500.00
Улайсдаг чийдэн	FSL_100	100 айл	500.00
	FSL_60	100 айл	500.00
Нүдэн	ERDENET_3		8,400.00
Урт чийдэн	T8_9		13,000.00
	T8_18		15,000.00

Насжилт

Насжилтыг тогтоохдоо Эрдэнэт Лэд брэндийн чийдэнд хэрэглэж буй Xu-Yu брэндийн гэрлэн диодын насжилтыг тодорхойлох LM 80 тестийн тайлан дээр үндэслэв. Гэрлэн диодын гэрэлтэлт 70% болтлоо буурахад доод тал нь 36,000 цаг ажиллана гэж үзсэн байна. Доорх хүснэгтнд өдөрт 4 цаг, 6 цаг, болон 8 цаг асахад хэдэн жилийн насжилттай вэ гэдгийг харуулсан байна.

	Нэр	Reported L(70%)	Насжилт (жил)		
			Өдөрт 4 цаг асах	Өдөрт 6 цаг асах	Өдөрт 8 цаг асах
1	XY YU 2835, XY YU 5730	> 36000 цаг	24.7	16.4	12.3

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

IV. Бүтээгдэхүүний давуу ба сул тал

Давуу талууд

1. **Хэмнэлт өндөр**: Эрдэнэт Лэд брэндийн гэрлүүд улайсдаг гэрэлтэй харьцуулахад 9.9-13.7 дахин бага цахилгаан хэрэглэж байсан нь тооцоогоор гарсан нь сайн үзүүлэлт юм.
2. **Гэрэлтэлт сайн**: Эрдэнэт Лэд брэндийн чийдэнгийн гэрэлтэлт ижил чадалтай бусад чийдэнгүүдтэй ойролцоо эсвэл илүү байсан нь сайн үр дүн юм.
3. **Халалт боломжийн**: Халалтын хувьд Эрдэнэт Лэд брэндийн чийдэнгүүд бусад чийдэнгүүдтэй ойролцоо байсан, мөн чадал ихсэх тусам халалт нь бусад чийдэнгүүдээс багасах хандлага харагдаж байлаа.
4. **Гэрэлтэлтээ барих чадвар сайн**: Эрдэнэт Лэд брэндийн 1 жил хэрэглэгдсэн 12Вт-н чадалтай чийдэнгийн цахилгаан хэрэглээ 25%-аар нэмэгдсэн байсан нь сул тал боловч гэрэлтэлт нь шинэ 12Вт-н чийдэнтэй харьцуулахад 4.5%-аар их байсан нь сайн тал. Учир нь 1 жил хэрэглэгчийн гар дээр ашиглагдсан гэрлийн гэрэлтэлт муудаж буураагүй нь Эрдэнэт Лэд брэндийн чийдэнгийн гэрлэн диодын чанар сайн байгааг илтгэж байна.

Сул талууд

1. **Хүнд**: Эрдэнэт Лэд брэндийн чийдэнгүүд нь бусад ижил чадалтай лэд чийдэнгүүдээс 45-105% хүртэл илүү жинтэй байсан. Харин зөвхөн 5 Вт-н чадалтай чийдэн нь LED_5 чийдэнгээс хөнгөн байв. Энэ нь чийдэнгийн хөргүүр зузаан хөнгөн цагааны хайлшаар хийгдсэн харин бусад лэд гэрлийн хөргүүр нимгэн метал эсвэл хуванцар материалаар хийгдсэнтэй холбоотой юм.
2. **Овор хэмжээ ихсэх**: Гэрлийн чадал ихсэх тусам овор хэмжээ нь бусад чийдэнгүүдээс харьцангуй ихээр ихсэж байна.
3. **Хөргүүр нүхтэй**: Чийдэнгийн хөргүүр агааржуулах нүхэлгээтэй байсан бол бусад чийдэнгүүдийнх ихэнхдээ битүү хийгдсэн байна. Битүү байх нь чийдэн дотор ус, тоос шороо орохгүй учир чийдэнгийн насжилт, гэрэлтэлтэнд эерэгээр нөлөөлнө.
4. **Цахилгаан хэрэглээ явцдаа ихсэх магадлалатай**: 1 жил хэрэглэгдсэн 12Вт-н чадалтай чийдэнгийн цахилгаан хэрэглээ шинэ 12Вт-н чадалтай гэрлийнхээс 25% аар нэмэгдсэн байсан. Энэ нь тэжээлийн блокын тотворгүй байдлыг харуулж байна. Гэхдээ энэ асуудлыг цаашид улам олон чийдэн дээр туршилт хийж нарийвчилж үзэх шаардлагатай, учир нь энэ зөвхөн нэг чийдэн дээр үндэслэгдсэн учир алдааны магадлал өндөр байх боломжтой.

V. Үр дүн

Энэхүү ажлын хүрээнд хийгдсэн туршилт болон үнэлгээний явцад дараах үр дүн гарлаа.

1. Үнийн хувьд Эрдэнэт Лэд брэндийн гэрлүүд OPPLE, GP зэрэг сүлжээ дэлгүүрүүдээр зарагдаж буй брэндүүдээс 50 хувь хүртэл хямд харин FSL, BAROM, LED зэрэг 100 айл дээр зарагдаж буй лэд гэрлээс 30% хүртэл үнэтэй байсан.
2. Эрдэнэт Лэд гэрлийн зардлаа эргэн төлөх хугацаа улайсдаг чийдэнтэй харьцуулан тооцоход 4.4-5.6 сар гарсан нь өрсөлдөгч бүтээгдэхүүнүүдтэй харьцуулахад дундаж үзүүлэлт байлаа.
3. Гэрлэн диодын ажиллах хугацаанд үндэслэн чийдэнгийн ажиллах хугацаа тооцвол 12 жил байна.
4. Эрдэнэт Лэд брэндийн бүтээгдэхүүн нь шилэн бус хуванцар, төмөр учраас бусад өрсөлдөгч бүтээгдэхүүнтэй харьцуулахад бат бөх байна. Улайсдаг болон сүүн чийдэн нь газар унагаахад хагарч байгаа бол лэд чийдэн нь хагарахгүй бөгөөд унагасны дараа ашиглахад ажиллагаа нь хэвийн байна.

VI. Дүгнэлт болон Цаашид Хөгжүүлэх Зүйлс

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
KA301070 4385772

Энэхүү хөндлөнгийн шинжээчийн судалгааны ажлаар Эрдэнэт Лэд брэндийн чийдэн болон өрсөлдөгч чийдэнгүүдийн харьцуулсан судалгаа хийлээ. Судалгааны ажлын явцад чийдэнгийн давуу болон дутагдалтай талууд туршилтын үр дүнд гарч ирснийг өмнөх хэсэгт дурьдсан бөгөөд шинжээчийн зүгээс доорх дүгнэлтийг өгч байна.

1. T8 загварын урт гэрлийн хувьд гэрэлтэлт сайн, тэжээлийн блок нь Тайваны нэр хүндтэй Meanwell брэндийнх, шалгалтаар явж үзэхэд 1-18 сар хүртэл хэрэглэгдэж буй гэрлүүдээс үндсэндээ 100% нь хэвийн ажиллаж байсан. Мөн хэрэглэчдийн сэтгэл ханамж өндөр байсныг харгалзан үзэж T8 төрлийн чийдэнг цаашид үргэлжлүүлэн үйдлвэрлэж худалдаанд гаргах бүрэн боломжтой гэж үзэж байна.
2. Мөн гудамжны гэрэлтүүлэгний гэрлийн хувьд 6 сар хүртэл ажиллаж буй гэрэлтүүлэгнүүдээс гадны нөлөөнөөс болж асахгүй болсон 2 гэрлээс бусад нь хэвийн ажиллаж байсан. Тэжээлийн блок нь Тайваны нэр хүндтэй Meanwell брэндийнх, хэрэглэгчдийн сэтгэл ханамж өндөр зэргийг харгалзан үзэж энэ төрлийн гэрэлтүүлгийг цаашид үргэлжлүүлэн үйдлвэрлэж худалдаанд гаргах бүрэн боломжтой гэж үзэж байна.
3. Харин гэр ахуй болон оффисийн зориулалтаар хэрэглэгдэж буй E27, E14 төрлийн лэд гэрлүүдийн хувьд тэжээлийн блокны сонголт болон битүү бүрхүүлэнд хийснээс үүдсэн хэт халалтаас болж гэрлэн диод шатах асуудал маш өндөр байлаа. Үндсэндээ худалдаанд гарсан бүтээгдэхүүний 30% нь шатсан, ажиллагаа нь доголдсон, анивчсан байдалтай байв. Хэдийгээр энэ төрлийн чийдэн нь гэрэлтэлт сайн, хэмнэлт өндөр, эргэн төлөгдөх хугацаа боломжийн, бусад чийдэнтэй харьцуулахад халалт бага, үнийн хувьд дундаж зэрэг нь өрсөлдөх чадварыг харуулж байгаа ч дээр дурдсан асуудлыг шийдвэрлэж найдваржилтыг 100% болгохоос нааш худалдаанд гаргахгүй байхыг зөвлөж байна. Дээрх асуудлыг шийдвэрлэхдээ доорх зөвөлгөөг дагахыг санал болгож байна.

Цаашид Хөгжүүлэх Зүйлс ба Зөвөлгөө

1. Чийдэнгийн тэжээлийн блокыг илүү найдвартай тэжээлийн блокоор солих, ингэснээр чийдэнгийн найдваржилт, насжилт уртсана.
2. Чийдэнгийн цаасан хайрцан дээр чийдэнг **"Битүү бүрхүүлэнд хийж ашиглаж болохгүй"** гэсэн анхааруулга бичих. Ингэснээр халалтаас болж шатах шаталтыг үгүй болгоно.
3. Чийдэнгийн цаасан хайрцан дээр чийдэнг зохистой орчны температурт ажиллуулах тухай анхааруулах, жишээ нь ажиллагааны орчны температур -10°C – +40°C.
4. Чийдэнгийн цаасан хайрцан дээр баталгаат хугацаг бичих. Баталгаат хугацаа бичих нь бусад өрсөлдөгч чийдэнгүүдээс давуу талыг бий болгоно.
5. Элемент болон тэжээлийн блок худалдан авахаас өмнө бүтээгдэхүүний судалгааг хангалттай хугацаанд хийсний дараа олон тоогоор худалдан авдаг байх. Ингэснээр их хэмжээний найдваргүй элемент авснаас үүдэн эргэлтийн хөрөнгөө гацаах, бүтээгдэхүүнийхээ чанарыг муутгаж хэрэглэчдийн итгэлийг алдахаас сэргийлнэ.
6. Дэлхий нийтээр хүйтэн цагаан өнгийг тохиромжгүй гэж үзэж байгаа тул лэд гэрлийн өнгийг дулаан цагаан болгож өөрчлөх.
7. Чийдэнгүүдийн хөргүүрийг хуванцар, эсвэл метал болгох, ингэснээр овор хэмжээ, жин, болон өртөг буурна. Ингэхийн тулд бусад лэд гэрлүүдийн технологийг судлах, гэрлэн диодоос ялгарч буй дулааныг үр дүнтэй хөргүүр лүү дамжуулах аргыг нэвтрүүлэх.
8. Хөргүүрийг нүхгүй болгох, ингэснээр ус, шороо тоос орохгүй болж чийдэнгийн насжилт уртсана.

294 "АНД-ЭНЕРГИ" ХХК

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

ХАВСРАЛТ 7. БУСАД

Бүтээгдэхүүний үнийн судалгаа

Candle буюу 3W-4W гэрлүүд

№	Үйлдвэрлэсэн улс, Бренд	Техник үзүүлэлт	Борлуулалтын цэг	Үнэ (төгрөг)	Бөөний үнэ (төгрөг)
1	Монгол, Эрдэнэт LED	3W/E14	Орхон, Зуун айл БМД, Стандарт БМД	4950	4750
2	Хятад, FSL	3W/E14	УБ, Зуун айл БМД/Сондор	250	1800
3	Хятад, FSL	4W/E14	УБ, Зуун айл БМД/Сондор	3000	2800
4	Хятад, FSL	3W/E14,E27	Оргил сүлжээ дэлгүүр, УБ, Зуун айл БМД	2420	
5	Хятад, FSL	3W/E14,E27	Оргил сүлжээ дэлгүүр, УБ, Зуун айл БМД	1850	
6	Хонгконг, GP	3W/E14,E27	Hermes худалдааны төв	9000	

5W-7W гэрлүүд

№	Төрөл	Үйлдвэрлэсэн улс, Бренд	Техник үзүүлэлт	Борлуулалтын цэг	Үнэ (төгрөг)	Бөөний үнэ (төгрөг)
1	5W	Монгол, Эрдэнэт LED	5W/E27	Орхон, Зуун айл БМД, Стандарт БМД	7700	7100
2		Хятад, FSL	5W/E27	УБ, Зуун айл БМД/Сондор	4000	
3		Хятад, FSL	5W/E27	Оргил сүлжээ дэлгүүр, УБ, Зуун айл БМД	3300	
4		Хятад, FSL	6W	Оргил сүлжээ дэлгүүр, УБ, Зуун айл БМД	2580	
5	7W	Монгол, Эрдэнэт LED	7W/E27	Орхон, Зуун айл БМД, Стандарт БМД	10000	9500
6		Хятад, MANHA	7W/E27	УБ, Зуун айл БМД	4000	
7		Хятад, FSL	7W/E27/E14	УБ, Зуун айл БМД	5000	
8		Хятад, IEK	7W/E27	Ampher House/100 айл/	5900	
9		Хятад, FSL	7W/E27	УБ, Зуун айл БМД	4500	

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КАЙ01070 4385772

9W-12W гэрлүүд

1	9W	Монгол, Эрдэнэт LED	9W/E27	Орхон, Зуун айл БМД, Стандарт БМД	12100	11600
2		GP	10.5W/E27	Hermes худалдааны төв	15000	
3		FSL, Хятад	9W/E27	Оргил сүлжээ дэлгүүр, УБ, Зуун айл БМД	3610	
4		FSL, Хятад	10W/E27	Оргил сүлжээ дэлгүүр, УБ, Зуун айл БМД	3910	
5	12W	Монгол, Эрдэнэт LED	12W/E27	Орхон, Зуун айл БМД, Стандарт БМД	15000	14300
6		FSL, Хятад	12W/E27	Оргил сүлжээ дэлгүүр, УБ, Зуун айл БМД	5460	
7		Opple, Хятад	12W/E27-3 өнгөөр асдаг	Ampher House/100 айл/	15000	
8		Хятад	12W/E27		10000	
9	T5	Монгол, Эрдэнэт LED	T5/18W	Орхон, Зуун айл БМД, Стандарт БМД	14500	14000
10		Хятад	T5/18W	УБ, Зуун айл БМД	700	

СЗХ
он сар
ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
RA#01070 4335772

Үйлдвэрийн шинэ байрны план зураг

Үйлдвэрийн байр нь 20х24 м-ийн харьцаатай 3 давхар байхаар төлөвлөв.

1-р давхарт – Дэлгүүр, складны хэсэг


2-р давхарт – Үйлдвэрийн хэсэг

3-р давхарт – Оффисын хэсэг байна.

1-р давхарт төлөвлөхдөө:

Нэрийн дэлгүүр	- Бүтээгдэхүүнийг үйлдвэрийн үнээр борлуулах цэг - Өөрийн бүтээгдэхүүнийг ашиглан гоёлын үзүүлэнгийн хэсэг болгон тохижуулна.
Склад дэлгүүр	- Бүтээгдэхүүнийг хадгалах склад - Бөөний бүтээгдэхүүн олгох байдлаар ашиглана.
Ажилчдын хувцас солих өрөө	Үйлдвэрийн ажилчдын амрах, хувцас солих өрөө


1-р давхрын төлөвлөлт



2-р давхарт төлөвлөхдөө:

Гэрэл үйлдвэрлэлийн хэсэг	- Гэрэл үйлдвэрлэх шат дамжлага - Угсралт хийх - Хаягжилт, савлагаа
Гэрэл шалгах хэсэг	- Үйлдвэрлэсэн гэрлийг шалгах
Гэрэл тестлэх өрөө	- Гэрэл тестлэх

2-р давхрын төлөвлөлт




3-р давхарт төлөвлөхдөө:

Оффисын хэсэг байхаар төлөвлөв. Үүнд:

- Захирал;
- Мастер;
- Санхүү;
- Хүний нөөц;
- Маркетингийн алба;
- Судалгаа хөгжүүлэлтийн төв;
- Уулзалтын өрөө (үзүүлэн бүхий).

3-р давхрын төлөвлөлт



Үйлдвэрийн шинэ шугамын үнийн санал



LEADSMT

SHENZHEN LEADSMT TECHNOLOGY CO., LTD.

Address: No.11 Minfu road,shatou Industrial Park , Shajing Town, Bao 'an, Shenzhen, P,R ,China 518103
Cell:+86-15820477064,+86-0755-27313069 Email:effi_leadsmt@163.com
Skype ID:effi1022 ; what's app:+86-1582047706 Website: http://en.leadsmt.com/

OFFER LIST

Item	Function basic Description	Model No.	QTY	Unit Price	Total account
Semi-auto LED SMT production line					
LED Printer(1.2M)	This machine is used for printing the solder paste on PCB before mount led chips on the board.	LD-P808AL	1set	USD4500	USD4500
Off line LED Pick & Place machine（full automatic, 6heads，screw ball）	After printer, pick the components(led chips) and place on pcb accurately by moving heads	LED-1206TS	1set	USD20000	USD20000
LED Oven(big,8 zones，big)	After pick and place machine, put the pcb into reflow oven, by high temperature melt the solder paste to fix the components on pcb.	RF-8810	1set	USD14000	USD14000
Uploading conveyor for oven	Transport the pcb from pick place machine into reflow oven	LD-330CR	2sets	USD800	USD1600
PCB separator(3 blades)	Cut the main pcb to separate one	LD-330PS	1set	USD1600	USD1600
Belt conveyor	Assembly and testing , transport	LD-330P	40M	------	------
LED aging line					
LED Aging line	Testing the power and brightness of led products to make sure a good quality before delivery.	LD-330A	12M	USD16000	USD16000
LED light testing machine					
Integrating sphere	Testing led performance parameters: luminous flux(LV value),color temperature(wave length),photosynthetic	X-10	1set	USD14000	USD14000



БУРГЭЛ
№ 01

SHENZHEN LEADSMT TECHNOLOGY CO., LTD.
Address: No.11 Minfu road,shatou Industrial Park , Shajing Town, Bao 'an, Shenzhen, P.R ,China 518103
Cell:+86-15820477064,+86-0755-27313069 Email:effi_leadsmt@163.com
Skype ID:effi1022 ; what's app:+86-1582047706 Website: http://en.leadsmt.com/

	efficiency				
Raw materials					
PCB	-------	-------	-------	-------	-------
LED chips	-------	-------	-------	-------	-------
LED housing	-------	-------	-------	-------	-------
Solder paste	-------	-------	-------	-------	-------
LED power driver	-------	-------	-------	-------	-------
					USD71700
Total account: SAY USD SEVENTY-ONE THOUSAND AND SEVEN HUNDRED ONLY					

Remark:

1. Price: please notice the price is FOB Shenzhen.
2. Payment by TT, 30% payment in advance, the balance before shipment.
3. Delivery within 30 days after received your deposit, not include holiday!
4. Packing in plywood case and film.
5. Not Include installation in your factory, you will need responsible Visa, round-trip air tickets, accommodation, and pay salary 100USD per day per one!
6. Warranty: One year without any artificial mistake and natural disasters.
7. Bank details:
   Beneficiary: OT-SHENZHEN LEADSMT TECHNOLOGY CO.,LTD
   Bank：BANK OF CHINA(HONG KONG) LTD
   Bank Address: 1 GARDEN ROAD, HONG KONG
   SWIFT: BKCHHKHH
8. Account No.: 0120177872138

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ
ХХК
КАМ01070 4385772

Тогтоолын хуулбарууд

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
01

“АНД-ЭНЕРГИ” ХХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2017оны 03 сарын 29-ны өдөр Дугаар 03 Орхон аймаг

Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай

Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, компанийн дүрмийн 9 дүгээр бүлгийн 9.1, 10 дугаар бүлгийн 10.10.4 дахь заалтууд, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн хэлбэрийг өөрчлөн хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэхээр шийдвэрлэсүгэй.
2. Компанийн хэлбэрийг өөрчлөн хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэх төслийг хавсралт 1-ээр батлалсугай.
3. Компанийн зарласан энгийн хувьцаанаас 26 544 058 (хорин зургаан сая таван зуун дөчин дөрвөн мянга тавин найман) ширхэг хувьцааг эргэлтэд нэмж гаргасугай.
4. Компанийн дүрмийг хавсралт 2-оор шинэчлэн батлалсугай.
5. Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу компанийн хувьцааг Монголын үнэт цаасны бирж, Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэх, эргэлтэд нэмж гаргасан хувьцааг нийтэд санал болгон худалдах бэлтгэл ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Ц.Гүррагчаа)-д үүрэг болгосугай.

АНД-ЭНЕРГИ ХХК –ний ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

1. ..... /Төмөрбат Барс/
2. ..... /Цэнд-Аюуш Гүррагчаа/
3. ..... /Ганхуяг Түвшин/
4. ..... /Далхаа Мөнхбаяр/

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА01070 4385772

СӨХ
он сар
БҮРТГЭВ
№ 01

"АНД-ЭНЕРГИ" ХХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 03-ны өдөр Дугаар 04 Орхон аймаг

Нийтэд санал болгох хувьцааны
үнийг тогтоох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4.4.8 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 03 дугаар сарын 29-ний өдрийнээлжит бус хурлын 03 тоот тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн

ТОГТООХ нь :

1. Нийтэд санал болгон худалдах энгийн хувьцааны үнийг 65 төгрөгөөр тогтоосугай.
2. Нийтэд санал болгох нэг багцын хэмжээг 1000 (нэг мянга) ширхэг энгийн хувьцаа байхаар тогтоосугай.
3. Компанийн нийтэд санал болгосон хувьцааг Монголын үнэт цаасны биржээр дамжуулан худалдах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Ц.Гүррагчаа)-д үүрэг болгосугай.
4. Хувьцааг нийтэд санал болгох үйл ажиллагааг хамтран зохион байгуулах андеррайтерийн компаниар "Бумбат-Алтай УЦК" ХХК-ийг сонгосугай.

ТУЗ-ийн дарга Т.БАРС

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ
ХХК
КАМ01070 4385772

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2016 оны 04 сарын 06 өдөр Дугаар 120

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 41
Улаанбаатар хот

"Бумбат-Алтай ҮЦК" ХХК-д
андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрөл нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, 63 дугаар зүйлийн 63.1.5, Хорооны 2015 оны 406 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх журам"-ын 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Бумбат-Алтай ҮЦК" ХХК-д андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж олгосугай.

2. Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллахыг "Бумбат-Алтай ҮЦК" ХХК /Ш.Батжаргал/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, Хорооны бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Ю.Нэргүй/-т үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ИЙЦЭГЧ,
ДЭД ДАРГА Э.БАТЭОЛД

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ
ХХК

КАМ01070 4385772

СЗХ
он сар
БҮРТГЭВ
№ 01

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2016 оны 06 сарын 10 өдөр Дугаар 206 Улаанбаатар хот

"Цогт энд Нандин" ХХН-ийг үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15, 24 дүгээр зүйлийн 24.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 451 дүгээр тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам"-ын 4.2 дахь хэсгийн тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Цогт энд Нандин" ХХН-ийг үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг "Цогт энд Нандин" ХХН /Б.Нандинчимэг/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Нацагдорж/-нд даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
ДЭД ДАРГА Э.БАТБОЛД

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА1101070 4385772

001170

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2016 оны 04 сарын 06 өдөр Дугаар 121

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 91
Улаанбаатар хот

"Од бүртгэл аудит" ХХК-ийг үнэт цаасны зах зээлд
оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх
хуулийн этгээдээр бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.17, 24.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 452 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам"-ын 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Од бүртгэл аудит" ХХК-ийг үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг "Од бүртгэл аудит" ХХК /У.Оюунаа/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Ю.Нэргүй/-т, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ,
ДЭД ДАРГА Э.БАТБОЛД

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ
ХХК

СЗХ
он сар
БҮРТГЭЛ
№ 01

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 08 сарын 08 өдөр Дугаар 259 Улаанбаатар хот

Үнэт цаас гаргагчид үйлчилгээ
үзүүлэх аудитын компаниар бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 2012 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан "Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх аудит, үнэлгээний байгууллага, хуулийн компанийг бүртгэх тухай" журмын 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Дор дурьдсан нэр бүхий компаниудыг үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх аудитын компаниар 3 жилийн хугацаагаар бүртгэсүгэй.

1/ "Конфиденс-Аудит" ХХК;

2/ "Иттэлт-Аудит" ХХК;

3/ "Далайван-Аудит" ХХК;

4/ "Прайсуотерхаускуперс-Аудит" ХХК;

5/ "Эс Эм-Аудит" ХХК;

6/ "Сүлд-Аудит" ХХК;

7/ "Тэд-Аудит" ХХК.

2.Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг дээрх нэр бүхий компаниудын захирлуудад үүрэг болгосугай.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КАМ01070 4385772

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

СЗХ сар өдөр БҮРТГЭВ № 01 Улаанбаатар хот

2012 оны 08 сарын 08 өдөр Дугаар 261

Үнэт цаас гаргагчид үйлчилгээ
үзүүлэх үнэлгээний компаниар бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 2012 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан "Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх аудит, үнэлгээний байгууллага, хуулийн компанийг бүртгэх тухай" журмын 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Дор дурьдсан нэр бүхий компаниудыг үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх үнэлгээний компаниар 3 жилийн хугацаагаар бүртгэсүгэй:

1/ "Далайван-Аудит" ХХК;

2/ "Эвиденсе-Аудит" ХХК;

3/ "Итгэлт-Аудит" ХХК;

4/ "Гэрэгэ эстимэйт" ХХК;

5/ "Бэсгэ" ХХК;

6/ "Үндэсний реалти" ХХК;

7/ "Мон үнэлгээ" ХХК;

8/ "Лэндс" ХХК.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг дээрх нэр бүхий компаниудын захирлуудад үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

ОРХОН АЙМАГ
АНД-ЭНЕРГИ ХХК
КА2201070 4385772